



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-9
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-111

1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	10-11
2.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	11-13
3.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	13-24
4.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	24-52
5. Ерөнхий сайдын мэдээлэл /Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар/	52-87
6. Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	87-111

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 91 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батцэцэг, С.Ганбаатар, Г.Дамдинням, Т.Доржханд, Б.Жавхлан, С.Одонтуяа, Ч.Ундрэм, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Х.Баттулга, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Б.Мөнхсоёл, М.Нарантуяа-Нара, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Д.Батлут, Х.Болормаа, Ц.Мөнхтуяа;

Тасалсан: Л.Гантөмөр;

Хоцорсон: Ц.Даваасүрэн-02 минут, Д.Жаргалсайхан-25 минут, Ч.Лодойсамбуу-02 минут, М.Мандхай-2 цаг 02 минут, З.Мэндсайхан-01 минут, Н.Номтойбаяр-07 минут, Б.Пунсалмаа-07 минут, П.Сайнзориг-02 минут, Г.Уянгахишиг-13 минут, Д.Цогтбаатар-21 минут, Ж.Чинбүрэн-07 минут, Д.Энхтуяа-2 цаг 34 минут, Р.Эрдэнэбүрэн-08 минут.

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 39

Бүгд: 97

59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Ж.Баярмаа, О.Номинчимэг, О.Саранчулуун, Ж.Галбадрах, Д.Ганмаа, Д.Рэгдэл, Б.Хэрлэн нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 68.0 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн нар байлцав.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан үг хэлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 32
Бүгд: 99
67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Т.Мөнхсайхан, Д.Энхтүвшин, Д.Рэгдэл, М.Ганхүлэг нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 72.7 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 32
Бүгд: 100
68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 73

Татгалзсан: 28
Бүгд: 101
72.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74
Татгалзсан: 27
Бүгд: 101
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 81
Татгалзсан: 20
Бүгд: 101
80.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 34
Бүгд: 101
66.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 31
Бүгд: 101
69.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга П.Цогтсайхан, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатарын зөвлөх М.Эрдэнэбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга П.Цогтсайхан нар хариулж, тайлбар хийв.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.7.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, М.Бадамсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	49
Татгалзсан:	55
Бүгд:	104

47.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	49
-------------	----

Татгалзсан: 55

Бүгд: 104

47.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар үг хэлэв.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, О.Номинчимэг, Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ж.Ганбаатар, Ц.Идэрбат, П.Батчимэг, Д.Пүрэвдаваа, П.Ганзориг, А.Ариунзаяа, Б.Хэрлэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 11 цаг 36 минутаас 15 цаг 16 минутад хуралдааныг даргалав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:36/

Уг асуудлыг 12 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 34 минут үргэлжилж, 12 цаг 37 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 30 минутад эхлэв.

Тав.Ерөнхий сайдын мэдээлэл /Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн ахлах шинжээч Ш.Бат-Эрдэнэ, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, мөн яамны Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга А.Хишигбаяр, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Тэмүүлэн, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн гүйцэтгэх захирал М.Энхсайхан, “И-Монгол академи” УТҮГ-ын захирал Б.Мягмарнаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг хийв.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа нар индрээс үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 15 цаг 17 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, С.Эрдэнэболд, Л.Мөнхбаясгалан, Ж.Баярмаа, Б.Пунсалмаа, Г.Уянгахишиг, Д.Жаргалсайхан нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Зах зээлийн хэлтсийн захирал П.Мөнхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Да.Цогтбаатар, Б.Батбаатар нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал хангах албаны дарга Н.Лхагвасайхан, Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Ажиллагааны хэлтсийн дарга С.Лхагвадорж, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга Г.Гүррагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Х.Баасанжаргал, О.Номинчимэг, Д.Ганмаа, Х.Тэмүүжин, Л.Мөнхбаясгалан, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал хангах албаны дарга Н.Лхагвасайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./18:04/

Уг асуудлыг 18 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 08 минут үргэлжилж, 126 гишүүнээс 107 гишүүн хүрэлцэн ирж, 84.9 хувийн ирцтэйгээр 18 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 03 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Нийт 91 гишүүн бүртгэгдэж, ирц 72,2 хувьд хүрсэн байна. 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

2 дугаарт Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

3 дугаарт Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

4 дүгээрт Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

5 дугаарт Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

6 дугаарт үдээс хойш Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцын зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

7 дугаарт Агаарын бохирдол, утааны асуудлаар ерөнхий хяналтын сонсголын бэлтгэлийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайлангийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсоно.

8 дугаарт “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэнэ.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж дууссан.

Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 58 гишүүн буюу 59,8 хувиар хэлэлцэх эсэх асуудал шийдэгдлээ.

Далайн Батбаяр, Жудагийн Баярмаа, Номинчимэг, Саранчулуун, Галбадрах, Ганмаа, Рэгдэл, Хэрлэн гишүүд бүртгэлд оръё. Ингээд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

10.06 цаг

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар.

Гишүүд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан байгаа.

Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооны саналаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна.

Санал хураалтын өмнө би бас гишүүддээ мэдээлэл өгье.

Өчигдөр Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор Улсын Их Хурал дээр хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг өргөн хүрээгээр явагдсан. 26 Улсын Их Хурлын гишүүн асуулт асууж, 4 Улсын Их Хурлын гишүүн үг хэлж, байр сууриа илэрхийлсэн. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүдэд мэдээж санал, шүүмжлэл бас байгаа.

Яг үзэл баримтлалын хүрээнд засаж сайжруулах, хуулийн төслийн хүрээнд засаж сайжруулах шаардлагатай зүйлс олон байгаа талаар байр сууриа илэрхийлсэн. Өчигдөр орой бас хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл мөн дээрээс нь бас Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл зэрэг төрийн бус байгууллагуудаас мэдэгдэл гаргаж, уг хуулийн төсөлтэй холбоотой асуудал дээр хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог хангаж, хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулах ийм шаардлагуудыг тавьсан.

Үүнтэй холбогдуулаад өнөөдөр өглөө 8 цаг 30 минутаас Их Хурлын даргын хувьд мөн Хүний эрхийн дэд хорооны дарга Эрдэнэболд гишүүн, Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Хэвлэлийн эрх чөлөөний эрх зүйн орчинд хяналт, дүн шинжилгээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийн дарга Лодойсамбуу нарын хамтаар бас 30 орчим хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллүүдтэй бас уулзалт хийсэн.

Тэгээд уг уулзалт дээр ярилцаад Улсын Их Хурлын түвшинд энэ хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг дэмжээд явъя. Дэмжсэний үндсэн дээр Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж ажиллана. Тэр ажлын хэсэгт бүх талын оролцоог бүрэн хангасан хэлэлцүүлгийг өргөн хүрээнд зохион байгуулсан байдлаар ажиллаж, шинэчилсэн найруулгын төсөл дээр өргөн хүрээгээр ажиллая гэдэг энэ санал дээр нэгдсэн.

Хэрвээ тэр ажлын хэсэг бүх талын оролцоог хангаад, ажиллаад, нэгдсэн шийдэлд хүрээд явсан тохиолдолд энэ хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр цааш нь дэмжээд явъя.

Хэрвээ нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй тохиолдолд анхны хэлэлцүүлэг хүрээд энэ хуулийн төслийн хэлэлцүүлэг зогсох юм гэсэн ийм байр сууриар нэгдсэн ойлголцолд хүрсэн гэдгийг бас гишүүдэд хэлье.

Тэгэхээр эдгээр саналыг бас гишүүд маань хэлэлцэх эсэх асуудал дээр нь дэмжээд, байр сууриа илэрхийлээд явах нь зөв болов уу гэсэн ийм байдалтай байна.

Ингээд санал хураалтыг эхлүүлье.

1.Байнгын хорооны саналаар Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 67,7 хувиар санал дэмжигдлээ.

Далайн Батбаяр гишүүн дэмжсэнээр бүртгүүлье гэж байна. Мөнхсайхан сайд, Энхтүвшин гишүүн, Рэгдэл гишүүн нар дэмжсэнээр протокол тэмдэглүүлье, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн.

2.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 68 хувиар санал дэмжигдлээ.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 72,3 хувиар санал дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 73,3 хувиар санал дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 80,2 хувиар санал дэмжигдлээ.

6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын

томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 66,3 хувиар санал дэмжигдлээ.

7.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 69,3 хувиар санал дэмжигдлээ.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

10.14 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатараас 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2025 оны 3 сарын 27-ны өдөр хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Лүндэг төсөлд “агнасан бол” гэж тусгасныг тодруулж, оновчтой үг хэрэглээгүйгээс үүдэн хийдэл зөрчил гарах, эрсдэл үүсэх эсэх талаар хууль санаачлагчдаас асуулт асууж, үг хэлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар төслийн 1 дүгээр зүйлд “өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан тохиолдолд амьтны тухай хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.” байхаар төслийн дагаж мөрдөх хугацааг 2025 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөр байхаар өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Пүрэвийн Цогтсайхан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга, Мөнхийн Эрдэнэбилиг Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын зөвлөх.

Энэ хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл дэмжигдсэнтэй холбогдуулаад би 1 өгүүлбэр дутуу уншихаж.

Анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан урьдчилж нэр ирүүлсэн байгаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Асуулт байгаа юм уу. Урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу гишүүд асуулт асуухаар 5 гишүүн нэр ирүүлсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Энэ өдрийн мэнд дэвшүүлье. Тэгээд Амьтны тухай хуульд орж байгаа өөрчлөлттэй холбоо бүхий асуудал Амгаланбаатар гишүүн маань бас өргөн барьсан байна. Хууль бол хууль. Хууль батлагдаад л хэрэгжинэ. Өнөөдөр Монгол Улс даяараа чононы асуудал үүсчхээд байгаа ч юм биш. Зохицуулалттай хэлбэр. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйл дээр энийг тусгаж өгчихсөн байдаг. Эрүүгийн тухай хууль дээр ч энийг бас тусгаад өгчихсөн байдаг.

Би уншаад өгье л дөө. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлд “мал сүргийг хамгаалах болон тодорхой нутаг дэвсгэр тоо толгойг сийрэгжүүлэх зорилгоор чоно агнахад төлбөрөөс чөлөөлөхөөр” зохицуулалт орчихсон байгаа. Аймаг, сумын Засаг дарга нар, аймаг, сумын удирдлагууд Байгаль орчны газартайгаа хамтраад энэ урьдчилсан байдлаар нөөцөөс тогтоогоод Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд ирүүлснээр агнах зөвшөөрлийг авч байгаа. Зүгээр өнөөдөр хуульд орж байгаа өөрчлөлтийг харахаар ахуйн чиглэлээр агнах гэж байгаа төлбөрийг чөлөөлөх гэж байгаа юм шиг харагдаад байгаа хэлбэр байгаад байгаа байхгүй юу.

Өнөөдөр зөвхөн баруун аймагт чоно их байгаад байгаа юм биш. Бусад аймгуудад тэгвэл бас их байгаа юу гэдэг асуудал. Зүүн аймгуудад ховор байна. Говийн аймгууд, хойд бүс ингээд л явж байгаа. Тэгэхээр бид нар энэ чонотой холбоотой асуудал Байнгын хороо дээр бас яригдаж байсан. Үргэлжлүүлээд ирвэсийн асуудал орж ирэх вий дээ. Малын хотонд ордог гэдгээр. Тэгээд уг нь одоо зохицуулалттай байгаа юмыг заавал ингэх шаардлага байгаа юу. Энэ чонын ан хийх сонирхолтой тусгай сонирхлын анчид чонын эд эрхтэн худалдаалах асуудлууд маш их нэмэгдэж байгаа.

Саарал чоно өөрөө зэрлэг амьтан ба ургамал аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцын 2 дугаар хавсралтад багтчихсан байдаг. Энийг судалсан уу. Энэ асуудал дээр би асуумаар байна.

Дээрээс нь нэгэнт жишээ нь ховордсон тохиолдолд эргээд сэргээх гэж тухайн улс байтугай олон улсын түвшинд бөөн асуудал үүсдэг. Маш их хэмжээний мөнгө зарцуулдаг. Өнөөдөр тоо толгойтой холбоотой асуудал дээр надад тоонууд байна л даа. 2019-2024 оны хооронд 1056 саарал чоныг ахуйн зориулалтаар агнах зөвшөөрлийг олгосон. 153-ыг л агнасан байгаа байхгүй юу. Мал сүргийг хамгаалах, хүн өөрийгөө хамгаалахтай холбоотой агнах гэж зөвшөөрөл авах гэж явж байна. Малын хотонд ороод ирснийх нь дараагаар зөвшөөрөл аваагүй учраас буудаж алж чадахгүй, мал амьтны, дээрээс нь өөрийнх нь амь насанд аюул учраад байна гэж яриад байгаа юм. Үгүй шүү дээ. Буудаж алах эрх нь байгаа. Ямар ч асуудал байхгүй. Бүрдүүлбэрийг нь хангаад л явуулчих ёстой асуудал. Малчид амь нас, мал сүргээ хамгаалах зорилгоор гэдэг дээр хариулгатай явж байгаа мал, эсвэл малчны хот руу дайрч байгаа чоныг агнасан тохиолдолд зөвшөөрөл авахгүй гэж ойлгуулж байгаа юм. Тэгвэл тухайн үед үүссэн нөхцөл байдлыг нотлох мэдээллийн сангийн бүртгэлийг хэрхэн хамруулах вэ. Мэдээллийн сангийн бүртгэл тодорхой бусаас шалтгаалалтай дараа дараагийн асуудлууд үүсдэг. Энэ дээр ямар асуудлууд дээр яаж шийдвэрлэхээр та хуулийн төсөлдөө тусгаж оруулж өгч байгаа вэ гэдгийг би асуумаар байгаа юм.

Европын эко систем чухал үүрэг гүйцэтгэж байгаа Популяцын тоо 23 мянга болж сэргэсэн гээд Дэлхийн байгаль хамгаалах холбооноос мэдэгдэж байгаа. Монгол Улстай холбоотой асуудал гэдгийг ойлгож байна. Гэхдээ Монгол Улсад өнөөдөр чоно өөрөө ямар үүрэгтэй амьтан бэ гэдгээ бас бид нар маш сайн бодохгүй бол нөгөө малын халдварт өвчин, сүргийн бүтэц маш олон асуудлууд цааш цаашдаа үүсэх вий дээ. Саяын 2 асуулт.

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя. Амгаланбаатар гишүүн.

О.Амгаланбаатар: Асуултад хариулъя. Сая та бас өөрөө бараг л асуултдаа хариулчихлаа даа. Тэгээд энэ сум зөвшөөрөл авахын тулд чоно агнахын тулд зөвшөөрөл авдаг. Тэгээд зөвшөөрөл авчхаад 1900 орчим зөвшөөрөл авчхаад 150-ийг агнасан байна гэж ярьж байна. Мэдээлэл хийлээ. Тэгэхээр үндсэндээ яг л тийм байгаа юм л даа. Манайхан чинь чоно агная гээд үнэхээр дийлдэггүй. Энэ модтой газрууд ер нь бол зүүн 3 аймгийг эс тооцох юм бол Монгол даяар энэ чоноо дийлэхээ больчихсон. Өнөөдөр 1987 оноос хойш Монгол Улсад чоно огт тооллого хийгээгүй байгаа шүү дээ. Сүүлийн бараг 40-өөд жил гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр ер нь бол нөхцөл байдал ямар байна гэхээр сумаасаа зөвшөөрлөө аваад, 5 хоногийн хугацаатай зөвшөөрөл аваад, яг энэ газраас чоно агнана гэсэн

зөвшөөрөл аваад явахаар яг тэр газар нь чоно алах, агнах ямар ч боломжгүй байдаг. 5 хоногийн хугацаанд чоно агнаж чадахгүй бол эргээд сумаасаа очиж дахиж зөвшөөрөл авдаг гэх зэргээр шат дамжлага нь маш их байгаад байгаа юм.

Тэгээд сүүлдээ хот руу нь дайраад, хүн рүү дайрсан нөхцөлд чоно агначихсан нөхцөлд сумын хэсгийн төлөөлөгчөөс гэдэг юм уу, сумын хуулийн байгууллагаас чингээд хууль бусаар чоно агнасан байна гээд машиныг нь хураадаг, бууг нь хураадаг, гурвуулаа явж байвал тус бүрд нь 2 сая төгрөгөөр торгодог ийм зүйл болчихоод байгаа юм. Тэгэхээр хууль маань 1 мөр ийм ойлгомжтой байх үүднээс амь нас, мал сүргээ хамгаалсан нөхцөлд энэ чоно агнавал тэр торгуулиас чөлөөлөгдөнө гэсэн ийм 1 мөр ойлгомжтой заалтыг оруулж байгаа юм гэдгийг бол хэлье.

Тэгээд үүссэн нөхцөл байдал нэгэнт агнахаасаа өмнө биш, агнасныхаа дараа баримтжуулах зүйлийг бол хийх боломжтой гэж хэлье. Асуултад хариуллаа.

Д.Амарбаясгалан: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Байгаль орчны яамныхан хариулчих. Хууль санаачилж байгаа гишүүндээ та нар мэдээлэл өгөөгүй юм шиг байна. Ахуйн зориулалт гэдэг утгыг ч ойлгоогүй явж байна. Нөөц тоо судалгаатай холбоотой асуудлыг судлаагүй байж байж яаж өнөөдөр агнах тухай асуудлыг шууд хөндөж байгаа юм бэ. Илүүдэлтэй гэж яаж тооцоод байгаа юм. Энэ дээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамныхан хууль санаачлагчдаа мэдээллүүдээ зөв өгөх ёстой. Дээрээс нь өнөөдөр бид нар хууль нэг мөр хэрэгжих ёстой гэдгийг та өөрөө хэллээ. Нэг мөр хэрэгжинэ гээд бүх газар чоно агнах процессууд явах вий дээ. Энэ чоно гэдэг амьтныг чинь буцааж тоо толгойг нь нэмэгдүүлэхийн тулд Монгол Улс нэлээн их хүчин чармайлт бас гаргасан шүү. Энэ дээр Байгаль орчны яамныхан хариулт өгмөөр байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

П.Цогтсайхан: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга Цогтсайхан. Бат-Эрдэнэ гишүүний тодруулгад хариулт өгье.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар амьтан агнасан барьсан төлбөрийн тодорхой хувийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ийм заалттай. Тэр хуулийн дагуу зарцуулах арга хэмжээнд энэ биологийн олон янз байдлын тархац, нөөцийн судалгаа орох ёстой юм. Энэ дээр манай аймгийн Засаг дарга нар санаачлаад энэ асуудалдаа тавиад, тэгээд Байгаль орчин, уур амьсгалын өөрсдийн яаманд хүсэлт ирүүлсэн тохиолдолд бид нар судалгааны дүнг үндэслээд квот тогтоодог. Харамсалтай нь энэ ажил Архангай, Дархан-Уул, Хэнтий гэсэн 3 аймагт л хийгдсэн байгаа. Тийм учраас 2020 .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн дахин тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Цогтсайхан дарга аа, та чинь гөлөг төөрүүлж байгаа юм шиг юм яриад байх юм. Чоно төөрүүлэх гээд байгаа юм уу. Ний нуугүй хэлэхэд мэргэжлийнхээ түвшинд бол мэргэжлийнхээ түвшинд хариултаа өг. Танаас ерөөсөө Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн орсон орлого хаашаа ордог вэ гэдгийг яриагүй шүү дээ. Аймаг сумууд өөрсдөө нөөцөөрөө тодорхойлоод, тэр дээрээ тодорхой хэмжээний урьдчилсан байдлаар Байгаль орчны яаманд ирүүлээд,

ямар ч төлбөргүйгээр чоно агнах ахуйн зориулалтаар агнах процессууд чинь ч бэлэн хуульд байгаа шүү дээ. Яагаад энийгээ ярихгүй байгаа юм. Байгаль орчны яам байгаа учраас өөрсдөө эсвэл хариултаа хэл. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам албан ёсоор энэ чоно агнах процессыг бодлогын хэмжээнд бид нар дэмжиж байгаа гэдгээ шууд хэлэх хэрэгтэй. 2009 оны Засгийн газрын тогтоолтой. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг чоногүй. Одоо ингээд хууль нэг мөр хэрэгжинэ. Зүүн бүсэд яах юм. Говийн бүсээр яах юм. Хойд бүсээр яах юм. Бүсчилсэн хэлбэр утга агуулгаараа энэ хуулийн заалтууд чинь оруулах боломжгүй байгаад байгаа цаг .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Амгаланбаатар гишүүн хариулт өгье.

О.Амгаланбаатар: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Ер нь бол өнөөдрөөс яагаад Монголд энэ зүүн аймгуудад чоно ингэж цөөрсөн юм бэ гэдгийг нь бас судлаад үзэхэд хил дээр чоно хууль бусаар үнэ гардаг. Өндөр үнэтэй байдаг 1 чоно 2 сая орчим төгрөгөөр хил дээр зарагддаг. Хятадууд маш их хэмжээгээр чоно авдгаас болоод чоно агнаж, арилжааны зориулалтаар бизнес мөнгө олох зорилгоор ийм хядлага явж байсан юм байна лээ. Одоо тэгээд аль аль талдаа байгаль хамгаалагч нар ч тэр, хуулийн байгууллага ч тэр, хил гааль ч гэсэн бас хууль мөрддөг болсонтой холбоотойгоор хилээр хууль бусаар конторвант хийх боломж хаагдсантай холбоотойгоор энэ чоно агнах зүйл ер нь бол эрс багасаж, бараг зогссон юм байна лээ шүү. Тэгэхээр энийг бас зөвөөр ойлгох хэрэгтэй юм байна лээ гэдгийг хэлье.

2-т гэх юм бол цаг дуусчихлаа.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Би бол Бат-Эрдэнэ гишүүнтэй эсрэг санал байр суурьтай, бараг ярьж байгаа зүйлийнх нь эсрэг шахуу л юм ярих гээд байна л даа. Энэ сарын өмнө шахуу юм даа. 3 сарын 28-нд Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас сумынх нь Хурлын төлөөлөгчид ирж, говийн бүсээс сонгогдсон гишүүдтэй уулзахдаа би нэр дурдаж хэлж болж байна. Сэржмядаг гээд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын төлөөлөгч Сэржмядаг тэр Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаанд ажилладаг юм шиг байгаа юм. Эрдэнэбаяр гээд олон улсууд Гурвантэс суманд ирвэс, чоно ихэссэн тухай, бүр айлын тооно дээр гараад суучхаад эзнийг нь отоод байдаг тухай, 2 настай хөгшин хотонд нь ирвэс ороод малыг нь сүйтгэхэд харин дүлийдээ болоод харин гараагүй учраас ч ирвэст бариулаагүй тухай маш их тийм ноцтой юмнууд яриад бид бүхэнд бас Улсын Их Хурлын гишүүдэд энэ талаар анхаарч өгөөч. Тэр хууль, эрх зүйн орчинд нь бас шаардлагатай бол өөрчлөлт оруулж өгөөч. Ер нь иргэдийн аюулгүй байдал бас алдагдаад, хүн, мал гэхээсээ илүү хувь хүн амь насаа хамгаалах, аргагүй хамгаалалт хийх тэр боломжийг нь олгохгүй бол удахгүй ирвэс хүн барьсан гэхэд гайхах зүйлгүй болж байна шүү гэж хэлсэн юм байгаа юм. Тэгэхээр энэ хууль яах вэ, Амгаланбаатар гишүүн бодвол баруун аймгуудад чоно ихэссэнтэй холбоотой бас хүн мал аюулгүй байдал, мал сүргээ хамгаалах, амь насаа хамгаалахтай холбоотойгоор энэ хуулийн заалтад өөрчлөлт оруулахаар орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ хуулийг хэлэлцэхдээ энэ Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас ирсэн саналыг бодолцож үзнэ үү гэж хэлэхээр байгаа юм.

Миний хувьд бол зүгээр ирвэсийг агная гээд байгаа юм биш. Гэхдээ ирвэсээс үнэтэй хүний амь нас байхгүй байх гэж бодож байгаа юм. Бас энэ хуулийг хэлэлцэхдээ тал хээр говийн бүсэд зээрийн цагаан чонын асуудал бол энэ ангилалд орохгүй байх. Тэгээд бүс нутгаар нь бас ялгавартай тогтоох нь зөв болов уу гэсэн ийм зүйлийг хэлэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: Хүний амь нас, эд хөрөнгө хамгаас чухал гэдгийг ойлгож байгаа. Гэхдээ саарал чонын байгальд гүйцэтгэж байгаа үүрэг бол үлэмж их шүү дээ. Ер нь бол байгальд илүү юм гэж байхгүй. Энэ тоо толгойг зохицуулдаг мал хүний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг хийдэг байгалийн хамгийн чухал зохицуулагч бол чоно гэж үзэж байгаа. Монголын нөхцөлд. Тэгээд тоо толгойн судалгаа хийгээд зохицуулалт хийх бас боломж байгаа талаар Байгаль орчны сайд байсан Бат-Эрдэнэ гишүүн бас санал хэлж байна. Хууль дээр ч бас ийм зохицуулалтууд байгаа. Би 1 дүгээрт нь олон улсын байгаль хамгаалах байгууллагууд энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ. Ер нь санал авсан уу гэдгийг 1 дүгээрт асууя.

2-т нь амь нас, мал сүргээ хамгаалах зорилготой байсан гэдгийг яаж нотлох вэ. Энэ дээр ямар зохицуулалт байгаа вэ. Энийг хууль санаачлагчийн хувьд юу гэж харж байна.

2 дугаарт нь би энэ асуултдаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас заавал мэргэжлийн яам хариулах ёстой гэж үзэж байна. Эндээс ингээд юу харагдаж байна гэхээр Монгол Улс чинь ийм өргөн уудам нутагтай. 1 сая 500 мянган км квадрат нутагтай. Монгол Улс 21 аймагтай. 21 аймгийн 1 аймаг нь Өмнөд Солонгосоос гэхэд том нутаг дэвсгэртэй. Тэгэхээр энэ дээр ингээд цаашдаа бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд бидэнд анхаарах асуудлууд олон байна. Энэ бол зөвхөн 1 илрэл нь гэж хэлж болно. Тэгэхээр талын бүс өөр, хангайн бүс өөр, баруун тал өөр, говийн бүс өөр. Тэгэхээр энэ дээр бид нар цаашид ер нь хууль тогтоомжууд Монгол Улсын бодлогын хувьд ер нь яаж анхаарч ажиллах вэ гэдэг дээр холбогдох энэ асуудлыг хариуцсан сайдаас, гишүүнээс энэ дээр хариулт өгөөч гэж хүсэж байна. Бүсчилсэн бодлогын хувьд яаж явах вэ.

Амьтан агнах төлбөр хэдэн төгрөг төвлөрөөд, тэгээд энэнээс хэдийг нь эргэж энэ амьтан хамгаалах үйл ажиллагаанд зарцуулдаг вэ. Энэ үр дүнтэй байгаа юу. Энийг Байгаль орчны яамнаас асууж байна.

Мөн байгаль орчны байцаагч байгаль хамгаалагчийн эрхийг яаж нэмэгдүүлэх вэ. Энэ чиглэлээр ер нь ямар ажил хийж байгаа вэ. Өөрөөр хэлбэл байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч гэдэг хүнээс хүн амьтан нэлээн эмээдэг. Энэ хууль тогтоомжийг мөрдүүлж байгаа хууль сахиулагчийнх нь хувьд хүндэлдэг. Энэ хүмүүсээс ноогдуулж байгаа тэр шийтгэл төлбөр энэ нь нэлээн өндөр байж байж өндөр хөгжилтэй орнуудтай адилхан энэ байгаль хамгаалагч, байгаль орчны байцаагч гэдэг бол их өндөр статустай байх. Бараг цагдаагаас илүү хэмжээний ийм эрх мэдэлтэй байж байж байгаль орчныг хамгаалах асуудал яригдана. Тэгэхгүй бол амьжиргааны түвшин өөр өөр байх юм бол байгалийн баялаг руугаа ханддаг, энэ рүү ордог асуудал бол байдаг байсан шүү дээ. Ялангуяа зах зээлийн шилжилтийн үед. Тэгвэл одоо үүнээс хойш бас нэлээд хугацаа өнгөрлөө. Энэ дээр ер нь ямар

өөрчлөлт шинэчлэлт хийж байгаа вэ. Энийг бас Байгаль орчны яамнаас асууя. Тэгээд дараа нь тодруулъя.

Д.Амарбаясгалан: Амгаланбаатар гишүүн хариулъя.

О.Амгаланбаатар: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Өөртөө хамаатайг нь.

Баримтжуулалтын хувьд бол мэдээж энэ амь нас мал сүрэг рүү нь дайрсан нөхцөлд алж агначих юм дараа нь баримтжуулалтаа хийх боломжтой түүнээс биш агнахаасаа өмнө баримтжуулалт хийх ямар ч боломжгүй шүү дээ гэдгийг бол хэлье. Тэгэхдээ дээр нь сая байгаль хамгаалагчдын талаар бас хөндөж байна. Энэ бол маш хамгийн зөв зүйтэй ийм санал байгаа юм. Байгаль хамгаалагчдын хувьд гэхэд зөрчилтэй таарах юм бол ямар нэгэн арга хэмжээ зэвсэг хэрэглэж болно гэж байгаа юм. Тэгсэн мөртөө доод талд нь тэр газ болон бие хамгаалах тийм зүйлээр хэрэглэж болно гээд л тодорхойгүй ийм зүйл хийгээд орхичихсон юм байна лээ. Тэгэхээр бид нарын хувьд бол нэгэнт байгаль хамгаалагчдын эрхийг нь нэмэгдүүлэх, тэр нөхцөл, зөрчлүүдтэй тааралдсан нөхцөлд тэр цагдаа шиг тийм эрхтэй байх талаас нь дараа дараа нь энэ Их Хурал дээр ярилцмаар юм байна лээ гэдгийг бол хэлье. Тэгээд байгаль хамгаалагчдын тал дээр нэмээд нэг зүйл хэлэхэд байгаль хамгаалагч нь ТЗ гэдэг ангилалтай байдаг. Заавал төрийн албаны шалгалт өгч байж ажилладаг. Гэтэл хөдөө орон нутгийн яг байгаль хамгаалж байгаа хүмүүс бол зүрх сэтгэлээрээ явдаг ийм хүмүүс байдаг. Тэр хүмүүс энэ төрийн албаны шалгалтад зарим нь дийлэнх нь бараг тэнцдэггүй. Чи төрийн албаны шалгалтад тэнцэхгүй байна гэдэг үүднээс бол хөдөө орон нутагт байгаль хамгаалагч бас ийм орон тоо дутуу байдаг. Ийм учраас бас дараа дараа нь ТЗ биш ТТ болгоод төрийн тусгай албан хаагч болгоод бас эрхийг нь нэмээд өгөх юм бол байгаль хамгаалалтад эерэг нөлөөтэй болох юм байна лээ гэдгийг бас дараа дараа нь Их Хурал авч хэлэлцмээр юм байна лээ гэдгийг бол хэлье. Олон улсын байгууллагуудаас санал аваагүй.

Д.Амарбаясгалан: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Байгаль орчны яамнаас олон асуулт асуусан.

Д.Амарбаясгалан: Байгаль орчны сайд чөлөөтэй байгаа билүү. Гадагшаа явсан. Гадаад томилолттой явчихсан. Яамнаас төлөөлөөд хариулах уу. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон. Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя.

П.Цогтсайхан: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хэлтсийн дарга Цогтсайхан. Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулийн дагуу амьтны нөөц ашигласны төлбөрөөс 2024 оны байдлаар 14,3 тэрбум төгрөг орсон байгаа. Энэ нь бол нийт байгалийн нөөц ашигласны төлбөрийн 5,1 хувийг эзэлж байгаа. Үүний зарцуулалт бол байгалийн нөөц ашигласны төлбөрийн бүх дүнгээрээ үзсэн тоогоор бол 63 хувьтай гарсан байдаг. Тэгээд энэ дээр бол амьтны нөөц ашигласнаас буцаад ан амьтныг хамгаалах, нөөц судалгаа хийх, энд зарцуулах хувь хэмжээ бол 42 хувьтай байж байгаа. Саарал чоныг агнуулах тухай энэ хуулийн өөрчлөлтийн асуудлыг бид нар олон улсын хамтрагч байгууллагуудтай олон удаа зөвшилцсөн. Олон улсын байгууллагуудын байр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

П.Цогтсайхан: Олон улсын байр суурь бол нэгдэн орсон конвенцуудынхаа хүрээнд асуудлыг харгалзаж үзэх ёстой.

2 дугаарт одоо байгаа зохицуулалтынхаа хүрээнд энэ асуудлыг шийдвэрлээд аймаг, орон нутагт чиглэл өгөх замаар энэ асуудлыг зохицуулах бололцоотой гэж үзсэн байдаг. Байгаль хамгаалагчдын хувьд хяналтын үйл ажиллагаа манай салбарын яаманд ирснээр бид нар байгаль хамгаалагчдыг чадавхжуулах ялангуяа байгаль хамгаалагчдынхаа төрөл ангиллыг дээшлүүлэх, тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч, сумын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагчдын статусыг дээшлүүлэх ийм чадавхжуулах ажлыг хийхээр төлөвлөөд байж байгаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, Бадамсүрэн гишүүн дахин тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Яах вэ, би хангалттай хариулт авч чадсангүй. Тэгээд чулуутай газар гэрээ барь, чонотой газар малаа өсгө гэдэг бол хувь хүний хувьд ингэж илүү ажилч хичээнгүй байх ёстой гэдэг зүйл байгаа шүү дээ. Тэгээд манай зүүн бүсэд бол чонотой холбоотой энэ зохицуулалт яг батлагдах юм бол маш их асуудалтай. Цагаан зээрийг халдварт өвчнөөс сэргийлдэг, шүлхий гоц халдварт өвчнөөс энийг хянадаг ганц амьтан бол чоно. Говийн бүсэд мөн гөрөөснүүд байгаа. Тэгэхээр саарал чоно хамгаалах сарын аян гээд манай Дорнод аймаг хүртэл өрнүүлдэг шүү дээ. Тэгэхээр энд бол асуудалтай. Тэгээд ирвэс хамгаалах олон улсын төсөл гэхэд жишээлбэл баруун аймагт хэрвээ бэлчээрт нь мал барьчих юм бол тэрний төлбөрийг нь олон улсын байгууллага төлдөг хүртэл хэлбэрээр ингэж бас байгальд байгаа зохицуулдаг амьтныг хамгаалах ажлыг хүртэл хийж байгаа. Тэгээд энэ дээр ямар байр суурьтай байна. Энийг ер нь юу гэж тооцож, ер нь бүхэлд нь энийг олон улсын байгууллага .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Амгаланбаатар гишүүн хариулт өгье.

О.Амгаланбаатар: Манайхан энэ чинь чоныг хөөж агнах гээд байгаа юм биш. Хөөж алах гээд, хядах гээд байгаа юм биш шүү дээ. Яг үнэхээр хот руу нь дайраад малаа хариулаад явж байхад нь дайраад эсвэл энэ галзуу солиотой, галзуурчихсан чоно жишээлбэл Говь-Алтай, баруун аймгууд Баян-Өлгийд гэхэд чинь хүн рүү дайраад, тэр ганжингаараа цохиж алсан гээд л интернэт фэйсбүүкээр явж байна. Айлын хот руу дайрч ороод 200 хэдээр нь хядчихсан ийм тохиолдлууд Монгол даяараа л байна шүү дээ. Ингээд малчдын амьдралын хамгийн гол орлого болсон бодынх нь төл ер нь энэ хангайн бүсэд, говийн бүсэд, баруун бүсэд ерөөсөө бодын төл авч чадахаа больсон шүү дээ. Тэгэхээр энэ чинь хүний амьдралаас илүү хуулиар хамгаалагдсан чоно болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ чинь амь нас, мал сүргээ хамгаалах зорилгоор чоно агнах юм бол тэр мөнгийг нь торгууль төлөхгүй л гэж байгаа юм. Тэгэхээр яг амьдрал дээр яваад очихоор нөгөө агнасан чоныг нь харчхаад л чи тэнд чоно агнасан байна гээд л 2 саяар торгочихдог ийм л асуудлууд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж

мөн аль нэг намын эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 гишүүн үг хэлж болно. Үг хэлэхээр 2 гишүүний нэр ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Батын Батбаатар.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын танилцуулъя.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.7.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар.

Энэ саналтай холбоотой нэр өгсөн гишүүд үг хэлэх үү. Бат-Эрдэнэ гишүүн. Зарчмын зөрүүтэй саналтай холбоотой байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн суудал дээрээсээ.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүд маань хуулиа уншаа. Наранбаатар гишүүн ээ. Та парламентад 2 удаа сонгогдсон хүн. Энэ ерөөсөө тоглоом биш. Чоно үг хэлж чадахгүй болохоор дээрэлхэж байх шиг байна гэдэг шиг 13176 чоно сүүлийн 4 жилийн хугацаанд бүртгэгдсэн Амгаланбаатар гишүүн ээ. Байгаль орчны яамныхан хариуцлагагүй байна. Холбогдох албан тушаалтнууд ажлаа мэдэхгүй байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлээр урьдчилсан байдлаар тогтоогоод, төлбөрөөс чөлөөлөгдөх, хөнгөлөгдөх бүх зохицуулалт орчихсон байгаа.

Эрүүгийн хуулийн 4 дүгээр зүйл дээр ч орчихсон байгаа. Эрүүгийн ямарваа нэг хариуцлага хүлээхгүй гэдгээрээ. Өнөөдөр өөрийгөө хамгаалах болон мал сүргээ хамгаалах зорилгоор зохицуулалт хийж байгаа бүх хэлбэр төлбөрөөс чөлөөлөгдөж байгаа. Дээрээс нь хотонд нь орж ирэхээр гүйж очоод зөвшөөрөл авах гэж байтал хамаг хонийг нь барчихлаа гэдэг ийм худал яриаг өнөөдөр ярьж болохгүй. Өнөөдөр хотонд орох байтугай малын бэлчээр дээр байгаа чоноо алаад төлбөрөөс чөлөөлөгддөг хэлбэр явж байгаа. Чөлөөлж байсан. Өнөөдөр Монгол Улс 57 сая малтай. 13100 орчим л чоно байна. Таны сонгогдсон Говь-Алтай аймагт 383 чоно байна. 383 чоно. Байгаль орчны яамны тооцоо судалгаагаар. Өнөөдөр бид нар энэ тооцоо судалгаатай холбоотой асуудлуудаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, холбогдох аймаг, сумын Засаг даргын Тамгын газрууд энэ дээрээ жоохон хариуцлагатай хандах хэрэгтэй. Хариуцлагатай хандах хэрэгтэй. Бид нар цаашдаа ингээд мал сүрэг барьж байна гэдэг утга агуулгаараа чонын асуудлыг оруулж ирээд үргэлжлүүлээд Өвөрхангай аймаг ирвэсийн асуудал оруулж ирээд, ингээд зэрлэг амьтад руугаа ороод эхлэх вий дээ. Ийм болгоомжлол яг ний нуугүй хэлэхэд байна.

Сая Бадамсүрэн гишүүн маш тодорхой хэлсэн. Өнөөдөр хуулийн зохицуулалт заалтууд нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бүх зөвшөөрлүүдийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам гаргаж байгаа. Өнөөдөр чононоос болоод эрүүгийн хариуцлага хүлээгээд ял аваад явж байгаа хүн байхгүй. Зөвшөөрөлтэй холбоотой зөвшөөрлөө аваагүйтэй холбоотой ан агнаад төлбөрт унаад явж байгаа хүмүүсийн тооцоо судалгааг авсан уу гэхэд хариулж чадахгүй байгаа. Өнөөдөр Байгаль орчин,

уур амьсгалын өөрчлөлтийн яам энэ сайзын 2 дугаар хавсралтад орсон дэлхий дахинаа ховордож байгаа энэ чонотой холбоотой асуудал дээр хариултаа өгч чадахгүй байна. Маш харамсалтай байна. Байгаль орчны яаманд үнэхээр энэ бодлогоо гаргаж чадахгүй байгаа дээр гүн эмгэнэлийг би илэрхийлмээр байна. Ийм түвшний асуудлаа мэдэхгүй. Тооцоо судалгаа хийснээ хэлж ярьж чадахгүй, хуулийн зохицуулалтуудаа өнөөдөр байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн зохицуулалтуудаа хариуцсан дарга нь мэдэхгүй.

Энэ Төрийн албаны тухай хуулийг бид нар нөгөө талдаа бас эргэж харах ёстой. Төрийн албанд ажлаа мэдэхгүйтэй холбоотой ийм албан тушаалтнууд хууль тогтоох засаглалд хүртэл орж ирээд хариулж чадахгүйтэй холбоотой хуулийн өөрчлөлтүүд орж байгаад харамсаж байгаа. Тэгэхээр би энэ асуудлыг эсэргүүцэж байгаа. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ажиллаж байхдаа ч гэсэн энэ дээр маш олон тохиолдлууд дээр ажиллаж байсан учраас бодит байдлыг, нөхцөл байдлыг мэдэж байгаа хүний хувьд энэ болохгүй зүйл юм байгаа юм шүү гэдгийг бас онцлон тэмдэглэж хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Бат-Эрдэнэ гишүүн үг хэллээ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн үг хэлье.

М.Бадамсүрэн: Амгаланбаатар гишүүний хувьд бол тойрогтоо тулгамдаж байгаа асуудал, иргэдийнхээ тавьж байгаа энэ амь нас, эд хөрөнгөтэй холбоотой асуудлуудыг сонгогдсон гишүүнийхээ хувьд, хууль тогтоогчийнхоо хувьд санал болгож, хуулийн төсөл өргөн мэдүүлж байгааг бол ойлгож байгаа. Нөгөө талдаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам энэ дээр маш хариуцлагагүй байна гэдгийг би бол бас онцлон хэлье гэж бодож байна.

Энэ бол зөвхөн нэг жишээ болж байна л даа. Цаашдаа энэ бүсүүд ийм ялгаатай, өөр зохицуулалттай явахгүй бол жишээлбэл бол уул уурхай дээр гэхэд зүүн бүс говийн бүс дээр хамгийн их асуудал тулгамддаг. Бусад бүс дээр харьцангуй гайгүй. Тэгэхээр бид нар ер нь бүсчилсэн бодлогын хүрээнд хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, бүсчилсэн байдлаар зарим асуудлуудаа шийдэж явахгүй бол тэгээд тал, говь, хангай ингээд бүх юм хосолсон ийм өргөн уудам нутагтай тэгээд 1 хуулиар зохицуулах гээд яваад байгаа олон зүйлүүд байгаа.

Ялангуяа энэ ашигт малтмал газрын тос ашиглалттай холбоотой олон асуудлууд үүний ард байгаа шүү. Тийм учраас Амгаланбаатар гишүүн бүсдээ тулгамдаж байгаа асуудлуудаа тавьж байгаатай адилхан бидний хувьд ч гэсэн зүүн бүс, говийн бүсээс сонгогдсон гишүүдийн хувьд бол уул уурхайтай холбоотой уул уурхайн баялгийн орон нутагт орох өгөөжтэй холбоотой, хуваарилалттай холбоотой шударга бус зүйл хуваарилж байгаатай холбоотой асуудал яривал бид нар бас зөндөө асуудал ярихаар асуудлууд байгаа шүү дээ.

Тийм учраас зүүн бүс, говийн бүсийн гишүүд хамтраад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөртэй холбоотой, газрын тосны нөөц ашигласны төлбөртэй холбоотой асуудлуудыг бол яг энэ зарчмыг өргөн барих нь зөв юм байна гэж би хувьдаа ажиглаж байна. Тойрог тойрогтоо тулгамдаж байгаа асуудлуудаа яг ийм маягаар өргөн бариад явбал Их Хурлын гишүүд бүгдээрээ л явна шүү дээ. Энэ дээр гол нь яамд энэ дээр яг ямар зохицуулалт хийж байгаа юм. Энэ чинь тухайн салбарын асуудал хариуцаж байгаа яам шүү дээ. Монгол төрийн өмнө Засгийн газар, Засгийн газрын өмнө салбарын яам хариуцаж байгаа яамд энэ зүйл дээр ач

холбогдол өгөөд оролцох ёстой шүү дээ. Тэгээд ингэж явахгүй ийм байдлаар ингээд орхичихдог. Тэгээд салбарын бодлого гэж ер нь байхгүй байна шүү дээ. Сая энэ олон улсын гэрээ хэлцлээр ч гэсэн энэ асуудлууд зөндөө гарч байна шүү дээ. Олон улсын гэрээ, хэлцэл хийдэг албан тушаалтан гэж байгаа юм уу. Тэр биччихсэн үг үсэг, нөгөө талтайгаа гадаад улстайгаа тохирсон тэр бичсэн тэр төслийнх нь үг үсэг энэ тэр арай ичмээр байгаа юм биш үү. Ийм байдалтай ер нь энэ ажил явахгүй шүү дээ. Тэгээд энэ зүйл дээрээ онцгой анхаараач ээ гэдгийг би бас онцлон хэлье.

Тэгээд энийг бол ялгаатай бодлого байх ёстой юм байна. Энэ нь харин Засгийн газарт эрхийг нь өгөөд, ялгаатай бодлогоор энийг зохицуулахгүй бол яг үүнтэй адилхан нөхцөл байдал үүсэх гээд байгаа байхгүй юу. Өчигдөр Хөдөө аж ахуйн сайд ч гэсэн бас асуудал хэлж байна лээ. Ер нь тэр тойрогтоо хуваарилагдаж байгаа аль бүсүүдэд давуу байдлаар хуваарилагдаж байна энэ тэр гээд зөндөө асуудлууд ярьж байгаа шүү дээ. Энэ зүйл дээр салбар хариуцсан сайд нар жоохон анхаарах хэрэгтэй байна. Энэ дээр томоор нь, цогцоор нь нэгэнт Монгол Улсын салбар хариуцсан сайд юм бол Монгол Улсын хэмжээнд асуудлаа хариуцаж, Монгол Улсын хэмжээнд байгаль орчин, хөдөө аж ахуй уурхай, бусад бүх бодлогуудаа авч үзэх хэрэгтэй шүү дээ. Энийг чинь сайд нар л хариуцаж авч энийг ялгаатай бодлогыг дэвшүүлж оруулж ирнэ шүү дээ. Тойргийн гишүүн тэр болгон энэ ялгаатай байдлыг мэдэхгүй шүү дээ. Өөрийнхөө тойргийн эрх ашигтай холбоотой асуудлаа түрүүлж оруулж байгаа. Тэгээд энэ зүйлийн ийм том зөрчил энэ дээр гарч байна. Бүсүүдийн хооронд ялгаатай.

Тийм учраас бүсчилсэн бодлогын хүрээнд хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах шаардлага байна гэдгийг бас онцлон хэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд байр сууриа илэрхийлж, үг хэллээ. Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна.

1 дүгээр санал хураалт. Би уншиж танилцуулсан байгаа.

“25.7 Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, мал сүргээ хамгаалах зайлшгүй шаардлагаар саарал чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар. Санал хураалт 49 гишүүн дэмжиж, 47,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Далайн Батбаяр гишүүн горимын санал гаргая.

Д.Батбаяр: Горимын санал гаргаж байна. Энэ санал хураалтад оролцож амжсангүй. Тэгээд энэ саналыг хүчингүй болгоод, дахиж санал хурааж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Амжсангүй гэдэг саналын томъёоллоор горимын санал гаргаж болохгүй л дээ. Улсын Их Хурлын гишүүд олонх нь дэмжсэнгүй. Гэхдээ энэ асуудал дэмжигдээгүй буцлаа гэхэд Байнгын хорооноос 2/3-ын саналаар босгож оруулж ирэх боломжтой. Дэмжээгүй заалттай. Би горимын санал гаргаж, ахиж санал хураалт явуулахгүй гэдэг ийм байр суурийг баримтлаад байгаа шүү дээ.

Заяабал гишүүн горимын санал гаргая.

Б.Заяабал: Баярлалаа. Миний бас төхөөрөмж сая ажилласангүй л дээ. Би хуруугаа дараад дараад ерөөсөө болсонгүй. Тэгээд энэ саналыг хүчингүй болгож, дахиж санал хураалт явуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабалын гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй. Гэхдээ энэ чинь нөгөө хуулийн төсөл унаж байгаа хэлбэр биш шүү дээ Амгаланбаатар гишүүн. Энэ чинь өргөн барьсан төслөөрөө явна гэсэн үг байхгүй юу. Гаргасан саналыг хүлээж авсангүй гэсэн үг.

2 дахь санал. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар.

Наранбаатар гишүүнд микрофон өгье.

Н.Наранбаатар: Эхний заалт унасан учраас дараагийн 2 дугаар заалтыг гүйцээн боловсруулах чиглэл авъя.

Д.Амарбаясгалан: Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

10.55 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жаргалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугараас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийн анхны

хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 11 саналын томъёолол бичгээр урьдчилан ирүүлсэн. Улсын Их Хурлын гишүүн Сэддорж Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан олон улсын жишиг зарчмыг баримтлан Монголбанкнаас тогтоосон нөхцөл шаардлагыг үндэслэн зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн үйлчилгээний хөлсөө өөрөө тогтоох, Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зээлдэгчийн мэдээллийг 5 жил хадгалах агуулга бүхий зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Мөн хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл, шаардлагыг Монголбанк батлах агуулга бүхий зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал тогтоолын төслийн 2 дугаар зүйлийг зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл, шаардлагыг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгах агуулгаар өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Түүнчлэн тогтоолын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сэддорж зээлдэгчийн зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд 3 жилээр тусгах гэсэн агуулга бүхий зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасны дагуу Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг 1 бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын

зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Бэгзийн Итгэлсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга, Өлзийбатын Мөнх-Ундрага Монгол банкны Санхүүгийн эрх зүйн хэлтсийн дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Энэ их чухал хууль явж байгаа. Зээлжих чадварын онооны систем нэвтрүүлээд явна гэдэг бол маш зөв асуудал. Гэхдээ бас хэд хэдэн юмнууд асуух юм байна. Саяхан манай Хөвсгөл аймгийн Мөрөн хотод байгаа “Шинэ мөрөн” худалдааны төв шатсан. 260 түрээслэгчийн асуудал энд хөндөгдөж байгаа. Арилжааны банкнуудаас асуухад 5 орчим тэрбум төгрөгийн зээл гарч ирж байгаа. Зээлжих оноо гэдэг маань зээлээ аваад, хариуцлагатай төлөөд ингээд процессууд явах хэлбэр. Сайн төлөх тусам зээлжих оноо дээшлээд, тэр хэмжээгээр банкнууд зээл олгох, дээрээс нь хүү буурах боломжууд бүрдэж байгаа гэж харж байгаа. Ийм нөхцөл байдалд яах вэ, эргэлтийн хөрөнгөгүй болчихсон. Барьцаагүй болчихсон. Худалдаалж байгаа бараа бүтээгдэхүүнгүй болчихсон. Өнөөдөр Хөвсгөл аймгийн Мөрөн хотын “Шинэ мөрөн” худалдааны төвийн хохирогчид маш хэцүү байдалд байгаа. Бүгдээрээ зээлтэй. Энийг бид нар энэ зээлийн мэдээллийн тухай хуульд яг ийм тохиолдолд форс мажор буюу давагдашгүй хүчин зүйлтэй холбоотой харилцааг зээлжих онооныхоо системийг нэвтрүүлнэ гэж ярьж байгаа учраас асууж байгаа юм шүү. Яаж оруулж цаашдаа яаж явах вэ гэдгийг 1 дүгээрт би асуумаар байна.

2 дугаарт хар жагсаалт алга болно гэж тооцож байгаа. Маш сайн. Энэ хэрэглэгчийг, иргэдийг хохироож байгаа, эрхийг нь зөрчиж байгаа 1 том асуудал. Зээл төлж чадаагүй л бол жагсаалт руу ордог гэж ойлгож байгаа. Энийг бид нар хар жагсаалтыг үнэхээр халж чадах уу. Өнөөдөр явж байгаа нэмэлт, өөрчлөлт маань бас батлагдаагүй байна. Энэ Зээлийн мэдээллийн тухай хуульд орж байгаа өөрчлөлтүүд маань батлагдаагүй байгаа учраас өнөөдөр өргөн баригдаад явж байгаа хуулиуд дээр заримыг нь хар жагсаалт яах вэ дээ гудамжны яриагаар ярьж байх шиг. Хүмүүсийн ярьдгаар. Бид нар ч ингэж ярьдаг. Бид нар цаашдаа энэ муу үзүүлэлттэй зээлүүдийн асуудал дээр үнэхээр энэ хар жагсаалт гэж нэрлэгддэг, энэ санхүүгийн эрхийг боомилдог, энэ эрх зүйн зөрчлийг авч байж үнэхээр чадах юм уу. Энэ дээр бол урьд нь би бас асууж байсан. Маш тодорхой асуултыг л маш тодорхой хариултыг л хариулаад өгөөч гэж хүсэж байгаа юм.

Зээлийн хүү буурахад эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа. Вьетнам улс зээлийн онооны систем нэвтрүүлснээр зээлийн хүүг 18 хувиас 12-14 хувь болгож бууруулсан туршлага байна. Маш сайн үзүүлэлт. Нөгөө талдаа ахмадууд өнөөдөр уг нь Үндсэн хуулиар хэн нэгнийг ялгаварлан гадуурхах нь хориотой. Ахмадууд өнөөдөр банк дээр очоод, зээлийн оноо авах байтугай зээлд хамрагдаж чадахгүй байна. Ялгаварлах бодлого явагдаж байна. Та тэтгэвэрт гарсан учраас 65 настай учраас, та 70 настай учраас зээл олгохгүй. Эсвэл давхар батлан даагч авчир гэдэг асуудлууд. Энэ зээлжих чадварын оноотой холбоотой асуудал дээр нөлөөлөл

үзүүлэх үү. Тухайн зээлдэгч нарт гэдэг ийм 3 асуултыг асуух гэж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Энхбаярын Батшугар гишүүн хариулт өгнө.

Э.Батшугар: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тийм ээ, энэ бол давагдашгүй хүчин зүйлс үнэхээр болдог. Үер ус, гал, ус энэ бол амьдрал баян гэдэг. Яг үүнтэй холбоотойгоор бас тогтоолын төсөлд орж байгаа юм. Энэ тогтоолын төсөлдөө нийгэм, эдийн засгийн байдал мөн байгалийн давагдашгүй хүчин зүйлстэй холбоотойгоор энэ зээлжих онооны нь систем нь илүү уян хатан байлгахад энэ систем рүү оруулах зүйл тогтоолын төсөлд орчихсон байгаа гэж танд хэлмээр байна.

2-т нь энэ хар жагсаалт алга болох уу гээд. Яалт ч үгүй энэ хар жагсаалт гэсэн зүйл байхгүй болно. Одоогийн тогтолцоо тодорхой байдлаар зээлээ төлж чадахгүй болоод эргээд төлсөн ч гэсэн 6 жилийн хар жагсаалтад орчихдог. 1 ёсны банк санхүүгийн байгууллагууд тас гээд хаалгаа хаачихдаг. Санхүүгийн ял үүрүүлээд л яваад байдаг. Энэ зүйл байхгүй болно. Харин эсрэгээрээ бодит горимын онооны системээ шилжинэ. Ингэснээр зээлээ төлөхгүй бол оноо нь буурна, төлөөд эхэлбэл оноо нь буцаад л өсөөд эхэлчихнэ. Үүгээрээ дамжуулаад ч гэсэн бас зээлийн хүү буурах нөхцөл байдал үүснэ. Яагаад гэвэл 1 дүгээрт санхүүгийн сахилга баттай иргэдийг илүү урамшуулна. 2-т нь иргэнд бусад банк санхүүгийн байгууллагуудтай харьцах тийм өрсөлдөөний чадамж нь нэмэгдэнэ. Тэгэхээр банк санхүүгийн байгууллагууд бол хүүгээрээ өрсөлдөнө. Тэгэхээр хамгийн таатай нөхцөл олгож байгаа банканд иргэн нь өөрөө очиж үйлчилгээ авах бололцоо нээгдэх юм.

Тэтгэврийн зээлийн асуудал үнэхээр бас чухал асуудал байгаа юм. Үүнтэй холбоотой хэд хэдэн зүйл хэлмээр байна.

1 дүгээрт энэ тэтгэврийн зээлийнх нь орлого нь тодорхой, улсаас тэтгэвэр авч байгаа зүйл. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор онооны систем нь илүү уян хатан, ялангуяа ахмадуудаа илүү урамшуулах систем рүү орох нь зүйтэй гэж бодож байна. Үүнтэй холбоотойгоор бас хүүгийн асуудал яригдаад байгаа юм. Зээлийн тэтгэврийн хүү, мөн арилжааны чанартай хүү адилхан байгаад байна. Энэ нь шударга бус юм гэж дотроо боддог. Яагаад гэвэл би түрүүн хэлсэн. Энэ тэтгэврийн зээлийн орлого нь өөрөө тодорхой байгаа болохоор эрсдэл нь илүү бага гэж ойлгож болох юм. Үүнийг дагаад хүү нь ч гэсэн бас буурах ёстой гэж бодож байгаа юм. Тэгээд Монголбанк ч гэсэн өнөөдөр энэ дээр ажиллаж байгаа гэсэн тийм сураг сонссон. Ялангуяа энэ праймерит гэдэг зүйлийг Монголын санхүү зах зээлд нэвтрүүлэх зүйл явагдаж байгаа гэж хэлж байсан. Тэгээд үүнтэй илүү дэлгэрэнгүй хариултыг Монголбанкнаас өгөх бололцоотой байх. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Эхлээд тэр Хөвсгөл аймагт гарсан галтай холбогдуулан зээлдэгч нарын банкнаас авсан зээл нь муудаад, ангилал буураад энэ дээр жагсаалтад орох уу гэдэг асуулт бол яригдаж байх шиг байна. Энэ дээр бол зээлийн эрсдэлийн оноотой болсноор янз янзын тийм бодит болон бодит бус эрсдэлээс хамаарсан давагдашгүй хүчин зүйлээс

шалтгаалсан оноо буурч байгаа асуудал бол илүү уян хатан болно. Ер нь бол арилжааны банкууд зээлийн эрсдэлийн даатгал гэж байдаг.

Зээлийн гэрээний үүргийг барьцаа хөрөнгөөр барагдуулах үед бол зээлийн эрсдэлтэй холбоотой асуудлыг бол даатгалаар хэрвээ шийдчихсэн гэрээ дээрээ заалт байх юм бол энийг бол даатгалын компани төлөөд явна. Хэрвээ барьцаа хөрөнгөөр гэрээний үүргийг гүйцэтгүүлэхгүй, бизнесийн орлогоороо явдаг тэр схемтэй зээл олгогдсон бол энэ дээр бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Энхтайван: Арилжааны банк энийг өөрийн зээлийн эрсдэлийн сангаараа дамжуулаад бас тодорхой хэмжээний зохицуулалт хийх боломжтой байгаа. Зээлийн оноо дээр бол мэдээж олон улсад хэд хэдэн төрлийн оноонууд ашиглагддаг. Хамгийн гол ашиглагдаж байгаа Файко, вантеж, экспериент гэдэг зэрэг оноонуудыг бол манай энэ зээлийн мэдээллийн үйлчилгээ хэрэглэж байгаа 2 компанийн зүгээс бол оруулж ирээд зээлийн оноонуудыг бол тооцоод явна. Хэрхэн ямар загвараар яаж аргачлалаар бодох вэ, энэ дээр ямар ямар төлбөрийн түүх нь хэдэн хувьтай байх юм, зээлийн ашиглалт нь хэдэн хувьтай байх юм зээлийн түүхийн урт нь хэдэн хувьтай байх юм гэх мэтчилэн оноо бодох аргачлалыг бол Төв банкнаас батлаад, санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах тэр зарчимдаа үндэслээд шийдвэр гаргалт нь явна. Тэгэхээр бол зээлийн түүхээр үндэслэсэн зээлийн оноо бол тухайн санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үндсэн тийм суурь хүрээнд нь бол болно.

Д.Амарбаясгалан: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Яах вэ тогтоолд орсон л гээд л хэлчихлээ л дээ. Тэгэхдээ би Монголбанкнаас асуумаар байна. Форс мажор буюу энэ гал гамшигтай холбоотой нөхцөл байдал манай “Шинэ мөрөн” худалдааны төвтэй холбоотой асуудал. Зээлижх чадварын онооны системтэй холбоотой асуудалтай холбож асуух гэж байгаа юм. Ингээд гал гарчихлаа. Зээлтэй маш олон иргэд байна. Зээлийг түр хугацаанд магадгүй Засгийн газраас зогсоох, зээлийн хүүг өнгөрсөн жил бид нар зуд турхантай холбоотой асуудал дээр бас тодорхой хэмжээний зээлийн хүү, эргэн төлөлтийг хойшлуулж байсан тохиолдлууд бий. 1 дүгээрт.

2 дугаарт зээлийн хүүг зогсоох боломж байгаа юу. Давагдашгүй хүчин зүйлийн хүрээнд. Энэ нь өөрөө энэ хууль хэрэгжиж эхэлснээр энэ тохиолдолд онооны систем дээр ямар нөлөөллийг зогсоосон гэдгээрээ үзүүлэх нөлөөлөл байдаг уу. Ихсэхгүй, багасахгүй ч гэсэн тодорхой хэмжээний ямар 1 нөлөөллийн юм байгаа юу л гэж би асууж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн. Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван нэмэлт хариулт өгье.

Г.Энхтайван: Зээлийн төлбөрийг хойшлуулах асуудал бол иргэний хуулийн дагуу бол нээлттэй. Хэрвээ зээлийн төлбөр хойшлогдоод, хойшлогдсон төлбөрийн дагуу төлбөр хийгдээгүй тохиолдолд зээлийн төлбөр хойшилсон тохиолдолд зээлийн ангилал буурахгүй буюу ангилал буураагүй тохиолдолд бол ямар нэгэн хэлбэрээр оноонд өөрчлөлт орохгүй ийм зохицуулалттай болно.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Зээлийн зэрэглэлийг оноогоор тооцсон нь бол урагшаа алхсан алхам гэж тайлбарлаж байгаа учраас хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа. Гэхдээ асуух юм байна. Банкнууд хажуудаа банк бус санхүүгийн байгууллагатай. Тэр банк бус санхүүгийн байгууллага нь 20-24 хувийн хүүтэй. Одоо бүр банк бус санхүүгийн байгууллага нь хажуудаа аппликэйшний зээлтэй болсон. Энэ нь 8-10 хувийн хүүтэй. Бүр 96 хувийн хүү төлж байгаа. Ямар ч барьцаа хөрөнгө шаардагдахгүйгээр, шаардагдахгүйгээр. Энэ бол мэдээж зээлээ төлөхгүй бол муу зэрэглэлийн ангилал руу орно. Яагаад ийм нөхцөл байдлууд үүсээд байна гэхээр энэ муу зээлийн ангилал чинь 6 жилээр байдаг. Энд буцаагаад зээл олгодоггүй учраас л энгийн иргэд зээлээс зээлийн хооронд амьдарч байгаа шүү дээ. Аль болохоор хөнгөлөлттэй зээл авах гээд л муу зээл нь тооцогддоггүй. Ингээд сүүлдээ аппликэйшний зээлүүд асар их гараад ирчихсэн.

Би сая 21 аймгаар тойроод явж байхад ерөөсөө энэ Монголын ард түмэн чинь татвар төлөхийн төлөө амьдраад байна. Дээр нь зээлээс зээлийн хооронд амьдраад байна. Сая Хөвсгөл аймагт болсон галыг ярьж байна. Давагдашгүй хүчин зүйл тийм үү. Тэгвэл манай говийн тойрогт бас ийм давагдашгүй хүчин зүйл байна. Дорноговь аймгийн Иххэт сумын малчин надаас надаас ингэж асууж байна. Малчны зээл авчихсан байсан. Зуд болсон. Мал нь үгүй болсон. 1 жилээр зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан. Одоо зээлээ төлөх болоход аппликэйшний зээл арга буюу авч нөгөө зээлээрээ төлж байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ тохиолдолд зээлийн тэр онооны систем нь яг яаж үйлчлэх юм. Яг яаж үйлчлэх юм. Буцаад л муу зээлийн ангилал руу орчихно. Аппликэйшний зээл авчихсан. Одоо дахиад төлөх ёстой болно доо. Ийм тохиолдолд яг энэ онооны системд шилжихээр яаж оноонд тооцогдох юм бэ. Муу зээлийн ангилал руу орно. Орохдоо нөгөө 6 жилийг нь аваад хаячихсан гэж байгаа шүү дээ Батшугар гишүүн ээ. Тэгэхээр энэ яг ямар зохицуулалтаар яаж орж байгаа вэ.

Монгол банкнаас асууя. Одоо ингээд л дахиад л банкнууд байсан. Банк бус санхүүгийн байгууллагатай болсон. Одоо аппликэйшний зээлүүд ингээд л гараад байдаг. Эд нар нь ямар ч барьцаа хөрөнгөгүйгээр, өндөр хүүтэй зээл өгөөд байна шүү дээ. Үүний зохицуулалт бий юу. Энэ нэг л өдөр Хадгаламж зээлийн хоршоо дампуурсан шиг энэ аппликэйшний зээлүүд нэг л өдөр дампуураад алга болоход ямар зохицуулалт хийх юм.

Д.Амарбаясгалан: Батшугар гишүүн хариулт өгье.

Э.Батшугар: Тийм энэ хар жагсаалт гэдэг зүйл алга болно. 6 жилээр санхүүгийн ял үүрүүлдэг зүйл байхгүй болно гэж ойлгож болно. Харин зүгээр мэдээлэл нь одоо зарчмын зөрүүтэй санал гаргаснаар 5 жилээр хадгалагдана. Энэ тэгэхдээ хар жагсаалт биш, зүгээр мэдээлэл хадгалагдана. Дата бааз нь. Үүгээрээ дамжуулаад банк болон банк бусууд болон онооны системээр үнэлээд зээл олгоно. Тэр онооны систем нь бол бодит горимоор явж байх юм. Яах вэ өнөөдөр яг бодит амьдрал дээр ямар кэйс гараад байна вэ, яг таны хэлснээр иргэн шууд 2, 3 аппликэйшнийг зэрэг асааж байгаад зээл аваад, үүгээрээ дамжуулж нэг ёсондоо санхүүгийн дампууралд орох түвшинд орчихоод байгаа юм. Иргэд төлж чадахгүй орлого, зарлагын хувь нь. Тэгэхээр бодит горимоор онооны систем рүү орсноороо бол ингэж олон аппликэйшн зэрэг зээл авах бас бололцоо нь тодорхой хэмжээгээр

хумигдана. Яагаад гэвэл тэр шууд харагддаг болно. Ямар ямар аппликэйшнээр зэрэг хандалт өгсөн бэ гээд.

Малчдын зээл ярьж байна л даа. Малчид бол үнэхээр хамгийн сайн зээлдэгч нарын нэг байдаг юм. Ипотекийн зээл, малчдын зээл эргэн төлөлтөөрөө. Тэгэхээр тодорхой хэмжээгээр энэ нь бол урамшуулдаг болно гэж ойлгож болно. Яагаад гэвэл тухайн иргэн, малчин зээлээ цаг хугацаанд нь төлөөд яваад байгаа бол оноо нь өөрөө өснө. Үүгээрээ дамжуулаад санхүүгийн сахилга баттай иргэн гэдгээ өөрөө тодорхой онооны системээр тодорхойлоод, банк болон банк бус санхүүгийн байгууллагууд үүн дээрээ хараад шууд бага барьцаа хөрөнгө шаардсан, аль эсвэл хүү нь буурах тийм бололцоо үүснэ л дээ. Яах вэ олон улсын кэйс дээр ч тэгж гарсан байгаа.

Түрүүн бас Бат-Эрдэнэ гишүүн дурдсан. Вьетнамд 2000 оны эхээр онооны системд шилжсэнээр яг манайхтай адилхан 18-20 хувийн жилийн хүүтэй зээлүүд нь буураад, өнөөдрийн нөхцөл байдал бол 12-14 рүү орсон юм. Энэ бол цэвэр эрсдэлээ үнэлж чаддаг болсон зүйл. 2 дугаарт банкнуудын урсгал зардал нь буурсан зүйлтэй холбоотой л доо.

Мөн зуд гэдэг асуудал үнэхээр би түрүүн бас хэлсэн. Би тогтоолын төсөл дээр 1 зүйл оруулчихсан байгаа юм. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан зээлдэгч нь зээлжих чадварын зэрэглэлийг уян хатан тогтоох гээд. Тэгэхээр 1 ёсны Монголбанк ямар дүрмээр тухайн 2 тусгай зөвшөөрөлтэй байгууллага нь онооны системээ оруулах вэ гэдгийг нь тодорхойлно. Энэ дээр яг давагдашгүй хүчин зүйлсээ бас оруулах нь зүйтэй гэж харж байгаа юм. Тэгээд энэ зорилгоор тогтоолын төсөл дээрээ яг энэ үгийг оруулсан байгаа юм.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн 2023 онд байгаль цаг уурын хүндрэлээс хамаараад зээлийн эргэн төлөлт дээрээ төлж чадахгүй болсон малчдын зээлийн эргэн төлөлтийг бол төв банкнаас хойшлуулсан байгаад байгаа юм. Хойшлуулсан нь бол Төв банкнаас өөрийн Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийн үндсэн дээр зээлийн эргэн төлөлтийг бол хойшлуулдаг. Зээлийн эргэн төлөлт явагдсаны дараа эргэн төлөлт эхэлсний дараа буцаад зээлээ төлөхгүй байгаа асуудал нь бол тухайн зээлийн гэрээний үүргийн дагуу л явна. Энэ дээр бол арилжааны банк дээр бид бүхэн бол тэгэхдээ хэрэглэгч, малчны зээлийн ангиллын түр хугацаанд бууруулахгүй байх тийм тухайн үеийн зохицуулалтыг бол өгч явсан түүний дараа бол ингээд зохицуулалт дууссаны дараа бол зээлийн ангилал бол буурна.

Аппликэйшний зээлтэй холбоо бол арилжааны банк өөрийн харьяанд банк бус ажиллуулж байгаа тохиолдол бол ерөөсөө ../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Одоо байгаа зээлийн хууль энэ нь байна шүү дээ. Зээл авч байгаа хүнийг хамгаалж байгаа биш, зээл өгч байгаа байгууллага, юуг хамгаалж байгаа тийм хууль байгаад байгаа байхгүй юу. Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон тохиолдолд гэрээний нэмэлт үүргээс чөлөөлж байгаа. Тийм үү. Алданги тооцохоос

чөлөөлж байгаа. Гэтэл нөгөө хүн нь жишээ нь малчны зээл дээр ярихад 1 жилээр зээлийг хойшлуулсан ч гэсэн тэр хүн чинь 1 жилийн дотор малжиж чадахгүй байхгүй юу. Зүгээр өөр бизнес дээр бол болох л байх. Тэгэнгүүт тэр малчин нь дахиад зээлээ төлж чадахгүй хэмжээнд ороход тэр шууд муу зээлийн ангилал руу явчхаж байгаа юм. Тэгэхээр Батшугар гишүүний сая хэлдэг дээр тэр давагдашгүй хүчин зүйлийг яг энэ тохиргоо дээр нь өөрчлөх юм байгаа юу. Хэрвээ байхгүй бол дараагийн удаа энийг санаачилж, хамтарч явуулахад бэлэн байгаа шүү гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн нэмэлт хариулт өгье.

Э.Батшугар: Ер нь одоогийн үйлчилж байгаа тогтолцоо бол яг таны хэлж байгаа зөв л дөө. Банк санхүүгийн байгууллага илүү давуу эрхтэй байгаад байдаг. Яагаад гэвэл нөгөө нэг зээлдэгчийн бүх мэдээлэл нь 1 том банканд байдаг. Тэгэхээр нөгөө зээлдэгч өөр банканд очъё, өөр санхүүгийн байгууллагад очъё гэхээр тэр мэдээллээ хуваалцдаггүй болохоор тэр банкны нөхцөл байдлаар л зээлээ аваад байгаа юм. Энэ онооны системд орсноор тухайн иргэний оноо нь өөрөө өөрийг нь тодорхойлж байгаа болохоор ямар ч банк санхүүгийн байгууллагад очоод, тэгээд санхүүгийн үйлчилгээгээ авах бололцоо нь нээгдчихэж байгаа юм. Нөгөө байгууллагууд нь хоорондоо бас өрсөлдөөд юугаар өрсөлдөх вэ гэхээр илүү таатай нөхцөлөөр бол өрсөлдөнө. Магадгүй илүү барьцаа хөрөнгийн шаардлага аль эсвэл хугацаа, зээлийн хүү гээд. Тэгэхээр энэ банк санхүүгийн байгууллагын хооронд өрсөлдөөн бий болгочхож байгаа яг энэ систем нэвтэрснээр онооны систем ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энхтайван Дэд ерөнхийлөгч. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Энхтайван: Мөнхбаясгалан гишүүний асуултад нэмээд тодруулахад малчны зээл маань өөрөө арилжааны банкнаас олгох олгогдохдоо даатгалтай олгогдож байгаа. Зээлийн эрсдэлийн даатгалтай. Барьцаа хөрөнгийн даатгалтай олгогдож байгаа. Малын индексжүүлсэн даатгалаар тухайн малчин даатгалд хамрагдсаны үндсэн дээрээс зээлийн гэрээнээс 2 хувь хөнгөлүүлж байгаа. Тэгэхээр нийт малчны зээлийн бараг 97, 98 хувь нь бол малын индексжүүлсэн даатгалтай холбоотой байгаа. Тэгэхээр тухайн бүс нутагт зуд болоод системик риск болсон тохиолдолд тухайн малчин өөрийн хорогдсон малынхаа хорогдлыг малын индексжүүлсэн даатгалаар тухайн эд хөрөнгөө хэрхэн үнэлснээр хамааруулаад буцаагаад авах тийм бүрэн боломжтой байгаа. Хэрвээ үнэхээр энэ нь бол бүр тэр хуулийн давсан шаардлагаас бүр давсан тохиолдолд бол энийг системик рискээс давсан эрсдэл гэж үзээд энэ дээр бол бүр хойшлуулах асуудлыг бол тусад нь хууль гаргаж ярих тийм үндэслэлтэй.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Ерөнхийдөө энэ зээлийн мэдээллийн санг онооны систем рүү оруулаад хар жагсаалт гэдэг юмыг байхгүй болгох дээр санал нэгдэж байгаа. Ийм байх л ёстой. Гэхдээ яах вэ энэ хуулийг харахаар жоохон явцуу хүрээнд боловсруулагдчихсан юм болов уу л гэж харж байгаа юм. Бид нар иргэндээ үнэхээр ээлтэй, зөв зохистой ийм онооны систем хийхийг зорьж байгаа бол дахиад илүү 3 юм дээр анхаарсан илүү бас үр өгөөжтэй байх байжээ гээд.

1 дүгээрт зээлийн мэдээллийн санд орж байгаа нөгөө өр төлбөртэй холбоотой асуудал дээр босго тавих бол чухал байгаа. Энэ босгоо минимум тэдээс дээшээ төгрөгийн өр авлага болж байж л орно гэдэг. Тэгэхгүй бол тэр Мобикомын төлбөр ч гэдэг юм уу, утасны төлбөр ч гэдэг юм уу сарын 20, 30 мянган төгрөгийн төлбөрөө төлөөгүйгээс болоод энэ нь өөрөө онооны систем рүү ороод байх юм бол энэ өөрөө нөгөө зээлжих зэрэглэл оноог хүнд ээлтэй бол байлгахгүй л гэсэн үг. Тэгэхээр дор хаяж энийгээ сонгоод, судлаад хэдэн мянгаас дээш гээд, хэдэн 100 мянгаас, хэдэн саяас дээш өр төлбөрт орж байж онооны систем рүү ордог болгоно гэдэг юмыг та бүхэн бас судалж оруулах боломж байна уу.

2 дугаарт иргэдэд бас нэг боломж, сонголт өгөх ёстой байна. Зөвхөн хар муу мэдээлэлд нь орохоосоо гадна иргэд өөрөө сайн мэдээллээ өгдөг боломжийг нь бүрдүүлэх ёстой байна. Тэр хүн үнэхээр сайн санхүүгийн хувьд сахилга хариуцлагатай, мөнгө төлбөрөө цагт нь төлдөг. Жишээ нь СӨХ-ны төлбөрөө ч байдаг юм уу цагт нь төлдөг байх юм бол иргэн энийгээ сонголтоор би сахилга хариуцлагатай шүү. Миний СӨХ-ны төлбөрийн төлөлтийг онооны системийг минь намайг сайн зээлдэгч гэдэгт ингээд ашигладаг болооч гээд, энийгээ и-монголиатай холбоод иргэд өөрийгөө сонголтоор энэ төлбөрөө зээлийн мэдээллийн санд өгч, өөрийнхөө оноог сайжруулах боломжийг нь бас өгөх хэрэгтэй байна.

3 дугаарт одоо бол нэг ийм байгаад байгаа. Жилдээ 1 удаа л иргэд маань өөрөө ямархуу онооны системтэй, хэд дээр явж байгаа гэдгийг үнэгүй үзэх боломжтой. Зөвхөн жилдээ 1 удаа, бусдыг нь бүрэн скор, сайн скорт 3 мянган төгрөг билүү 5 мянган төгрөг өгч байгаад үздэг юм шиг байна лээ. Энийг илүү ээлтэй болгох ёстой. Хүн чинь өөрийгөө ямархуу байна, ямар оноотой байна гэдгээ өөрөө мэдэж байж үүн дээрээ би юун дээрээ анхаарах вэ, тэгвэл яах вэ гэдгээ мэднэ шүү дээ. Энэ олон их мэдээллийн дунд мартаж байгаа юм ч байгаа. Тэгэхээр ядаж байна шүү дээ улиралд 1 удаа И-монголиагаасаа хүн өөрийнхөө оноог хараад би иймэрхүү явцтай явж байгаа юм байна гэдгээ харчих хэрэгтэй. Тэрийг нь үнэгүй байлгах хэрэгтэй. Улиралд 1 удаа. Улиралд 1 удаагаас их байх юм бол тэр үнэ төлбөрөө төлөөд, тэр онооны системүүд, тодорхойлолт эд нараа авдаг байж болно. Гэхдээ энэ тодорхойлолтоо авахдаа ингээд ер нь бодлого байгаа юм уу. Тэдээс тэдэн төгрөг байна гэдгийг Монголбанк тогтоож өгөөд байгаа юм уу эсвэл энэ хувийн 2 онооны компани өөрсдөө шийдээд 3 мянгаар авна. Жилийн дараа 10 мянгаар авна гэдэг юмыг өөрсдөө шийдээд байгаа юм уу. Энэ дээр Монголбанк дээр ямар нэгэн журам гарсан юм байгаа юм уу гэдгийг асуумаар байна.

Дахиад 2 юм анхааруулмаар байна. Энэ Бүрэнскор, Сайнскор гээд хувийн компаниуд Кредит оноо хийж байгаа. Гэхдээ эхнээсээ энэ хувийн скорингийн энэ компаниуд төрийн байгууллагатай шууд холбогддог систем рүү явахаар хүсэлт, өргөдлөө өгөөд байгаа юм байна. Татвараас шууд бид нар мэдээллээ татаж авъя ч гэдэг юм уу. Хэн нэг нь ингээд явах юм бол угаасаа зах зээл дээр монопол байдал үүснэ. Төрийн байгууллагуудтай болон санхүүгийн байгууллагуудтай холбогдохыг уг нь бодлогоороо Төв банк маань бүгдийг нь базаад, эндээсээ мэдээллээ уг нь өгөөд эрх тэгш сонголттой, эрх тэгш өрсөлдөөнтэй энэ онооны сангууд компаниуд ажиллах ёстой. Тэгэхээр ийм юм байгаа юу гэдэг дээр Монголбанк нэг дахиад тодруулга өгөөч.

Ер нь Батшугар гишүүн энэ хуулийг ярьж явахдаа онооны систем нэвтэрснээр зээлийн хүү 2 хувь буурна ч гэдэг юм уу ингээд хэлээд байгаа. Зөвхөн энэ хуулиар бол би ийм хэмжээний зээлийн хүү буурах боломжтой гэж үзэхгүй байгаа. Энэ

яагаад вэ гэвэл манай системийн гажуудал байгаа. Бид нар төр бодлогоороо ч байдаг юм уу, ямар нэгэн байдлаар зээлийн хүүг бууруулъя гээд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүнд 1 минут нэмж өгье.

О.Номинчимэг: Олон оролтууд хийдэг боловч одоо манай арилжааны банкнуудын бизнесийн модель нь ямар ч эрсдэлгүй бизнесийн модель болчихсон. Арилжааны банкнууд бүгд бүх эрсдэлүүдээ тооцоод, тэр дээрээ ашгийн маржинаа нэмээд, зээлийн хүүгээ тодорхойлдог болчихсон. Тэгэхээр энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь сайжирна уу, онооны систем чинь сайжирна уу тэд нарт ямар ч падли байхгүй болохоор ямар ч хүчин чармайлт өөрсдөө хийдэггүй. Энд бид нар л ёстой зээлийн хүүгээ бууруулах юм сан, бууруулах юм сан гээд л олон талын арга хэмжээ гэдэг боловч арилжааны банкнуудын хувьд тэн дээр ерөөсөө түй ч анхаарч байгаа юм бай байхгүй. Яагаад гэвэл эрсдэлгүй бизнесийн модель руу орчихсон тэд нарт бол аль нь ч хамаагүй. Угаасаа ашгаа л олж байгаа. Тэгэхээр энэ арилжааны банкнууд ер нь эрсдэлгүй бизнес гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ арилжааны банкнуудын хувьд яаж үйл ажиллагаагаа үр ашигтай болгох вэ, яаж энэ зээлийн хүүг бууруулах оролдлогод өөрсдийгөө нэгдүүлэх вэ, энэ дээр үзүүлэлтүүдийг нь ямар шалгуур үзүүлэлтүүд тавьж сайжруулах вэ гэдэг дээр Монголбанк ямар нэгэн ийм .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн асуултад хариулъя.

Э.Батшугар: Тэгээд одоогийн 2011 онд баталсан Зээлийн мэдээллийн хуулиар бол таны хэлсэн тэр СӨХ болон бусад мэдээллийг өгөх бололцоотой байгаа юм. Төлбөрийн үүрэгтэй холбоотой мэдээллийг өгч болно гэж байгаа. Гэхдээ 1 зүйл анхаарах ёстой л доо. Тэр нь юу вэ гэхээр энэ 9 дүгээр зүйл дээр зээлийн мэдээллийг зээлдэгчийн зөвшөөрлийг үндэслэн нь мэдээлнэ гэж байгаа юм. Тэгэхээр тухайн иргэн хэрвээ би хүсээд, би СӨХ-ынхоо төлбөр, Мобикомын төлбөрөө өгье гэвэл уг нь хуулиараа нээлттэй байгаад байгаа юм. Тэр мэдээлэл нь авах. Нөгөө талаараа босгын талаар бас Монголбанкнаас дэлгэрэнгүй хариулт өгнө байх. Тэгэхдээ ер нь бас Солонгос улсын жишгээр ч гэсэн бас босго байдаг юм байна лээ. 200 мянган вон ч билүү. Гэхдээ энэ чинь бас 2 талдаа зүйл л дээ. 5 мянган төгрөг байна уу, 500 мянган төгрөг байна уу энэ чинь л өөрөө тухайн иргэний санхүүгийн сахилга батын асуудал. Тэгээд хэрвээ үнэхээр 5 мянган төгрөгөө цаг хугацаанд төлөөд байгаа бол энэ бол оноог нь нэмэгдүүлдэг л зүйл. Заавал 500 мянга ч гэдэг юм уу, 200 мянга ч юм уу босго тавьчихвал нөгөө жижиг төлбөр тооцоонууд нь орохгүй байгаа бол нөгөө иргэнээ бас тодорхой хэмжээгээр хохироочхож байгаа юм. Яагаад гэвэл тэр ч гэсэн өөрийнх нь оноог нь нэмэгдүүлэх хүчин зүйлс болчихож байгаа болохоор.

Яг 2 компани байгаа тусгай зөвшөөрөлтэй. 3 мянган төгрөг гэж та дурдаж байна. Үнэн. 3 мянган төгрөгөөр мэдээллээ авдаг. Тэгээд яг энэ нь ямар байдлаар 3 мянган төгрөг юм бэ гэхээр бас тодорхой бус байгаад байгаа юм. Нөгөө компаниуд нь өөрсдөө тодорхойлчихсон. Тэгээд яг энэ зорилгоор бас энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр 1 зүйл орж байгаа юм. Бүтээгдэхүүн үйлчилгээний хөлсийг Монголбанк тогтооно гээд ийм агуулгатай зүйл. Монголбанк тогтооно гээд яг 5 мянга, 3 мянга гэхгүйгээр хамгийн дээд тааз нь тогтоож өгнө. Картын гүйлгээн дээр ч гэсэн шимтгэлийн 1 хувь гээд дээд таазыг нь Монголбанк тогтоодог. Тэгээд acquiring merchant банк нь хоорондоо хуваадаг. Яг үүнтэй адилхан Монголбанк магадгүй юу гэдэг юм тэдэн мянган төгрөг гээд судалгаан дээр үндэслээд тогтоох

бололцоотой болж байгаа юм. Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр. Та хэлж байна. Энэ зээлийн хүү дан энүүгээр буурахгүй гээд. Зээлийн хүүг бол яг харахад бол бас бол дүн шинжилгээ өгөхөд харахад 63 хувь нь эх үүсвэрийн зардал нэг ёсны хадгаламжийн хүү байна. 15 хувь нь эрсдэл, 22 хувь нь банкных нь урсгал зардал. Тэгэхээр яг ийм өөрчлөлт хийснээр ямар өөрчлөлт орох вэ гэхээр эрсдэл болон нөгөө operational kiosk болон урсгал зардал нь буурах юм. Эрсдэл нь тодорхой болохоор үүнийгээ дагаад санхүүгийн сахилга баттай иргэдээ илүү урамшуулдаг, илүү бага хүүтэй зээл олгоно. Зээлийн шийдвэрээ өдөртөө гаргадаг болохоор заавал зээлийн эдийн засагч нь юу гэдэг юм ажлын 5 хоног судлаад л бүх зүйлийг нь хараад л цаг хугацаа үрэхгүйгээр шууд олох бололцоо үүсэхээр зардал нь буурах юм. Тэгэхэд энэ 2 хүчин зүйлсээр болоод зээл өгөх, хүү буурах бололцоотой болно.

Мөн Активын удирдлагын компани гэж ярьдаг. Энэ манай Монголын санхүүгийн зах зээлд зайлшгүй шаардлагатай зүйлүүдийн 1 л дээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван нэмж хариулт өгье.

Г.Энхтайван: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тухайн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч өөрийн шимтгэл, зээлийн шимтгэл болон сервист үзүүлж байгаа хураамжаа өөрсдөө тогтоодог. Энэ дээр нь бол төв банк үндэслэлгүй гэж үзэх юм бол төв банкнаас энэ дээр бол хүчингүй болгодог. Яг мөрдөгдөж байгаа хуулийн дагуу л тухайн 2 компани өөрийн 3 мянган төгрөгийн гэдгээ бол өөрсдөө тогтоосон байгаад байгаа.

Тэр ялгаатай хэлбэрээр босго оруулаад, зээлийн мэдээлэл нийлүүлэгч нь босгоноос давсан хэсгээ мэдүүлээд доошийгоо мэдүүлэхгүй байя гэж байгаа юм. Энэ бол яах вэ, олон улсад байдаг жишиг. Гэхдээ жишээлбэл 5 мянган төгрөгийн өртэй байлаа гээд тухайн зээлийн оноонд бодох хувь нь л бага байна гэсэн үг шүү дээ. 5 мянган төгрөгийн өртэй хүн, 50 сая төгрөгийн өртэй хүний зээлийн оноонд нь учирч байгаа дарамт ../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн тодруулж асууя.

О.Номинчимэг: Босго дээр бол угаасаа тийм. Тэгэхдээ энэ өөрөө нэг ийм жоохон иргэндээ ээлтэй байя гэдэг үүднээс тэр 1 босгоос доош тэр өр төлбөрийг нь хэтэрхий битгий авч үзээч ээ. Мэдээж том юман дээр гарах юм бол тэр нөлөөлөл нь оноонд нь нөлөөлнө шүү дээ. Тэр өөрөө зээлдэгч маань өөрөө онооны системээ байнга шалгаад, өөрөө сахилгын сахилга хариуцлагатай байх, мэдээлэл дээр үндэслэн сахилга хариуцлагатай байх системийг суулгаж өгөх боломж байна уу. Хуульд өөрчлөлт оруулахгүйгээр. Эсвэл заавал хуульд өөрчлөлт оруулах ёстой юу. Улиралдаа 1 удаа үнэгүй бас би хаана явна вэ гэдэг оноогоо шалгачих боломжийг нь бас нээж өгмөөр байна.

2 дугаарт Монголбанкнаас хариулаач. Тэр банкнуудын ямар ч эрсдэлгүй бизнесийн модель болчихсон байгаа юман дээр бид нар хэчнээн энэ зээлийн хүүгээ бууруулъя гээд юм хийгээд үнэндээ бол үр дүн нь хагас шүү дээ. Банкнуудыг өөрсдийг нь жоохон хөдөлгөх хэрэгтэй байхгүй юу. Та хэд бизнес хийх гэж байгаа бол, ашиг олох гэж байгаа бол өөрсдөө эрсдэлээ бас үүрэх ёстой. Энэ дээр нь

Монголбанк ямар тэр шалгуур үр дүнтэй, үр ашигтай байх ажиллагааных нь энэ шалгуур .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн нэмж хариулъя.

Э.Батшугар: Энэ хуулийн өөрчлөлт батлагдсанаар Монголбанк улиралдаа 1 удаа өөрийнхөө оноогоо төлбөргүй шалгадаг болох бололцоог нь нээж өгөх бүрэн бололцоотой. Мөн дээрээс нь бас хэлээд байгаа яг 2 компани хоорондоо монопол хийх бүрэн бололцоотой байгаад байгаа байхгүй юу. Өнөөдрийн нөхцөл дээр Өнөөдөр 3 мянган төгрөг гэхэд ирэх жил 5, 15 мянга болгочих. Тэгэхээр энэ бас хуулийн нэмэлт, өөрчлөлт орсноор бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг Монголбанк тогтооно гэсэн агуулгатай нэмэлт, өөрчлөлт орсноор Монголбанк дээд хязгаарыг нь тавьж болох юм. Яг зах зээлийн үндэслэл, судалгаа хийж байгаад. Тэгэхгүй бол энэ чинь бас 4 сая 600 мянган хүний мэдээлэл яваад байгаа. 1 сая 600 мянган хүний бас иргэний мэдээлэл орчихсон байна. Тэгэхээр энэ чинь маш ашигтай. Тэгсэн мөртөө цэвэр монопол болох бололцоотой тийм бизнес байгаад байгаа юм. Тэгэхээр тодорхой хэмжээний хэрэглэгчдийг хамгаалах гэсэн зүйлээс болоод дээд хязгаарыг нь тавих бололцоотой.

Д.Амарбаясгалан: Энхтайван Дэд ерөнхийлөгч нэмэлт хариулт өгье.

Г.Энхтайван: Гишүүний тэр ярьсан улиралд 1 удаа өөрөө үнэ төлбөргүйгээр оноогоо харах боломжийг бол төв банкнаас журам батлаад ш, журмаар шийдээд явчих боломжтой. Энийг бол хууль дээр өөрчлөлт оруулж байх шаардлагагүй.

Тэр арилжааны банкнууд зөвхөн эрсдэлгүй бизнес хийгээд байна гээд тэгж байна. Одоо 2025 оны 2 дугаар сарын байдлаар бол чанаргүй зээлийн хэмжээ системийн хэмжээнд 5,2 хувь байна. Яах вэ, чанаргүй зээлийн хэмжээ 5,2 гэдэг маань бол олон улсын жишгийн дагуу бас харьцангуй өндөр л байгаа гэсэн үг. Өндөр байгаа. Манай банкны актив өөрөө энэ оны эхний улирлын байдлаар бол 70 их наяд төгрөгт хүрч байгаа. 70 их наяд төгрөгийн чинь 5,2 хувь гэдэг маань өөрөө үндсэндээ 3,5 их наяд төгрөгийн чанаргүй зээл байна гэсэн үг. Тэгэхээр энэхүү чанаргүй зээл өөрөө ихсээд явснаар тухайн системийн бол эрсдэл банкны системийн санхүүгийн тогтвортой байдалд бол маш сөргөөр нөлөөтэй. Тийм учраас төв банкны зүгээс арилжааны банкны .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Энхтайван: Арилжааны банкны чанаргүй зээлийг зохистой түвшинд нь барих үүднээс арилжааны банканд бол маш олон төрлийн дүрэм журам, стандарт мөрдүүлдэг. Яг энэ хүрээнд бол арилжааны банк өөрийн эрсдэлээ тодорхой хэмжээнд шингээгээд явдаг. Арилжааны банк бол ямар ч эрсдэлгүй бизнес хийж байгаа юм бол байхгүй. Бусад бизнесийн салбаруудтай харьцуулахад хөрөнгийн өгөөжийн хувь гэж тооцоод явдаг. Энэ маань өөрөө дөнгөж 2 хувьтай байгаад байгаа. 2 хувьтай байгаад байгаа гэдэг маань олон улсын жишгийн хувьд ч өндөр биш, манай бусад бизнесийн салбарын хувьд ч бас өндөр биш байгаад байгаа. Яах вэ, ерөнхийдөө бизнесийн модель нь өөрөө актив нь томрохын хэрээр ашигт ажил нь абсолют дүнгээрээ том харагдаад байгаа боловч энэ нь маш олон хувьцаа эзэмшигчтэй 70 хэдэн мянган хувьцаа эзэмшигч арилжааны банк дээр бий болсон. Энэ илүүтэйгээр хувь эзэмшлийн төвлөрөл саарах хүрээнд бол илүү олон хүн банкны хувьцаа эзэмшигч болоод явахаар энэ..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ренчинбямбаагийн Сэддорж гишүүн асуулт асууя.

Р.Сэддорж: Энэ зээлийн нөгөө хар жагсаалтын хугацаа дээр яагаад ингээд олигтой хөдөлгөж чадахгүй байгаа юм болоо. Тэгээд жоохон асуудлаас болоод 1 удаагийн утасны төлбөр төлөөгүй тэр сардаа төлөөгүй байж болно шүү дээ. Тэгээд эд нарыгаа утасны компанийн төлбөрийн асуудлыг банктai ингэж холбох шаардлага байхгүй шүү дээ. Тэр хүн 1 сард ямар нэгэн шалтгаанаар төлөөгүй байж болно шүү дээ. Тэгэхээр энэ банкны хар жагсаалтад 6 жилээр ордог нь ямар учиртай юм бэ. Том зээлдэгч нарыг бол ойлгож байна. Том том хэдэн тэрбумын зээл ойлгож байна. Иргэдийн нийтлэг зээлдэг хэмжээний хугацааг 2-3 жил болгож болохгүй юу ядаж. Хэдэн 10 сая төгрөгийн зээл авч байгаа хүн байгаа. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань юу гэж үзэж байна вэ.

Монгол банк энэ аппликэйшний зээл хэтэрхий хялбар, хурдан шуурхай авч байгаа дээр иргэд маань бол маш их өрөнд орж байна. Мэдээж хүний эрхийн асуудал ч гэсэн маш хялбар аргаар зээл аваад, ингээд өрийн сүлжээнд ороод байгаа юм биш үү.

Тэтгэврийн зээл дээр Монголбанк юу хийчхэв. Сая 3 сарын хэдэнд байна. Тэтгэвэр авч байгаа хүмүүс бол хамгийн хариуцлагатай, хамгийн хэрэгтэй болоод л авч байгаа. Тэгээд тэр настан буурлуудаас тэтгэврийнх нь хэмжээг багасгаад 70/30-тай байсныг 50/50 руу ингээд буулгачихсан юм байна. Иргэд энд бол туйлын дургүйцлээ илэрхийлж байна. Ийм учраас энэ асуудал ямархуу байна вэ. Яагаад ийм шийдвэрийг гаргав. Тэгээд энэ иргэдээ бодож гаргахгүйгээр ийм янз бүрийн шийдвэр гаргахаа болиоч гэдгийг хэлмээр байна.

Ингээд анх зээл авч байгаа хүнийг муу зээлдэгч гээд хамгийн өндөр хүүгээр өгдөг байсан энэ хэвээрээ байгаа юу. Тэгээд оноотой болсноор тухайн хүний мэдээлэл сайн гэж харагдах уу. Зээлдэгчийн зээлийг төлж байгаа теллерийн алдаанаас болоод 1 төгрөгийн өр үүсээд, тэр нь хамгийн муу гэсэн ангилалд орсон байсан тохиолдол гарч байсан. Энэ алдааг яаж хаасан бэ. Зээл авах гэж байгаа хүн оноо харах зөвшөөрлөө өгч байж л зээл авах эрх үүснэ. Тэгэхээр улиралд 1 удаа үнэгүй оноогоо харах эрх заавал байх ёстой гэж үзэж байна. Ийм асуултуудыг асууя.

Дээрээс нь энэ дараагийн хууль дээр орж ирэх байх. Монголбанк энэ гар утасны төлбөрөө төлөөгүй хүнийг энэ жагсаалт руу оруулдаг. СӨХ-ны төлбөрөө төлөөгүй хүнийг энэ банкны энэ жагсаалт руу оруулдаг энэ асуудал бол дараагийн хууль дээр Монголбанкнаас оруулж ирэх байх. Энийг Улсын Их Хурлын гишүүд маань бас санаачилж оруулж ирэх байх. Энэ дээрээ ноцтой асуудлууд байгаа учраас Их Хурлын гишүүд маань сайн ярилцсан нь дээр байх гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Асуултад Батшугар гишүүн хариулна.

Э.Батшугар: Тийм. Энэ 6 жилийн хар жагсаалт гээд байгаа санхүүгийн ялыг байхгүй болгоно. Тэгээд Мобикомын зээлтэй холбоотой асуудал яах вэ 5 жилээр болгож байгаа л даа. Зарчмын зөрүүтэй саналаар Байнгын хороонд дэмжигдсэн. Энэ нь бол муу зээл нь хадгалагдана гэсэн зүйл биш зүгээр дата бааз нь хадгалагдана. Хар жагсаалт гээд зүйл байхгүй болно. Зүгээр тухайн хүнийг тодорхойлох нийт том дата баазыг нь хамгаалах л зүйл байгаа юм. Үүн дээрээ

хувийн хэвшил нь өөрөө анализ хийгээд, тэгээд онооны систем рүүгээ эрсдэлийг нь үнэлээд явчих юм.

Анх удаа зээл авах гэж байгаа иргэд яах вэ гэж. Тэгээд яах вэ олон улсын судалгаа байдаг юм билээ. Онооны систем рүү орсноор анх удаа зээл авах ялангуяа эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн. Энэтхэг улсад 2005, 2006 оны үед энэ зээлийн мэдээллийн сангийн хууль нь өөрчлөгдөөд, онооны системдээ шилжсэн юм. Үүнийг дагаад 119 сая шинэ зээлдэгч бий болсон. Латин Америкт мөн адилхан. Энэ онооны системд шилжсэнээр анх удаа зээл авах гэж байгаа, аль эсвэл санхүүгийн харилцаанд орох гэж байгаа иргэд нь нийтдээ 31,7 хувиар нэмэгдсэн. Тэгэхээр 1 ёсны бид нар илүү сахилга баттай болно. Санхүүгийн боловсролоо нэмэгдүүлэх зүйл яригдаад байгаа л даа. Нийт систем нь өөрөө онооны систем рүү орсноор эрсдэл нь буурах тийм нөхцөл байдал үүсэж байгаа юм. 28 орны судалгаа хийхэд энэ онооны систем рүү орсноор нийт системийн чанаргүй зээл нь 1,9 хувиар буурсан тийм судалгаа байгаа юм.

Аппликэйшний зээлийн талаар Санхүүгийн зохицуулах хороо бас ирчихсэн байна. Илүү дэлгэрэнгүй хариулна байх. Тэгэхдээ ер нь хэлэхэд бол онооны систем рүү орсноор бодит горимоор нөгөө оноо нь өсөөд, буураад явах болохоор 1 зэрэг олон аппликэйшнаас зээл авахад үүгээрээ дамжуулж санхүүгийн дарамтад орж бүүр дампуурлын байдалд нөхцөл байдалд орох тийм эрсдэл байгаад байгаа юм. Энэ нь болино гэж ойлгож болно.

Тэтгэврийн зээлийн өр, орлогын харьцаа гэж байна. Энэ дээр бас Монголбанк илүү дэлгэрэнгүй хариулт өгнө байх. Тэгэхдээ сая мөнгөний бодлогын хурлаараа энэ өөрчлөлт хийчихсэн гэж би ойлгож байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван хариулъя.

Г.Энхтайван: Сэддорж даргын асуултад хариулъя. Тэр 5 жилтэй одоо мөрдөгдөж байгаа 6 жилтэй холбоотой асуудал дээр хэлэхэд зээлийн мэдээллийн түүх гэдэг маань өөрөө дан ганц муу зээлийн түүх ч биш. Энэ сайн зээлийн түүх явж байгаа. Тухайн санхүүгийн хэрэглэгч өөрийн авсан гэрээний үүргээр хүлээсэн үүргээ хэдэн жил тухайн санд хадгалуулах вэ л гэсэн зохицуулалт байгаад байгаа юм. Хэрвээ энийг багасгаад жишээлбэл 3 жил болгочих юм бол өнөөдөр 2025 оны 4 сарын 25, 3 жил гэхээр 2022 оны 4 сарын 25-аас өмнөх ямар ч мэдээлэл харагдахаа болино гэсэн үг. Тэгэхээр энэ зээлийн оноо тооцоход сүүлийн 3 жилд санхүүгийн үйлчилгээ аваагүй, зээл аваагүй хүн байх юм бол энэ оноо нь бол яаж гарах нь бас тодорхойгүй болно гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энэ зээлийн оноо бодож байгаа энэ аргачлал маань өөрөө урт хугацааны энэ дата дээр үндэслэх тусам илүү бодитой тогтоогдоно гэж үзэж байгаа. Тэгээд 5 жил бол дэлхийн дунджаас бол харьцангуй бага байгаа. Гэхдээ бид бүхэн бол бас одоо байгаа энэ хууль дээр байгаа 6 жил .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Г.Энхтайван: 6 жил гэдгийг бууруулаад, 5 жил болгоод явж байгаа. Тэр тэтгэврийн зээлтэй холбоотой асуудлыг 3 сард өр, орлогын харьцааг бол бид бүхэн нэмэгдүүлсэн. Энэ нь бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн саналын дагуу тэтгэврийн зээл авч байгаа хөгшчүүд зээлийн дарамт нь их байна. Зээл төлөөд өөрт нь үлдэж байгаа орлого нь ахуй амьдралаа аваад явахад

бас хүрэлцэхгүй байгаа учраас зээлийн дарамтыг бууруулахын үндсэн дээрээс ийм зохицуулалт хийж өгөөч гэж хүсэлт тавьсны дагуу бид бүхэн бол энэ тэтгэврийн зээлийн өр, орлогын харьцааг нэмэгдүүлж шийдвэрлэсэн байгаа.

Б.Пүрэвдорж: Сэддорж гишүүн нэмж асуулт асууя.

Р.Сэддорж: Сайн зээлийн түүхийг бол ерөөсөө тэр 6-аар байгаасай гэж хүсэж байна. Тэр муу зээлийн түүхийг л яриад байгаа юм. Тэгээд хүн чинь бас 6 жил хүний амьдрал чинь урт хугацаа шүү дээ. Тэгэхээр 2 жил санхүүгийн ийм боломжтой болж болно шүү дээ. Тэгээд том зээлдэгчийн муу түүхийг бол би яриагүй байна шүү дээ. Тэр бол 6-аараа байдаг юм байгаа биз. Тийм үү. Хэдэн тэрбумын. Тэр бага хэмжээний иргэдийн зээлийн түүхийг тийм олон жилээр дахиж зээл авахгүй болтол нь ингэж чангалах хэрэг байна уу л гэж байгаа. Тэгээд сайн муугаа ялгаад хийчхэж болдоггүй юм уу. Сайн зээлдэгчийн хугацаа, муу зээлдэгчийн хугацаа гээд.

Тэгээд тэтгэврийн зээл дээр Нийгмийн хамгааллын яамнаас ирсэн бичгийн дагуу Монголбанк ингэж ажиллана гэж ийм хурдан шуурхай тэтгэвэр авагч нийт иргэдийнхээ зээл авах эрхийг нь ингэж 20 хувиар хасдаг чинь буруу. Энийгээ яаралтай өөрчил өө. Энийгээ .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Монголбанкны Дэд ерөнхийлөгч Энхтайван хариулъя.

Г.Энхтайван: Хуулийн дагах тогтоол дээр уян хатан хэлбэрээр зохицуулна гэсэн тогтоолын төсөл дээр бол заалт орж байгаа. Тэгэхээр зээлийн мэдээллийн санд бүртгэгдэж байгаа зээлийн түүх нь хэмжээнээсээ хамаараад яаж бүртгэгдэх вэ оноонд хэрхэн тооцогдох вэ, хувийн жин нь хэр байх вэ гэдэг тэр аргачлалаараа нарийн тооцоод явъя. Таны хэлж байгаа саналыг бол тусгаад явъя.

Тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал дээр бол төрийн захиргааны төв байгууллагаас нь ирүүлсэн саналын дагуу бид бүхэн тэгсэн. Мөн тэгэхдээ манай төв банкнаас хийсэн судалгаагаар тэтгэвэр авагчид маань тэтгэврийн зээл авсны дараа үлдэж байгаа хувь нь өөрийнх нь ахуй амьдралд нь бас хүрэлцэхгүй. Зээлийн дарамт өндөр байгаа нь бол хэд хэдэн судалгаагаар бол гарсан учраас бид бүхэн энийг бол хугацаатай арга хэмжээ авсан. Мөн хэрэглээний зээлийн хувь хэмжээ эдийн засаг дээр нэмэгдэж байгаатай холбогдуулан инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах хүрээндээ бодлогын арга хэмжээг аваад явж байгаа. Ер нь бол энэ хугацааны .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батшугар гишүүн хариулъя.

Э.Батшугар: Сэддорж гишүүний бас хөндсөн асуудал зөв л дөө. Яг уян хатан тогтоох ёстой л доо. Яг үүнтэй холбоотойгоор тогтоолын төсөлд оруулчихсан байгаа юм. Эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан зээлдэгчийн зээлжих чадвар зэрэглэлийг уян хатан тогтоох гээд. Тэгэхээр байгалийн давагдашгүй зүйл гэх мэтчилэн зүйлээс болоод тодорхой хэмжээнд уян хатан тогтоогдох нь зөв гэж харж байгаа юм. Гэхдээ ахиад 1 заалт оруулсан. Тэр нь юу вэ гэвэл Хөгжлийн банк, Засгийн газрын тусгай сан, төсвийн мөнгийг авсан, зээлсэн иргэдэд энэ уян хатан нөхцөл нь орохгүй гээд. Яагаад гэвэл энэ ард түмний л мөнгө, татвар төлөгчийн мөнгө. Энэ татвар төлөгчийн мөнгөтэй илүү хариуцлагатай байх ёстой. Тэгээд энэ тогтолцоогоороо тогтоолын төслөөр орохгүй харин иргэн, аж ахуйн нэгж орно.

Б.Пүрэвдорж: Ганхүлэг гишүүн асуулт асууя. Алга байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Батшугар гишүүний энэ өргөн барьсан энэ хууль бол өөрөө маш чухал хууль гэж ингэж харж байгаа. 2 үндсэн том агуулга байна.

1 дүгээрт энэ нөгөө хар жагсаалт гэж ярьж байгаа энэ зүйл бол онооны систем рүү ороод ингээд явчихна байна.

2 дахь нэг том зүйл бол бидний байнга ярьдаг зээлийн хүүгийн асуудал. Тэгээд Батшугар гишүүн зээлийн хүү буурах бололцоог хэлчихсэн учраас шууд Монголбанкныхнаас асуухад зээлийн хүү бууруулах энэ том бололцоог хууль, эрх зүйн хувьд нээгээд өгөхөөр манай арилжааны банкнууд энийг яг тэр хууль санаачилсан, батлагдсан хуулийн үндсэн тэр зорилго агуулга руу чиглүүлсэн үйл ажиллагаа авах уу. Энэ дээр авхуулах тал дээр Монголбанк яаж ажиллах вэ гэдгийг би бас нэлээн тодруулж асууя гэж бодоод байгаа юм. Эрх зүйн орчныг нь нээж өгөөд байдаг. Эс үйлдэхүйгээрээ энэ чинь хийхгүй бол тэгээд л нөгөө зээлийн хүү чинь бахь байдгаараа л байх гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр Монголбанк яаж манлайлалтай ажиллах вэ.

2 дугаарт ер нь бол энэ Монголбанкныхнаас байнга асууж байгаа. Энэ зээлийн энэ хураамжийн асуудал байгаа юм. Бид дэлхийд байхгүй өндөр хүүтэй гээд л ярьдаг. Тэгэхдээ эх үүсвэр олон юмнууд нөлөөлдөг байх. Гэхдээ энэ хураамж аваад байдаг. Тэгээд өнгөрсөн энэ 3 жилийн хугацаанд харахад ядаж ипотекээс авахаа болино л гэсэн. Өнөөдөр ипотекээс энэ хураамж чинь авсан хэвээрээ л байгаа юм байна. Одоо энэ чинь тэгээд л цалингийн зээл, нөгөө ахмадуудаас тэтгэврийн зээлээс нь хүртэл аваад л байгаа шүү дээ. Тэгэхээр энэ үнэхээр хураамж гэдэг зүйл зайлшгүй байх ёстой юм уу. Энэ ер нь хэзээнээс ингэсэн юм. Энийг бууруулах бололцоо байна уу. Яагаад гэвэл нөгөө зээлийн хүү юмаа бууруулах тийм л юм талаас нь яриад байгаа 2 дахь асуудал.

3 дахь асуудал энэ ахмадын зээлтэй холбоотой асуудал. Сая тойргоороо ажиллаж байх үед ахмадууд бол Хэнтий, Дорнод, Сүхбаатар аль ч аймаг дээр очсон энийг яриад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас хэдүүлээ жоохон бодолтой хандах хэрэгтэй юм билээ. Хуучин бол энэ чинь 2 жил 100 хувь өгчихдөг байсан байхгүй юу зээлийг нь. Тэгэхээр 2 жил гар дээрээ ахмад 1 ч төгрөг авахгүйгээр зээлээ төлөөд, 1 ч төгрөгийн тэтгэвэр авдаггүй байсан. Сүүлд нь 70/30 болгосон. Одоо болохоор ямар зүйл хэрэгжээд эхэлсэн гэхээр нөгөө амьжиргааны баталгаажих доод түвшин буюу тэр 470-аад мянган төгрөгийг нь авч үлдээд үлдсэн зээл дээр нь 1 жилийн хугацаатай зээл олгож байгаа байхгүй юу. Тэгэхээр ихэнх хүмүүс 600 гаруй мянган төгрөгийн тэтгэвэртэй хүн байвал 400 хэдийг нь аваад, цаана нь 200 хэдэн мянга дээрээ жилийн хугацаатай гэхээр 2 сая хүрэхгүй төгрөгийн зээл авах гээд байна. Аваад байна. Яг одоогийн зохицуулалтаар. Тэгэхээр хуучин бол 2 жил бүтнээр нь өгчихдөг байсан бол одоо баталгаажих доод түвшний мөнгийг аваад үлддэг болчихсон юм чинь хугацааг нь 12 биш, 24 болгоод өгчих бол нөгөө та бүхний судалгаан дээр гараад байгаа тэр гар дээрээ 1 ч төгрөг авахгүй байх тэр хүндрэл байхгүй болчихно. Дээрээс нь сая ахмадууд бол ярьж байна л даа. Энэ чинь тэтгэвэртээ гарсан. Энэ чинь залуу гарчихсан ч хүн байна. Ажил амьдралаа залгуулмаар байна. Өвгөнийхөө тэтгэврийг идээд, өөрийнхөө тэтгэврээр бид 2 юм хийдэг энэ тэр гээд бидэнд жоохон тийм сонголт өгчхөөч. Нэг болохоор бүр хуу

авдаг зээл. Эсвэл 70/30 гээд заагаад өгчихдөг. Эсвэл тэтгэврийнх нь бараг энэ чинь доод түвшний тэтгэврийнх нь бараг 60, 70 хувийг авч үлдээд үлдсэнд нь зээл ав гэхээр 2-ын хооронд 1 сая гаруй төгрөг гар дээр ирээд байна. Энийг та бүхэн маань хэлээд яриад өгөөч гэсэн учраас би энэ хэлж байгаа юм. Тэгэхээр энэ яамнаас ийм хүсэлт ирсэн ч гэсэн энэ дээр бас эргэж .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Энхбаярын Батшугар хариулна.

Э.Батшугар: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Та зээлийн хүүг дурдлаа. Тэгээд зээлийн хүү буурах бүрэн нөхцөл байдал үүсэх юм. Яагаад вэ гэвэл би товчхон танилцуулъя. Нийт зээлийн хүүг 100 хувь гэж бодож үзвэл 63 хувийг нь эх үүсвэрийн зардал, 1 ёсны хадгаламжийн хүү. Энэ бол шууд инфляцтай холбоотой зүйл л дээ. Үлдсэн нь 15 хувь нь эрсдэлийн зардал гэж явж байгаа юм. Энэ нөгөө эрсдэлийн сангийн зардал дээрээс нь нэмээд, иргэдээ яаж эрсдэлийг нь үнэ үнэлж байна гээд. Тэгээд одоогийн тогтолцоо юу болоод байна гэхээр нийт иргэдээ нэг том баганад авчраад, тэгээд тодорхой юу гэдэг юм 5 хувь нь ч юм уу, чанаргүй зээлдэгч болчихвол тэр шархаа чанартай сайн зээлдэгчээсээ нөхчихнө, өндөр хүүгээрээ нөхчихнө гээд. Энэ шууд динамик амьд кредит онооны болон зээлийн онооны систем рүү орохоор санхүүгийн сахилга баттай иргэнээ ялгачихна. Тэгээд тухайн иргэндээ илүү таатай нөхцөлтэй зээл олгоно.

2 дахь зүйл нь бол зээлийн шийдвэрлэх хугацаа. Энэ нь олон улсын кэйсийг харахад 5 өдөр байсныг онооны системд шилжсэнээр шууд өдөртөө шийддэг болж байгаа юм. Тэгэхээр нөгөө үйл ажиллагааны зардал нь буурч байгаа юм. Нэг ёсны зээлийн эдийн засагч нар суулгаад, судлуулаад байхгүй шууд оноо нь тухайн иргэнийг тодорхойлчхож байгаа болохоор зардал нь буурчаж байгаа юм.

3-д нь өнөөдөр яг бодитоор ямар нөхцөл байдалд байна вэ гэвэл тухайн том банканд тухайн харилцагч нь тэр банктэй л харьцаад байгаа юм. Өөр банктэй харьцах бололцоо байхгүй. Яагаад гэвэл тэр иргэний мэдээлэл нь Төрийн банк ч байдаг юм уу, Хаан байдаг юм уу, Голомт байдаг юм уу, Хас байдаг юм уу тэр банканд л байдаг. Тэр мэдээллээ өөрөө хуваалцдаггүй тухайн банк нь. Онооны систем рүү орчихоор тэр оноо нь өөрөө тухайн иргэнээр шууд тодорхойлчхож байгаа болохоор аль ч банк санхүүгийн байгууллагад очоод үйлчилгээ авах бололцоо нь нээгдэх юм. Үүнтэй холбоотойгоор ч гэсэн бас гаднын банк санхүүгийн байгууллага Монголд орж ирэхэд үүд хаалга нь нээгдэж байгаа юм. Яагаад гэвэл олон улсын жишгийн дагуу онооны систем рүү орсноор Монголын нийт зах зээл нь маш тодорхой ойлгомжтой болно. Тэгэхээр энэ бүгдээрээ нийлээд өөрөө зээлийн хүүг Монголд бол 2-4 хувиар буурах бололцоо нэгж хувиар буурах бололцоог нь нээж өгч байгаа юм.

Хураамжийг Монголбанк дээд хязгаарыг нь тодорхойлдог. Энэ нь картын хураамжийг 1 хувийг тодорхойлдог дээд хязгаарыг нь. Нөгөө талдаа ч гэсэн энэ зээлийн 1 ёсны шийдвэрийн 1 хувийн хураамжийг ч гэсэн дээд хязгаарыг нь Монголбанк тодорхойлдог. Тэгээд үүгээр ч гэсэн уг нь бууруулах бололцоотой юм. Эрх зүйн байдал нь нээлттэй байгаад байгаа юм. Тэгэхээр яг үүнтэй холбоотой Монголбанкнаас илүү дэлгэрэнгүй хариулт өгнө байх.

Мөн энэ тэтгэврийн зээл ч гэсэн бас чухал асуудал л даа. Би түрүүн хэлсэн. Угаасаа орлого нь тодорхой байгаа юм чинь заавал тэд ахмадуудаа ингэж чангалах ямар хэрэг байгаа юм бэ. Сар болгон улсаас өгөх мөнгө нь тодорхой юм чинь.

Б.Пүрэвдорж: Энхтайван Ерөнхийлөгч хариулъя.

Г.Энхтайван: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа банк болон бид бүхний урт нэртэй хууль гэж ярьдаг банк эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу бол санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн шимтгэлээ тогтоодог. Шимтгэл нь хуульд нийцээгүй буюу бодит бусаар тогтоогдсон бол төв банк дээр хүчингүй болгодог. Яг энэ хуулийн дагуу төв банк бол шимтгэлийн дээд хязгаарыг тогтоож байгаа. Тэгэхээр энэ дээд хязгаар илүү амьдралд нийцсэн, уян хатан байх талаар бол Төв банк энэ аргачлал дээрээ журам батлахдаа бол зохицуулаад явна.

тэтгэврийн зээлтэй холбоотой таны шүүмжлэлийг бол хүлээж авч байна. Тэтгэврийн зээлийн тухайн зээлдэгч маань зээлээ төлөөд, өөрт нь үлдэж байгаа хувь нь амьжиргааны баталгаажих түвшнээс доошлуулахгүй байх гэдэг бодлогыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тавьсан хүсэлтийн дагуу бид .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Өнөөдөр Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах Батшугар гишүүний хуулийн төслийг бас танилцлаа. Тэгээд манай гишүүд бол асууж л байна. Ер нь тойргийн чанартай тэгээд л зээлийн хүү буурах уу гээд зээлийн талаар ихэвчлэн их ярьж байна. Одоо энэ хүчин төгөлдөр мөрдөж байгаа Зээлийн мэдээллийн тухай хуулиар зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох үйл ажиллагааг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээд Монголбанкны тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд өнөөдөр бас үйл ажиллагаа явуулаад, Сайн скор, Бүрэн Скор гэсэн 2 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаад, үйл ажиллагаа нь бүр тогтмолжчихсон, хэвшчихсэн байгаа. Тийм ээ. Тэгвэл өнөөдрийн энэ 2 компани өөрсдийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлалыг нэвтрүүлж, зээлдэгчид үйлчилгээ үзүүлээд хэвшчихсэн байхад заавал энийг Монголбанк авч ингэж явуулах нь хэр их юунд нийцэж байгаа юм бол.

Уг нь бол энэ 2 компанийн үйл ажиллагаа бол үнэхээр хувийн хэвшлийн байгууллагууд бол ард иргэдэд, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлээд, аргачлал онооны юугаар бол бүрэн дүүрэн үйлчилгээгээ үзүүлээд явуулчхаж байгаа шүү дээ. Тэрийг заавал Монголбанк энийг татаж авч, онооны аргачлал журам боловсруулж үйл ажиллагааг нь авах нь хэр зохистой байгаа юм бэ гэдэг хариулт. Тэнд очсоноор Монголбанканд очсоноороо ер нь үйл ажиллагаа яаж сайжрах гээд байгаа юм. Энийг хариулаад өгөөч.

Хуулийн төсөлд зээлдэгчийн сүүлийн 6 жилийн зээлийн түүх буюу зээлийн лавлагааг 6 хүртэлх гэж өөрчлөхөөр тусгасан байгаа юм. Тэгэхээр зээлийн лавлагаа чинь 1 талаасаа төлбөрийн түүх үүсгэж, өнөөдөр банк санхүүгийн байгууллагууд болон бусад зээлдүүлэгч байгууллагууд зээлдэгчийн эрсдэлийг үнэлэх ийм зорилгоор ашигладаг маш чухал мэдээлэл. Гэтэл муу зээлийн түүхтэй зээлдэгчийн мэдээлэл тодорхой хугацаагаар хадгалагдахгүй болчихоор цаашдаа ер нь яах вэ. Ингэснээр муу зээлдэгч нарыг энэ хуулийн төслөөр харахад өөгшүүлж байгаа хэрэг болох уу. Энэ 2 асуултад хариулж өгөөч.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Энхбаярын Батшугар хариулна.

Э.Батшугар: Тэгээд энэ 2 тусгай зөвшөөрөлтэй компани нь яг л үйлчилгээ өгөөд л явна. Өөрийн гэсэн загвараараа, өөрийн гэсэн аргачлалаараа ямар онооны хэд хэдэн депозон дотор вэ гэдэг нь явна. Зөвхөн Монголбанкнаас аль аль мэдээллийг авах вэ гэдэг нь хяналт тавина. Зааж өгнө. Нөгөө талдаа хяналтаа тавина. Олон улсын жишиг чинь ийм юм байна лээ. Жишээлбэл тухайн компани өөрсдийнхөө сонирхлын бүлэг ч юм уу, өөрийнхөө тухайд ажилтнуудынхаа оноо нь хэд нэмэгдүүлээд шударга бусаар бусдуудыг нь буулгаад яваад байгаа бол бас л зөрчил гарч байгаа байхгүй юу. Ийм зөрчил гарчихсан юм. Тэгэхээрээ бүх л дэлхийд үндсэндээ төрийн захиргааны төв байгууллага нь хяналтаа тавьдаг, харин хувийн хэвшил нь хоорондоо өрсөлдөөд, чанараараа, үнээрээ өрсөлдөөд явдаг юм байна лээ.

Жишээлбэл танд дурдахад ийм байна. АНУ-д Consumer financial protection bureau болон Trade commission 2 нь хяналтаа тавьдаг. Британид Financial conduct authority гээд FCA гэдэг юм. Канадад Financial consumer agency of Canada, Японд Financial service agency гээд бүх л дэлхийн жишигт харахад ерөөсөө л төр захиргааны төв байгууллага нь тодорхой хэмжээний хяналтыг нь тавьж өгнө. Мэдээллээр нь хангана. Харин хувийн хэвшил нь хоорондоо ямар бүтээгдэхүүн ямар загварчлалаараа явах вэ гэдгээрээ хоорондоо өрсөлдөөд тэр үйлчилгээгээ өгөөд үүний үр дүнд нь бас үнэ төлбөрөө зарна гэсэн үг. Энэ үйлчилгээ зарж байгаа.

6 жилийг яагаад 6 хүртэл болгосон бэ гэвэл яах вэ, энэ түрүүн Байнгын хорооны хурлаар зарчмын зөрүүтэй санал гараад, тэгээд 5 болгочихсон байгаа. Тэгэхдээ яагаад 6 хүртэл гэсэн тийм юу явсан бэ гэвэл яг тогтоолын төслийг та харвал байгалийн болон давагдашгүй хүчин зүйлээс болоод үер ус байна, гал түймэр байна, тухайн иргэнээс нь хамаарахгүйгээр орлого нь хэрвээ хаагдчихвал энэ аргачлал нь арай уян хатан болгоосой гэсэн л тийм л зүйл байгаад байгаа юм.

Харин эсрэгээрээ Хөгжлийн банкнаас, Засгийн газрын тусгай сангаас зээл авчхаад төлөхгүй байгаад байгаа бол энэ 1 ёсны уян хатан аргачлал нь тооцохгүй гэсэн тийм тогтоолын төсөл орчихсон байгаа гэж танд хэлье.

Б.Пүрэвдорж: Пүрэвийн Батчимэг гишүүн нэмж тодруулъя.

П.Батчимэг: Өргөн барьж байгаа хуулийн төсөл бол өнөөдөр иргэд зээлтэй, иргэн, хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагууд үнэхээр хамрах хүрээ ач холбогдлоороо бол маш том хуулийн төсөл. Гэхдээ гол нь одоо мөрдөгдөж байгаа хуулийг ахисан түвшинд нь үнэхээр ач холбогдлынх нь хувьд, хамрах хүрээнийх нь хувьд ингэснээрээ үнэхээр сайн тийм хууль болж чадах уу гэдэг л гол асуулт байгаа юм. Тэгээд Монголбанк энэ Бүрэн Скор, Сайн Скор гээд 2 хувийн хэвшлийн байгууллага зээлжих зэрэглэлийг тогтоогоод, аргачлалаараа бүр банк бус байгууллагууд хүртэл аргачлалаа өөрсдөө тогтоогоод л өнөөдөр үйл ажиллагаагаа хэвийн явуулаад ирсэн. Энийг Монголбанк өнөөдөр тусгайлсан ийм аргачлал олон улсын жишигт нийцсэн журам гэдэг юмаар ингээд түрий барьж энэ .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Монгол банкны дэд ерөнхийлөгч Энхтайван хариулъя.

Г.Энхтайван: Батчимэг гишүүний асуултад нэмээд тодруулъя. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Зээлийн мэдээллийн тухай хуулиар энэ тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа 2 компани нь өөрөө оноогоо тогтоогоод явах эрх нь бол нээлттэй байгаад байгаа юм. Нэмэлт, өөрчлөлт орсны дараа ч гэсэн энэ 2 компани

өөрсдөө оноогоо тогтоогоод явна. Оноо тогтоохдоо ямар зарчмыг үндэслэн санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах вэ гэдгийг энэхүү аргачлалаар нь тооцож, бид бүхэн оруулж байгаа юм. Энэ дээр тухайн хэрэглэгч нь ямар эрхтэй байх юм, тухайн зээлдэгч нь ямар эрхтэй байх юм, ямар үүрэгтэй байх юм. Энэ нь тухайн зээлийн оноо тооцогдоход ямар ямар юмнууд нь заавал орох юм, ямар ямар зүйлүүд нь юу гэдэг юм хувийн жинтэйгээр нөлөөлөх юм гэдэг ерөнхий аргачлалыг бид хэд тогтоохоос биш яг зээлийн оноо тооцож байгаа болон зээлийн оноог бодож гаргаж байгаа үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс ямар ч тийм зохицуулалт журмаар бол халдахгүй байгаа. Тэгэхээр бол энэ Бүрэн Скор болон Сайн Скор компани өөрсдийн бодоод байгаа оноо нь бол яг тухайн.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууя.

Д.Пүрэвдаваа: Өдрийн мэнд хүргэе. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн санааг нь дэмжиж байгаа. Тэгээд Монголбанканд бол банкны үйл ажиллагаанд маш шүүмжлэлтэй хандаж байгаагаа хэлмээр байна. Хууль санаачлагч Батшугар гишүүн бол өмнө нь бас Монголбанкны Дэд захирал хийж байсан. Тэгээд миний асуулт бол би энэ Монголбанкны хүмүүсээс, мэргэжлийн хүмүүсээс нь асууя гэж бодож байгаа. Тийм учраас гишүүнээс бол асуумааргүй байна. Өнөөдөр 400 гаруй банк бус байгууллага, 10 гаруй банк үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгээд дийлэнх нь 20 орчим мянган аж ахуйн нэгжүүдтэй харьцдаг гэдэг мэдээлэл өгсөн. Банк бусууд дунджаар хэдэн хувийн ашигтай бизнес хийдэг юм бэ. Банкнууд ер нь жилдээ хэдэн хувийн ашигтай ажилладаг юм бэ. Ингээд нийгмээ шинжлээд үзэх юм бол улс нь ч өртэй аж ахуйн нэгжүүд нь ч өртэй. Банк нь ч өртэй. Иргэд нь бас юу гэдэг юм. Өр тавьж ингэж амьдардаг 1 ийм өрийн сүлжээ гэдэг улс болчихоод байна л даа. Тэгээд та бүхний энэ тарааж өгсөн материалыг ажаад үзэх юм бол үндсэндээ энэ Монголбанк өөрсдөдөө л давуу байдлыг нэмэгдүүлсэн, ялангуяа харилцагч талдаа буюу зээл төлж байгаа, зээл авч байгаа хүмүүсийн давуу байдлыг оруулсан зүйл огт алга. Иргэний оролцооны тухай бол огт дурдаагүй. Жишээлбэл холбогдох төрийн болон арилжааны банкны төлөөлөлтэй мэдээлэл хуваалцана л гэж байгаа боловч хэчнээн хүнээс, хэчнээн иргэдтэй уулзаж, яг ямар асуудлыг шийдвэрлэж, саналыг авсан нь ердөөсөө тусгагдаагүй. Хамгийн ноцтой нь та хэд өөрсдөдөө давуу байдлыг бий болгож байгаа гэж харж байгаа. Би бол хурлын тэмдэглэлд тусгуулмаар байгаа юм. Өгөгдлийн аюулгүй байдал гэдэг асуудал ер нь яаж та нар шийдвэрлэсэн юм. 400 гаруй төр чинь 2 янзын тоо яваад байна. 512 төрийн бус байгуул маш олон дээрээс нь ломбард, дээрээс нь Хадгаламж зээлийн хоршоо байгаа. Эд нар чинь өрсөлдөөний зарчмаар явж байгаа шүү дээ. Мэдээллийн аюулгүй байдлыг Монголбанк хариуцаж байгаа юм. Хяналтаа Монголбанк хариуцаж байгаа юм. Монголбанк аргачлалаа батална гэчихсэн байгаа юм. Тэгээд маргаан үүсэх тохиолдолд хэн шийдвэрлэх юм. Дээрээс нь ялангуяа явцын хяналтыг хэн тавих юм. Нөгөө иргэдийн эрх ашгийг хамгаалж байгаа субъект яаж хуульчлагдсан юм. Тэгээд хамгийн чухал нь энэ хуулийн үр дүн тодорхойгүй байна. Өнөөдөр 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр. Жилийн дараа Монгол Улсад санхүүгийн хувьд бол 12 сараар тооцоод үзэх юм бол жилийн дараа ямар үр дүнд хүрэх нь тодорхойгүй. Үндсэндээ эргээд харах юм бол Монголбанк өөрийнхөө эрх мэдлийг эрс нэмэгдүүлсэн ийм л өөрчлөлт орж ирж байна уу гэж харж байгаа юм. Тэгэхээр та бас нэг хариулаадхаарай. Ялангуяа Монголбанкны Дэд ерөнхийлөгч гэдэг чинь бас маш том албан тушаал шүү дээ. Тэгээд энэ яг батлагдсанаараа хэдэн хувь нь иргэдэд нэмэр болж байгаа юм. Хэдэн хувь нь банк санхүү ялангуяа банк болон банк

бус байгууллагуудад үр өгөөжөө өгөх юм. Хувьчлаад та нэг тайлбарлаж өгөөч. Тэгээд тодруулна.

Б.Пүрэвдорж: Монгол банкны дэд ерөнхийлөгч Энхтайван хариулъя.

Г.Энхтайван: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Арилжааны банкнуудын ашигтай холбоотой асуудал асууж байна. 2024 оны 12 сарын 31-ний байдлаар банкны салбар системийн хувьд бол 1,7 их наяд төгрөгийн ашигтай ажилласан. 2025 оны 2 дугаар сарын байдлаар бол одоогоор 252 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байна. Энэ бол тухайн өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бол 21 орчим хувийн өсөлттэй байгаа. Банкны ашигт ажиллагааг тооцдог олон улсын маш олон харьцаанууд байдаг. Бид бүхэн бол өөрийн хөрөнгийн өгөөж гэж ярьдаг. Манай арилжааны банкны системийн хувьд бол түрүүн би бас хэлсэн 70 их наядын активтай байгаад байгаа юм. 70 их наяд. 70 их наядын активтай байхад 1,7 их наядын цэвэр ашигтай байна гэдэг маань өөрөө бас тухайн бизнесийн салбар маань хэдийгээр абсолют дүнгээрээ ашгийн хэмжээ өндөр харагдаад байгаа боловч бас тодорхой хэмжээний эрсдэл байгаа гэдгийг бол илэрхийлж байгаа.

Банк бус санхүүгийн байгууллагын хувьд бол ашиг хэдий хэмжээтэй байгааг Санхүүгийн зохицуулах хорооноос дэлгэрэнгүй хариулах байх. Ер нь бол арилжааны банкнуудыг бол Зээлийн мэдээллийн тухай хуулиар эрсдэлээс бол тодорхой хэмжээнд бол хамгаалдаг. Хэрэглэгчийг таньж мэдэх хэрэглэгчийн таньж мэдсэний үндсэн дээр зээлийн судалгаа хийх зардал нь бол энэ зээлийн мэдээллийн сангаар дамжуулан тодорхой хэмжээнд буурдаг. Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулж энэ мэдээллийн санд орж байгаа мэдээлэл нь бол харьцангуй уян хатан хэлбэртэй, хугацааны хувьд илүү харилцан зохицуулалттай байдлаар ороод явж байгаа нь бол арилжааны банкны зээлийн эрсдэлийг бол тодорхой хэмжээнд бууруулна. Зээлийн эрсдэл буурснаар хүү буурна. Бид бүхэн зээлийн хүү бууруулах маш олон стратеги төлөвлөгөөнүүд батлаад явдаг. Зээлийн хүүгийн 2 үндсэн бүрэлдэхүүнээс бүрдэж байгаа. Арилжааны банкны өөрийн эх үүсвэрийн зардал болон бусад нь арилжааны банкны өөрийн зардал гэж байгаа. Зардал дотроо бол эрсдэлийн зардал бол 15 орчим хувийг эзлээд явж байгаа.

Тэгэхээр энэ эрсдэлийн зардлыг бол хэрэглэгчийг таньж мэдэх процесс нь илүү дэлгэрэнгүй тод болсноор бол тодорхой хэмжээнд буураад явна гэж байгаа. Зээлийн мэдээллийн хууль нь өөрөө Кибер аюулгүй байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг төв банк мэдээллийн аюулгүй байдлыг нь хянаад явдаг. Энэ дээр бол кибер аюулгүй байдлын аудитыг бид бүхэн хараат бус аудитыг зөвшөөрөл эзэмшиж байгаа 2 компанид бол жил болгон оруулаад явдаг. Тэгэхээр мэдээллийн аюулгүй байдлыг бол төв банк бол хянана.

Зээлийн мэдээллийн тухай хууль нь өөрөө хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахгүй зөвхөн банкны эрх ашгийг хамгаалаад байна гэж. Энэ нь бол бас оноо тооцдог болсноор тухайн хэрэглэгч өөрийн зээлийн .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн нэмж тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Тоймтой хариулт бол авсангүй. Ер нь бол ойлгомжтой л байна шүү дээ. Банк бус санхүүгийн байгууллага, банкны активын өсөлт, үр өгөөж, ашиг нь бол маш өндөр хувьтай. Өнөөдөр жирийн хоол үйлдвэрлэгч гэдэг юм уу, үйлдвэрлэл эрхэлж байгаа субъектүүдийн байгууллагын ашиг нь тэгээд 2, 3

нугарахгүй. Эргэлт нь, хөрөнгийн хэмжээ нь нэмэгдэхгүй байгаа. Гэтэл банк бус ажиллуулдаг, банк ажиллуулдаг хүмүүсийн актив нь жил жилд л 2, 3 дахин өсчихсөн байдаг. Саяхан л нэрийг нь хэлээд яах вэ, 1 банк гэхэд л 10 жилийн өмнө 10 их наядын хөрөнгөтэй байсан бол өнөөдөр актив нь 100 их наяд, 100 тэрбум ч юм уу болчихсон гээд 10 дахин өсчихсөн байх жишээний иймэрхүү байгаа юм. Тэгэхээр зэрэг та бүхэн бүх хяналтаа өөрсөд дээрээ авчихсан, мэдээллийн аюулгүй .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Пүрэвжавын Ганзориг гишүүн асуулт асууна.

П.Ганзориг: Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хуулийг бол дэмжиж байгаа. Ер нь манай банкны салбар маш их хоцрогдсон. Ямар утгаар нь хэлж байна вэ гэхээр гол үйлчилгээ болох нь зээлийн үйлчилгээ дээрээ нэг ломбард шиг ажилладаг. Зээл авах гэж 7 үеэрээ, 70 булчирхайгаа тооцож, хамаг байдгаа барьцаалж байж ард иргэд, аж ахуйн нэгж зээл авдаг ийм салбар. Тэгээд Монгол Улсын санхүүгийн зах зээлийн 90 хувийг дангаараа эзэлж байгаа. Энэ ерөөсөө буурдаггүй. Бусад санхүүгийн зах зээл, хөрөнгийн зах зээлүүдээ хөгжүүлдэггүй. Хөгжих боломжийг нь бас лоббидоод олгодоггүй юм шиг байгаа юм. Өнөөдөр банкны нийт актив 70 их наяд буюу Монгол Улсын ДНБ-тэй тэнцэх хэмжээнд хүрчихсэн. Цэвэр ашиг нь 1,7 их наяд төгрөг. Манай Монгол Улсын жилийн төсөв чинь 1,7 их наядын ашигтай ч гарч чадахгүй байгаа шүү дээ. Бид нар алдагдалгүй л арай гэж батлаад явж байгаа. Тэгэхээр энэ хоцрогдсон тогтолцоог өөрчлөх гээд бас ядаж энэ иргэдийн хар жагсаалтад оруулдаг байдлыг өөрчлөх, дээр нь энэ кредит скорын системийг бас оруулж ирж байгааг дэмжиж байгаа. Энийгээ бол оруулаад явах ёстой.

Тэгээд үүнтэй холбоотой 2, 3 асуулт асууя. 1 тодорхой хэмжээгээр зээлийн хүү буурна гэж тооцоолж байгаа юм байна. Буурах ч ёстой л доо. Тэгэхээр зээлийн дундаж хүү 2-4 хувиар буурна гэж түрүүн Батшугар гишүүн хэлж байх шиг байна лээ. Яг хэзээнээс буурах вэ. Хэзээнээс яг 2-4 хувиар буурна гэж тооцож байгаа вэ гэдэг дээр тодорхой хугацаа хэлээч гэж асуумаар байна.

2-т энэ хууль батлагдангуут дагаад Их Хурлын тогтоол батлагдана. Энэ тогтоол дээр зээлийн аргачлалыг тооцох асуудлыг Монголбанканд даалгачхаж байгаа юм. Тэгэхээр уг нь Улсын Их Хурал чинь бас хууль, эрх зүйн орчинд хуулиасаа давсан журам зохицуулалтуудыг батлаад байна. Тэр нь эргээд иргэд, аж ахуйн нэгжийн нийгмийн харилцаанд маш их хүндрэлүүд учруулж байна. Үүнээсээ аль болох зайлсхийе гээд байгаа. Гэтэл Монголбанк дээр энэ аргачлалыг нь өгчихдөг. Энэ нь нөгөө арилжааны банкнуудын нөлөөлөлд автаад, дахиад нуухыг нь авах гээд нүдийг нь сохлов гэгчээр маш хүнд ийм журам дүрэм батлаад явчих вий дээ. Ингэхгүй гэсэн баталгаа нь хэр байгаа вэ. Энэ арилжааны банкнууд, зарим банкнууд шүү. Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн дагуу хэрэгжилтийг нь хангахгүй байгаа, зээлдэгчийн мэдээллээ цаг тухайд нь рийл тайм, дата юунд мэдээлэхгүй, мэдээллээ нийлүүлэхгүй байгаа гээд асуудлууд байгаа юм байна лээ. Энэ дээр жишээ нь Монголбанк ямар арга хэмжээ авч байгаа юм. Хэдэн арилжааны банк зээлээ, зээлийн мэдээллүүдээ мэдээлэхгүй байгаа вэ. Энэ дээр цаашид ямар хариуцлага тооцож явах вэ.

3-д энэ яг энэ хуулийн заалттай холбоотой бас тодруулах юм байгаад байна. Энэ хуулийнхаа яг заалтууд дээр зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл гээд заачхаад байгаа юм. Тэгэхээр зэрэглэл гээд заачихаар яг иргэний зээлийн оноо

гэдэг агуулгаасаа илүүтэйгээр нөгөө зээлдэгчийн зээл авах чадварынх нь зэрэглэлийг тогтоох гээд байгаа юм шиг ойлголт төрж, төөрөгдүүлэх ийм байдал үүсчих гээд байна. Тэгэхээр энийг жоохон найруулгын хувьд хэлэлцүүлгийн явцад жоохон засаад, иргэдийн зээлийн оноог тогтоох асуудлыг нь илүү тодотгоод явахгүй бол энэ зээлжих зэрэглэл чинь эргээд нөгөө санхүүжих чадварыг тодорхойлж байгаа юм шиг ойлголт руу бас хөтөлчих вий дээ. Энэ 2 бол тусдаа, 2 өөр тусдаа ойлголт. Тэгэхээр энэ дээр хууль санаачлагчийн хувьд бас ямархуу саналтай байгаа вэ гэдэг ийм 3 асуултыг асууя. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Хариултыг хууль санаачлагч Энхбаярын Батшугар гишүүн хариулна.

Э.Батшугар: Манай Монгол улс чадалтай банкны системд шилжээд одоо 33, 34 жил болж байна. Үүнтэй холбоотойгоор бас арилжааны банкнууд яалт ч үгүй хөгжиж дэвших ёстой. 2011 онд зээлийн мэдээллийн хууль батлагдаад, үүрэг ролио гүйцэтгэснийг харж байгаа юм. Харин дараачийн шатад онооны систем рүү орох ёстой. Энэ онооны систем нь өөрөө хэрэглэгчийг хамгаалсан 1 ёсны зүйл. Тэр нь яг хар жагсаалтаар 6 жил тас хаалга барьчихдаг биш. харин бодит горимоор мэдээлэл нь өгөгдөөд, санхүүгийн сахилга баттай иргэдийг урамшуулдаг, харин тодорхой хэмжээгээр бас доголдол үүсвэл эргэж зассаных нь дараа буцаж сайжрах бололцоог нь олгож байгаа тийм систем л дээ. Тэгээд үүнийг дагаад зээлийн хүү буурах тийм кейс зөндөө байгаа дэлхий даяар. 28 орныг судлахад зээлийн хүү нь онооны систем рүү шилжсэнээр буурсан байгаа юм. 1989 онд анх АНУ энэ онооны систем рүү шилжсэн. Тэгээд үүнийг дагаад зээлийн хүү нь ч гэсэн бас буурсан. 1989 онд Америкийн дундаж хүү нь 10,5 хувь байсан. Онооны систем рүү шилжсэнийх нь дараа 8,5 хувь болсон. Бид нарын сайн мэддэг Солонгос улс байна. 2000 оны эхээр онооны системдээ шилжсэн. Өмнө нь 9,3 хувьтай жилийн дундаж хүүтэй банкнууд нь 6,5 руу буурсан байгаа юм. Тэгээд яриад байвал бүх л улс оронд буурсан үзүүлэлтүүд харагдаад байгаа юм. Тэгээд Монголд ч гэсэн буурах бүрэн бололцоотой. Яагаад гэвэл түрүүн бас хэлсэн. Нийт банкны зээлийн хүүг 100 хувь гэж бодвол үүний 63 хувь нь эх үүсвэрийн зардал, үлдсэн 15 болон 22 хувь нь эрсдэлийн зардал байгаа. Тэгээд эрсдэл нь тодорхой болохоор банкнууд заавал өндөр хүү тавихгүйгээр, харин санхүүгийн сахилга баттай иргэдийнхээ зээлийн хүүг бууруулах бололцоо нь үүсэж байгаа юм. Хэзээ хэрэгжих вэ гэвэл ямар ч байсан дунд хугацаандаа хэрэгжих бүрэн бололцоотой. Эхлээд хүмүүст дасна, хэрэглэж эхэлнэ, банкнууд нь эрсдэлээ тооцдог болно, хэрэглэгч нь дуртай банкаа сонгодог болно, банкнуудыг хооронд нь өрсөлдүүлдэг болно. Ингэж байж энэ хүү яваандаа ямар ч байсан дунд хугацаандаа буурах бүрэн бололцооны нөхцөл байдал үүснэ гэж хэлье.

Тогтоолын төсөл дээр яагаад Монголбанк журам батлаад байгаа юм бэ гэвэл ер нь Монголбанк болон тодорхой хэмжээнд санхүүгийн байгууллага бүх дэлхий л хянадаг юм байна лээ. Яагаад гэвэл энэ 2 тусгай зөвшөөрөлтэй компани чинь ажилтнуудынхаа оноог хиймлээр өсгөчихвөл яах вэ. Яаж бүх иргэдийгээ адилхан шударга, зөв онооны систем рүү оруулах вэ гэдэг дээр бол ямар нэг хяналт байдаг. Бүх л дэлхийд энэ кэйс харагдсан. АНУ гэхэд 2 бүр төрийн агентлаг нь хянаж, журмаар хянадаг Consumer financial protection bureau, Federal trade commission гээд. Герман улс гэхэд Federal financial supervisory authority гээд л бүх л дэлхийд тийм кэйс байдаг юм байна лээ. Харин эсрэгээрээ ард иргэдийн .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ганзориг гишүүн нэмж тодруулъя.

П.Ганзориг: Би тэр зээлийн хүү тодорхой хэмжээгээр буурна. Барьцаа баталгаа бас шаардах нь багасна гээд энэ маш чухал асуудал. Тэгэхээр хугацааны хувьд асуугаад байгаа юм. 2-4 хувь буурна гэж бол яг хэзээнээс буурч эхэлнэ гэж та тооцож байгаа вэ.

2-т тэр Монголбанканд яах вэ, мэдээж аргачлалыг нь тогтоох эрхийг нь өгч байгаа. Энэ хууль батлагдсантай холбоотой. Зүгээр аргачлалынх нь гол агуулгуудыг энэ хуульдаа тусгачхаж болоогүй юм уу гэдэг агуулгаар асуугаад байгаа юм шүү. Тэгэхгүй журам дагуулж дахиад л бас хүндрэлүүд, нөгөө хуулийн концепц анхнаас нь өргөн барьсан үндэслэлээсээ гажуудсан зүйлүүдийг тусгачих гээд байдаг. Энэ бол Монголбанк бие даасан, хараат бус байдлаар энийгээ батлах чадварт эргэлзээ бас байдаг учраас асууж байгаа асуулт шүү. Шулуухан хэлэхэд.

3-д энэ санхүүгийн салбар нь бол гажуудчихаад байна. Мэдээж Монгол Улсын аль ч салбарын бизнесүүд томорч байх ёстой. .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Асуулт байгаа юм уу. Хэн хариулах юм. Энхбаярын Батшугар гишүүн хариулна.

Э.Батшугар: Латин Америк болон 28 улс орны судалгааг харахад 2-3 жилийн дотор бүрэн буурсан байгаа юм. Бүрэн санхүүгийн зах зээл нь хөгжсөн, жишээлбэл АНУ, Өмнөд Солонгос улс, Герман улсыг харахад бол 4 жилийн дотор буурсан байгаа юм. Яах вэ манай Монголын санхүүгийн систем илүү динамик жижигхэн. Тэгэхээр өөрчлөлт орох нь илүү хурдан байдаг. Бид нарын бодлогын хүүгээ ч гэсэн өөрчлөхөд бол ер нь дэлхийд жилийн 12 сараас 18 сарын дотор өөрчлөлт ороход манайд бол 6 сарын дотор эдийн засагтаа өөрчлөлт орчихдог. Тэгэхээр болох л хурдан үйлчилгээг нь л нэвтрүүлмээр байгаа юм. Яагаад Монголбанк бэ гэхээр санхүүгийн зах зээл өөрөө байнга хөгжиж байдаг. AI байна, финтекүүд байна. Тэгэхээр журмаараа хурдан өөрчлөлтүүд нь оруулах ёстой. Америкууд ч гэсэн энэ журамдаа 13 удаа өөрчлөлт орсон байна лээ. Хамгийн сүүлийн өөрчлөлт нь 2 жилийн өмнө орсон байна лээ. Тэгэхээр аль болохоор хэрэглэгчдийг хамгаалахын тулд энэ өөрчлөлтүүдээ цаг алдахгүйгээр өөрчилж байх ёстой л гэж хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Монгол банкны Дэд ерөнхийлөгч Энхтайван хариулъя.

Г.Энхтайван: Ганзориг гишүүн энэ олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас нөхцөл шаардлагыг үндэслэн журам батлах гэж байна гэж байна. Бид бүхэн бол маш олон зах зээлийг зохицуулж байгаа журам, дүрэм, заавар, стандартыг бол төв банкнаас бол зохицуулаад, батлаад явдаг. Эдгээр бүх Монголбанкнаас батлан гаргасан эрх зүйн актууд нь Банкны холбоо болон тухайн салбарт оролцож байгаа зохицуулалтад хамрагдаж байгаа бүхий л аж ахуйн нэгжүүд, мөн бизнесийн байгууллагууд, төлөөллүүд, санхүүгийн хэрэглэгчдийн дунд хэлэлцүүлэг явсны үндсэн дээрээс батлагддаг. Тэгэхээр энэ удаагийн аргачлалыг ч гэсэн бид бүхэн Банкны холбоо, зөвшөөрөл авчхаад байгаа 2 компани, санхүүгийн хэрэглэгчид, төрийн захиргааны бусад байгууллагууд, бизнес эрхлэгчид, олон нийтийн байгууллагын дунд нээлттэй хэлэлцүүлэг явуулсны үндсэн дээр тэдгээрийн бүгдийнх нь саналыг тусгаж .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Батшугар гишүүний санаачилсан оруулж ирсэн хуулийг дэмжиж байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор ганц 2 тодруулах асуулт байна. Ер нь бид нар хар жагсаалт буюу муу хүмүүсээ л хэрхэн яаж торгох вэ, хэрхэн яаж хязгаарлах вэ гэдэг талаас нь л яриад байдаг. Гэтэл сайн хүмүүсээ, сайн зээлдэгчээ ер нь үүргээ сайн биелүүлж байгаа хүмүүсийг хэрхэн яаж урамшуулах вэ гэдэг талаас огтоос ярьдаггүй. Энэ зөвхөн зээлийн хүү ч байна уу, бусад татвар, торгууль ч байна уу, энэ дээр ердөөсөө ярьдаггүй. Тэгэхээр энэ дээр эхнээс нь зээлээ сайн төлж байгаа хүмүүстээ, хамгийн өндөр оноотой байгаа хүмүүстээ зээлийн хүүгийн бодлогоороо дэмжлэг үзүүлэх боломжтой юу. Энэ бодлого ер нь явах уу, үгүй юу. Энэ маш чухал. Ер нь Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан яг энэ зээлийн хүүг бууруулах маш олон бодлого чиглэлийг явуулж байгаа. Өнгөрсөн 2 7 хоногийн өмнө бас эмэгтэйчүүдийн буюу эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн кодын нээлтийг бас хийсэн. Үүнтэй холбоотойгоор тавьж байгаа мэдээллүүд нь нийт бизнес эрхлэгчдийн 40 хувь нь эмэгтэйчүүд, аж ахуйн нэгжүүдийн удирдах албан тушаалтны 37 хувь нь эмэгтэйчүүд. Гэтэл жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 70 хувь нь эмэгтэйчүүд. Тэгээд авч байгаа зээлийг нь аваад үзэхээр зээлдэгчийн дансны тоо бол эрэгтэйчүүдийнхээс 33 хувиар их байгаа байхгүй юу. Тэгсэн мөртөөсөө дундаж зээлийн хэмжээ нь эрэгтэйчүүдийнхээс 45 хувиар бага. Зээлийн дундаж хүү нь эрэгтэйчүүдийнхээс 0,8 буюу бараг 1 хувиар их байгаад байна. Энэ юу гэсэн үг вэ гэхээр үндсэндээ бизнесийн жижиг зээлүүдийг дийлэнхдээ эмэгтэйчүүд авдаг юм байна. Богино хугацаагаар авдаг юм байна. Өндөр хүүтэй авдаг юм байна. Тэгээд тулгамдаж байгаа асуудал нь яг юу юм бэ гэхээр барьцаа хөрөнгө ер нь байдаггүй, бизнесийн сүлжээ зах зээлийн хязгаарлагдмал нөхцөл байдал байна. Жендерийн хэвшмэл ойлголт байна. Төрийн зүгээс бодлогын дэмжлэг хууль, эрх зүйн орчин сул байна гэдэг ийм дүгнэлтүүдтэй байдаг. Тэгэхээр яг энэ зээлээ эргэн төлөлт нь эмэгтэйчүүдийн хувьд ямар юм бэ, хариуцлагатай юм уу, үгүй юм уу гэдгийг бас гаргаж ирэх хэрэгцээ шаардлагатай байна гэдгийг олон жил ярьсан учраас банкууд ямар ч байсан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, мэргэжлийн оролцогч байгууллагууд хамтдаа эмэгтэйчүүдийн санхүүгийн кодтой болж байгаа Европын сэргээн босголтын банкттай хамтраад дэлхийн шилдэг үлгэр жишээ болж байгаа санхүүгийн кодыг Монгол Улсдаа нэвтрүүлж байгаад би бас талархлаа дэвшүүлмээр байна.

Яагаад гэхээр яг бид нар дата судалгаа мэдээлэлтэй болж байж сая тулгамдсан асуудлууд нь юу юм, хэрхэн яаж дэмжих вэ, хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг 1 баримттай болно. Тэгэхээр миний үндсэндээ яг асуух гээд байгаа асуудал нь бол яг зээлийн сайн зээлдэгчдийн хувьд үнэхээрийн л эмэгтэй бизнес эрхлэгчид буцаагаад цаг хугацаандаа, хариуцлагатай төлдөг юм бол барьцаа хөрөнгийг нь юу гэдэг юм шаардахгүй байх гэдэг ч юм уу, эсвэл бууруулдаг ч юм уу. Нэгэнтээ эрэгтэйчүүдээс өндөр хүүтэй зээл аваад байгаа юм бол нөхцөл байдал байгаа юм бол энэ дээр бас тэнцүүлэх, тэнцвэржүүлэх, илүү давуу байдал өг гээд байгаа юм биш шүү дээ. Ердөөсөө л зүгээр ижил гараанаас байх энэ боломжийг нь төрөөс олгох нь зүйтэй. Ийм бодлого байх хэрэгцээ шаардлага байна гэдгийг бол хэлээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр боломжтой юу. Зээлийн хүүг бууруулах бодлогыг ярьж байна. Орж ирнэ гэсэн хүлээлт үүссэн байгаа. Үүнтэйгээ уялдуулаад яг энэ хариуцлагын асуудлыг зөвхөн эмэгтэйчүүд гэлтгүй ер нь нийт зээлдэгч нарын хувьд сайн байх юм бол бага хүүгээр, арай харьцангуй багаар байдаг, муу байх юм бол өндөр хүүтэй зээл авдаг энэ хариуцлагын тогтолцоонд нь оруулж болох уу. Энэ бодлого байна уу гэдгийг асууя.

Б.Пүрэвдорж: Гишүүний асуултад Энхбаярын Батшугар гишүүн хариулна.

Э.Батшугар: Ариунзаяа гишүүн маш чухал асуудлыг хөндлөө л дөө. Яг нийт Монгол Улсад зээлийн багцыг харахад хамгийн чанар сайтай, цаг хугацаандаа төлдөг зээлдэгч нар эмэгтэйчүүд болон малчид байдаг. Эд нарт ямар урамшуулал ирэх юм бэ, яагаад эрсдэлтэй иргэдтэйгээ адилхан байгаад байгаа юм бэ гэж тийм аргумент гараад байгаа юм. Тэгэхээр энэ онооны систем рүү орсноороо цаг хугацаанд нь зээлээ төлдөг эмэгтэйчүүд байна, дээрээс нь малчид байна, иргэддээ илүү урамшуулна. Оноо нь өөрөө өсөөд явчих юм. Оноо нь өөрөө өсөж авахаар зээлийн нөхцөл нь сайжраад явчихна. Энэ зээлийн хүү байна, цаг хугацаа байна, дээрээс нь барьцаа хөрөнгийн шаардлага ч буураад явчихна. Олон улсын жишээ байгаа юм. Латин Америкийн жишээ байгаа юм. Саяхан энэ кредит скорын систем рүү шилжсэнээр барьцаа хөрөнгийн шаардлага нь 12 хувиар буурсан судалгаа байна. Дээр нь нэмж хэлэхэд тэр иргэний өөрийнх нь оноо нь биет бус хөрөнгө болчихоод байгаа юм. Тэгээд тэр оноонд нь суурилад зээл авчхаж байгаа юм. Заавал барьцаа хөрөнгө шаардахгүйгээр тэр оноо нь өндөр бол тэр иргэн тэртээ тэргүй санхүүгийн сахилга баттай иргэн зээлээ эргэн төлөх нь тодорхой юм чинь илүү сайн нөхцөлтэй зээл олгоё гэж банкнууд гэж харах юм. Үүнтэй холбоотойгоор бас Энэтхэг болон Колумбад судалгаа хийсэн билээ. Under bank population гэж ярьдаг. 1 ёсны зээл авч чаддаггүй, санхүүгийн үйлчилгээ авч чаддаггүй иргэдийг энэ хүртээмж нь нэмэгддэг. Санхүү хүртээмж нь кредит онооны систем рүү орсноор. Энэтхэгт энэ систем рүү шилжсэнээр 119 сая шинэ иргэн банк санхүүгийн байгууллагатай санхүү үйлчилгээ авсан байгаа юм. Ялангуяа энэ бол эмэгтэйчүүд алслагдсан нутаг дэвсгэрт амьдардаг иргэд ч гэсэн бас орчхож байгаа юм. Тэгэхээрээ санхүүгийн хүртээмж өөрөө нэмэгдэнэ гэж та ойлгож болно. Зээлийн шийдвэр гаргадаг процесс өөрөө өдөртөө болно. Хүнд суртал нь арилна гэж ойлгож болно. Мөн шийдвэр гаргадаг шийдэл нь өөрөө 10 хувиараа илүү нэмэгддэг юм байна лээ. Энэ бас нөгөө нийт систем нь өөрөө эрсдэл нь буурахаар зээлийн хүү буурна, чанаргүй зээлийн хэмжээ буурна. Үүнийг дагаад нийт зээлийн авах хүртээмж ялангуяа эмэгтэйчүүд ч гэсэн бас хамаагүй нэмэгдэнэ. Ялангуяа хувиараа бизнес эрхэлдэг жижиг дунд үйлчилгээ явуулдаг эмэгтэйчүүдэд бас л хүрнэ гэж ойлгож болох юм.

Б.Пүрэвдорж: Аюушийн Ариунзаяа гишүүн нэмж тодруулъя.

А.Ариунзаяа: Жендерийн үндэсний хороог Ерөнхий сайд ахалдаг. Жендерийн үндэсний хорооны 2021 оны 6 сарын 7-ны шийдвэрээр Монгол Улсад Төв Ази дахь Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ийм шийдвэр гараад, тэгээд Удирдах зөвлөлийг бас байгуулаад тухайн үедээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Удирдах зөвлөлийн даргаар буюу би бас томилогдоод ажиллаж байсан. Тэгээд энэ тогтоол 1 дүгээрт шинэчлэгдээгүй байгаа. Энийг бол Жендерийн үндэсний хорооныхон маань бас анхаарч шинэчлэх хэрэгтэй.

Тэгээд хамгийн гол яригдаж байгаа асуудал нь юу юм бэ, яагаад эмэгтэйчүүдийг онцлоод байгаа юм бэ гэхээр энэ өөрөө 1 талдаа ядуурлыг бууруулах бодлого байдаг юм байна. Итгэлцлийн зээл гээд бүр хүүгүй, барьцаагүй зээлийн санаачилгыг анх дэлхийд гаргаад, Нобелийн шагнал хүртэл хүртэж байсан. Тэгээд тухайн үедээ Оюунхорол гишүүн санаачлаад энэ хууль бас явж чадаагүй. Энэ хэлбэрээрээ ийм зээлийн бодлогуудыг гаргах боломж .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Энхбаярын Батшугар гишүүн хариулъя.

Э.Батшугар: Эмэгтэйчүүдэд зээл авахад тулгамдаж байгаа асуудал нь барьцаа хөрөнгө байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө онооны системд шилжсэнээр иргэний оноо нь өөрөө биет бус хөрөнгө болчхож байгаа юм. Барьцаа хөрөнгө болчхоод нэг ёсны. Үүгээрээ дамжуулаад санхүүгийн үйлчилгээ авах хүртээмж нь өөрөө нэмэгдэх юм гэж хэлмээр байна. Яагаад гэвэл тэр иргэнийг оноо нь тодорхойлно. Тэр оноогоо өсгөхийн тулд иргэн өөрөө санхүүгийн хариуцлагатай, сахилга баттай байна. Эргээд банк харахад өндөр оноотой иргэн юм чинь энэ зээлээ эргэн төлөх нь тодорхой. Энэ утгаараа зээлийн нөхцөлөө сайжруулаад, зээл олгоё. Хэрвээ тэр иргэн өөрөө санхүүгийн боловсрол нь өндөр иргэн бол ойлгоно. Би хэрвээ зээлээ цаг хугацаанд төлөхгүй бол миний оноо буурах юм чинь би ч гэсэн бас цаг хугацаандаа төлөх ёстой гээд. 1 ёсны 2 талд байгаа харьцаа байгаад байгаа юм. Тэр оноо бол хамгийн чухал зүйл болчхоод байгаа л даа. Тухайн иргэний. Яагаад гэвэл санхүүгийн харилцаа ../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууна.

Б.Хэрлэн: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр зээлжих чадварыг оноогоор үнэлж тогтоох энэ аргачлалыг нэвтрүүлэх санааг бол дэмжиж байгаа. Тэгэхээр ялангуяа сая Ариунзаяа гишүүн ярьж байна л даа. Энэ бол сайн зээлдэгч зээлээ найдвартай төлдөг эмэгтэйчүүдийн хувьд бол маш их тийм бас боломжийг нээж өгөх ийм аргачлал орж ирж байна гэсэн энэ санаануудыг сая ярьж байна. Тэгэхээр ер нь бол эмэгтэйчүүд зээл авахад барьцаа хөрөнгийн тухай асуудал хамгийн хүнд байдаг л даа. Тэгээд 1 статистик байдаг. Эмэгтэйчүүд өнөөдөр үл хөдлөх хөрөнгийг эзэмших байдлаараа эрчүүдтэй харьцуулах юм бол 2 дахин бага. Газар эзэмших, өмчлөх нь хүртэл эрчүүдтэй харьцуулах юм бол бас 6 дахин бага байдаг учраас зээл авах үед бол барьцаа хөрөнгө гэдэг бол үнэхээрийн том даваа болдог гэж. Тэгэхээр энэ зээлжих чадварыг оноогоор дүгнээд, үнэхээр зээлжих чадвар нь сайн байгаад, оноо нь өндөр байх юм бол энэ барьцаа хөрөнгө шаардах явдал дээр бас арай жаахан уян хатан байдал үүсэх болов уу. Ер нь энэ бол ийм боломжтой юу, үгүй юу. Тэгэхээр ер нь зээлийн нөхцөл нь илүү уян хатан болох, хүү нь магадгүй бас багасах ийм боломж бас бүрдэх үү гэж 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт нь ер нь би бас энэ зээлжих чадварын оноогоор дүгнэх энэ системд нэвтэрч байгаа байдал бол манай Монголын нийгэмд санхүүгийн хариуцлага, санхүүгийн сахилга бат гэдэг юмыг дээшлүүлэх, хариуцлагын ухамсар гэдэг юмыг дээшлүүлэхэд маш их ач холбогдолтой зүйл болж байна гэж бол ерөнхийдөө харж байгаа. Тэгэхээр энэ маань өөрөөр хэлэх юм бол оноо өндөр байгаад байх тусмаа тэр зээлийн нөхцөл нь улам уян хатан болох, яг энэ дээр ямар ямар урамшууллууд орж ирэх вэ гэдгийг илүү тодорхой хэлж өгөөч гэж асуумаар байна.

3 дугаарт ер нь энэ зээлжих чадварыг оноогоор дүгнэх явдал бол бас улс орны нийгмүүдэд бас янз янзын нөлөө үзүүлдэг юм байна л даа. Ингээд уншаад судлаад үзэж байхад бол заримдаа энэ бол нийгэм дэх тэгш бус байдлыг бэхжүүлэх, хадгалахад нөлөөлчхөж болзошгүй гэсэн ийм судалгааны дүгнэлтүүд гарсан байна лээ. Өөрөөр хэлэх юм бол зээлжих чадварын үнэлгээ доогуур байгаа бол авах зээлийнх нь хэмжээ бага болоод явчихна. Тэгээд дээр нь хүү нь бас арай жаахан ахиухан болчихно. Эргээд энэ нь хүний санхүүгийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй учраас эргээд нөгөө нийгэм дэх тэгш бус байдлыг хадгалаад байж болзошгүй байдаг гээд ийм дүгнэлтүүд гарсан байдаг. Тэгэхээр энийг яг аргачлалыг боловсруулах, аргачлалыг батлах тухай дээр Монголбанкнаас яг энэ тухай асуудлыг хэрхэн яаж анхаарч үзэх бол.

4 дүгээрт нь ер нь бол зээлжих чадварын үнэлгээг тогтоохдоо хэд хэдэн ийм аргачлал үзүүлэлтийг харгалздаг юм байна л даа. Ер нь 5-6 үзүүлэлтүүдийг харгалздаг гэж үзсэн байгаад байдаг. Тэгэхээр энэ зээлийн хэмжээ ч байдаг юм уу, төлбөрийн үлдэгдэл ч байдаг юм уу, зээлээ цаг хугацаанд нь төлж байсан уу, үгүй юү ч гэдэг юм уу. Хэдэн удаа зээл авсан гээд л. Тэгээд энэ зүүлтүүдээс гадна арай эд нараас гадна шаардлагыг өнөөдөр арилжааны банкнууд зээлдэгчид тавьж байдаг. Ялангуяа хэрэглээний зээл дээр тэр настай, хүйстэй холбоотой ийм шаардлагуудыг тавиад явчихдаг. Тэгээд хамтран зээлдэгчтэй байхыг шаардаад явчихдаг. Хэрвээ ганц бие хүн байх юм бол хамтран зээлдэгч дагуулаад очоод зээл авах боломжгүй л дээ. Тэгээд насны хувьд гэхэд тухайлах юм бол эмэгтэй нь 55, эрэгтэй нь 60 нас хүрч байгаа тохиолдолд хэрэглээний зээл олдохгүй байх ийм нөхцөлүүд бас байгаад байдаг. Тэгэхээр сайн оноо авч байгаа зээлдэгч зээлдэх чадвар нь өндрөөр үнэлэгдэж байгаа зээлдэгчид саяын энэ зохицуулалтууд бас адилхан хэвээр үйлчилсээр байх уу. Эсвэл энэ саяын шаардлага ер нь өөрчлөгдөх болов уу. Энийг би асуух гэсэн юм.

Б.Пүрэвдорж: Хууль санаачлагч Энхбаярын Батшугар гишүүн хариулна.

Э.Батшугар: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Банк санхүүгээс үйлчилгээ авахдаа заавал барьцаа хөрөнгө шаарддаг тогтолцоо өнөөдөр үйлчлээд байгаа. Тэр нь үл хөдлөх ч юм уу гэх мэтчилэн. Тэгэхээр энэ кредит оноо болон онооны системдээ шилжсэнээр тэр оноо нь өөрөө санхүүгийн биет бус хөрөнгө болчих юм. Энэ оноо дээр нь суурилуулаад банк санхүүгийн байгууллага үйлчилгээгээ олгоно. Өндөр оноотой иргэнд илүү таатай нөхцөлтэй зээлийн үйлчилгээ олгоно.

Ахиад нэг зүйлийг давтаж хэлэхэд энэ хар жагсаалт гэдэг юм байхгүй болно. Жинхэнэ нийгмийг хуваагаад байгаа, өнөөдөр 200 мянган иргэн энэ хар жагсаалтад орчихсон байгаа юм. Тэгээд 6 жилээр ямар ч банк санхүүгийн байгууллагаас үйлчилгээ авах үүд хаалга нь хаалттай. Энэ том санхүүгийн шударга бус ял байхгүй болно. Эсрэгээрээ цаг хугацаанд нь төлдөг иргэнийг урамшуулна. Энэ нь барьцаа хөрөнгийн шаардлага нь буурна. 1 ёсны түрүүн би хэлсэн оноо нь өөрөө санхүүгийн биет бус хөрөнгө болчихно.

2-т нь сахилга бат сайжирна. Энэ нь бол нийт системээрээ сайжрах тогтолцоо үүсэх юм. Олон улсын жишгийг харахад бол чанаргүй зээлийн хувь нь 1,9 нэгж хувиар буурсан байгаа. Үүгээрээ дагаад зээлийн хүү ч гэсэн буурах тийм үндсэндээ тогтолцоо нь бий болчхож байгаа юм.

Ямар ямар дата ордог вэ гэхээр одоогийн байдлаар 1,6 сая иргэний 4,7 сая дата бааз байгаа юм. Энэ боловсруулалт нь нөгөө 2 компани өөрсдийнхөө аргачлалаар хийгээд, магадгүй ямар онооны тогтолцоо хийх юм. Түүнд нь Монголбанк оролцохгүй. Тэгээд энэ үйлчилгээгээ иргэдэд олгоно. Зөвхөн Монгол банк энэ үйлчилгээ нь шударга, нийгмийн хүсэлтийг хангасан тийм зүйлийг нь л хянана. Шинэ зээлдэгч нар ч гэсэн бас үүнд орчхож байгаа. Ялангуяа эмэгтэйчүүд үүнд орох бололцоог нь нээж өгч байгаа юм.

Латин Америкийн судалгаа гарсан байгаа юм. Тэр нь бол анх удаа зээл авч байгаа иргэд 16 хувиар нэмэгдсэн. Энэ онооны систем рүү орсноор. Колумбия улсад бол бүр 32 хувиар нэмэгдсэн байгаа юм. Энэтхэгт 119 сая иргэн шинээр зээл авах бололцоо нээгдсэн. Тэгээд заавал зээл гэхгүй санхүүгийн үйлчилгээ авах нөхцөл нь бүрдэж байгаа. Энэ иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд болон алслагдсан нутаг

дэвсгэрт амьдардаг иргэд байгаа юм. Санхүүгийн хариуцлагыг ярьсан л даа. Энэ бол маш чухал зүйл. Яагаад гэвэл энэ оноо нь өөрөө биет бус хөрөнгө болчихоор иргэн өөрөө хариуцлагатай болчихно. Үүнийгээ дагаад өндөр оноотой иргэн барьцаа шаардлага нь буурсан, урт хугацааны, бага хүүтэй зээл олгох нөхцөл байдал бүрдэнэ.

Харин эсрэгээрээ тодорхой хэмжээний алдаа гарвал тэрэнд 6 жилийн ял өгөхгүйгээр засах бололцоог нь өгөх юм.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зээлийн мэдээллийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбоотойгоор нийтдээ 8 зарчмын зөрүүтэй санал байгаа. Энэ зарчмын зөрүүтэй саналыг 14 цагаас Ерөнхий сайдын мэдээллийн дараагаар үргэлжлүүлж явуулна.

14 цагаас Монгол Улсын Ерөнхий сайдын Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар мэдээллийг хийнэ.

Үдээс өмнөх чуулган завсарлалаа.

12.37 цаг.

ЗАВСАРЛАГА.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэллээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг хийнэ. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хүрээнд иргэн бүрд хуримтлалын нэрийн данс нээж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зорилгоор зарцуулах ажлын зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар мэдээллийг хийнэ.

Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнийг индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр та бүхэнд Ерөнхий сайдын мэдээллийн цагаар дамжуулж Монгол Улсын Засгийн газраас Үндэсний баялгийн сангийн талаар баримталж буй бодлого, үйл ажиллагааны үндсэн зарчмын талаар товч мэдээлэл өгье.

Байгалийн баялаг бол геологийн процессын олон 100 сая жилийн тасралтгүй өөрчлөлтийн үр дүнд бүрэлдэн бий болдог бөгөөд ашигт малтмалын орд урт хугацаанд үүсэх нь байгалийн дахин давтагдашгүй нэн ховор үзэгдлүүдийн нэг гэж үздэг. Тийм ч учраас хүн төрөлхтний түүхийн үечлэл бүхэнд байгалийн баялгийн төлөөх өрсөлдөөн байсаар ирсэн.

Аж үйлдвэрийн хувьсгалаас хойш нүүрс, төмөр, зэс зэрэг ашигт малтмалын хэрэгцээ эрс өссөнөөр дэлхийн геополитикийн бодлогын төвд ашигт малтмалын асуудал орж, 20, 21 дүгээр зуунд дэлхийн стратегийн бодлогын салшгүй нэг хэсэг болон хувирсан. Өнөөдөр зэс газрын ховор элемент зэрэг цахим технологи, сэргээгдэх эрчим хүч, батарей, хиймэл оюун ухаан, цэргийн технологид хэрэглэгддэг ашигт малтмалууд стратегийн ач холбогдолтой болж, их гүрнүүдийн өрсөлдөөний гол талбар болж байгааг бид бүхэн харж байна.

Байгалийн баялаг бүрэлдэн бий болоход олон зуун сая жилийн хугацаа ордог учраас уул уурхайн салбарыг хөгжүүлж буй бүх л улсад нийгмийн зөвшилцөл зайлшгүй шаардлагатай болдог. Манай улсын хөгжлийн түүхээ болсон Эрдэнэт, Оюутолгой, Таван толгойн бүлэг орд гэхэд л одоогоос 250-300 сая жилийн өмнө үүсэн тогтсон гэж үздэг.

Монгол Улсын хувьд Орос, Бельги, Франц улсуудын хувь нийлүүлсэн Монголоор хамтарсан нийгэмлэг 1990-ээд оны эхэн үеэс үйл ажиллагаагаа эхлүүлж байсан түүхтэй. Энэ цаг үеэс хойш манай улсад ашигт малтмал, геологи хайгуулын судалгаа эрчимжиж, 1924 онд Сангийн яаманд Баялгийг бадруулах хэлтэс байгуулсан нь ашигт малтмалыг төрийн бодлогоор системтэй ашиглах асуудлыг хариуцсан өнөөгийн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны суурь болсон түүхтэй.

Байгалийн баялгийг ашигладаг аль ч улс орны хувьд ойлголцол зөвшилцлийн үндсэн шийдэл нь баялгийн сан байсаар иржээ. Кувейтийн хөрөнгө оруулалтын сан анх 1953 онд Лондонд байгуулагдсанаар баялгийн сангийн орчин цагийн түүх эхэлсэн гэж үздэг. Дэлхийд тэргүүлэгч Норвегийн баялгийн сан 1990 онд байгуулагдсан бол өнөөдөр дэлхий дахинд нийт 100 гаруй баялгийн сан, нийтдээ 13 их наяд ам.долларын хөрөнгийг захиран зарцуулж байна.

Монгол Улс уул уурхайн орлогоос бүрдсэн Баялгийн санг байгуулах алхам хийж, 2009 онд Хүний хөгжил сан, 2016 онд Ирээдүйн өв сангуудыг байгуулж байсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуульчлан тогтооно хэмээн хуульчилснаар Үндэсний баялгийн сангийн тогтолцооны эрх зүйн суурь зарчим тавигдсан гэж үзнэ.

“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 4 дүгээр бүлгийн 6-д заасан зорилтыг хангах хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталж, хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш яг 1 жилийн хугацаа өнгөрч байна. Үндэсний баялгийн сангийн иргэдийн хуримтлалын дансанд өнгөрсөн жил 495,6 тэрбум төгрөг төвлөрч, иргэн бүхэн и-монгол системээр өөрийн хуримтлалыг бүрдүүлж буй эх үүсвэрийн хамт харах тогтолцоо бүрдсэн нь Үндэсний баялгийн сангийн засаглалын хувьд чамлахааргүй эхлэл цэг юм.

Үндэсний баялгийн сангийн хууль батлагдахад улс төрийн дэмжлэг үзүүлсэн баялагтаа эзэн монгол уриаг дэвшүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн

Хүрэлсүх, зөвшилцөж баталсан Ардчилсан нам, ХҮН намын удирдлагууд, парламентын эрхэм гишүүд та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Баялгийн сан бүрдүүлэх эхлэл үйл явц аль ч улсад улс төр нийгмийн халуун мэтгэлцээн дунд өрнөсөн байдаг. Бид ч үүнийг тойроогүй. Эрдэнэт, Таван толгой, Оюутолгой зэрэг ордыг тойрсон олон жилийн мэтгэлцээн ч өөрийн онцлогт тохирсон үндэсний баялгийн санг үндэслэн байгуулж арвижуулан хөгжүүлэх арга замыг хайхад оршиж байсан гэж дүгнэж болно.

Үндэсний баялгийн сангийн тухай хууль хэрэгжиж эхэлсний дараа олон жил гацсан мега төслүүд гацаанаас гарч, хөрөнгө оруулагчид идэвхжиж эхэлсэн нь баялгийн сангийн эерэг үзүүлэлт бөгөөд бусад улсад ч ийм жишээ болж байсныг түүх нотолж байгаа юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Одоо та бүхэнд Үндэсний баялгийн сангийн хууль батлагдан хэрэгжиж эхэлсэн 1 жилийн дүгнэлт, олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн саналд үндэслэн цаашид баримтлах үндсэн чиглэлийн талаар товч танилцуулга хийе.

Цар тахал, дайны нөхцөл байдлыг бүрэн даваагүй дэлхийн эдийн засаг олон улсын тарифын асуудалтай нүүр тулснаар худалдааны дайн эхэлж, ОУБ-ын судалгаагаар тодорхой бус байдлын индекс түүхэнд 2 дахь удаагаа хэвийн хэмжээнээс 2 дахин өслөө. Энэхүү тарифын хямрал Монгол Улсын эдийн засагт экспортын гол бүтээгдэхүүний үнэ буурах байдлаар шууд нөлөөлж байна. Тодорхойгүй байдлыг даван туулах бидний байр суурь туйлын тодорхой байхад чиглэх учиртай. Энэ бол үндэсний баялгийн санд тулгуурласан олон нийтийн дэмжлэгтэй уул уурхайн салбар. Хөрөнгө оруулалт, тээвэр, логистик, эрчим хүчний мега төслүүдийг цаг алдалгүй тууштай хэрэгжүүлэх явдал юм.

Манай улсын төсвийн орлогын 31 хувь нийт экспортын 90 гаруй хувийг уул уурхайн салбар эзэлдэг ч иргэдийн амьдралын чанар ул уурхай олборлуулж буй орон нутгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хангалттай шийдвэрлэгдэж чадахгүй байгаа нь олон нийтийн шүүмжлэлийг дагуулсаар ирсэн. Уул уурхай ашигт малтмал ашигласны нөөцийн төлбөр буюу рояалти нь Английн хууль, эрх зүйн уламжлалаас үүсэлтэй бөгөөд анх хааны өмчлөлийн газар нутагт ашигт малтмал олборлох эрхийн төлбөрийг илэрхийлдэг утгатай байжээ.

Монгол Улсын хувьд өнөөдрийн АМНАТ буюу АМНАТ, хөрөнгө оруулагчид, хувийн хэвшил, орон нутаг, иргэдэд үндэсний баялгийн сангаар дамжуулан тэгш хүртээмжтэй хуваарилагдаж, нийгмийн хөгжлийн суурь асуудлыг шийдвэрлэх үндсэн механизм болж чадахгүй, ойлгомжтой бус, ил тод бас биш байна.

Тиймээс нөөцийн төлбөр рояалтыг олон улсын сонгодог утгаар нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т заасан одоо ба ирээдүйн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээх үндсэн зарчмыг баримтлан Үндэсний баялгийн сангийн төлбөр болгон утгыг нь тодорхойлж, Ирээдүйн өв санд 50 хувийг хуримтлуулан хадгалж, хуримтлалын санд 5 хувь ба стратегийн ордын 34 хувьд ноогдох ноогдол ашиг ашигт малтмалын нөөц

ашигласны тусгай төлбөрийн хамт, хөгжлийн санд 5 хувийг, бүс ба орон нутгийн санд 15 хувийг төвлөрүүлж, цаашид 2030, 2040, 2050 онуудад үе шаттай нэмэгдүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна. Ирээдүй хойч үед цаашид 33 хувь, иргэдийн хуримтлалд 33 хувь, үндэсний хөгжил ба бүс орон нутгийн хөгжилд 33 хувийг бүрдүүлэх урт хугацааны стратегийг эрх зүйн хувьд тодорхойлох нь уул уурхайн цаашдын салбар олон нийтийн дэмжлэгтэй байх үндсэн суурь хэмээн Засгийн газар үзэж байна.

Ингэснээр үндэсний баялгийн санг арвижуулан бүрдүүлэхийн төлөө иргэд, орон нутгийн удирдлагууд, иргэний нийгмийн байгууллагууд, үндэсний аж ахуйн нэгжүүд, хөрөнгө оруулагчид бүх нийтээрээ хамтран ажиллах шинэ гэрээ зөвшилцөл ойлголцлын суурь зарчим бүрдэнэ гэдэгт Ерөнхий сайдын хувьд бас итгэлтэй байна.

Эрхэм парламентын гишүүд та бүхнийг Үндэсний баялгийн сангийн тухай хуульд оруулах энэхүү өөрчлөлтийг бас хэлэлцэн дэмжихийг хүсье.

Эрхэм уул уурхайн компаниудын удирдлага та бүхнийг олон нийтийн нийтлэг хүсэл эрмэлзэл, ирээдүйн уул уурхайн шинэ төслүүдийг нийгэмд хүлээн зөвшөөрөх байдлыг дэмжиж, Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчмыг хүндэтгэж, Монгол Улсын Засгийн газартай хэлэлцээрийн ширээний ард суухыг урьж байна.

Хурдтай хөгжлийн төлөө зориг гарган үндэсний баялгийн сангийн тогтолцоогоор дамжин олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн уул уурхайн салбар хөрөнгө оруулалтын шинэ хуудсыг хамтдаа нээхийг мөн уриалж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэд баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Пүрэвдоржийн Мөнхбаяр Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын Зах зээлийн хэлтсийн захирал, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Басангийн Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Баяраагийн Тэмүүлэн “Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ванчины Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Лувсаншаравын Энхжаргал Үндэсний баялгийн сан орон сууцжуулалтын үндэсний хорооны Ажлын албаны дарга, Амарсайханы Хишигбаяр Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга, Хүүгийн Мөнхжаргал “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Мандахын Энхсайхан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн гүйцэтгэх захирал, Бавуужавын Мягмарнаран И-монгол Академи УТҮГ-ын захирал, Шаравын Бат-Эрдэнэ Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн ахлах шинжээч. Энэ орон сууцжуулалттай холбоотой асуудал байгаа учраас бас Батсуурь сайд энд байгаа юм байна. Учрал сайд бас ирсэн байна.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Хурал дахь цөөнхийн төлөөлөл Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Хишигдэмбэрэлийн Тэмүүжин үг хэлнэ.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд ирүүлсэн Үндэсний баялгийн сангийн үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилтийн талаарх Ерөнхий сайдын мэдээлэлтэй танилцаад Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс дараах дүгнэлт өгч байна.

1.Үндэсний баялгийн сангийн хуулийг сайжруулж, тогтолцоо засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай тухай.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2024 оны 4 дүгээр сард Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Засгийн газраас өргөн барьсан төслөөр Улсын Их Хурал баталсан.

Уг хуулийн дагуу Үндэсний баялгийн сан байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн нь ололттой. Гэсэн хэдий ч төрөлжсөн сангуудын чиг үүргийн давхцал, орлогын эх үүсвэрийн оновчгүй хуваарилалт, улс төрөөс хараат бус мэргэжлийн удирдлага засаглалын зарчмуудыг олон улсын сайн туршлагаас өөр өөр эрх баригчдын сонирхолд нийцүүлэн баталсан. Үүнээс үүдэлтэй сөрөг талууд нь өнгөрсөн ганцхан жилийн дотор илт мэдрэгдэж, ажиглагдаж байна.

Тухайлбал, Үндэсний баялгийн сангийн хөгжлийн сан нь улсын төсвийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл, Хөгжлийн банк зэрэг одоогийн механизмуудтай давхацсан тодорхой бус чиг үүрэгтэйгээр хуульчлагдсан байна. Үүний улмаас тус сан одоо хүртэл байгуулагдаагүй бөгөөд цаашид үр дүнтэйгээр ажиллах эсэх нь тодорхойгүй байна. Уг санд зөвхөн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд давсан орлогын 50 хувийг төвлөрүүлэхээр заасан нь төсвийн зардал ихээр тэлж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ унаж буй энэ цаг үед бодитойгоор хэрэгжих боломжгүй харагдаж байна. Ийм орлого бий болсон ч гэлээ тэр нь төсвийн тогтвортой байдлын санд хуримтлагдаж, хямралын үед төсвийн алдагдлыг нөхөн тэнцвэржүүлэлтийн зорилтоор ашиглагдах жишигтэй байна.

Үндэсний баялгийн сангийн өөр нэг төрөлжсөн сан болох хуримтлалын сан нь нийгмийн халамжийн чиг үүргийг хэрэгжүүлдэг Засгийн газрын тусгай сан болсон нь мөн олон улсын баялгийн сангуудын жишгээс зөрж байна. Эдгээрээс үзэхэд дээрх 2 сан үнэн хэрэгтээ Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан төсвийн дагуу зарцуулагдах ёстой орлогыг төсвөөс гадуур Засгийн газар дур мэдэн зарцуулах боломжтой эх үүсвэр болон хувирчээ. Энэ нь Үндэсний баялгийн сангийн тухай хуульд сангуудын бүтэц, зарлага гаргах зориулалт, засаглалын тогтолцоог Засгийн газарт эрх өгөх байдлаар тааруухан хуульчилсантай холбоотой байна. Үндэсний баялгийн сангийн хамгийн том хэсэг болох ирээдүй өв санд хуримтлагдаж байгалийн баялгийн өгөөжийг хойч үедээ өв болгон үлдээх ёстой орлогоос өнөөгийн Засгийн газар сүүлийн 2 жил дамнан зарцууллаа.

Уг санд орох ёстой АМНАТ-ийн орлого 65 хувийг Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар дамжуулан 2024 онд 20 хувь,

2025 онд 40 хувь болгож бууруулсан. Ингэснээр 3 орчим их наяд төгрөгийн ирээдүйн хуримтлалыг Засгийн газрын сонгуулийн амлалтад зориулжээ гэхэд хилсдэхгүй байна.

2.Үндэсний баялгийн санд улс төрөөс хараат бус мэргэжлийн хөрөнгө оруулалтын менежмент дутагдаж байгаа тухай.

Олон улсын баялгийн сангуудын алтан стандарт болох Сантьягогийн зарчимд зааснаар Баялгийн сан амжилттай ажиллах гол шалгуур нь улс төрөөс ангид байдал, мэргэжлийн хөрөнгийн удирдлага, хараат бус бүтэц юм. Эдгээр нь Монгол Улсад үндэсний баялгийн санд хангагдаагүй байгаагаас байгалийн баялгийн орлого, төсвийн орлуулга, улс төрийн сэдэлтэй популист амлалтуудад зориулагдаж бодит үр өгөөжгүй болдог. Өмнөх алдаа дахин давтагдах эрсдэлтэй байна. Зарим баримтаар тодотгоё. 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн өмнө хуримтлалын сангаас иргэдийг орон сууцжуулах боллоо хэмээн сурталчилсан. Улмаар тус сангийн 2024 оны орлого болох 480 тэрбум төгрөгийг ипотекийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт зарцуулсан бол 2025 онд мөн 500 гаруй тэрбум төгрөгийн орлогыг бүхэлд нь ипотекийн зээлд зарцуулахаар төлөвлөжээ.

Хуримтлалын сан нь иргэн бүрийн нэрийн дансанд хуваарилагдаж өсөж, боловсрол, эрүүл мэнд, орон сууцын зориулалтаар авч ашиглах зориулалттай. Гэтэл 6 хувийн хүүтэй ипотекийн зээлд сангийн хөрөнгийг зарцуулснаар хуульд заасан бодлогын хүүгээс багагүй хувиар өсөж байх шаардлага хангагдахааргүй байна. Иймэрхүү үндэсний баялгийн сангийн хөрөнгийг Засгийн газрын халамжийн шинжтэй төсөлд ашиглаж байгаа нь хуримтлалыг дотоод эдийн засгийн хямрал эрсдэлээс хамгаалах хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх боломжгүй болгож байна. Энэ янзаар үргэлжилбэл иргэн бүрийн нэрийн данс дахь мөнгө нь бодитойгоор авч ашиглах гэхээр бодитой байдаггүй шилний цаадах чихэр шиг болж болзошгүй байна. Ирээдүйн өв сангийн үлдэгдэл болох 1,2 тэрбум орчим ам.долларыг гадаад зах зээл дээр өндөр зэрэглэлтэй хувьцаа бонд зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд оруулж өсгөж үржүүлэх ёстой. Гэтэл төрийн санд олон жил байлгасны эцэст өнгөрсөн сараас Монголбанкны гадаадын төв банк дахь дансанд байршуулжээ.

Мөн 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр бөөндөн баталсан хуулиудын дотор Ирээдүй өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар тус сангийн хөрөнгө оруулалтын мандатыг батлах менежмент хэрэгжүүлэх корпорацыг байгуулах, түүний Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийг гэрээ байгуулах нэрээр томилох бүх эрх мэдлийг Ерөнхий сайдад олгосон нь сангийн хөрөнгийн удирдлага үр ашиггүй байх, төрийн байгууллага, албан тушаалтнаас хэт хараат байх нөхцөл байдал руу оруулсан байна.

Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн болон үйл ажиллагааны удирдлагыг Төв банк, Засгийн газрын холбогдох яаманд хэрэгжүүлэхээр хуульд заасан. Цаашид улс .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Минут нэмээд өгчихье. Намын бүлгүүдэд хувааж өгөөд 6 минутаар ярьж байгаа шүү. Тийм учраас дараа дараагийн хүмүүс анхаараарай. Индрийн микрофоныг өгье.

Х.Тэмүүжин: Үндэсний баялгийн сантай холбогдуулан хийж буй дүгнэлтээс гадна төгсгөлд нь нэмж дурдахад энэ удаагийн үндэсний баялгийн талаарх болон өмнөх олон удаагийн Ерөнхий сайдын мэдээлэл нь олон нийт, хууль тогтоогчдын мэдэхийг хүссэн авах шаардлагатай мэдээллийг агуулаагүй, зөвхөн Засгийн газрын пропаганд хийхийг хүссэн мэдээллээр хязгаарлагдаж байна. Үүний цаана төрийн эрх барих дээд байгууллага болон гүйцэтгэх засаглалын хоорондын харилцааны том зарчмууд бүдгэрч байна. Цаашид энэхүү парламентын дэгийг парламентын ардчилал хөгжсөн улсуудын жишигт нийцүүлж Ерөнхий сайдын мэдээллийн цаг биш Улсын Их Хурлын асуулгын цаг болгон өөрчлөх шаардлагатай байгааг Ардчилсан намын бүлэг үзэж байна.

Өөрөөр хэлбэл Ерөнхий сайд өөрийн хүссэн сэдвээр биш иргэд, хууль тогтоогчдын асуусан хүрээнд өмнөөсөө хэн нэгэн сайдыг илгээх биш заавал биеэр ирж хэдэн хуудас цаас унших биш үзэл бодлоо уралдуулан мэтгэлцдэг байх дэгийг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүнд баярлалаа. Одоо Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг гишүүн үг хэлнэ. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Их Хурлын эрхэм гишүүд, Ерөнхий сайд аа,

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөлөөс дараах дүгнэлтийг гаргаж байна.

Үндэсний баялгийн сангийн хуримтлалын сангийн үйл ажиллагаа амжилттай ажиллаж байгаа тухайд мөн Ирээдүйн өв сангийн хөрөнгийг олон улсын санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааг зохион байгуулж эхэлсэн талаарх мэдээллийг сонслоо.

Гэхдээ энэ нь өөрөө удирдан зохион байгуулах ажиллагаа явж байгаа талаар мэдээлэл байх боловч бид асуулга асуух эрхгүй байгаа учраас үг хэлэх хүрээнд тодруулах маш олон асуултууд байна гэдгийг бас дурдмаар байна. Мөн түүнчлэн Ерөнхий сайдаас гаргаж байгаа мэдээлэлд тодорхойлон жишээлэх юм бол олон улсын санхүүгийн байгууллагад төвлөрүүлээд байгаа Ирээдүйн өв сангийн хөрөнгөөс төвлөрүүлсэн хөрөнгийг ямар өгөөжтэйгөөр байршуулсан юм. Ямар хөрөнгийн хэрэгсэлд, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулсан юм гэдэг талаар жишээлбэл нарийвчилсан мэдээлэл байхгүй байгаа учраас энэ талаар бас нэмэлт дүгнэлт хийхэд бас боломжгүй байгаад байна.

Мөн түүнчлэн хуримтлалын нэрийн данстай болж байгаа хэдий боловч бид энэ мэдээллээс харахад хуримтлалын сангийнхаа хөрөнгийн зарцуулалт талдаа хуулийнхаа өөрийнх нь зорилгыг умартаад байна уу даа гэж хэлмээр санагдаж байна.

Өөрөө хэлэх юм бол хуримтлалын санд хуримтлагдсан 480 тэрбум төгрөгийг орон сууцын хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн эх үүсвэрт хөрөнгө оруулсан гэж байна. Тэгвэл энэ хөрөнгө оруулалтын өгөөж нь хэд юм бэ. Энэ хуримтлалын сангийн 480 тэрбум төгрөгт сарын, жилийн хэдэн хувийн өгөөжтэйгөөр байршуулсан бэ гэдэг мэдээлэл бид нарт ирсэнгүй. Танилцуулагдсангүй.

Тэгвэл буцаан нэгтгэсэн дүнгээр нь харахад 2024 оны хүүгийн орлого 4,9 тэрбум гэдэг бол нийт хөрөнгийнхөө 1 хувьтай тэнцүү байна. Энэ нь өөрөө хуримтлалын сангийн хөрөнгийг хэрхэн өгөөжтэй байршуулах талаар хуулийнхаа зохицуулалтыг зөрчөөд явж байгаа мэт энэ ойлголтыг төрүүлж байна.

Тийм учраас энэ 4,9 тэрбум төгрөгийн хүү чинь өөрөө хэдэн сарын хугацаатай ямар хэмжээтэй хөрөнгөөс бодогдсон хүү вэ гэдгийг бидэнд мэдээлэлдээ өгсөн бол илүү ойлгомжтой болох байлаа гэдгийг хэлмээр байна.

Мөн түүнчлэн Үндэсний хуримтлалын сангийн хөрөнгийг хэн удирдаж байгаа талаар, хэрхэн удирдаж байгаа талаар мэдээллийг бид авах хүсэлтэй байна. Өөрөөр хэлбэл Чингис хаан Үндэсний баялгийн сан гэж нэрлэсэн. Гэтэл шилэн дансны мэдээлэл дээр Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК буюу төрийн өмчит ХХК-ийн хэлбэрээр байгуулагдсан харагдаж байгаа. Энэ дээр шилэн дансны мэдээлэл дээр бол огт мэдээлэл байхгүйгээс гадна тухайн хуримтлалын санг ХХК хэлбэрээр удирдан зохион байгуулж явах нь хэр зөв зүйтэй вэ гэдэг асуудал урган гарч ирж байна. Энэ талаар мөн мэдээлэл авах хүсэлтэй байна. Энэ талаар мөн асуулга явуулах шаардлагатай байна гэж үзэж байна.

Энэ бүхэн дээр үндэслээд хэлэхэд Ардчилсан намын бүлгийн саналтай мөн санал нэгдэж байгаа зүйл гэх юм бол хуримтлалын санг төрийн байдаг л нэг сан шиг болгомооргүй байна. Өөрөөр хэлбэл төрийн хуримтлалын сан иргэн бүрийн нэр дээр хуримтлагдаж байгаа мөнгө. Энэ өөрөө хуримтлалын сангийн зорилго юу вэ. Өгөөжтэй байх ёстой. Гэтэл Засгийн газар өөрөө удирдах замаар тэр өгөөжөөс үл хамаараад, Засгийн газрын хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх бас нэг карма болж ашиглах юм бол энэ хуримтлалын сан гэж байгаагийн зорилго өөрөө алдагдах гээд байна. Тэгэхээр энэ талаасаа бид энэ хуулийнхаа зарчмыг барьж ажиллах тал дээр Засгийн газрыг үйл ажиллагааныхаа хөтөлбөр дээр эргэж хараач гэдэг энэ саналыг хэлмээр байна.

Мөн түүнчлэн цаашид бид одоо энэ хуримтлалын сан гэдгийг энэ маягаараа удирдан зохион байгуулаад явах юм бол цаашид бид нар энэ хуримтлалын санг илүү тэтгэврийн сан чиглэл рүүгээ оруулах, энэ хуримтлалын сангийн хөрөнгийг тэтгэврийн шинэтгэлээ хийхэд зарцуулах юм бол энэ нь иргэд болгон дээр очих өгөөжийг илүү тодорхой болгох, тэгш шударга хуваарилалт дээр илүү ойлгомжтой болоход илүү нөлөөтэй юм. Ийм учраас энэ хуримтлалын сангийн мөнгөний удирдлага зохион байгуулалтын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг авмаар байна. Нөгөө талаасаа хуульд заасан зорилго зорилтынхоо хүрээнд зарцуулалтыг хийхийг Засгийн газраас мөн хүсмээр байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Гончигдоржийн Уянгахишиг гишүүнд баярлалаа. Одоо Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн үг хэлнэ. Батын Батбаатар гишүүн урд нь үг хэлэх ёстой байсан байхгүй байна. Индэрт. Дэгтэй.

Д.Пүрэвдаваа: Эрхэм гишүүд, эрхэм дарга нартаа энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхий сайдынхаа үгийг анхааралтай сонслоо. Танин мэдэхүйн шинжтэй, түүхийн шинжтэй, үр дүнгийн шинжтэй мэдээлэл өгсөнд талархаж байгаагаа илэрхийлье.

Мөн Дэгийн тухай хуулиараа Ерөнхий сайддаа хандаж үг хэлэх боломж олдсонд бас талархууштай байгаагаа илэрхийлэх нь зүйтэй байх.

1 дүгээрт Үндэсний баялгийн сан болон энэ хуримтлалын сангийн ил тод байдлын асуудлыг хөндмөөр байна. Ерөнхий сайд нь заавал мэдээлэл хийсний дараагаар мэдээллээ олж авдаг, явц нь ямар байгааг мэддэг энэ асуудлыг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Ялангуяа уул уурхайн баялгийн эх үүсвэрээс орж буй орлогын бүртгэл, тайлагнал, сан руу орсон мөнгөн хөрөнгө, түүний хөрөнгийн ашиглалт, бодит үр дүнд хүрсэн талаарх цаг үеийн мэдээ холбогдох хуулиудаараа байнгын ил байх ёстой. Тэр нь шилэн дансны сайт болон бусад мэдээлэл авах боломжийн тэр сувгууд дээр бол байхгүй байгаа нь бас иргэдийн олон нийтийн итгэл буурах хандлагатай байна шүү гэж бас хэлмээр байна.

Дараагийн нэг зүйл гэх юм бол энэ Үндэсний баялгийн санд бол АМНАТ-өөр дамжуулаад ингээд мөнгөн хөрөнгө цугларч байгаа юм. Тэгээд энэ орхигдож байгаа асуудал нь тухайн орон нутаг орхигдоод байна. Ялангуяа орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг бүрдүүлэхдээ хүн ам болон газар нутгийн хэмжээг тооцож үзэж байгаад жил болгон төсвийнхөө хөрөнгө оруулалтын 5-10 хувийг л байршуулаад байгаа юм. Энэ нь бол аймаг, орон нутагт ялангуяа уул уурхайгаар баян, уул уурхайн үйл ажиллагаа явдаг аймаг орон нутгийн эрх ашиг, иргэдийн болоод байгаль орчны эрх ашиг ноцтойгоор зөрчигдөж байна гэж харж байгаа.

Тийм учраас төрөлжсөн сангийн нэр төрөл буюу Ирээдүй өв сан, хуримтлалын сан, хөгжлийн сан гэсэн 3 сангаас бүрдэж байгаа энэ Үндэсний баялгийн сан дээр орон нутгийн хөгжлийн сангийн тодорхой хувийг энэ сангаас олгох нь зүйтэй юм гэдэг байр суурийг илэрхийлж байна.

2 дугаарт Ашигт малтмалын нөөц ашигласны татвар бид нар 5 хувь авдаг. Нийт борлуулалтын орлогоос. Оюутолгой компанийн жилийн борлуулалтын орлого ойролцоогоор 5 тэрбум доллар байна уу. Тэгэнгүүт түүний бид нар 2009 онд байгуулсан гэрээгээрээ ердөөсөө 5 хувь дээр тогтворжуулаад барьчихсан. Эрдэнэт болон Монгол Улсын бусад зэсийн баяжмал олборлож байгаа компаниуд 5 дээр нэмэх нь 11 хувийн татвар авдаг. Өнөөдөр зэсийн үнэ 9400 гарчихсан. 9 мянган доллароос даваад гарчихсан. Тэгэхээр 11 хувийн авч болох орлогоо бид нар алдаад байна. Энэ дээр Засгийн газар ажиллаач. Зоригтой, хурдтай хөгжил гээд 3 нам эвссэн. 11 хувийн Оюутолгой компаниас авах энэ асуудлаа ярих цаг нь болсон байх гэж хэлмээр байна.

Дээрээс нь яг өнөөгийн энэ цаг мөчид алтны үнэ түүхэндээ дээд цэгтээ хүрч байгаа юм. Нэг килограмм алт 360 сая төгрөг болсон. Өнөөдөр манай доллар маань 3600 руу 100 мянган доллар 1 килограмм алт болчихоод байна. Тэгэхээр зэрэг манай нүүрсний үнэ уначихсан. Энэ баялгийн сандаа төвлөрүүлж болох өөр эх үүсвэр байгаа учраас Алт хөтөлбөрийн асуудлаар Засгийн газар хурдтай зориглооч гэж бас хэлмээр байна. Тэгэхгүй сая ингээд Ардчилсан нам, ХҮН намынхан маань бас шүүмжлэлтэй хандаж байх шиг. Нэгэнтээ гэрээгээ ил болгоод бид нар хамтарсан засаг байгуулаад явж байгаа юм чинь та бүхэн маань бол энэ алт хөтөлбөрийг бас энэ орлого талдаа нэмэгдүүлэх тал дээр ажиллах нь зүйтэй байх гэж хэлье.

Тэгээд хамгийн сүүлд ил тод байдал бид нар авторитаар гэдэг тэр дэглэм рүү маш ойртоод дөхчихсөн байгаа учраас энэ баялгийн сангийнхаа явцын хяналт дээр хөндлөнгийн байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийг оролцуулах энэ хаалга үүдийг нээж өгөөч ээ гэж Ерөнхий сайддаа хандан хэлмээр байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүнд баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан Ерөнхий сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Миний нэр орохгүй байх юм. Орчихлоо.

Ингээд баялгийн сан бол анхных нь биш ээ. Ер нь бол баялгийн сан 5 удаа байгуулагдсан. Өөрөөр хэлбэл хамгийн анхных нь бол Монгол Улсыг хөгжүүлэх сан гэж 2007 онд байгуулагдсан. Тэгээд энэ байгуулагдаад анх гараа дээрээ л бараг дампуурсан. Яагаад гэвэл 2008 оны сонгуулиар энэ улс төрийн сонгуульд мөнгө амлах нь бол амжилтад хүрэх юм байна гэж үзээд АН 1 сая төгрөг, МАХН 1,5 сая төгрөг тараагаад эндээс эхлээд явсан байгаа.

Дараагийнх нь бол Хүний хөгжлийн сан гэж байгуулагдсан 2009 онд байгуулагдаад, дандаа зарлага нь орлогоосоо давдаг учраас энэ сан амжилттай ажиллахгүй явсаар байгаад 10 гаруй жил яваад ингээд Төсвийн тогтворжуулалтын сангийн тухай хуулиар солигдож байхгүй болсон байгаа.

Төсвийн тогтворжуулалтын сангийн тухай хууль бол 2010 оноос хуулийн дагуу 2010 оноос байгуулагдаад, нийтдээ 13 удаа нэмэлт, өөрчлөлт ороод, үндсэн зорилгоосоо тэс хазайж явсан учраас энэ Тогтворжуулалтын сан бол үр дүнгүй байгаа.

4 дэх сан бол Ирээдүй өв сан байгаа. 2016 онд байгуулагдсан. 2030 он хүртэл энд хуримтлагдсан мөнгийг ерөөсөө огт хүрэх ёсгүй байсан. Гэвч үе үеийн Засгийн газар эндээсээ авч, төсвийн цоорхойгоо нөхдөг. Энэ байдлаасаа болоод Ирээдүйн өв сан нь өнөөдөр үйл ажиллагаа нь доголдоод явж байгаа юм.

Өнөөдөр ингээд Баялгийн сангийн тухай хууль батлагдаж байна. Бас тодорхой хэмжээгээр энэ хамтарсан засгийн үед энэ баялгийн сангийн үйл ажиллагааг илүү идэвхжүүлэх ийм оролдлого, зүтгэл байна. Гэвч бас яг энэ дээрээ бас тодорхой хэмжээний санал хэлж бас анхаарах зүйлүүд байна. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд явагдсан тэр 4 сангийн асуудал дээр бол хамгийн гол нь сангийн эх үүсвэрийг нь дандаа тийм төсөв 2 буюу төсвийн цоорхойг нөхөх, дээрээс нь төсөвгүйгээр тэр сангийн зарцуулалтаар бусад төсөв 2 болгож ашиглах ийм явдал хэрээс хэтэрсэн байсан.

Дээрээс нь сангууд дээр бол сангийн засаглал байхгүй, мэргэжлийн баг байхгүй байгаагаас болж энэ сангууд чанартай үйл ажиллагаа явж чадаагүй.

3 дугаарт нь бол сангийн үйл ажиллагаанд бол хяналт шалгалт маш сул байсан. Үүнээс болж доголдсон байгаа.

4 дүгээрт нь сангийн хөрөнгийг өсгөх, арвижуулах ийм эрх зүйн орчин байхгүй учраас ерөөсөө өсдөггүй ийм нөхцөл байдалтай байсан.

5 дугаарт нь улс төрийн шийдвэрээр сангийн хөрөнгийг дураараа зарцуулах ийм нөхцөл байдал маш их байсан. Тийм учраас энэ баялгийн сан дээрээ илүү гадаад менежменттэй, дээрээс нь маш зөв зүйлд зарцуулдаг шууд бэлэн мөнгө тараагаад ард иргэдэд өгчихдөг биш ийм сан байгаасай гэж бас хүсэж байна. Тэгэхээр ер нь бол Монгол Улс сүүлийн 10 жилийн дотор 100 тэрбум долларын баялгийг экспортолсон. Гэвч өнөөдрийн байдлаар 37 сая 115 сая долларын өртэй

байна. 1 хүнд 40 сая төгрөгийн өртэй болсон ийм л үзүүлэлттэй байна. Тийм учраас энэ баялгийн сангийнхаа менежментийг илүү зөв болгох, тэр орлогыг арвижуулах тэр тал дээр илүү сайн ажиллаасай гэж Засгийн газраас хүсэж байна.

Ингээд дараагийн хүн Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууж, үг хэлье.

Да.Цогтбаатар: Би үг хэлнэ. Ерөнхий сайдад баярлалаа. Мөн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд баярлалаа. Мэдээлэл өгч байгаад. Бид нар Үндэсний баялгийн сан гээд зөвхөн уул уурхайн баялгаас орж ирэх орлого, тэдгээрт удирдлага, менежмент хийх талаар ярилцаж явж байгаа. Тэгээд сая манай бүлгийн байр суурийг Тэмүүжин гишүүн илэрхийлсэн. Энэхүү байр суурьтай бас санал нэгтэй байгаа.

Тэгээд дээрээс нь нэмж хэлэх бас хэдэн асуудлууд байгаа. Одоо жишээлэхэд Засгийн газраас оруулж ирж байгаа онгоцны түлшийг хувийн хэвшил хийгээд өнөөдрийг болтол явчихсан ажлыг төр өөр дээрээ дахиад хувийн ийм онгоцны түлш зардаг компани байгуулаад, тэрийгээ хувийн хэвшилтэйгээ өрсөлдөж борлуулах юм шиг харагдаж байгаа ийм үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгээд энийг жишээлэхэд хувийн хэвшилдээ үнийнх нь дээд хязгаарыг тогтоож өгөөд, үүнээс дээш гаргахгүйгээр та нар хийж чадна гэвэл төр заавал ийшээ орж онгоцны түлш авчирч зарах шаардлагагүй гэдэг дээр бас бодож үзээд, дахиж оруулж ирвэл бас зүгээр байна гэж ийм санал хэлэх гэж байгаа юм.

2 дахь санал нь одоо бид нар хувийн хэвшлээ дэмжинэ гээд бараг л сүүлийн 30 жил ярьж, хувийн хэвшлээ 30 жил дарамталсан. Тэгтэл бас нэг жишээ нь Монголбанкны өөдөөс хараад сууж байгаа энэ Ард кино театр гэдэг барилга нураад, хувийн хэвшил хөрөнгө оруулалт татаж ирээд, шинээр бүтээн байгуулалт хийгээд хөрөнгө оруулалт татаад ирье, ажлын байр нэмэгдүүлье гэхээр тэрийг нураагаад, бүр балгас болгоод хэн ч ашиглаж чадахааргүй, хувийн хэвшил нь ч ашиглаж чаддаггүй, төр нь ч ашиглаж чаддаггүй ийм хотынхоо төвд нурсан байшинтай, тэрийг нь тойруулж нэг татсан хашаатай ийм л нийслэл болоод байна. Тэгээд энэ талбай тойроод харах юм бол бас ийм дүр зураг байгаа. Энэ Ардчилсан намын нэр дээр яригддаг байсан СТӨ-ний хүзүүвч хүртэл одоогийн байдлаараа гацчихсан байдалтай байгаа. Тэгэхээр бусад д хувийн хэвشلүүд рүүгээ бас анхаарал хандуулаад, хувийн хэвшил нь өөрсдөө хөрөнгө оруулалт олж ирээд зөвхөн уул уурхай гэхгүйгээр хөрөнгө оруулалт оруулж ирээд үйл ажиллагаагаа явуулъя гэж байгаа бол энэ дээр илүү нээлттэй бодлого барьж, тэдгээрийгээ дэмжих шаардлагатай байна гэж санал хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Зарчмын хувьд бол энэ бид нарын нөгөө олон жил удтал ярьсан шударга ёсыг тогтоох, баялгийн тэгш хуваарилалт, цөөн хүмүүст хамааралтай байгаа далд эдийн засгийг ил гаргаж ирэх, эдийн засгаа либералчлах гээд олон зүйл энэ баялгийн сантай шууд холбоотой болчихоод байгаа.

Асуултуудаа асуухаасаа өмнө 2 асуулт байгаа. Тэрнээс өмнө нэг жижигхэн мэдээллийн чанартай ч юм уу, зүгээр асуултын суурь болгож хэлэхэд 1960-аад оны сүүлээр жишээлбэл тэр Норвегийн баялаг илрээд 30 гаруй жил 1997 он хүртэл энэ дээр судалгаа явуулж байгаад Норвегийн баялгийн санг байгуулж, 29 жилийн өмнө энэ сан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тэгээд 2012 онд тус санг бас судлах зорилгоор очиж байхад улсын төсөв, баялгийн сангийнх нь харьцаа. Жишээлбэл

баялгийн сангийнх нь хэмжээний 3,5 орчим хувьтай тухайн жилийнх нь улсын төсөвт тэнцэж байсан. 2022 онд түүхэндээ хамгийн дээд хувьцааны ханшаас үүдэлтэй алдагдал буюу 147 тэрбум долларын хохирол амсаад явж байсан. Гэхдээ буцаагаад нөхөгдөөд 3 жилийн хугацаанд нөхөгдөөд явчхаж байгаа юм. Энд ямар зүй тогтол харагдаж байна гэхээрээ Норвегчууд бас их ухаалаг.

1 дүгээрт энэ гадаад улс дахь үл хөдлөх хөрөнгүүдийг худалдаж авч, түүнийг түрээслэх байдлаар нөгөө мөнгөө хөдөлгөөнд оруулж, ашигтай салбарууд руу хөрөнгө оруулалт хийсэн.

2 дугаарт тодорхой томоохон баталгаатай байж болохуйц газруудын хувьцааг авна. Гэхдээ хувьцааг 50 дээр нэмэх 1 ч юм уу мажорити хувьцаа авахгүйгээр үр өгөөжийг нь ингээд тооцдог. Гэхдээ үүний цаана юу ажиллаж байдаг вэ гэхээрээ маш олон судлаачид маш олон мэргэжилтнүүд юунд хөрөнгө оруулалт хийвэл зөв бэ гэдэг дээр байнга ангуучилж байдаг. Энэ нь ингээд шийдвэр гаргалт буюу энэ баялгийн сангаа улам арвитгахтай шууд холбоотой бодлогыг тэнд байнга статистик анализ хийгээд бодож байдаг. Тэгэхээр манай улсын хувьд гэх юм бол Ерөнхий сайдын мэдээллээс харахад 2030 он гэхэд бол 4-5 тэрбум ам.доллар-т хүрнэ гэж тооцож байгаа. Тэгэхээр бид нар жишээлбэл Англи, Франц, Люксембург Улсын төв банканд одоогийн байгаа мөнгөө байршуулчихсан. Хадгалуулчихсан гэж байгаа. Тэгэхээр зарчмын хувьд одоо бид нар энэ тодорхой орж ирж байгаа мөнгийг аль нэгэн улсын банканд байршуулах гэхээсээ илүүтэйгээр тодорхой хэмжээнд Норвег маягийн байдлаар хөрөнгийн зах зээл энэ смарт технологи ч гэдэг юм уу энэ зүйл рүү хөрөнгө оруулах боломж бололцоог судалсан уу. Судалсан бол энэ ер нь ямар боломжтой байна вэ гэдэг асуулт 1 дүгээр асуулт нь байгаад байгаа юм.

2 дугаарт нь гэх юм аль болох бид нар саяын бас энэ намын бүлгүүдийн илтгэлд.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Эхлээд Ерөнхий сайд хариулчихъя. Тэрний дараа нэмэлт.

Л.Оюун-Эрдэнэ: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Дэлхий дээр уул уурхайн баялгаас бүрддэг янз бүрийн л ийм баялгийн сангууд байгаа юм. 100 гаруй баялгийн сан. Зарим нь бол Норвегийн сантай төстэй буюу бүрдсэн орлогоо арвижуулах байдлаар асуудлаа шийддэг ийм сангууд байгаа. Зарим нь бол өнөөдөр байгаа дэд бүтэц болон бусад асуудлуудаа шийдэхэд баялгийн сан нь зохистой менежмент хийдэг ийм сангууд байгаа. Казакстан эд нар бол бас нэг ийм томоохон асуудлуудаа шийдвэрлэдэг. Зарим нь бол энийг илүү иргэдийн эрүүл мэнд, боловсрол, орон сууц зэрэг ийм хөтөлбөрт зарцуулдаг хадгаламжийн сан байгаа. Тухайн улс бүхэн л өөр өөрийн үндэсний онцлогт тохирсон ийм менежментийн зохист хэлбэрийг олоод уул уурхайн төслүүдээ олон нийтийн дэмжлэгтэй болгох арга хэлбэрийг л ер нь баялгийн сан гэж үздэг юм байна лээ.

Манай Улсын хувьд яг судлаад үзэхээр бид нар Норвегийн сан дээр бас очиж үзэж байсан. Манай Улсын гол асуудал бол ирээдүйдээ хадгалахыг бол зөв гэдэг. Гэхдээ өнөөдрийнхөө асуудлыг шийдмээр байна. Тийм учраас өнөөдрийн асуудал шийдэгдэхгүй байгаа учраас бол уул уурхайн төслүүд бол өгөөж багатай байна гэдэг ийм шүүмжлэл байдаг. Дээрээс нь шууд иргэдийн дансанд хуримтлагдахгүй учраас захиран зарцуулах болон засаглалын хувьд хяналт тавих боломжгүй байна гэдэг ийм асуудлууд яригддаг. Тэгэхээр энэ Үндэсний баялгийн сан буюу яг 1 жилийн өмнө батлагдсан энэ хууль бол энэ 3 зүйлийг Үндсэн хуульд заасны дагуу

гурвуулааг нь нэгдсэн удирдлагаар хангах ийм л эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болно. Тэгээд яах вэ, мэдээж 1 жил гэдэг бол дүгнэлт хийх хугацаа мөн. Гэхдээ энэ бол бас 1 л жил юм. Одоо бид нарын хувьд ярилцаад, ирээдүйд яаж олон нийтийн дэмжлэгтэй уул уурхайн салбарыг олон нийтийн дэмжлэгтэй уул уурхайн хөрөнгө оруулалтыг бий болгох вэ гэдэг бол Үндэсний баялгийн сангийн хамгийн гол концепц байна. Тэгээд үүнийг бид нар ойлголтоо нэгтгэж байж бас хөрөнгө оруулагчид болон компаниудтай энэ нөгөө 34 хувьтай холбоотой бас энэ хэлэлцээрийг хийхгүй бол ойлголт өөр өөр байгаа учраас энэ асуудлыг оруулж ирэхлээр бас илүү тийм улс төрийн асуудал нь яг хөрөнгө оруулалт болон бусад асуудлаасаа Үндэсний баялгийн сангийнхаа асуудлаас өмнө гарчих гээд байгаа учраас бас өнөөдөр энэ үндэсний баялгийн сангийн асуудлыг мэдээлэл өгөөд ярилцах нь бол зүйтэй юм гэж үзэж оруулж ирж байгаа. Тэгэхээр Эрдэнэболд гишүүний асуултад хариулахад бол ийм байна.

Мэдээж Ирээдүйн өв сантай холбоотой асуудлын менежментийг одоо бол эрсдэлийн хамгийн бага байх байдлаар Монголбанк банкны хадгаламж хийх нь бол зүйтэй гэж үзсэн байгаа. Энэ эрх зүйн орчноор бол яг өөрийн чинь хэлдгээр цахим компаниудын хувьцаа авах ч юм уу эсвэл хөрөнгө оруулалт хийх ч юм уу хамгийн эрсдэл багатай газар хөрөнгө оруулалт хийх боломж нь бол эрх зүйн хувьд нээгдсэн байгаа. Зүгээр энийг ярилцаад 3 сан нэгдээд Чингис хаан сан гээд нэрлэгдээд ингээд явж байгаа. Энэ зүйлүүд яригдаад цаашдаа явах, хараат бус гаднын удирдлагаар удирдуулах нь зүйтэй юм гэдэг дээр Эрдэнэс Монголд чиглэл өгчихсөн. Энэ асуудлууд яригдаад зарлагдаад явж байгаа ийм цаг үе байна.

Б.Пүрэвдорж: Энэ дэгээр бол 3 минутаар л асуух юм байна. Нэмж асуухгүй юм байна. Тэгэхдээ би танд асуулгана гээд хэлчихсэн учраас 1 минут нэмээд өгчихье.

С.Эрдэнэболд: Пүрэвдорж даргад баярлалаа. Ер нь бид нар удтал ярьсан энэ хулгай, дээрэм, хууль бус хөрөнгийн асуудал, дээрээс нь энэ улс төржилт, мөнгө, далд эдийн засаг, баян ядуугийн ялгаа, үнэт зүйлсийн доройтол гээд энэ бүх зүйлийг мэдээж 1 алхмаар бүгдийг шийдэж чадахгүй ч гэсэн хамгийн эхний алхам бол энэ бүх юмыг хуулийн дагуу болгох, ил тод болгох, нээлттэй болгох, inclusive economics буюу хүртээмжтэй эдийн засаг руугаа алхам хийх ёстой гэж үзэж байгаа. Энэ утгаараа бол ирээдүйн өв сан буюу баялгийн сантай холбоотой асуудлыг би бол итгэл үнэмшилтэйгээр дэмжиж байгаа.

Гэхдээ яг менежментийн хувьд, эрсдэлийн хувьд, ил тод байдлын хувьд, олон нийтийн хяналтын хувьд, мэргэжлийн байдлын хувьд гээд олон талаас нь бас энэ хэлэлцүүлгийн явцад бид нар цаашдаа бас энэ дээр чамбай хандаж, аль болохоор улс төржихгүйгээр энэ асуудалд хандаасай гэж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ баялгийн сантай холбоотойгоор төр ахиад л мөнгө хуримтлуулаад, тэгээд зарцуулалтыг нь бол төрөөс дахиад хийнэ гэж ярьж байгаа юм. Гэхдээ өнөөдөр бид нар 33 их наядыг зарцуулж байгаа засагтай байгаа. Тэгэхээр 1 зүйлийг харахаар бид нар дандаа ирээдүй цаг дээр л иргэдээ маш гоё болчихно. Ирээдүй цаг дээр бид нар асуудлуудыг нь шийдчих юм шиг ярьдаг. Тэгээд урин дулаан цаг ирчихээр бид нар ахиад утааны асуудлаа мартаад

хаяж байгаа юм шиг байна. Тэгээд энэ 7 хоногт бол бас зайлшгүй Ерөнхий сайдаас асуух зүйл гарч ирчхээд байна л даа.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албанаас болохоор хувийн компаниуд руу шингэрүүлсэн хийн түлшийг ирэх 2025-2026 онд ашиглаад яв гэдэг ийм чиглэл ч юм уу, албан бичиг бол ирээд яваад байгаа юм. Тэгээд ер нь бид нар энэ утааны тухай асуудлыг шийднэ гээд л бөөн үндэсний хороо байгуулаад л, хэлэлцээрүүд хийгээд яваад байсан. Тэгээд тэрнийхээ эцэст нь шингэрүүлсэн хийн түлшийг сонгосон юм уу Монгол улс өөрөө. Тэгээд энийг хэн ямар замаар, хэдэн төгрөгийн үнэтэйгээр нийлүүлж байгаа юм бэ. Энэ ямар байдлаар шийдлүүд нь гараагүй байхад ингэж шууд хувийн компаниуд руу хорооноосоо тийм шаардлагууд тавиад явж байх нь хэр зөв юм бэ. Иргэдийн хувьд болохоор ер нь саяхан л хэдэн хүн амь насаараа хохирлоо, хордлогод орж угаартсан хэдэн мянган хүн байгаа. Тэгэхээр энэ хүмүүс дээр бид нар ахиад Таван толгой шахмал түлшийг ашиглаад байж байх уу ирэх өвөл. Тэгэхээр хавар болоод ирэхээр энэ утааны асуудлаа орхичихдог. Тэгээд шийдэл нь ерөөсөө гараагүй, тал талд өөр өөр бодлогууд яваад байхаар чинь хувийн аж ахуйн нэгжүүд нь бол бизнес төлөвлөлтөө хийгээд явахад хүндрэлтэй. Иргэд нь энд бүр амь нас эрүүл мэндээрээ хүртэл хохироод явж байна. Тэгээд бид нар энэ ирээдүй цаг дээр баялгийн сангийн сангийн асуудлуудыг шийдээд ч байдаг юм уу, ирээдүйд энэ юмнууд шийдэгдэнэ гэж харах гэхээсээ илүү өнөөдөр байгаа цаг үе дээрээ урин дулаан цаг дээр ч гэсэн бид нар энэ утааны шийдлүүдээ маш тодорхой гаргаж ирэх ёстой гэж харж байна. Тэгэхээр Ерөнхий сайдын хувьд та 2025-2026 оны өвөл Монгол Улс ямар байдлаар энэ халаалтыг шийдэх юм бэ. Яаж явах юм бэ гэдэг дээр яг тодорхой хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгөх үү. Хэлэлцэж байгаа асуудалтайгаа холбогдуулаад асууна шүү дээ. Үндэсний баялгийн сангийн тухай асуудал хэлэлцэж байгаа.

Л.Оюун-Эрдэнэ: Яг дэгээр бол үндэсний баялгийн сантай холбоотой асуудал дээр л асуулт, хариулт яг энэ цаг дээр яригдах нь зүйтэй байх л даа. Шаардлагатай тохиолдолд илүү тэр дэлгэрэнгүй мэдээллийг хотын удирдлагууд болон мэргэжлийн хүмүүсийг нь байлгаж байгаад, бэлдэж байгаад ярих нь бол илүү зохистой байх. Зүгээр баялгийн сантай уялдуулаад ярихад яг л наад асуудлыг л Үндэсний баялгийн сан дээр бид нар шийдлээ гаргамаар байгаа юм. Ийм 2, 3 асуудлууд байна.

1 дүгээрт Монгол Улсын экспортын 90 хувь уул уурхай гэдэг. Тийм. Үнэн. Тэгэнгүүт уул уурхайн төслүүдийг өнөөдрийн байгаа асуудлуудаа шийдэхэд зарцуулмаар байна гэдэг. Энийг шийдэх нь зүйтэй. Гэтэл юу вэ гэхээр төсвөөр дамжуулж ийм асуудлыг шийдэх ёсгүй гэдэг. Ингээд төсөв алдагдалгүй батлах нь зүйтэй гээд баталчихсан. Тэгэхээр төсөв бол цаашдаа зөвхөн боловсрол, эрүүл мэнд, төрийн албан хаагчдын цалинтай холбоотой асуудлыг л шийддэг ийм хэв маяг руу явна гэсэн үг. Энэ ч зөв байх. Тэгвэл яаж шийдэх вэ гэдэг асуудал. Өөрөө агаарын бохирдол ярьж байна. Сая Тэмүүжин гишүүн болохоор ер нь ийм давхар төсөв яваад байна гэж байна. Тэгээд яг хаагуур нь явах вэ. Энийг бид нар ингээд их прагматик яримаар байгаа юм. Зүгээр мэдээж иргэдэд бид нар өөр өөрсдийнхөө бодлоор мэдээлэл өгчихдөг. Тэгээд яах вэ, гэхээр бид нар дунд нь ийм зэтгэрийн гацаа гэдэг шиг ингээд хөгжлөө гацаачих нэг ийм асуудал руу орчхож байгаа юм. Тийм учраас үндэсний баялгийн сангийн энэ концепц бол ирээдүй үедээ хадгалъя. Ирээдүй үедээ хадгалъя. Гэхдээ тэр нь бол АМНАТ-ийн 50 орчим хувь байг. Хөгжлийн сандаа зарцуулъя. Хөгжлийн сандаа зарцуулъя. Уул уурхай ашиглаж

байгаа орон нутаг түрүүлж хөгждөг байя гэдэг энэ асуудлыг нь л эрх зүйн хувьд бид нар ингээд хуульчилж тодорхой болгох нь зүйтэй юм гэж л үзээд байгаа юм л даа.

Иргэдийн нэрийн дансанд хуримтлал үүсгэе. Энэ нь харин зохих түвшиндээ ямар ямар байх вэ. 34 хувийн ноогдол ашиг нь хаанаа орох юм. АМНАТ нь хаанаа орох юм гэдэг энэ зарчмыг бид нар тогтохгүйгээр том том тоо яриад, уул уурхайн төслүүдийг хөдөлгөх нь зүйтэй гэж яриад, тэгээд л бид нар дахиад л ингээд л дороо хий эргэчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээрээ одоо бид нар энэ юуг ч гэсэн бас Их Хурлын гишүүд та бүхэн маань их нухацтай бодоорой гэж хүсэж байгаа юм.

Одоо уул уурхайн баялгаар бид нар дэд бүтцийн асуудлыг бол шийдэж болохгүй. Valeu exchange хийх нь бол буруу гээд ингээд шийдчих шиг амархан юм байхгүй. төсвөөр бас ийм асуудлыг шийдэж болохгүй. Зөвхөн BOT хэлбэрээр ч юм уу хувийн хэвшлээр шийдүүлнэ гээд. Гэтэл хувийн хэвшил ашигтай бизнест л орно. Хувийн хэвшил нийслэлийн дэд бүтцийг шийдвэрлэх тийм үүрэг хүлээхгүй. Тийм учраас энэ бүх зүйлүүдээ бид нар баялгийн сангаар дамжуулж бусад улстай адилхан хөгжлийн сандаа бид нар ямар зарчмаар хандаж асуудлуудаа шийдвэрлэх вэ. Ямар зарчмаар бид нар хадгаламж үүсгэх вэ. Ямар зарчмаар уул уурхайг ашиглуулж байгаа орон нутаг илүү давуу эрх эдэлж хөгжих вэ. Энэ зүйлийг нь бидний хувьд хамтдаа нээж өгөх нь л Үндэсний баялгийн сан.

Тийм учраас энэ дээр бид нар ойлголтоо нэгтгэх нь бол туйлын чухал юм. Энэ дотор агаарын бохирдолтой холбоотой, нийслэлтэй холбоотой олон асуудлууд баялгийг хэрхэн зөв зохистой ашиглах вэ гэдэг менежмент дээр л байгаа шүү дээ. Яагаад гэвэл экспортын 90 хувь уул уур уурхай юм чинь. Цаашдаа ч гэсэн мэдээж бид нар аялал жуулчлал, хөдөө аж ахуй, эрчим хүч гээд тэргүүлэх салбаруудыг гаргаж ирж болно. Гэхдээ цаг орно. Цаашдаа ч гэсэн ойрын 15-20 жил, 30 жил магадгүй уул уурхайн салбар Монгол Улсын тэргүүлэх салбар хэвээр л байх болно.

Тийм учраас олон нийтийн дэмжлэг авдаг, нийгмийн дэмжлэг авдаг, орон нутгийн дэмжлэг авдаг уул уурхайн хөрөнгө оруулалт, уул уурхайн салбарыг хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг бол Баялгийн сан. Энэ нь өөрөө юу вэ гэхээр нийгмийнхээ тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх ийм боломжит механизм руу явах ёстой л гэсэн үг. Өнөөдөр энэ механизм оновчлолтой биш байсан учраас л уул уурхайн салбарт бас тодорхой хэмжээнд нийгэм ийм хүлээн зөвшөөрөгдөх байдал өгөхгүй байгаад байгаа нь бас үүнтэй холбоотой гэж хариулъя.

Яагаад гэвэл би Баялгийн сангийн талаар л өнөөдөр ярих дэгийн ийм хуулийн хязгаартай учраас.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн. Тодруулж асуух дэг байхгүй.

Л.Мөнхбаясгалан: Говийн гишүүний хувиар асуух асуулт байна. Үндэсний баялгийн сан бол 2024 оны 4 сарын 19-ний өдөр хууль нь батлагдсан байдаг. Энэ хууль батлагдахаас 2 сарын өмнө Энержи Ресурс, Эм Си Эс компани өөрийн эзэмшдэг байсан манай Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт байдаг Баруун нарангийн уурхайг 88 сая доллароор зарсан байдаг. Энэ бол мэдээлэлд ойрхноо далимдуулж, амжиж зарсан. 2011 онд энэ Баруун нарангийн уурхай 980 сая доллароор үнэлэгдэж байсан байхгүй юу. Тэгээд Хятадын Жи Ай Ю гэдэг компанид зарсан логистикийн. Энэ компани нь Энержи ресурстэй 20 жилийн турш урт

хугацааны гэрээ байгуулчихсан байсан. Энэ компанийн түүх бол дандаа ингэж төрд өөрийнхөө төлөөллүүдийг суулгаж байгаад мэдээ мэдээллийг түрүүлж авсан байдлаар хөлждөг ийм л компани. Тэгэхээр би Ерөнхий сайд, Хууль зүйн сайд, Улсын Их Хурлын дарга гурвуулаа 1 танхимд суугаад, надад асуулт асуух боломж олдсон дээр нь 1 асуулт асууя.

Ухаа худгийг Энержи ресурс авсан нь Засгийн газрын тэмдэглэлээр хууль зөрчиж авсан байна гэж Засгийн газраас дүгнэлт гарсан. Тогтоолын төслийг өргөн барихаар болсон. Алтангэрэл сайд тогтоолын төслийг Улсын Их Хурлын дарга Амарбаясгаланд өргөн барьсан боловч одоо хүртэл авахгүй байгаа гэдгээр Алтангэрэл сайд мэдээлэл хийсэн. Улсын Их Хурлын дарга аа, яагаад авахгүй байгаа юм бэ.

Ерөнхий сайд, Алтангэрэл сайд 2 хариулаач. Үнэхээр та нар тийм бүрдүүлэлт дутуу юм хийгээд, хууль бус юм хийгээд өргөн бариад байгаа юм уу. Одоо Ухаа худаг, Төгрөг нуур гээд хэрэлдэж байх хооронд нөгөө Энержи ресурс чинь Ухаа худгаа зарчих юм биш биз дээ. Ийм асуулт байна.

Тэгэхээр Ухаа худгийг хянан шалгах Засгийн газрын тэмдэглэлээр өгсөн гэдэг нь хууль бус гэсэн тогтоолын төслийг өргөн барьсан. Яагаад авахгүй байгаа юм бэ. Өргөн барих чиг чинь зориг чинь хэвээрээ юу. Ингээд хэрэлдэж байх хооронд Ухаа худгийг зарчих вий дээ гэсэн бодол байна. Хардалт байна.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд эхлээд хариулах уу. Би хариулах уу.

Засгийн газраас Ухаа худагтай холбоотойгоор тогтоолын төсөл өргөн барихаар Улсын Их Хуралд ирүүлсэн. Ирүүлсэнтэй холбогдуулаад Улсын Их Хурлын Тамгын газар Хуулийн газраас бүрдэл хангасан эсэхтэй холбоотой асуудлыг нягталж үзээд, баримт материал дутуу байна гүйцээж ирүүл гэдэг шаардлагыг хуульд заасны дагуу хариу бичгийг хүргүүлсэн. Хариу бичиг очсонтой холбогдуулаад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайдын гарын үсэгтэйгээр нэмэлт материал ирсэн байгаа. Ирсэн нэмэлт материалтай холбоотой өргөн барих тогтоолын төсөлтэй холбоотойгоор Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Дүн шинжилгээний хэлтэс хууль зүйн дүгнэлт гаргаж байгаа юм. Тэр хугацаа өнөөдөр буюу 4 дүгээр сарын 25-ны өдрөөр дуусгавар болж байгаа. Уг дүгнэлттэй холбогдуулаад өнөөдөр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр энэ асуудлаар бид бас олон талаас ярилцлаа. Энэ дотор Хууль зүйн сайд бас оролцож бид асуудлыг хэлэлцсэн. Тэгээд даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд энэ асуудлыг ирэх 7 хоногт дахин хэлэлцэх нь зүйтэй, зарим мэдээ материал баримтаар бас Улсын Их Хурлын гишүүдийг хангах шаардлага байна гэдэг талаасаа ярилцсан байгаа.

Тэгэхээр Их хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр энэ асуудлыг бид бас өргөн барихтай холбоотой асуудал нь өөрөө хүлээж авахтай холбоотой 2 зөрчлийн асуудал үүсэж байгаа юм. 1 дүгээрт Засгийн газар иргэний хуулиар аж ахуйн нэгж, иргэнтэй хийсэн гэрээг зөв, буруу гэдэг асуудлыг Улсын Их Хурал шууд татаж авч дүгнэж байгаа байдал нь өөрөө зарчмын хувьд зөв үү, буруу юу. Улсын Их Хурал энэ асуудлыг хэлэлцэх нь зөв үү, буруу юу гэдэг дээр дүгнэлт гаргаж, албан ёсны хариу өгөх процесс явагдаж байгаа гэсэн үг.

2 дугаарт энэ асуудал нь хэлэлцэгдээд явснаар Улсын Их Хурлаас гарах гэж байгаа тогтоол нь 2007 онд гарсан Улсын Их Хурлын тогтоолтой агуулга 1 буюу Улсын Их Хурлаас нэгэнт өгөгдсөн үүрэг даалгаврыг Засгийн газар хэрэгжүүлэх үүрэгтэй. Тэр үүргийг хэрэгжүүлээгүй дахиад Улсын Их Хурлаас үүрэг даалгавар өгөөч гэдэг хэлбэрээр тогтоолын төсөл өргөн барьсан байдал нь зарчмын хувьд зөв үү, буруу юу. Нэг ёсондоо Улсын Их Хурлаас нэгэнт шийдвэр гараад, Засгийн газар хэрэгжүүлээд, Улсын Их Хуралд эргэж мэдээлэх үүрэгтэй байтал дахиж үүрэг өгөөч гэж хандаж байгаа байдал нь Улсын Их Хурлаар хэлэлцэх ёстой юу, үгүй юу гэдэг асуудал яригдаж байгаа юм.

Тэгэхдээ үүнтэй холбоотойгоор эцэслэсэн шийдвэр гараагүй байна. Эцэслэсэн шийдвэрийг Улсын Их Хурлын даргын зөвлөлийн бүрэлдэхүүний хүрээнд энэ асуудлыг ярьж, зөвлөлийн гишүүд бас Улсын Их Хурлын дарга болон Улсын Их Хурлын үйл ажиллагаанд зөвлөх үүрэгтэй оролцдог учраас саналыг нь сонсож нэгтгэж шийдвэр гаргая гэсэн ийм байдлаар асуудалд хандаад явж байна. Тэгээд өнөөдөр бас энэ асуудлыг бид албан ёсоор хэлэлцсэн байгаа гэдгийг хэлье. Алтангэрэл сайд нэмж хариулах уу. Алтангэрэл сайд

О.Алтангэрэл: Их Хурлын даргын хэлсэнчлэн дөнгөж түрүүхэн даргын дэргэдэх зөвлөлөөр энэ асуудлыг хэлэлцсэн. Тэгээд энэ дээр бол Засгийн газрыг төлөөлж байр сууриа илэрхийлсэн. Үүний түрүүнд Эрдэнэт үйлдвэртэй холбоотой шийдвэр гаргасан Засгийн газрын тогтоолыг Улсын Их Хурал хэлэлцэж хүчингүй болгож байсан. Мөн энэ шийдвэрийг нь Үндсэн хуулийн цэц хянан хэлэлцээд, зөв байна гэсэн ийм жишиг байна гэдэг энэ асуудлыг ярьсан. Хамгийн гол зарчмын шинжтэй асуудал нь Улсын Их Хурлаас ямар ч шийдвэр гаргасан Засгийн газар биелүүлэх үүрэгтэй. Хүндэтгэж хүлээж авна. Гэхдээ энийг Улсын Их Хурлын албан ёсны бүтцээр хэлэлцүүлж өгөөч гэдэг энэ хүсэлтээ Их Хурлын даргын зөвлөлд тавьсан.

Өөрөөр хэлбэл Байнгын хороогоор яриад, бид нарын энэ тогтоолын төслийг боловсруулах болсон үндэслэл энэ зүйлүүдийг сонсоод Улсын Их Хурал өөрийнхөө шийдвэрийг гаргаач ээ гэж. Тэгээд яг үүнд зориулаад бид энэ Таван толгойн орд газартай холбоотой эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл гээд 2 боть энэ стратегийн орд газар буюу Энержи ресурс компанийн эзэмшиж байгаа ордыг тойроод юу болсон юм бэ гэдэг бүх баримтыг сүүлийн 1950 оноос эхэлж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Яах вэ энэ дээр бас 2 зүйл байгаа юм. Яах вэ Алтангэрэл сайд бас ялгааг нь бас нэлээн сайн судалж олох ёстой болов уу гэж байгаа юм. Эрдэнэтийн 49 хувьтай холбоотой асуудал Засгийн газрын тогтоол гарчихсан юм. Нэг ёсондоо Улсын Их Хурлын эрхэд Засгийн газар халдаж өмнүүр нь тогтоол гаргаж, шийдвэр гаргаж хэрэгжүүлчихсэн. Яг энэ асуудалтай холбохоор яг тогтоол мөн үү, биш үү гэхээр тогтоол биш тэмдэглэлээр үүрэг өгчихсөн гэж байгаа. Тэгээд Засгийн газар маань Иргэний хуулийн дагуу иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ хэлцэл хийгээд асуудал шийдчихсэн байдаг. Тэгэхээр тэр асуудлыг магадгүй хууль шүүхийн байгууллага зөв, буруу гэдгийг нь дүгнээд шүүгээгүй байхад нь Улсын Их Хурал татаж аваад, хэлэлцээд зөв, буруу гэдэг асуудлыг яриад явах нь Их Хурлын хувьд хийх ёстой ажил мөн юм уу, биш юм уу гэдэг дээр л энэ хуулийн мэргэжлийн байгууллагынхан ажиллаад байгаа байхгүй юу. Түүнээс биш Улсын Их Хурал энийг хэлэлцэхгүй гэж татгалзаж байгаа зүйл байхгүй. Бид зарчмын хувьд ер нь гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагч иргэд Монголынхоо төрд итгэлтэй байх уу үгүй юу. Ер нь хууль зөрчсөн асуудалтай холбоотой асуудал нь хаанаа хэн дүгнэж цэгнэж

эцсийн шийдвэр гаргадаг байх юм. Ер нь тэгээд Улсын Их Хурал аж ахуйн шинж чанартай ажлуудыг Засгийн газрын өмнүүр ороод хийг гээд байх уу үгүй юу гэдэг л ийм зарчмын асуудлууд яригдаад байгаа учраас бид энэ дээр цаг хугацаа алдаж байна. Түүнээс энийг хэлэлцэхгүй гэж буцааж байгаа зүйл алга. Хэлэлцье гээд оруулаад ирэхээр зөрчлүүд байгаа учраас энийг яаж арилгаж, хуулийн зөрчилгүй асуудлыг Улсын Их Хуралд орж ирж хэлэлцүүлэх вэ. Улсын Их Хурал гэдэг байгууллага эцсийн шийдвэр гаргадаг байгууллага. Магадгүй Улсын Их Хурал хөнгөн гоомой асуудалд хандаад, шийдвэр гаргасан тохиолдолд Улсын Их Хурлын энэ шийдвэр цаашлаад Цэц дээр очиж шийдэгддэг болно. Нэг ёсондоо аж ахуйн шинж чанартай Засгийн газрын үйл ажиллагааны эцсийн шийдвэр нь Улсын Их Хурал ч биш Цэц дээр очиж шийдэгддэг нөхцөл рүү бид оруулах уу, үгүй юу гэж байгаа юм. Өмнө нь 2, 3 удаа Цэц дээр тийм шийдвэр гарсныг та бүгд мэдэж байгаа. Бүгдээрээ шүүмжлэлтэй ханддаг шүү дээ. 2, 3 стратегийн ордтой ч холбоотой асуудал бензин шатахууны нийлүүлэлттэй ч холбоотой асуудал дээр Улсын Их Хурлаар дутуу шийдвэр гарснаас болоод Үндсэн хуулийн цэц дээр очоод эцсийн шийдвэр болчихдог. Ингээд үндсэндээ гүйцэтгэх засаглалын эрхэнд, магадгүй хуулиар, цаашлаад бүр Үндсэн хуулийн цэцээр асуудал ханддаг хэлбэр лүү бид оруулах уу, үгүй юу гэдэг л асуудал хөндөгдөж байна. Гэхдээ энэ асуудал Мөнхбаясгалан гишүүн эцсийн шийдвэр гараагүй байгаа. Ирэх 7 хоногт тодорхой болчихно. Ерөнхий сайд нэмэлт хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Засгийн газрын хувьд Ерөнхий сайдын хувьд тэр Ухаа худаг нь байна уу, Төгрөг нуур нь байна уу, эсвэл бусад орд нь байна уу энэ нэг их тийм чухал асуудал биш гэж үзэж байгаа юм. Ерөөсөө өнөөдөр энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг мэдээлэл хийж байгаа нь ерөөсөө бид нар стратегийн орд гээд байгаа энэ ойлголтоо цэгцэлье. Хэдэн стратегийн орд байгаа юм бэ. Энэ мэдээллээ нэг болгоё. Тэгээд стратегийн ордоос орж ирж байгаа АМНАТ-ийн хэдэн хувийг нь энэ 3 сангийнхаа хаана нь өгөх юм бэ. Тоглоомынхоо дүрмийг тодорхой болгочихъё. Тэгээд хэлэлцээрт оръё л гэж байгаа. Тийм учраас байр суурь яг бүгдийг нь оруулж ирж ярилцах ёстой. Засгийн газрын байр суурь бол. Мэдээж ямар шийдвэр гаргах вэ гэдэг бол Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал. Тэгээд энэ асуудлыг нэг мөр ойлгож байж бид нар хөрөнгө оруулагчид болон компаниудтай нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Энэ Үндэсний баялгийн сангийн асуудлаар Ерөнхий сайдын мэдээлэл хийсэнтэй холбогдуулаад асуух, санал болгох зүйл байна. Тэрнээс өмнө бас Үндэсний баялгийн сан биш энэ Ерөнхий сайдын мэдээллийн цагийн тухайд бас хэлмээр байгаа. Одоо ингээд цөөн хүн асуулт асуугаад, хариултаа авна гэж байгаа. Тэрний дараа иргэдийн асуултыг Их Хурлын гишүүд дамжуулж асуугаад, хариулт авна гэж байгаа юм. Энэ Засгийн газрын сайдууд чинь өөрийнхөө намын хүмүүст асуултаа 10, 20-оор нь бичиж өгчхөөд, нөгөөдүүл нь дуржигнатал иргэний нэр бариад уншихад хариултыг нь дуржигнатал нь буцаагаад л уншаад л өгчхөөд байгаа юм байна лээ шүү дээ. Түрүүчийн мэдээллийн цагаас харахад ийм тоглоом тогломооргүй байна. 118 гишүүн нэг дор цуглаж, Засгийн газар байгуулчхаад цөөнх гэж юугаа ярьдаг юм бэ. Нөгөө Засгийн газрын кабинетын зарчим нь хаанаа явж байгаа юм. Одоо асуулт асууж байгаа, үг хэлж байгаа гишүүд бол цөөнх биш засагт бодлогоо хэрэгжүүлж байгаа улс төрийн намын гишүүд шүү дээ. Энэ парламентад Иргэний Зориг ногоон нам, Үндэсний эвсэл 2 л албан ёсоор засагт ороогүй цөөнх байгаа. Энэ нь өөрөө юуг хэлж байна вэ гэхээр энэ асуулга, мэдээллийн цагаар

дамжуулж өөрсдийнхөө сонирхлоо Улсын Их Хурлын танхим дотор илэрхийлж, төрийн бодлого, засгийн бодлогод шургуулдаг ийм л ажил хийж байгаа шүү дээ. 118 гишүүн үүндээ бол гаршиж байна гэж үзэж байна. Үүнийгээ бас өөрчилмөөр байгаа юм. Их Хурлын даргад байнга хэлж байгаа. Энэ тал дээрээ анхаараасай гэж хүсэж байна.

Үндэсний баялгийн сангийн тухай мэдээлэл хийсэн. Энэ хүрээнд аваад үзэхэд бол бид нар үндэсний баялгийн сангаа яаж өргөжүүлэх вэ, орлогыг нь яаж нэмэгдүүлэх вэ, нэмэлт эх үүсвэрийг яаж бий болгох вэ гэдэг дээрээ нэг талдаа анхаарах ёстой. Нөгөө талдаа орлогыг нь нэмэгдүүлж байгаа бол буцаагаад тэрийг хэрхэн захиран зарцуулж, ямар зорилгоор ашиглаж ямар газар хадгалуулж байна. Юунд ямар зориулалтаар байлгаж байршуулж байна вэ гэдэг дээрээ концепц дээрээ үзэл баримтлалыг нь бий болгох хэрэгтэй. Мөн томоохон төслүүд, 14 мега төсөл гээд л ярьж байгаа. Энэ зүйлүүдэд хэдэн хувь нь орж байх ёстой юм. Тийшээ орох ёстой юм уу, орох ёсгүй юм уу.

Дээрээс нь Монголын 3 сая иргэн 2 сая 500 мянган зээлдэгч байж байгаа шүү дээ. Бүгдээрээ банк болон банк бус, ломбардын ажилчид болоод хувирчихсан. Бүтээгээд байна, бүтээгээд байна, тэд нарын хүүг төлөөд өөртөө үлдэх юмгүй болчихож байгаа юм. Үндэсний баялгийн сан энэ банкнуудад болон Монголбанк дээр байршихад энэ зээлийн хүүг бууруулах, иргэдээ чөлөөлөх чиглэлд ажиллаж болохгүй юу. Энэ чиглэл дээр анхаарах ёстой зүйл байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэллээ. Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууж, үг хэлж болно.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Ерөнхий сайдын мэдээлэл дунд ийм өгүүлбэр байна л даа. Сангийн орлого жил бүр нэмэгдэж, 20, 30 гэхэд сангийн нийт хөрөнгө 3 их наяд төгрөгт хүрэх төсөөлөл байна гэж байна. Энэ сангийн бүрдлүүд бол нөгөө манай төсвийн тэнцвэржүүлсэн орлого нэмэгдэлтэй буюу ашигтай гарч байж, түүнээс нь авах ийм хуультай байгаа. Гэтэл өнөөдрийн байдлаар мөн өнөөдрийн эхний улирлын байдлыг өмнөх оны эхний улирлын байдалтай харьцуулахад нөгөө манай төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл маань хасахтай явж байгаа. 353 тэрбумын алдагдалтай явж байгаа. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,6 их наяд байсан. Тэгэхээр хэд дахин буурсан нь бол эндээс харагдаж байна.

Нөгөө гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, экспортын бараа бүтээгдэхүүн болох нүүрс маань юу болчихсон явж байгааг бид бүгд маш сайн мэдэж байгаа. Нүүрсний экс спорт гэхэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 883 сая доллароор буураад, өөрөөр хэлбэл 42 хувиар буурчихсан явж байна. Үнэ нь 129 доллар, 105 доллароор зарж байж энэ ашигтай гараад, энэ ашгаасаа бид нар энэ сангуудаа төвлөрүүлнэ гэж төлөвлөсөн маань үнэ нь бараг 50-иад доллароор буурчихсан явж байна. Энийгээ алтаар нөхнө гэж яриад байгаа. Гэтэл алт чинь бас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47 сая доллароор буурчихсан явж байна. Ингээд бүх юм чинь хасах үзүүлэлттэй буурчихсан яваад байна.

Нийт орлого бас бид бүхэн мэдэж байгаа. 1,2 их наяд буюу 16 хувиар буурчихсан явж байна. Экспортын гол бүтээгдэхүүн энэ нүүрс чинь угаасаа бараг 45-55 хувийг нь бүрдүүлж байгаа. Үүний үнийг бид сая ярилаа. Экспортын нийт орлого бас яаж буурснаа ярилаа. Тэгээд энэ ирээдүй гэдэг гоё нэрийн доор баялаг

гэдэг гоё ийм нэр хоч юм шиг ийм юмыг л нэг их яриад байна. Гэтэл өнөөдрийн бодит амьдрал чинь ямар байгаа юм бэ. Та энэ дээр ер нь санаа зовж байна уу. Тэр баялаг бүтээх гэж энэ сан гэж ярихаасаа илүү өнөөдрийн ард түмний амьдралыг та яая гэж бодож байгаа юм бэ. Гадаадын хөрөнгө оруулалт дээр ямар бодлого барьж байгаа юм бэ. Энэ баялгийн санд хуримтлуулна гээд хийж байгаа энэ ажил чинь нэг талаасаа зөв боловч нөгөө талаасаа гаднын хөрөнгө оруулагч нарт яаж тусах юм бэ. Гаднын хөрөнгө оруулалт орж ирэх баталгаа байгаа юм уу. Таны энэ дээр тусгасан 2030 он гэхэд 3 их наядаар энэ чинь арвижих баяжих ийм боломж гарц гаргалаа харагдаж байгаа юм уу. Та ер нь 6 жил энэ төрд өндөр дээд албан тушаал хашлаа. Ерөнхий сайдаар ажиллаад та 5 дахь жилдээ орж байна. Та хэтэрхий вакумжаад хэтэрхий амьдралаас тасарчихсан юм биш үү. Цаана чинь яг иргэдийн амьдрал ямар байгааг та мэдэж байгаа юм уу. 145 мянган төгрөг тараагаад, тэгээд бүгдээс нь хөрөнгө эзэмшигч болгочихсон. Тэгээд 3 сая хүн хөрөнгө эзэмшиж байна гээд өнөөдөр статистик дээр орчихсон. .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Баярцогт даргын асуултад хариулъя. Улс төржиж байгаа учраас би бас улс төржиж хариулъя. Яг бодитоор Хөгжлийн банк ямар байдалтай болчихсон байлаа. Энэ Эрдэнэтийн 49, энэ саяын яригдаад байгаа энэ стратегийн ордууд ямар үед хэний гараар ороод юу болчихлоо. Энэ байдлыг цэгцлэхэд нэлээдгүй хугацаа орсон. Би энийг ярихгүй л яваад байгаа юм. Одоо энэ стратегийн ордууд орж ирэх энэ материалуудаас тэгээд өөрсдийнхөө хийсэн зүйлийг сайн харна биз. Гэхдээ би өөртэй чинь юм ярихгүй ээ. Цаана чинь үг хэлүүлээд байгаа тэр хэдэн нөхдүүдтэй чинь би байр сууриасаа нэг их хазайхгүй ээ. Сүүлийн 20 гаруй жил бантан зуураад, Монгол Улсын өмч хувьчлалыг хэдэн ордтой нь аваад будаа болгочихсон байгаа зүйл удахгүй энэ материалаар орж ирнэ. Ийм зүйл дээр залуу хүн байж битгий хүний өмнөөс хачин хачин юм яриад бай за юу.

Д.Амарбаясгалан: Пунсалмаа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Пунсалмаа: Минутаа эхнээс нь авах уу. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Баялгийн сангийн тухай ярьж байна. Баялгийн сан энэ уул уурхайн орлогыг бүх ард түмэнд тэгш хувь хуваарилах, ирээдүйдээ өвлүүлэх ийм сан. Энэ санг сайн яваасай гэж бүх ард түмнээрээ хүсэж байгаа. Тиймээс ч стратегийн ач холбогдолтой 34 хувь, хувийн хэвшлүүд төрд шилжүүлэх энэ ажил шат дараатайгаар энэ гэрээнүүд бас тодорхой хэмжээнд амжилттай явж байгаа. Энэ бол ард иргэдийн хүсэл шүү гэж хэлэх гэж байгаа юм.

2 дугаарт нь энэ баялгийн санд орж ирсэн энэ хөрөнгийг төсвийн алдагдлыг нөхөхөд бүү оруулаарай ирээдүйд. Ингэх юм бол энэ сан өсөхгүй шүү. Мөн энэ санд орж ирсэн мөнгийг хуримтлалын сангаар дамжуулаад, ард иргэдэд шууд тараачихмааргүй байна. Энэ өөрөө инфляцыг өрдөөд байна. Тэгэхээр энэ тал дээр бид нар анхаармаар байна. Ер нь бол Норвегийн Санг манай энэ баялгийн сан өөрөө жишиг болгож авч үздэг. Норвегийн санг хэн удирддаг вэ гэхээр улс төрчид нь удирдахгүй байна. Норвегийн санг бол Норвегийн төв банкны дэргэд байдаг Санхүүгийн корпорац удирдаж байна. Энэ корпорац нь сангаа өсгөөд, үржүүлээд, нэмэгдүүлээд, хадгалаад ингээд ард түмэн нь энэ сангийн үйл ажиллагааг нь хянаад ингээд ажилладаг. Сангийн яам нь болохоор энэ сангийнх нь үйл ажиллагаанд нь эрх зүйн орчныг нь сайжруулж өгөөд ажилладаг. Яг үүнтэй ижилхэн манай баялгийн санг Монголбанкны дэргэд санхүүгийн том корпорац бий болгоод ингэж ажилламаар

байна. Ингэж баялгийн сангийн хөрөнгийг өсгөдөг, нэмэгдүүлдэг, хадгалдаг, ард иргэддээ хянуулдаг ийм тогтолцоо руу бид нар орж ирэх хэрэгтэй байна. Цаашдаа энэ дээрээ анхаараач ээ. Та бүгдийн бодол санаа энэ дээр ямар байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Анхааръя гээд л хэдүүлээ ярих гээд оруулж ирээд байна л даа. Тэгэхээр баялгийн сантай холбоотой ойлголтоо бид нар ингээд цэгцлэх нь бол яалт ч үгүй чухал нь харагдаж байгаа юм. Судалгаа хийгээд үзэхээр жишээлбэл АМНАТ-ийн талаар ч ойлголт цэгцтэй биш байна. Өнөөдөр АМНАТ-ийн 65 хувь Ирээдүйн өв санд, Тогтворжуулалтын санд тодорхой хэсэг, орон нутагт 10 хувь байгааг ч яг ингээд судалгаа хийгээд фокус групп хийгээд үзэхээр парламентын түвшин ч нэг ойлголттой бүтэн биш, иргэдийн хувьд ч бүтэн биш, аж ахуйн нэгжүүдийн хувьд ч, хөрөнгө оруулагчдын хувьд ч бүтэн бас биш байгаад байгаа юм. Тэгээд уул уурхайн компаниудтай бас бид нар уулзаад энэ олон нийт дээр байгаа асуудлуудыг сая энэ бид нар Орано-ийн үед бас нэлээдгүй ийм уулзалтууд хийсэн юм. Ингээд Баялгийн сангийн хуулийн дагуу нөгөө 34 хувь зайлшгүй авах ёстой гэдэг зүйл дээр сая бид нар тусгай АМНАТ-өөр орлуулах ийм хувилбарыг гаргаад, Их Хурлаар баталсан. Ингээд яах вэ гэхээр 10 хувь нь тухайн аж ахуйн нэгжтэй бид нар эзэмшлийн хувь тохироод, 24 хувийг орлуулсан анхны ийм хэлцлийг Их Хурал баталсан. Энэ бол их тийм сайн загвар болсон. Сайн загвар болсон. Одоо энэ дээр их олон олон хөрөнгө оруулагчид ийм ийм асуудал дээр томоохон бусад төслүүд дээр хамтран ажиллахаа илэрхийлж байгаа юм. Бид нар яах вэ гэхлээр АМНАТ гэдэг буюу сая би мэдээлэл дээр хэлсэн рояалти нөөцийн төлбөр гэдэг энэ ойлголтоо яг энэ үндэсний баялагтайгаа уясан байдлаар нэгдсэн ойлголтыг өгөхгүй бол болохгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ ойлголтыг өгөхгүйгээр жишээлбэл орон нутаг дэмжихгүй байгаад байгаа юм. Уул уурхайн төслийг. Яагаад вэ. Үгүй ээ бид нар уул уурхайг дэмжлээ гээд яах юм, манай орон нутагт ямар хэрэгтэй юм. Иргэдийн хувьд ч гэсэн энэ тэгээд яг надад ямар хүртээмжтэй юм. Ирээдүйд хадгална, менежмент сайжруулна гээд байна. Үгүй ээ, яг бодитоор жишээлбэл тэр ирээдүйд хуримтлагдаж байгаа хуримтлал ямар байдлаар хэдэн жилийн дараа надад хүртээмжтэй байх юм бэ. Зарим гишүүдийн хэлж байгаа дэд бүтэц болон агаарын бохирдол гээд олон асуудалд зарцуулъя. Зарцуулах механизм нь хаана байгаа юм бэ гэдэг зүйлийг л яаж оновчтой болгох вэ гэдэг дээр л бид нар ойлголтоо нэгтгэх ёстой болчихоод байгаа юм. Энэ бүх зүйлийг хийсний дараа бид стратегийн орд эзэмшигч компаниудтай хэлцэлд уриалж байгаа. Үүнийг АМНАТ-өөр орлуулах уу, эсвэл борлуулалтын орлогын тодорхой хувиар орлуулах уу. Тэгээд үүнийг бид нар эрүүл мэнд рүү зарцуулах уу, боловсрол руу зарцуулах уу, орон сууц руу зарцуулах уу. Хэдэн хувийг нь бид нар иргэдийн хадгаламж болгох юм бэ. Орон нутаг буюу ялангуяа уул уурхайг дэмжиж байгаа орон нутаг яаж тулгамдсан асуудлаа шийдэх юм бэ гэдэг л энэ механизмыг л бидний хувьд тодорхой болгох нь зүйтэй.

Тийм учраас бид нар дахин дахин ярих ёстой. Дахин дахин мэтгэлцэх ёстой. Энэ мэтгэлцээнээс олон нийтийн хувьд бас ойлголт авах ёстой. Ингээд хөрөнгө оруулагчид, үндэсний компаниуд, орон нутаг, иргэний нийгмийн байгууллагууд, улс төрчид нэгдсэн ойлголттой болж байж ирээдүйн Оюутолгой, ирээдүйн Таван толгой, ирээдүйн уул уурхайн төслүүд хөдлөх гээд байна. Тэгэхгүй энэ нь ч бүрдэхгүй байгаад байна. Тэр нь ч ингээд байна, тэр нь ч ингээд гээд өөрсдөө бид нар ийм зүйл ярьсаар байгаад, тэгээд нийгмийн хувьд ямар ч уул уурхайн төслийг ер нь л хөдөлгөх нь буруу юм байна. Энийг ер нь тэр чигт нь ирээдүйд олон жилийн дараа

ашиглах нь зүйтэй юм байна гэдэг дүгнэлт рүү 60-аас дээш хувь нь оччихоод байна. Энийг дэлхийн олон улсын шийдсэн цорын ганц гарц ерөөсөө л Баялгийн сангийн хууль. Эсвэл татвар. Тийм учраас энэ асуудал дээр бидний хувьд байр сууриа нэгтгэх нь зүйтэй юм л гэж өнөөдөр оруулж ирж байгаа юм. Тийм учраас өнөөдөр хэлэлцэх асуудал дээрээ илүү төвлөрөөд, илүү тийм гүнзгий асуудал дээр тоонуудаа болон мэдээллүүдээ нэгтгэх нь өнөөдрийн энэ цагийн зорилго гэж үзэж байгаа юм.

Бусад сэдвээр мэдээж бидний хувьд дахиж оруулж ирээд ярилцах ийм боломж байгаа учраас өнөөдөр бол яг энэ Баялгийн сан, тэр дундаа АМНАТ-ийг хэрхэн хуваарилах вэ. Баялгийн сангийн 3 данс хоорондоо хэрхэн хяналт тэнцэлтэйгээр засаглалын хувьд зөв зохион байгуулалттай байх вэ. Хууль батлагдаад 1 жил болчихлоо. 1 жилийн маань дүгнэлт юу байх вэ. Тэгээд цаашлаад бид нар ирээдүйд яаж илүү зөв менежмент рүү явах вэ гэдэг дээр л хэдүүлээ төвлөрч яривал илүү цаг маань зөв болох болов уу л гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууя.

Г.Уянгахишиг: Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотой яг маш тодорхой 3 асуулт асууя.

1 дүгээрт хуримтлалын сангийн хөрөнгийг ямар өгөөжтэйгөөр, ямар хугацаатайгаар байршуулаад, 495 тэрбумын хөрөнгийн өгөөж нь 1 хувьтай тэнцэх буюу 4,9 тэрбум төгрөг байгаа вэ гэдэг 1 дүгээр асуулт. Энэ хүрээнд Засгийн газрын 2025 оны 72 дугаар тогтоолоор баталсан хөрөнгийн удирдлагын бодлогоор Монголбанк хөрөнгийн удирдлагыг хийж байгаа. Энэ талаасаа тухайн бодлогын 4.2 дээр яг ямар хөрөнгө оруулалтын хэрэгслүүд рүү оруулж болох вэ гэдгийг маш тодорхой зааж өгсөн. Мөн түүнчлэн 4.1-д нь өгөөжийн хэмжээ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 13-д заасан өгөөжөөс доошгүй байна гэдгийг бас маш сайн тодорхой зааж өгсөн байгаа. Тийм болохоор яг ямар хувь хэмжээтэйгээр, ямар хүүтэйгээр, ямар хугацаатайгаар, ямар нөхцөлтэйгөөр энэ орон сууцын санхүүжилтийн хөтөлбөрт хөрөнгө оруулсан бэ гэдэг 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт нь Ирээдүйн өв сангийн хөрөнгийг гаднын санхүүгийн байгууллагад байршуулсан байна. Тэгвэл энэ нь мөн яг ямар хугацаатай, ямар хувь, хэдэн хувийн өгөөжтэй, ямар нөхцөлтэй хөрөнгө оруулалтын санхүүгийн хэрэгсэлд байршуулсан бэ гэдэг ийм 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт нь Чингис хаан баялгийн сан ХХК гээд шилэн данс дээр гарч ирж байгаа. Тэгээд яг шилэн данс руу оруулаад харахаар яг Үндэсний баялгийн сангийн хөрөнгийг зохион байгуулахад зориулагдсан хуулийн этгээд гэж гарч ирээд байгаа юм. Тэгэхдээ тэр дотор ямар ч мэдээлэл одоогоор ороогүй байгаа. Тэгэхээр энэ нь өөрөө Чингис хаан баялгийн сан гэдэг маань ХХК-ийн хэлбэртэйгээр байгуулагдчихаад байна уу. Тэгээд энийгээ яаж зохицуулах гэж байгаа вэ. Статус нь ямар юм бэ гэдэг талаар бас мэдээлэл авмаар байна. Яг ийм 3 л асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Учрал сайд.

Н.Учрал: Үндэсний энэ баялгийн сангийн хууль батлагдсаны дараа тэр хуримтлалын сан дахь хуримтлалыг нэмэгдүүлэх ажлууд бол хийгдсэн. Тэгэхээр энэ уул уурхайн компаниудын 34 хувийн ноогдол ашиг бол тэр хуримтлалын сан руу

төвлөрч байгаа гэсэн үг. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд 490 орчим тэрбум төгрөг бол уул уурхайн төрийн өмчийн 7 компанийн ноогдол ашгийн хуримтлал. Үүнийг эрүүл мэнд, орон сууц, боловсролд зарцуулах буюу одоо үедээ хүртээх ийм хууль, эрх зүйн орчинтой. Үүний дараа Засгийн газраас тогтоол гарсан. Тогтоол бол энэ хуримтлалын сангийн мөнгийг хэрхэн иргэдэд хүртээх вэ гэдэг дээр ийм журам гаргаад, энэ хуримтлалын сан нь бол одоогийн хуулиар бол гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр хариуцдаг. Тэгэхээр боловсрол, эрүүл мэнд, орон сууц дээр юундаа зарцуулах вэ гэдэг дээр иргэд бол хүсэлтээ гаргаад, тэр хүсэлт гаргасны дараа түүн дээр нь тэр журмын дагуу Монголбанкнаас тухайн хуримтлагдсан хуримтлалыг иргэдэд хүртээх ажил хийгдэнэ гэсэн үг.

Тэгээд сая бид Засгийн газар дээр яриад Үндэсний баялгийн сангийнхаа хуулийг концепцоор нь бас дахиж эргэж харах ийм шаардлагатай байна гэж үзэж байгаа. Энэ ч утгаараа ер нь бол Ирээдүй өв сан гэдэг яг энэ saving буюу хадгаламж. Ирээдүй өв сан. Гэхдээ адилхан л ер нь цаашдаа нэрийн данстай иргэд өөрөө үүнийгээ ирээдүйд өөрөө хэрэглэх ийм бололцоог нь бид нар нэгэнт 2030 он хүртэл түгжчихсэн байгаа учраас цаашдаа үүнийг зарцуулах боломжийг нь хуулиар нээх, цаашлаад яг одоогийн хуулиар тэр Ирээдүйн өв сангийн хадгалагдаж байгаа буюу тэр АМНАТ-ийн 65 хувиар хадгалагдаж байгаа мөнгийг бол 2030 оноос хойш санхүүгийн хэрэгсэлд оруулах бололцоог хуулиар нээчихсэн байдаг.

Одоогийн хуримтлалын санг бид нар зүгээр Монголбанкны бодлогын хүүгээр нэмэгдүүлээд л явдаг. Хөгжлийн сан бас дахиад тусдаа ийм сан байгаад байна шүү дээ. Гэтэл яг Хөгжлийн сан бол яг бодит утгаараа яг хөрөнгө оруулалтын сан шиг ажиллаж огт чадахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр яг таны хэлж байгаа энэ саналуудыг ч гэсэн бид нар бас тусгаад цаашдаа Үндэсний баялгийн сангийн хууль дээр бүтэн концепцын өөрчлөлт хийхгүй болохгүй нь. Хуримтлалын сан үр өгөөж нь нэмэгдье гэвэл зайлшгүй төрийн эзэмшлийн 34 хувиас гадна стратегийн ордуудад тооцогдож байгаа тэр ордуудын 34 хувийг Их Хурал өөрөө хэрвээ шийдэх юм бол яг тэр нөгөө АМНАТ-өө нэмэгдүүлээд байна уу, бүтээгдэхүүн хуваахаар нэмэгдүүлээд байна уу шийдсэний дараа тэр нэмэгдүүлсэн хэсэг нь өөрөө хуримтлалын сан руу очдог байх нөхцөлийг зайлшгүй бүрдүүлэх ийм шаардлагатай байгаа.

Тийм учраас Үндэсний баялгийн сангийн хуулийг бид нар оруулж ирээд, өнөөдрийн иргэдэд хэрхэн зарцуулах бололцоог нь нээх вэ гэдэг ийм том алхам хийх ёстой. Ирээдүйдээ зарцуулахыг нь бол хадгаламж хэлбэрээр буюу цаашлаад бид нар яг тэр Норвеги шиг нөгөө тэтгэвэртээ гарахдаа давхар тэтгэврийн тогтолцоотой яг адилхан тэр баялгийн сангаасаа бас тэр Баялгийн сангаасаа тэтгэврээ авдаг ийм тогтолцоо руу шилжүүлэх ийм үе шаттай алхмуудыг баялгийн сан дээр хийж явж байж л энэ байгалийн баялагтаа ард түмэн үнэхээр эзэн болж байгаа юм байна гэдэг нь мэдрэгдэнэ. Тэр ч утгаараа эхний алхмууд хийгдэж байгаа. Энэ бол үе шаттай хийгдэх алхмууд.

Тэгээд түрүүн бас нэлээн олон асуулт асуугдаад байсан энэ дээр Сангийн яам бас тодорхой хариултуудыг өгөх байх гэж ингэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан сайд нэмж хариулъя.

Л.Энх-Амгалан: Уянгахишиг гишүүн яг тоо асуугаад байх шиг байна л даа. Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар хуримтлалын сангийн хөрөнгийг

яг Төв банкны бодлогын хүүгээс багагүйгээр арвижуулахаар хуульчилчихсан бид нар. Тэгээд энэ зохицуулалтын дагуу Монголбанктай 2024 оны 5 сарын 9-ний өдөр гэрээ байгуулсан. Ингээд энэ гэрээ бол 5 сарын 9-нд дуусна. Энэ гэрээгээр яг бодлогын хүүгээр тооцож өгөөж өгнө гэж тохирсон учраас бол 30 тэрбум төгрөгийн өгөөж авах юм. 483 тэрбумаас 30 тэрбум. Үүний 4,9 тэрбум төгрөг өнөөдөр Монголбанкнаас 2024 оны эцсээр манай дансанд орж ирсэн. Одоо ингээд бид нар 5 сарын 9-нд жилийн гэрээ дуусахад нөгөө цаана нь байгаа 35 тэрбум төгрөгийн өгөөжийг авч хуримтлалын дансандаа байршуулж иргэдийнхээ дансанд энэ өгөөжийг хуваарилах ийм л ажил байгаа. Яг тоо гэвэл.

Д.Амарбаясгалан: Наранцогт захирал хариулт өгье. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

С.Наранцогт: Уянгахишиг гишүүний асуултад тодруулж хариулъя. Хуримтлалын сангийн хөрөнгө бол иргэдийн хадгаламж яг Монголбанкны бодлогын хүүгээр өсөж байгаа. Энэ хөрөнгийн менежментийг Монголбанк хариуцаж байгаа. Тэр ипотекийн зээлд оруулсан асуудал, тэр мөнгийг аваад үрсэн асуудал биш. Зүгээр л хөрөнгийн удирдлагын л хийгдэж байгаа асуудал. Тэгэхээр энэ дээр сая Энх-Амгалан сайд тодорхой хэлчихлээ. Энэ бодлогын хүүгээр ямар ч тохиолдолд өсөөд явна. Чингис хаан тэр компанийн тухай асуусан. Энэ бол Улсын Их Хурал Баялгийн сангийн хуулийг дагалдуулж гарсан тогтоол дээр 2030 он хүртэл энэ баялгийн санг цаашдаа 2030 он хүртэл хуримтлуулаад, үүнээс цааш бол бид яг олон улсын ассет менежментийн компаниар удирдуулах ёстой. Тэгэхэд бол бид нар тодорхой мөнгөтэй болно. Дээр нь нэмээд боловсон хүчнээ бэлдэнэ. Хууль, эрх зүйгээ сайжруулна. Энэ ажлыг хийх саяын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. 8 дугаар микрофон.

С.Наранцогт: Таны асуугаад байгаа энэ хүүг тооцоо хийх, энэ бүх ажлыг хийх тэр бэлтгэл ажлыг хангаж байгаа компани болохоос биш энэ хөрөнгийг удирдаж байгаа юм биш. Зүгээр бид нар 2030 онд цаашаа энэ компани өөрөө ер нь Ассет менежмент компани болох энэ зорилго тавьж ажиллаж байгаа гэсэн үг. Энэ дээр бол компаниудаас зөвхөн оролцож байгаа нь Эрдэнэс Монгол орлого төвлөрүүлэгч, Эрдэнэс Монгол энэ орлогыг төвлөрүүлж өгч байгаа. Ирээдүйн өв сангийн хөрөнгийн менежментийг бол мөн Монголбанк яг хийж байгаа. ЗА зэрэглэлтэй олон улсын санхүүгийн хөрөнгөд оруулж байгаа гэсэн мэдээлэлтэй байгаа. Нарийн тоо авъя гэвэл энд Монголбанкны төлөөлөл ирчихсэн сууж байна.

Д.Амарбаясгалан: Монголбанкнаас хэн байна. 3 дугаар индэр дээрээс нэмэлт хариулт өгье.

П.Мөнхбаяр: Гишүүний асуултад нэмж тодруулъя. Ирээдүй өв сангийн хөрөнгийг Монголбанк болон Сангийн яамны хооронд 2025 оны 3 сарын 7-ны өдөр харилцан хадгаламж байршуулах гэрээ байгуулаад, үүнийхээ хүрээнд хөрөнгийнхөө удирдлагыг хийж гүйцэтгэж байгаа. Энэ хөрөнгийн удирдлагыг мэдээж 1 дүгээрт эрсдэл, 2 дугаарт хөрвөх чадвар, 3 дугаарт өгөөж гэсэн энэ дарааллаар яг нөгөө валютын нөөцийг удирддаг хүрээнд удирдлагыг нь хэрэгжүүлээд явж байна. Одоогийн байдлаар хамгийн хөрвөх чадвартай 3 Төв банкны хадгаламж дээр байршуулсан. Өгөөжийн хувьд 4,32 хувийн өгөөжтэй. Энэ дээр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Манай Ерөнхий сайд маань сая маш муухай хүнтэй харьцлаа. Бид бүхэн цөөнх, сөрөг хүчний бас байр суурийг илэрхийлж, тэр тусмаа эмэгтэй хүн үг хэлж байна. Энэ улс оронд болж байгаа ч юм байгаа, болохгүй ч юм байгаа. Монголын Үндэсний статистикийн хорооноос 2024 он, 2025 оны 1 хүний амьдрах зардлыг гаргасан байна лээ. 24 хувиар өсчихсөн байна өнөөдөр. Амьдрал маш дордож байна. Хүмүүсийн амьжиргаа муу байна. Үүнийг хэлсэн. Энийг хэлүүлэх ёстой. Өнөөдөр Монгол Улсыг удирдаж байгаа хүн ийм зэргийн үгийг бол сонсож байх ёстой. Тэгэхэд өнөөдөр Улсын Их Хурлын гишүүн энд үгээ хэлж байхад Монгол Улсын Ерөнхий сайдад ийм байдлаар эмэгтэй хүнийг бас хэлнэ гэдэг бол хэрдхийлгэм эвгүй байлаа. Энэ дээр бас Монгол Улсын Ерөнхий сайд цаашид анхаараарай.

Миний бас 2, 3 асуудал байсан юм. Тэрийгээ яаралтай асуухгүй бол минут маань бас хүрэхгүй болж байх шиг байна. Энэ 2007 онд Улсын Их Хурлын тогтоолоор стратегийн ордуудыг баталсан. Эхнийх 16, дараа нь ингээд 39 орд. Үүнээс хойш стратегийн ордуудын 34-50 хувийг Монгол Улс ашиг хувь байдлаар авна гэсэн энэ ажил хэрэгжихгүй яваад байсан. Тэгээд Ардчилсан намын бүлгийн 5, 6 гишүүн аймаг, орон нутгаараа тойроод, энэ хуулийг хэрэгжүүлэх, энэ ашиг орлогоос ард иргэдийнхээ амьдралыг сайжруулах, тулгамдаж байгаа олон асуудлаа шийдвэрлэх дээр санал санаачилга гаргаад явсан. Энэ Үндэсний баялгийн санд төвлөрүүлэхийг бид бүхэн дэмжиж, ард иргэдээсээ санал авсан.

Үндсэндээ бол Монгол Улсын Засгийн газрын хийж байгаа ажил буюу Улсын Их Хурал бүхий л хүмүүсийн ажил бол энэ зүгт байгаа гэж ингэж бодож байгаа. Гэсэн хэдий ч төрийн сайд хүн нь яахаараа та нар ингээд явж байдаг юм гэсэн байдалтай бүр нэг хүнийг онцлоод, маш их хэмжээний худал гүтгэлэг, янз янзын зүйлүүдийг бол ярьсан. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр энэ Засгийн газар чинь яг үүний төлөө байгаа юм уу. Энэ ажлыг яг хийж хэрэгжүүлэхийн төлөө байгаа юм уу. 1 дэх асуулт.

2-т нь энэ стратегийн ордуудыг цааш нь нэмэх асуудлыг ярьж байна. Ард иргэд. Энэ 39, 16 энд чинь ороогүй зөндөө ордууд байна. Үүн дээр ямар ажиллагаанууд хийж байгаа вэ.

Дараагийн асуудал нь энэ Оюутолгойн борлуулалтын орлого Монголбанкаар орж ирэхгүй байна. Энэ Монгобанкаар оруулж ирэх ёстой. Өнөөдрийн бидний энэ валютын өсөлт Монгол мөнгөний ханшийн уналт бол маш их хурдацтай явж байна. Энэ дээр Монгол Улсын Засгийн газар, Их Хурлын ямар бодлого шийдвэр байна вэ гэдгийг бид нараас асууж байсан. Олон хүн асуусан. Энэ дээр хариулт авъя гэж ингэж бодож байна. Мөн дээрээс нь бид бүхэн Үндэсний баялгийн санг бол хамгийн сайн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Баялгийн сан бүрдэх энэ процесс Оюутолгой, Эрдэнэт гээд л бас нэлээдгүй юм болсон. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Оюутолгойн 2,3 тэрбум доллар тэглэгдэхгүй болохоор 34 хувьтай холбоотой асуудлыг баялгийн сангийн 1 бүрэлдэхүүн хэсэг гэж хуульчлах боломжгүй болчихоод байсан юм. Ингээд энэ бас нэлээдгүй асуудал болсон.

Эрдэнэттэй холбоотой асуудал нэлээдгүй асуудал болсон. 49-тэй холбоотой асуудал маргаантай байхаар Эрдэнэтийн 34 хувь бас хуримтлалын санд орох ийм боломжгүй болчихоод байсан. Дээрээс нь Хөтөл эд нар гээд ийм олон асуудлууд гарсан. Тэгээд энэ бүх асуудлуудыг шийдэж байж л түрүү жил энэ хууль батлагдсан. Энийг бол Жаргалсайхан гишүүн бол сайн мэдэж байгаа байх. Үүнтэй холбоотой л ийм олон асуудал дээр нэлээдгүй ийм олон төвөгтэй зүйл дундуур энэ баялгийн сан яваад, өнөөдөр бас бид нар яригдаад, одоо яах вэ гэхээр стратегийн орд эзэмшиж байгаа компаниудтай хэлцэл хийх зайлшгүй шаардлага үүсэж байгаа. Өнөөдрийн энэ ярьж байгаа олон ордууд, өнөөдрийн байж байгаа энэ уур амьсгал ч гэсэн яг үүний цаана байгаа, наана цаана олон ил далд тоглолтуудаас болж байгаа юм байгаа. Энийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Үүний ард бид нар гарах учиртай. Ингэхгүйгээр бид нар цаашдаа томоохон уул уурхайн төслүүдийг хөдөлгөх боломжгүй. Нийгэм хүлээн зөвшөөрөхгүй. Тийм учраас өнөөдөр бид нар үнэнээ яриад, ил тод ярилцаад, парламентаар оруулж ирж асуудлуудаа яриад, тэгээд шинэ ийм төслүүдийг өмнөх алдаагаа давтахгүйгээр гаргах ийм л зүйл рүү явах нь бол зүйтэй. Энийг би танд эхний асуултад хариулъя.

2 дахь асуулт дээр би мань гишүүн рүү хандаж хэлж байгаа юм биш. Урьд нь энэ хэд хэдэн удаа давтагдаад, би өөртэй нь ч бас уулзаж ярьж байсан. Яг энэ зарчим дээр зарчмын байр суурь нь өөр байгаа зарим улс төрчдийн өнөөдөр яг энэ Үндэсний баялгийн санг бүрдүүлэхтэй холбоотой асуудал дээр удаа дараалан бас ил далд саад хийж байгаад л би бухимдаж тэгж хэлж байгаа юм. Энэ байр суурь дээрээ би байна. Тэр хүмүүсийн хувьд хэлэхэд ямар нэгэн байдлаар залуучуудыг өмнөө турхирах биш, асуудал байвал ил тод гарч ирээд, тэр мэтгэлцээнээ шууд хийх ёстой. Стратегийн ордууд хэн эзэмшиж байгааг бид нар мэдэж байгаа. Үүний цаана ямар ямар асуудлууд байгааг бас мэдэж байгаа. Тийм учраас эрхэм гишүүд та бүхэн маань ийм зүйлд бас битгий автаарай. Одоо энэ удахгүй энэ хаврын чуулган, намрын чуулганы хамгийн том сэдэв бараг энэ болох байх. Олон янзын зүйлүүд гарах байх. Энэ том нөхцөлүүдтэй адилхан.

Тийм учраас нэгэнт цагаа өнгөрөөчихсөн байгаа улс төрчид өөрсдийнхөө хэлж чадахгүй байгаа асуудлыг эрх ашиг нь зөрчигдөөд ирэхээр энд тэндээс энгийн залуучуудаар дамжуулж, эсвэл хэвлэл мэдээллээр дамжуулж ийм байдлаар бохир технологио энэ цаг үеийн улс төрд хэрэглэх гээд хэрэггүй л гэж би хэлж байгаа юм. Энэ дээр би дахиад ч яг ийм байр сууриуд бас илэрхийлнэ.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.11-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс 1 гишүүн төлөөлж, Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултуудыг асууна. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Батбаярын Жаргалан асуулт асууна. Гишүүнд асуулт асуух зөвшөөрөл 20 минутын хугацаатай олгогдоно. Энэ хугацаанд асуулт, хариулт явагдана.

Б.Жаргалан: Юуны өмнө асуултуудыг асуухаас өмнө Улсын Их Хурал бол чөлөөт мэтгэлцээний талбар байх ёстой гэдгийг дахин хэлье. Тэгээд бас сая Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 112.2-т заасан Ерөнхий сайдын хийх мэдээллийг

нэгдсэн хуралдаанаар сонсохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдэд бичгээр ирүүлнэ гэсэн заалт бас зөрчигдчих шиг боллоо. Яагаад гэхээр сая Ерөнхий сайд мэдээлэл хийхдээ бидэнд тарааснаас өөр мэдээлэл уншихсан. Тухайлах юм бол Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулна гэх мэтчилэн зүйлс нь энэ тараасан мэдээлэл дээр бол байгаагүй. Тэгэхээр цаашдаа бол бас дэгээ баримтлаад, тэгээд энэ мэтийн зарчмын шинж чанартай маш том өөрчлөлтүүдийг бид нар бас хөнгөн хуумгай ярьж болохгүй байх. Тэгээд 7, 7 хоногоор бодлогоо өөрчлөөд явах нь зөв үү үгүй юу гэсэн ийм зүйл байна.

Тэгээд иргэдээс Ерөнхий сайдын илтгэлтэй холбоотой асуултууд ирснийг багцалж асуухаар бэлтгэсэн байгаа. Тэгээд юуны өмнө бага зэрэг түүх бас ярья. Яагаад гэхээр Монголын төр бол ой санамжтай байх ёстой. Ерөнхий сайдын мэдээлэл гэж тарааж өгсөн материалд 2024 оны 4 дүгээр сард Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсанаар л Монголчууд бид байгалийн баялгаасаа тэгш шударга хүртэж эхэлсэн гэж удаа дараа дурдагдсан байгаа. Харин сая та яриандаа бас үүнийгээ засварласан байна. Бид ямагт өмнөх түүхээ санаж, алдаа онооноосоо суралцаж байх ёстой. Байгалийн баялгийн хуваарилалт хүртээмжийн асуудал өнгөрсөн 20 гаруй жилийн Монголын улс төрийн гол сэдэв байлаа шүү дээ. Баялгийн сан байгуулах санал санаачилгыг Ардчилсан намын үе үеийн гишүүд манлайлж ажилласан бөгөөд хамгийн анхны баялгийн сан 2006 онд Монгол Улсыг хөгжүүлэх сан нэртэйгээр байгуулагдаж байлаа. Уг санд хуримтлагдсан хөрөнгө хүүхдийн мөнгө хэлбэрээр Монголын айл өрх бүрд хүрч байсан төдийгүй дэд бүтэц зэрэг улсын хөгжилд нэн шаардлагатай хөрөнгө оруулалтад зарцуулсан байдаг. Улмаар Хүний хөгжил сан байгуулсан. Мөн Монгол Улсын иргэн бүрд Хүний хөгжил сан гэсэн нэртэй дэвтэр байсныг бас хүмүүс санаж байгаа байх. Цаашлаад 2016 онд Ирээдүй өв сангийн тухай хууль батлагдаад явж байна. Үндэсний баялгийн сангийн хууль бол жилийн өмнө 2024 оны 4 дүгээр сард батлагдсан. Тэгээд яг энэ хуулийг батлахдаа, мөн сая хуулийн өөрчлөлт гэж дурдахдаа энэ өмнөх сангуудаасаа та ямар сургамж авсан бэ гэдэг эхний асуулт байна. Тэгээд олон асуултууд байгаа учраас товч хариулахыг хүсье.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдын микрофоныг өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Өмнөх сангууд дээр бидний сургамж авах ёстой зүйл өнөөдрийн бидний яригдаж байгаа удирдлага зохион байгуулалтын асуудал. Тэгэхээр энэ дээр бид нар дүгнэлт хийгээд, нэгдсэн сангаа яаж зөв удирдах вэ гэдэг энэ асуудал.

2 дугаарт би дахиад хэлэхэд АМНАТ-ийг бид нар юу гэж нэрлэх вэ. Үндэсний баялгийн сангийн төлбөр гэх үү. Энийг нийгэм нэг мөр ойлгох ёстой. Тэгж байж уул уурхайн төслүүдийг дэмжинэ.

2 дугаарт өмнөх хугацаанд уул уурхайн бидний ярьж байгаагаар Стратегийн орд гэж байгаа асуудал дээрээ бид нар ойлголтоо цэгцлэх ёстой. Энэ дээр маш их олон мэдээллийн зөрүү, маш их олон маргааны сэдэв бол үүнтэй холбоотой. Тэгээд энэ асуудлаа шийдээгүй учраас бид нар баялгийн сангаа яг бодитой бүрдүүлэх тал дээр эрх зүйн орчин байсан мөртөө улс төрийн зоримог шийдлүүд дээрээ бүтэн бас парламент нэг талдаа гарч чадаагүй зүйл байгаа.

Б.Жаргалан: 2016-2024 онд Монгол Улс нийт 72,4 тэрбум ам.долларын эрдэс бүтээгдэхүүн экспортолжээ. Нүүрс, зэс, алт, төмрийн хүдэр, газрын тос гэх мэт

байгалийн баялгаа экспортолсноос нийтдээ 72,4 тэрбум ам.доллар олсон байна. Өнөөдрийн ханшаар 260,6 их наяд төгрөг. Бид аливаа тоон мэдээлэлд маш баримжаатай хандах ёстой. Гадаад зах зээл өсөлттэй байх үед борлуулалт нэмэгдсэн нь сайн хэрэг. Нөгөө талдаа төсөв энэ үед маш ихээр тэлсэн. Төр томорсон. Энэ хугацаанд ирээдүй өв санд дор хаяж 3-3,5 тэрбум ам.доллар хуримтлагдсан байх ёстой атал өнөөдөр та Ирээдүйн өв санд 1,2 тэрбум ам.доллар байгаа гэж тайлагнаж байна. Ирээдүй өв санд хуримтлагдсан байх ёстой хөрөнгө хаачсан бэ. Түүнчлэн хуульд заасанчлан ирээдүйн өв сангийн хөрөнгө тогтмол орлого олж байх ёстой. Сангийн хөрөнгийг зэрэглэл өндөр, эрсдэл багатай бонд, хувьцаа зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгсэлд тухай бүр байршуулах ёстой атал яагаад хөрөнгө оруулалт хийхгүй, Төв банкны дансанд байршуулсан гэж тайлагнаж байна. Уг сангийн хөрөнгө гадаад валютын албан нөөцөд тооцогдож байгаа юу гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Валютын нөөцөд тооцогдолгүй яах вэ. Тооцогдож байгаа. Ирээдүй өв санд би дахиад л хэлье. АМНАТ-ийн 65 хувь төвлөрч байгаа. Тийм учраас тэр төвлөрч байгаагаараа л энэ орлого бүрдэж байгаа. Харин энэ Үндэсний баялгийн сангийн хуулиар хөгжлийн асуудал болон дахиад хэлэхэд хуримтлалтай холбоотой асуудлыг бид нар хэрхэн зөв зохистой хуваарилалтыг хийх вэ гэдэг л өнөөдрийн тулгамдсан асуудал болчихоод байгаа юм. Судалгаа хийгээд үзэхээр уул уурхайн өгөөжийг зөвхөн 34 хувийн ноогдол ашиг гэж л ойлгоод байгаа юм. Ноогдол ашиг байхгүй болохоор уул уурхайн төсөл бүхэлдээ үр өгөөжгүй байна гэж иргэд ойлгоод байгаа юм.

Гэтэл АМНАТ-ийн 65 хувь төсөв бүрдүүлж байгаа, төсвийг тэлж байгаа гэдгийг тэр бүр бас ойлгохгүй байгаа. Үүнийг Сангийн яам орлогоо бүрдүүлж байгаа л гэж ойлгож байгаа. Дээрээс нь орон нутаг өөрийнхөө дэд бүтцийн хөгжлийн асуудалд хэрэгжиж байгаа энэ уул уурхайн төслүүдээс яаж санхүүжиж байгаа вэ гэдэг тэр АМНАТ-ийн 10 хувь бас тодорхой биш байгаа. Үүнийг орон нутгийн удирдлагууд ажлаа сайн хийж байна л гэж ойлгоод байгаа юм. Үүнээс болоод компани компанийн нэр дээр байгаа орлого, зарлагын хяналт тэнцэл, тайлан Үндэсний баялгийн санд иргэдийн хувьд нээлттэй харагдахгүй байгаа. Тийм учраас энэ ил тод байдлыг бий болгочихвол томоохон компаниуд болон хөрөнгө оруулагчидтай бидний хувьд хэлцэлд ороод, ингээд ирээдүйн төслүүд илүү нийгмийн дэмжлэгтэй, иргэний нийгмийн байгууллагууд ч гэсэн үүнийг дэмждэг байх ийм асуудлууд бол үүснэ. Энийг ингээд толгой эргүүлээд байгаа бас ийм хэсэг бүлэг хүмүүс байгаа. Үүнийг л бид нар нэвтэлж гаргах учиртай. Ингэхгүйгээр цаашдаа уул уурхайн төслүүд ч явахад Монголд туйлын хүнд. Орон нутагт ч гэсэн энэ том төслүүд хэрэгжихэд бол туйлын төвөгтэй байдалд орно.

Тийм учраас энийг хийх нь бол өнөөдрийн бас мэтгэлцээн, таны ярьж байгаа асуултад ялангуяа Ирээдүйн өв сантай холбоотой асуудлыг яаж менежмент хийх вэ гэдэг бол туйлын чухал асуудал болчихоод байгаа юм.

Б.Жаргалан: Тэгэхээр иргэдийн дэмжлэг байж байж бас уул уурхайн төслүүд хөдөлнө. Явна. Цаашдаа бид бас илүү их мөнгө хуримтлуулна гэж та хэлж байна. Гэхдээ яагаад иргэд бас эргэлзээд байгаа вэ гэхээр яг түрүүний миний хэлдэг энэ өнгөрсөн 8, 9 жилийн хугацаанд бид улс орноороо 72,4 тэрбум ам.долларынхоо уул уурхайн байгалийн баялгийг гадагшаа гаргачихсан байна. Тэгээд яг үүнийхээ эсрэг

бидэнд бас үзүүлж харуулах зүйл байхгүй байгаад байна. Иргэдийн амьдрал, амьжиргаа бодитоор сайжрахгүй байгаад байна. Нөгөө дэд бүтэц, нийгмийн асуудлууд шийдэгдэхгүй байгаад байна гэсэн шүүмжлэл байгаад байгаа учраас нийгмийн дэмжлэг сул байгаад байна. Тэгэхээр бид цаашид яг энэ асуудал дээр энэ уул уурхайгаас орж ирж байгаа мөнгийг яаж бодит амьжиргаанд бодит эдийн засаг руу чиглүүлэх вэ гэдэг асуудал дээр анхаарах ёстой гэж харж байна. Тэгээд үүн дээр бол бас ноогдол ашгийн асуудал, төрийн өмчит компаниудын бас үр өгөөжийн тухай асуудал яригдана. Тэгэхээр манай төрийн өмчит компаниуд дийлэнх нь орлого олж байгаа компаниудын дийлэнх нь уул уурхайн чиглэлийн компаниуд байгаа. Тэгээд төрийн өмчит компаниуд дээр жишээлэх юм бол 58 мянган ажилтан байгаа гэж байна. Энэ асуудал бас асуудал болоод л байгаа. Тэгэхээр тэнд бол жишээлбэл иргэдэд очих ёстой ноогдол ашгийг тэнд наана нь компанийн зардлаар бас зарцуулалт хийгээд яваад байна гэсэн асуудал ярьж байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор энэ 2 дугаар сард Эрдэнэс Монгол нэгдлийн доор Чингис хаан Үндэсний баялгийн сан гэдэг төрийн өмчит компани байгуулсан байна. Тэгээд уг нь Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн болон үйл ажиллагааны удирдлагыг төв банк болон Засгийн газрын холбогдох яаманд хэрэгжүүлэхээр хуульд заасан байдаг юм байна. Цаашид улс төрийн нөлөөгүй олон улсын менежмент ажиллуулах тухай их ярьсан. Гэтэл энэ компани байгуулаад тэгээд сая Баяраагийн Тэмүүлэн гэсэн үү захирал томилчихсон байж байна. Энэ компани жишээлэх юм бол хэдэн орон тоотой, ямар төсөвтэй вэ. Санхүүжилт нь хаанаас гарах вэ.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ Үндэсний баялгийн сангийн хуулиар 2030 он хүртэл Ирээдүйн өв санг бид нар цоожилсон байгаа шүү дээ. Тэгээд түүнээс хойш бол энэ санхүүгийн хэрэгсэлд ялангуяа эрсдэлгүй санхүүгийн хэрэгслүүд энэ Засгийн газрын бонд, үнэт цаас авахад ч гэдэг юм уу яг тэр ассет менежмент хийх, хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэх, түүнийг бол мэдээж энэ хөрөнгө оруулалтын сангийн хуулиар бол хөрөнгө оруулалтын менежментийн компани л удирддаг. Тэгээд тэр утгаараа явах ёстой. Цаашдаа одоо байгаа энэ сангуудынхаа менежментийг зөв зохион байгуулахын тулд бид нар бэлтгэл ажлыг хангуулах зайлшгүй шаардлага байгаа. Ер нь нийгмийн шүүмж ч байдаг. Иргэдийн шүүмж ч байдаг. Яагаад өнөөдөр энэ хөрөнгийг удирдлагыг нь шинэ түвшинд гаргахгүй байгаа юм бэ. Яагаад байгаа мөнгийг байгаагаар нь байлгаад байдаг юм бэ. Үүнийг үржүүлдэг, хөрөнгийг нь үржүүлэх ийм үйл ажиллагааг яагаад хийхгүй байгаа юм бэ гэдэг дээр бэлтгэл ажлыг хангуулахын тулд энэ Чингис хаан үндэсний баялгийн сангийн зүгээр менежментийн компани. 1 ёсондоо энэ компани бол зүгээр төслийн удирдлагыг л хэрэгжүүлж байгаа. Энэ чинь 12, 13 хүний орон тоотой. Тэгээд энэ залуучууд яг мэргэжлийн санхүүч нар, хуульчид, ерөнхийдөө ингээд бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр төслийн үйл ажиллагааг л явуулж байна гэсэн үг. Тэгэхээр энэ бол ямар нэгэн мөнгө санхүү удирдаад байгаа тийм хууль, эрх зүйн боломж угаасаа байхгүй. Тийм учраас энэ Чингис хаан баялгийн санг цаашдаа хэрхэн зөв удирдах вэ гэдэг чиглэлийн бэлтгэл ажлыг хангуулж байгаа, нийгэм олон нийтэд санхүүгийн зах зээлийн талаар, хувьцааны талаарх бас ойлголтуудыг өгөх энэ ажлыг л хийж байна гэсэн үг. Тэгэхээр бид бол яг өнөөдөр төрийн албан хаагч нарыгаа уриад, энэ баялгийн сангийн менежментийг нь аваад яваач, энэ дээр ажиллаач гээд тухайлан цаг гаргаад явах тийм бололцоо байхгүй. Эрдэнэс Монгол нэгдэл дэргэдээ энэ төслийн компани дээрээ харин ч энэ олон улсад зөвшөөрөгдсөн, хуульч, санхүүч, олон улсын банк, санхүүгийн байгууллагад ажиллаж байсан мэргэжлийн чадвартай залуучуудыг уриад, бэлтгэл ажлыг нь хангуулж байгаа. Тэгэхээр угаасаа хуулиараа

ч тэр цаашдаа энэ Ирээдүй өв сан менежментийг авч явахад бид мэргэжлийн хөрөнгө оруулалт, менежментийн компанийг л ажиллуулна. Тэгэхээр хөрөнгө оруулалт, менежментийн компанийг урьж ажиллуулахад энэ баялгийн сангийн менежментийг хэрэгжүүлж байгаа компани бэлтгэл ажлыг хангуулж байна л гэж ойлгож болно. Тэрнээс биш энэ компани бол ямар нэгэн хөрөнгө санхүү удирдах тийм чадамжтай ийм хууль, эрх зүйн угаасаа боломж ч байхгүй. Тэгэхээр энэ бол зүгээр ийм төслийн хэлбэртэйгээр л бэлтгэл ажлыг хангуулж байна гэж ингэж ойлгож бол болно.

Б.Жаргалан: Тэгэхээр бид Улсын Их Хурал дээр ч тэр төрийн өмчит компаниудын тоог цөөлье. Үр өгөөжийг нь нэмэгдүүлье гэсэн зүйлийг байнга ярьж байгаа. Тэгэхээр нэг талаараа ингэж яриад байгаа боловч нөгөө талдаа Засгийн газраас бас ийм сүртэй сүртэй нэртэй компаниуд байгуулаад, тэгээд тэр нь мэдээлэл нь ил тод биш, сая л мэдэж байгаа байхгүй юу. Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК гээд ийм сүртэй нэртэй компани байгуулчихсан гэдгийг. Ингээд байхаар бас итгэлцэл төрөхгүй байгаад байна. Иргэдийн дэмжлэг чинь бас бий болохгүй байгаад байна гэдэг асуудал чинь бас байна. Уг нь бол хэрэв нэгэнтээ гадаадын ч гэдэг юм уу, тийм олон улсын менежментийн баг сонгох гэж байгаа бол заавал ийм шат дамжлага байхгүй. Тэр иргэдэд хувьцааны талаар мэдээлэл олгох тийм боломж бололцоонууд зөндөө байгаа шүү дээ. Санхүүгийн зохицуулах хороо ч байна, Хөрөнгийн бирж нь ч байна. Тэгээд заавал ийм давхардсан бүтцүүд хийгээд байх тусам л энэ итгэлцэл, дэмжлэг суларна гэсэн ийм зүйл байна. Тэгээд хуримтлалын сангийн 2024 он, 2025 оны орлогыг бүхэлд нь ипотекийн зээлийн эх үүсвэрт зарцуулж байгаа гэж тайлагнасан байна. Энэ дээр бол иргэдээс бас маш их асуулт ирсэн байна. 2024 онд хуримтлалын санд төвлөрсөн төвлөрсөн 480 тэрбум төгрөгийг нийтдээ 4.184 иргэний ипотекийн зээлд зарцуулсан гэжээ. Тэгэхээр хуримтлалын нэрийн дансанд байршсан мөнгөө иргэн бүр өөрийн орон сууц, боловсрол, эрүүл мэнддээ зарцуулах эрхтэй байна гэсэн тийм ойлголт, хүлээлттэй яваад байгаа. Гэвч өнгөрсөн жил сангийн мөнгийг нийт иргэдэд бус зөвхөн 4000 хүний ипотекийн асуудлыг шийдвэрлэхэд зориулжээ. Энэ ипотека руу зарцуулах шийдвэр ямар үндэслэлээр хаанаас гарсан бэ. Тэгээд яагаад ер нь энэ төсвийн шинж чанартай зарцуулалтад зарцуулаад байна вэ. Хуримтлалын сангийн хөрөнгө өгөөж олох ёстой. Бодлогын хүүгээс багагүй хувиар өсөж байх ёстой гэж хуульд заасан байгаа. Тэгээд түрүүн Уянгахишиг гишүүний асуугаад байдаг 2024 онд хүүгийн орлого 4,9 тэрбум төгрөг олсон. Тэгэхээр 480 тэрбум төгрөгийн өгөөж 4 тэрбум төгрөг гэхээр бас чамлалттай л байгаа юм л даа. Тэгэхээр цаашид энэ хуримтлалын санд хуримтлагдсан гэх иргэн бүрийн нэрийн дансанд байгаа гэх 138.993 төгрөг ойрын хугацаанд хэд хүртэл нэмэгдэх боломжтой вэ гэж иргэн Дөлгөөнзаяа асуусныг уламжилж байна.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан сайд хариулт өгье.

Л.Энх-Амгалан: Бид нар баялгийн сангийн тухай хуулиараа 3 сан байгуулсан. Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөрөнгө оруулалтын сан. Тэгээд хуримтлалын сан дээр иргэд дээрээ данс нээгээд, уул уурхайн компаниудын 34 хувиас хуваарилж байгаа дивиденд ноогдол ашгийг цуглуулж, бид нар иргэдийнхээ дансандаа хуваарилалт хийж байгаа. Өнөөдөр бас иргэд бүх дансныхаа үлдэгдлийг харах ийм боломжтой байгаа. Тэгэхээр энэ хуримтлалын сан дээр хуримтлагдаж байгаа энэ мөнгө өөрөө 2030 он хүртэл тодорхой хуримтлагдах ёстой юм. Тодорхой цаг хугацаа бас энд хуримтлал хийх цаг хугацаа хэрэгтэй байгаа. Тэгэхээр юу гэдэг юм шууд сая

1072 ширхэг хувьцаа шиг шууд данс руу нь өгчихнө гэсэн үг биш шүү дээ. Яагаад гэвэл хуримтлал үүсэх байхгүй юу. Тэр үүссэн хуримтлалаар нь ирээдүйд харин. ...

Б.Жаргалан: Иргэдийн хуримтлалыг яагаад ипотект зарцуулаад байна вэ гэдэг байна.

Л.Энх-Амгалан: Харин тийм. Одоо би танд тайлбарлах гэж байна л даа. Тэгээд яг энэ хуулиар чинь бол хуримтлалын үүссэн хуримтлалыг ирээдүйд эрүүл мэнд, боловсрол, орон сууцад зарцуулна гэдэг угаасаа хуультай, хуулийн зохицуулалттай. Тэгэхээр энэ дээр нэгэнт иргэдийн данс дээр ирж байгаа хуримтлалыг бид нар бас хөрөнгө оруулалтын энэ чинь хуримтлалын сан чинь нөгөө талдаа хөрөнгө оруулалтын сангийн хэлбэрээр ажиллах ёстой шүү дээ. Тэгээд угаасаа хуульчилсан. Сая та өөрөө хэлж байна. Баялгийн сангийн тухай хуулиар энэ хуримтлалын сангийн өгөөж бодлогын хүүгээс багагүй байна гэж. Тэгэхээр бид нар Монголбанктай гэрээ хийгээд, Монголбанк бол хөрөнгийн менежментийн удирдлагыг хийж байгаа. Өнгөрсөн жил хийсэн. Энэ хөрөнгийн менежментийн удирдлагыг хийсэн 1 арга хэрэгсэл нь тэр ипотекийн санхүүгийн эх үүсвэр болгосон. Гэхдээ энэ дээр ямар ч байсан Монголбанктай хийсэн гэрээгээр бид 1 жилийн гэрээ хийсэн. 1 жилийн гэрээгээр 480 тэрбум төгрөгийг ипотекийн сангийн санхүүжилтэд оруулаад, үүнээс хүртэх өгөөжийг бодлогын хүүгээс багагүй байна гэхээр 30 тэрбум болж байгаа юм. 30 тэрбум. Тэгэхээр оны төгсгөлөөр 12 сарын 31-ээр оны төгсгөлөөр бид нар 4,9 тэрбум төгрөг авсан өгөөж. Одоо ингээд энэ гэрээ 5 сарын 9-ний өдөр дуусах учраас бид нар гэрээгээ дүгнээд үлдэгдэл 25 тэрбум төгрөгийг бид нар хуримтлалынхаа данс дээр авч, иргэдийн хуримтлуулж байгаа мөнгөний тэр өгөөжийг хүү хэлбэрээр нь өгөх ийм л юм байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сүүлийн асуулт. Үндэсний баялгийн санд төвлөрөх хөрөнгийг бид аль болох арвижуулах, нэмэгдүүлэх үүрэгтэй байгаа. Тэгээд харамсалтай нь 2025 оны төсөв батлах үед Ирээдүй өв санд төвлөрүүлэх АМНАТ-ийн хувийг бас бууруулж, төсвийн орлого бүрдүүлсэн. Тэгвэл сая Засгийн газраас өргөн бариад буцаагаад татчихсан байж байгаа Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд Баялгийн сангийн орлогыг бас улам бүр бууруулж болзошгүй заалт тусгагдсан байгаа. Төрийн өмчит компаниуд мега төслүүд бариулах зорилгоор ашигт малтмалаа бараа солилцоогоор бартерлаад эхлэх юм бол баялгийн санд төвлөрөх мөнгөн орлого илт багасах нь тодорхой. Энэ талаар ямар тооцоо судалгаа хийсэн бэ гэж.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье. Тэгээд ер нь баялгийн сангийнхаа хуримтлалыг нэмэгдүүлэх гээд л бүх талаар л оролдож байгаа л даа. Тэгэхээр одоо долоохон компани төрийн эзэмшлийнхээ 34 хувийн ноогдол ашгийг 1 жилийн дотор хуримтлуулахад 480 тэрбум хүрнэ гэдэг бол төрийн эзэмшлийн тэр ноогдол ашиг буюу 34 хувийн ноогдол ашиг, тэгээд энэ төрийн өмчийн компаниуд өөрөө ашигтай ажиллаад эхэлбэл баялгийн сангийн хуримтлал жил ирэх тусам нэмэгдэх юм. Тэгээд ер нь цаашдаа ашиггүй ажиллаж байгаа төрийн өмчийн компаниуд бид нарт хэрэггүй. Ерөөсөө ямар ч шаардлага байхгүй. Энэ бол баялгийн сан дээр илэрнэ. Иргэд тэр М-монголынхоо аппликэйшнийг гаргаад үзэхээр энэ компани баялгийн санд багахан ч хувь хэмжээний ноогдол ашиг хуримтлуулж өгөхгүй байна. Энэ компани хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу л гэдэг ийм асуултыг тавьж эхлэх байхгүй юу. Тийм учраас энэ бол нэг хэлбэр.

Цаашлаад ер нь энэ хувийн хэвшлийн үйл ажиллагаанд төр нэг их тийм ноогдол ашиг аваад л, хувь хувьцаа эзэмшиж явдгаасаа илүүтэйгээр ер нь бол шууд тэр амнаас нь ашигт малтмалын нөөцийг баялгийг ашиглаж байгаа бол төлбөрийг нь авдаг. Тэгээд тэр хувийн хэвшлийн үйл ажиллагаанд оролцоод байдаггүй. Тэгээд худлаа үнэн хэдэн хүнийг тэжээх гэж ТУЗ-д нь хүн суулгадаг энэ тэрээсээ салах л ёстой. Тийм учраас тэр сая Ораногийн гэрээн дээр ч гэсэн зөв жишиг гарсан. Түүнтэй адилхан баялгийг ашиглаж байгаа бол тэр уурхайн компаниуд төлбөрөө төл. Тэр төлбөр нь шууд иргэдийн хуримтлалын дансанд орно. Тэгээд жил болгон санхүүгийн тайлангийн жил нь дууссаны дараа ингээд иргэд гар утсаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 20 минутын хугацаа дууссан байна. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал асуулт асууна.

О.Батнайрамдал: Баярлалаа. Ерөнхий сайдын хийх мэдээлэлтэй холбогдуулан иргэдийн үлдсэн асуултыг асуух дэгтэй байгаа. Иргэн Өлзийбатаас дараах асуултуудыг асуусан байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг бол дэмжиж байгаа. Сингапур, Норвегт, Саудын Араб, Казахстан шиг Монгол Улс болох ёстой. Үүнийг хийхийн тулд тэр стратегийн ордуудын эзэмшлийг хэрхэн тодорхойлох вэ гэдгээс шууд шалтгаална. Тийм учраас их тодорхой хэдэн асуулт тавьсан байна. Асуулт нэг бол тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамруулах тухай Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолыг дурдаад, үүндээ яг Ухаа худаг ордын стратегийн ач холбогдол бүхий ордод авах, эндээс төр ямар хувь эзэмших вэ. Засгийн газар энэ дээр ямар шийдэлтэй вэ. Энэ яагаад удаад байна гэсэн асуултыг тавьсан байна.

2 дугаарт мөн яг энэ 2007 оны 27 дугаар тогтоолтой холбоотойгоор 39 стратегийн ордын жагсаалт дотор 18 дээр эрэмбэлэгдсэн нийгмийг бас 2 талцуулаад байгаа Төгрөг нуурын ордыг бас дурдсан байна. Энэ Төгрөг нуурын ордыг бас төрийн мэдээлэлд хувь хэмжээг нь авах энэ хэлцэл яагаад бас шийдвэрлэгдэхгүй байна вэ. Энэ хэр их хугацаа шаардах вэ гэж бас асуусан байна.

Мөн үргэлжлүүлээд Засгийн газрын БЭТ Батзандан 2025 оны 4 сарын 14-нд дурдсан Баян хөндийн Алтаннар, Хармагтай, Халзан бүрэгтэй зэрэг 8 ордыг Засгийн газарт саналаа оруулсан. Энэ дээр ямар нэмэлт мэдээлэл байна. Мөн Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр сумын нутаг дэвсгэр дамнасан Баян хөндий, Алтан нар ордуудын талаар асуусан байна.

Мөн 2 дугаарт энэ нэмэлт ордуудаас гадна стратегийн орд газрыг анхнаас нь стратегийн ордын жагсаалд оруулахгүй байх зорилгоор албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглаж жижиглэн олон хуваах ийм болзошгүй эрсдэл байна. Энэ дээр ямар байр суурьтай байгаа гэж 2 багц асуултыг иргэн Өлзийбат асуусан байна. Хариултаа авчхаад, дараагийнхаа асуултуудыг нь үргэлжлүүлж асууя.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Тэгээд 18 жил Их Хурлын тогтоол гаргачхаад энэ стратегийн ордод тооцуулах тогтоолоо Их Хуралд оруулж ирээгүй 18 жилийн хугацаанд ер нь юу олгосныг бол тэгээд та бүхэн зүгээр 1, 2 жишээнээс харж байгаа шүү дээ. Тэгээд энэ

орчин үеийн залуучууд их өөр болсон юм билээ. Түрүүн бас Жаргалан гишүүн хэлж байсан. Энэ Чингис хаан баялгийн сангийн менежментийн компанид энэ орчин үед өндөр боловсрол эзэмшсэн залуучуудыг орж ажиллуулж, тэр дэлхийн хөрөнгө оруулалтын менежментийн компанийг урьж авчрах, менежментийг сайжруулах тэр ассет менежмент хийлгэх гээд бид нар чинь урьж залж байгаа байхгүй юу. Яг үнэндээ. Тэгэхгүй бол энэ төрд чинь ажиллах хүнгүй болчихоод байна л даа. Тэгээд нөгөө өгөөжийг нэмэгдүүлэх ажлуудыг хийлгэхэд дэлхийн хэл усаар ярих гаднын менежмент эд нар олж ирэхэд бас л зүдэрч л байгаа байхгүй юу. Тэгээд энэ залуучууд чинь өөрсдөө нөгөө оффшороор дамжуулаад яаж мөнгө төгрөг гаргадаг юм, яаж үндэстэн дамнасан хэлхээ холбоо үүсгэдэг юм, яаж жонхууруулдаг вэ гэдгийг надаар хэлүүлэлгүй өөрсдөө гаргаж ирээд олон улсын тэр биржээс мэдээ мэдээллийг нь аваад ингээд нэгтгээд гаргаад ирж байна л даа. Тэгээд л ингээд л байгаа л баримтууд гаргаад л тавихад зүгээр нэг дээр нь л нэг ийм юм болдог. Түүн шиг одоо бол бид нар цаашдаа нөгөө нуурыг нь харахгүй худгийг нь хараад, овоог нь харахаар овоолохыг нь харахгүй байдаг ийм зарчимгүй үйлдлээ бол таслан зогсоогоод баялгийн сан дээр яг тэгш хандах ёстой. Хэлэлцээр хийх ёстой. Тэгээд байгалийн баялгийг хэн нэгэн бүтээгээгүй. Бүгдтэй нь тэгш сайхан хэлэлцээр хийгээд ингээд асуудлаа шийдэх юм бол баялгийн сангийн хуримтлал нэмэгдэнэ л гэж ойлгож байгаа. Тийм учраас бүгдэд тэгш хандъя гэдэг энэ зарчмаар баялгийн сангийн хуулийг хэрэгжүүлэх гээд л ажиллаж байгаа. Тэгээд энэ хүрээндээ асуудлаа шийдээд явна.

Тэгээд бид нар нэг зүйлийг ойлгох ёстой. Тэнд хэрвээ янз бүрийн орд газрууд байгалийн баялаг дээр хуулийн хариуцлагатай асуудал байвал татвараас нуугдсан, тэр оффшороор дамжуулсан янз бүрийн асуудал байвал тэрийг хуулийн байгууллага тогтооно. Бусдаар бол тэр баялгийн сангийн хэлэлцээр тусдаа асуудал. Бүгдэд нь тэгш хандана. Их Хуралд оруулж ирнэ. Тэгээд асуудлуудаа хамтдаа шийд явна. Хуулийн хариуцлагын асуудал бол хуулийн байгууллагад янз бүрийн баримтууд олдсон бол түүнийг хуулийн байгууллагаар илгээнэ, түүнийг хуулийн байгууллага шалгана. Гэхдээ үүнээс үл хамаараад монголчууд байгалийнхаа баялагтаа эзэн болох ажил бол тасралтгүй хийгдээд явна л гэдэг ийм байр суурьтай л байгаа.

Д.Амарбаясгалан: Батнайрамдал гишүүн үргэлжлүүлэн асууя. Энэ асуудал Ерөнхий сайдын мэдээллийн дараа Жагсаал, цуглааны эрх чөлөөний тухай хуулийн асуудал орно шүү. Тамгын газар бэлдээрэй. Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Дараа нь иргэн Ганбаярын маш тодорхой асуулт байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК болгож орон нутгаас нь боловсон хүчин нөөцөө бүрдүүлж болохгүй юу. Мөн иргэн Ганбаярын 2 дахь асуулт. Асуулт давхцаж байгаа ч гэсэн иргэний асуултыг асуух ёстой. Эрх зүйн зохицуулалтаа сайн хийж иргэн бүрд бодитой хүрсэн бүх шатдаа үнэнч шударга ажилламаар байна. Эрх мэдэл албан тушаалаа ашиглаж боломжийг дээгүүрээ хүрдэг байж болохгүй байна. Үүн дээр бол бухимдалтай хандаж байна. Иймд тэгш хүртээмжтэй зохицуулалт хийх талаар бас илүү дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч, бодлоо хэлээч гэсэн ийм 2 асуултыг иргэн Ганбаяр асуусан байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Ганбаярт баярлалаа. Өнөөдөр бид Баялгийн сангийн тухай хуулийг яг сонгодог агуулгаар нь батлаад, яг 1 жил болж байна. Хэрэгжиж эхлээд.

Хэрүүлтэй уруултай зөндөө юм болсон. Би бас хэлсэн. Оюутолгойтой холбоотой 2,3 тэрбум доллар тэглэгдэх гэж Их Хурлаар 3 ч удаа бас нэлээдгүй л мэтгэлцээн өрнөсөн. Эрдэнэтийн 49-тэй холбоотой асуудал бас бөөн л юм болсон. Наад Дархан төмөрлөг, Хөтөл гээд. Гэхдээ энэ бүх зүйлийн үр дүнд бид нар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өнгөрсөн жил баталж чадсан. Намууд зөвшилцөж чадсан. Өнөөдөр мэдээж бид нар 1 жилийн дараа яг нэгдсэн 3 сангийн тухай ярьж байна. Тэгээд дэлгэрэнгүй тайлбарла гэсэн учраас би маш товч байдлаар стратегийн ордын 34 хувь болон түүнтэй тэнцүүлж зөвшилцөх борлуулалтын орлого эсвэл АМНАТ, үүнийг бид нар хэрхэн томьёолох вэ гэдгийг өнөөдөр бас бид нар ярьж байна. Үндэсний баялгийн сангийн төлбөр гэх үү, роялти гэдэг ойлголтыг хэрхэн тодорхойлох вэ. Энэ бол иргэдийн хуримтлалын нэгдсэн сан. Гэхдээ энэ бол банк шиг боловсрол, эрүүл мэнд, орон сууцад зарцуулагдана. Мэдээж жишээлбэл орон нутаг руу иргэд шилжиж байгаа бол давуу байдлаар тэр сангаас түрүүлж зээл авах ч юм уу ийм боломжийг бол менежментийн баг бүрдүүлнэ. Энэ бол хуримтлалын сан. Тийм учраас өнөөдөр маргаан болоод байгаа стратегийн ордуудын 34 хувьтай холбоотой асуудлыг яаж бид нар АМНАТ-өөр юм уу эсвэл борлуулалтын орлогоор эсвэл 34 хувиар нь байлгах вэ гэдэг хуримтлалын нэгдсэн сан хэрэгжих хамгийн том ийм сорилт өнөөдрийн мэтгэлцээний гол асуудал болчихоод байгаа юм. Энэ үе шаттай Их Хурлаар орж ирнэ. Тус бүрдээ бас нэлээдгүй мэтгэлцээнтэй. Энэ дээр парламентын гишүүд манай иргэдийн хувьд ч тэр туйлын мэдээллээ нягталж, маш хэрсүү хандах ийм чухал сорилт дундуур бид нар гарна. Тус бүрдээ л бас томоохон асуудлууд дагуулна.

2 дахь нь бол Хөгжлийн сан. Сая Жаргалан гишүүн ч бас асууж байна. Үнэн. Яагаад уул уурхайн баялгийг ашиглуулаад байгаа мөртөө манай орон нутаг хөгжихгүй байгаа юм бэ гэдэг асуудал. Энэ бол аргагүй бас АМНАТ 65 хувь нь шууд ирээдүйд гэж хуваарилагдаж байгаа учраас зөвхөн улсын төсөв бүрдэх дээр л уул уурхайн томоохон төслүүд нэмэр болж байгаа юм. Гэтэл бид нар төсвөө уул уурхайн төслүүдийг яваад байхаар дагаж тэлээд байна гэж байгаа юм. Цаашлаад бид нар төсвийг бол уур уурхайн бус орлогоор уул уурхайн орлогын зохих хувиар бүрдүүлдэг байх ийм эрх зүйн орчин руу бол Үндэсний баялгийн сангаар дамжиж шилжих учиртай. Ингээд зарим жил мэдээж нүүрсний ч юм уу, зэсийн үнэ өсвөл түүгээрээ дамжаад бид нар шууд дэд бүтцийнхээ төслийг хийдэг байх ёстой. Багасчихвал хийхгүй байх ёстой. Тийм учраас энэ асуудлууд дээрээ бид нар 1 жилийн дараа өнөөдөр дүгнэж ярилцаж байна. Цаашлаад Засгийн газар дээр дүгнэж яриад, бас бүлгүүд дээр танилцуулаад, тодорхой бас хэд хэдэн ийм эрх зүйн орчныг өөрчлөх нь бол зүйтэй юм гэж үзэж байгаа. Энэ бол Хөгжлийн сан. Зарчим нь бол иргэд орон нутаг уул уурхайн төслийг дэмжиж байгаа бол түрүүлж хөгжих зарчим. Энэ бол бас олон нийтийн дэмжлэгтэй байлгах тал дээр бол туйлын чухал юм.

Мэдээж ирээдүйд хадгалагдах Ирээдүйн өв сан. Ирээдүйн өв сангийн арвижуулах менежментийг илүү боловсронгуй болгох асуудал. Энэ 3-ын нэгдсэн менежментийг Үндэсний баялгийн сан гэж нэрлэж байгаа юм. Тийм учраас бид нар Үндэсний баялгийн сангаа хамгаалах учиртай. Хуулиа хэрэгжүүлэх ёстой. Хэлцлүүдээ хийх ёстой. Тэгээд баялаг үндсэн хуулийн дагуу өнөөдөр ба ирээдүйн иргэдэд иргэдийн сайн сайхан амьдрахад асуудлаа шийддэг байх ёстой. Яагаад гэвэл экспортын 90 хувь учраас.

О.Батнайрамдал: Бас нэг асуулт байсан байгаа. Дарханы Төмөрлөгийн үйлдвэртэй холбоотой. Тэгээд энийг бас жоохон дэлгэрүүлмээр байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэр гэлтгүй ер нь төрийн өмчит компаниуд, тэр дундаа хамгийн

том орлогыг бүрдүүлэгч бол дандаа уул уурхайн компаниуд байгаа юм. Тэгэхээр 1 ёсондоо газрын баялгийг ашиглаж байгаа төрийн өмчит компаниуд бол орлогын дийлэнхийг бүрдүүлдэг. Тэгэхээр энэ төрийн өмчит компаниудын ил тод байдлыг хангах илүү сайн засаглал руу шилжүүлэх энэ процесс бол өөрөө Үндэсний баялгийн сангийн хууль хэрэгжихтэй шууд холбоотой. Тэгэхээр энэ үндэсний баялгийн санг тэр дундаа энэ дээр бас нэг комплект гараад байгаа юм л даа. Жишээлбэл бид нар Тимасеки гэх жишээ авдаг. Тимасеки гэхдээ энэ бол төрийн өмчит компаниудын нэгдэл. Олон улсад бол serving development fund буюу Монголоор орчуулах юм бол яг Хөгжлийн сан гэсэн концептоор явж байсан. Тэгэхээр орлого хэн бүрдүүлж байна. Орлогоо сайн бүрдүүлж чадсан уу. Тэгэх юм бол бид нарт хуваарилалт байна л гэсэн үг. Тэгэхээр энэ орлогыг илүү сайжруулах үйл процесс өөрөө энэ төрийн өмчит компанийн шинэчлэлүүд, тэр дундаа Эрдэнэс Монгол, Эрчист Монгол хэрхэн цаашдаа илүү шинэчлэлийг сайн хийж чадах вэ гэдэгтэй нэг ёсондоо шууд холбоотой гэсэн үг. Энэ шинэчлэл сайн хийгдэхгүй бол бид нар хэчнээн сангууд ярьсан ч гэсэн тэр нь мөнгөжиж өгөхгүй гэсэн үг. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор энэ төрийн өмчит томоохон компаниудыг иргэн Ганбаярын асуулт бол яг л Дарханы төмөрлөгийн үйлдвэр гэж жишээ аваад байна л даа. Олон нийтийн компани хэзээ болох вэ. Орон нутгаас илүү боловсон хүчнээ татдаг ийм шийдэл рүү хэзээ орох вэ гэсэн тодорхой асуултыг асууж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Уул уурхайн компаниуд бол Эрдэнэс Монгол нэгдлийн доор Үндэсний Баялгийн сангийн хуулиараа төвлөрсөн. Эрчист Монгол буюу уул уурхайн бус төрийн өмчит компаниудыгаа мөн Эрчист Монголын доор нэгтгэсэн энэ ерөөсөө бүтээмж нэмэгдүүлэх зорилготойгоор л ингэж 2 нэгдэл бий болж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ 2 нэгдэл бол цаашдаа юу хийх вэ гэхээр ер нь бид нар баялгийн сангийнхаа хуулийн концепцын хүрээнд энэ хөгжлийн сан буюу хөрөнгө оруулалт хийдэг, томоохон төслөө санхүүжүүлдэг, ашиг орлогоо нэмэгдүүлдэг төсвөөс гадуур ийм төслүүдээ санхүүжүүлдэг ийм нэгдлийг л бий болгож байгаа юм. Тэгэхээр энэ нэгдлүүд бол цаашдаа ер нь бол баялгийн сангийн хуулиар Эрчист Монгол ч гэсэн өөрөө ноогдол ашгийнхаа тодорхой хувийг баялгийн сандаа төвлөрүүлдэг болж чадвал ашиггүй компаниуд бол шаардлагагүй болно гэсэн үг. Тэгэхээр Их Хурлын гишүүдээс бид хүсэж байгаа нь сая өргөн мэдүүлчихсэн байгаа төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулийг хамтдаа баталж чадвал одоо тэр янз бүрийн улс төрийн нөлөөтэй томилгоонууд бол цаашдаа хийгдэхгүй болно. Энэ шинэ төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулиар бол ТУЗ-ийн гишүүд гүйцэтгэх захирлуудын босго шаардлага бол асар өндөр болж байгаа. Энд янз бүрийн тийм шахааны томилгоо нөлөөлөх бололцоо бол үнэн хүнд болно. Яагаад гэвэл ашиггүй ажиллуулж байгаа татан буулгаад явчихаар ашигтай ажиллуулж чадах сайн менежерүүдийг л томилох шаардлага үүснэ. Ингэснийхээ хэрээр төрийн өмчит компаниудын энэ захирлуудын нэр хүнд энэ компаниудын нэр хүнд түүнийгээ дагаад өснө. Эрдэнэс Монгол ч бай, Эрчист Монгол ч бай баялгийн сандаа ноогдол ашгийнхаа тодорхой хувийг хуримтлуулдаг болохыг л бид нар шаардана. Ингэж байж цаашдаа энэ засаглал өөрөө зөв болно. Баялгийн сангийн хөгжлийн сан өөрөө хөрөнгө оруулалтын яг сангийнхаа жишгийн дагуу төслүүдээс санхүүжүүлдэг ийм л статустайгаар болгоё гэдэг утгаараа энэ 2 нэгдэлд хувааж бүтээмжийг нэмэгдүүлэх, хэмнэлт бий болгох, тэгээд захиргааны орон тоонуудыг багасгах чиглэлээр ажлууд хийгдээд явж байгаа. Одоо Их Хуралд Нийтийн өмчийн тухай хуулийг бариад нийтийн өмчийн хууль нийтийн өмчит компанийн засаглал ил тод байдлыг

сайжруулах хууль батлагдсанаараа компани бие дааж засаглах бололцоо үүнээс бүрдэнэ гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

О.Батнайрамдал: Үүнтэй холбоотойгоор бас нэмэлт мэдээлэл өгөөд Учрал сайдаас илүү тодруулчихмаар байна л даа. Эрдэнэс Монголын санхүүжилтээр би Ди Өү Интернэйшнл гээд олон улсын консалтинг компани цаашдаа Эрдэнэс Монголын ирээдүй хаашаа чиглэх вэ гэсэн томоохон судалгааг бол одоогоос 6,7 жилийн өмнө хийсэн байдаг. Эрдэнэс Монгол дээр энэ судалгаа бараг 1000-аад хуудас олон улсын консалтинг компанийн хийсэн судалгаа байгаа. Тэр компани юу гэж Эрдэнэс Монголд зөвлөсөн бэ гэхээр Эрдэнэс Монгол өөрөө баялгийн сан болж хувирах ёстой. Тэр дундаа хөгжлийн сан болж дотоод Фортеолли компанитай үүнийхээ олон улсын баялгийн сангийн Сантёгийн зарчмаас эхлүүлээд хэрэгжүүлээд явах ёстой гэсэн зөвлөгөөг өгсөн байдаг л даа. Тэгэхээр сая нэгэнтээ Ерөнхий сайд бас энэ хэлцлүүд явахын хажуугаар баялгийн сангийн энэ концепт энэ бүх зүйлээ маш ойлгомжтой болгох ёстой. Нэмэлт, өөрчлөлт оруулна гэж байгаа бол бид нар энэ 3 сан дотроо тэр дундаа хөгжлийн санг энэ яг олон улсын зарчим руу шилжүүлэх нь бас зүйтэй гэж бодож байгаа юм л даа. Тэгээд яг сая Учрал сайд тайлбарласан шиг дотроо уул уурхайн, уул уурхайн бус гээд хуваагдана уу. Хамгийн гол нь яг олон улсын баялгийн сангийн зарчмыг биелүүлсэн ийм сан болж хөгжих ёстой л доо. Тэгэхээр энэ дээр бас Учрал сайдаас нэмэлт тайлбар авчихъя.

Д.Амарбаясгалан: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Тийм хөгжлийн сан бол цаашдаа бол хөрөнгө оруулалтын сангийн жишгээр бол ажиллах ёстой. Одоо бол хуулиараа Эрдэнэс Монгол бол нөгөө баялгийн сангийн орлого төвлөрүүлж байгаа хуулийн этгээд. Ер нь бол цаашдаа Баялгийн сангийн орлого төвлөрүүлэх бол нэг чиг үүрэг нь, нөгөө чиг үүрэг нь бол улс орны хэмжээний энэ томоохон төслүүдээ санхүүжүүлээд, түүнийхээ хариуд ашиг орлого нь нэмэгдэж байдаг энэ хэлбэр лүү орох нь зөв юм гэж ингэж үзэж байгаа. Зүгээр баялгийн сангийн хуулийнхаа дагуу мэдээж хэлэлцээрүүд бол явагдана. Хэлэлцээрүүд явагдахад бид нар тэр дю дилиженс гэж байгаа. Энэ хяналт шинжилгээг хийх хэрэгтэй. Хяналт шинжилгээг хийгээд бид стратегийн ордуудын 34-ийг авна. 50 хувь дээрээ хэлэлцээр хийнэ гэдэг чинь бол хэн ч гэсэн шинэ машин авахад хүртэл ядаж л будагтай байна уу, замасктай байна уу гэдгээ энэ чинь бас шалгаж байж л авах ёстой шүү дээ. Тэгээд тэр утгаараа ажиллана л гэж ингэж ойлгож байгаа. Тэгэхээр бид нар хэлэлцээрийг бол хяналт шинжилгээ хийж байж хийнэ.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ингээд Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг нэгдсэн хуралдаанаар сонслоо.

16.47 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэл уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

О.Алтангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 35 дугаар тогтоол, Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 1994 онд батлагдсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Тус хуулийн төслийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, Монгол Улсад хүний эрхийн төлөв байдлын нийт 6 удаагийн илтгэлд тусгасан мэдээлэл, дүгнэлт, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн талаар Эмнести Интернэйшнл төрийн бус байгууллагаас гаргасан тайлан, дүгнэлт, зөвлөмж, Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооноос 2021 онд зохион байгуулсан Жагсаал, цуглаан зохион байгуулах журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэгт тусгагдсан зарим асуудлуудад үндэслэн нэрийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл гэж өөрчлөн дараах агуулгаар боловсруулаад байна. Үүнд:

1.Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд жагсаал цуглааныг Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага зохион байгуулах эрхтэй байгааг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага зохион байгуулах эрхтэй байхаар өргөжүүлэх.

2.Хүчин төгөлдөр хууль, жагсаал, цуглаан зохион байгуулах, санаачлах асуудал нь тодорхой хүрээ хязгаартай. Тухайлбал, улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар гэж тусгайлан заасныг өөрчилж, ямар ч асуудлаар жагсаал, цуглаан хийж болохоор нээлттэй байх.

3.Жагсаал, цуглааны төрөл хэлбэр болох аяндаа бий болсон зэрэгцэн эсрэг жагсаалыг зохион байгуулахыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хэв журмыг хамгаалах.

4.Бүртгүүлэх нэртэй боловч зөвшөөрөл авдаг тогтолцоог халж, зөвхөн авто замын зорчих хэсэг дээр урьдчилан мэдэгдэж хариу авсны үндсэн дээр, хуулиар хориглосноос бусад газарт мэдэгдэл хүргүүлснээр зохион байгуулах боломж бүрдүүлэх.

5.Мэдэгдэл хүлээн авах, хариу өгөх, хууль бус жагсаал цуглааныг албадан тараах эрх бүхий этгээд нь Засаг дарга буюу улс төрийн албан тушаалтан байгааг өөрчилж, мэдэгдэл хүлээн авах этгээд нь Цагдаагийн байгууллага, харин албадан тараах этгээдийг Цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн Засаг даргын Тамгын газрын дарга байхаар өөрчлөх.

6.Хориглолт хязгаарлалтыг тодорхой болгохоор төсөл зохицуулалтыг тусгасан. Нийтийн хэв журам, үндэсний аюулгүй байдлыг хангах, бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах шаардлагаар зөвхөн хуулиар байршил, зорилго, агуулга, субъект, цаг хугацааны хориглолт, хязгаарлалт тавихыг хүлээн зөвшөөрч, жагсаал,

цуглаан хийх эрхийг хориглосон, хязгаарласан агуулгатай захиргааны акт баталж мөрдүүлэхийг хориглох.

7.Зөвхөн хуульд заасан үндэслэлээр албадан тараах. Ингэхдээ тус ажиллагааг баримтжуулах, урьдчилан сануулах, оролцогчийн хувийн байдалд тохирсон арга хэмжээ авах, аль болох хамгийн бага хүч хэрэглэх аргыг сонгох, тус ажиллагааг хэрэгжүүлсэн талаар олон нийтэд мэдээлэл өгдөг байх.

Түүнчлэн хуулийн төсөл хүчин төгөлдөр үйлчилж байгаа зарим зохицуулалтыг хэвээр хадгалсан болно. Тухайлбал, онц байдал, дайны байдал зарласан гамшиг, осол тохиолдсон хугацаанд хориглох, энэ хууль болон бусад хуулиар хориглох тодорхой байршлууд зохион байгуулагч болон оролцогчийн үүрэг мэдэгдэл хүргүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хууль үйлчлэх, мөн хууль бус жагсаал цуглаан нь албадан тараах үндэслэл болох зэрэг болно.

Түүнчлэн шөнийн цагаар жагсаал, цуглаан хийхийг хориглох агуулгыг нэмж тусгаад байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактад заасан иргэдийн иргэдийн тайван хуран цуглах эрх чөлөө хангагдаж, зөвхөн хуульд заасан үндэслэлээр энэхүү эрхийг хязгаарлах зорилт баталгаажна. Жагсаал, цуглааны хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрнө. Жагсаал, цуглааны хориглолт, хязгаарлалтын хүрээ, хязгаар тодорхой болно. Хуульд зааснаас бусад аливаа хэлбэр, тухайлбал, захиргааны хэмжээний актаар хязгаарлах боломжгүй болох юм.

Жагсаал, цуглаан зохион байгуулахад бүртгүүлэх үүрэгтэй эрх бүхий байгууллага бүртгэсэн тохиолдолд жагсаал, цуглаан хийх эрхтэй болох зохицуулалт үйлчлэл байгаа байдал хязгаарлагдаж, зөвхөн онцгой нөхцөл байдал, зайлшгүй хориглох цөөн тохиолдлоос бус тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэл хүргүүлснээр жагсаал, цуглаан зохион байгуулах боломж бүрдэнэ. Цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулахдаа хүний эрхийн зөрчил гаргахгүй байх, хууль ёсны тайван жагсаал, цуглаан, жагсагч болон цагдаа хамтран ажиллах, хоорондоо идэвхтэй харилцаатай байх, мэдээлэл солилцох, зөвлөн туслах нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дагалдуулан боловсрууллаа.

Иймд хуулийн төслийн үзэл баримтыг хэлэлцэх эсэхийг хэлэлцэн шийдвэрлэж, дэмжиж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төслүүдийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ардчилсан намын бүлгийн дэд дарга Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, Хүний эрхийн Үндэсний Комиссоос боловсруулсан Хүний эрх эрх чөлөөний байдлын илтгэлүүдэд тусгасан жагсаал, цуглааны талаарх судалгаа, мэдээлэл, дүгнэлт, зөвлөмж, Эмнести Интернэйшнл төрийн бус байгууллагаас жагсаал, цуглааныг хийх журмын тухай хуулийг шинэчлэн сайжруулахтай холбоотой хийсэн дүгнэлт тайлан, Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооноос 2021 оны 12 дугаар сард зохион байгуулсан Жагсаал, цуглаан зохион байгуулах журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг, түүнчлэн нэр бүхий Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан зарим асуудал болон бусад эх сурвалжийг үндэслэн жагсаал, цуглаан болон түүний төрөл, хэлбэрүүдийн шинээр томъёолох, жагсах, цуглах эрх чөлөөнд үндэслэлгүйгээр хязгаарлалт тавихгүй байх, аяндаа үүссэн жагсаал цуглааны талаарх зохицуулалт, түүнчлэн жагсаал, цуглаан хийх мэдэгдэл хүргүүлэх, бүртгүүлэх үйл ажиллагаанд дэвшилтэт зохицуулалт бий болгох, хууль сахиулах нийтийн журмыг хангах чиг үүрэг бүхий байгууллагаас гүйцэтгэх үйл ажиллагааны хүрээ хязгаарыг тодорхой болгосон зэрэг зохицуулалтыг тусгаж, хуулийн төслийг боловсруулжээ.

Хууль санаачлагч хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдон гарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардлыг одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомжтой нийцүүлэн иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад нэмэлт зардал үүсгэхгүй, одоогийн батлагдсан орон тоо төсөв зардал нөлөөлөхгүй гэж үзсэн байна.

Улсын Их Хурлын Тамгын газар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийн талаар хууль зүйн дүгнэлт хийж, гишүүдэд тараасан бөгөөд үүнд уг дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан болно.

Уг хуулийн төслийг парламентын цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаагаа илэрхийлж, үзэл бодлоо илэрхийлж жагсаал, цуглаан хийж байгаа нэрийн дор аж ахуйн нэгж, иргэдийн эрхийг зөрчсөн тайван бус жагсаал, цуглаан зохион байгуулах, хууль ёсны дагуу холбогдох зөвшөөрлөө авсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаар эд хөрөнгөд халддаг асуудлыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал жагсаал цуглааныг тараахтай холбоотой шийдвэр гаргах эрх бүхий этгээдийн хуулийн төсөлд оруулж өөрчлөлт оруулж ирсэн үндэслэлийн талаар, хууль бус жагсаал цуглаан гэх нэр томъёоны талаар, хуулийн төсөлд жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөг илүү нээлттэй болгож байгаа мэт боловч процессын шинжтэй

зохицуулалтуудаар хязгаарлалт хийж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир жагсаал, цуглаан зохион байгуулан санаачилж байгаа этгээд гэж хэнийг ойлгох, тухайн жагсаал цуглааныг зохион байгуулж байгаа талаар мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлж байгаа субъектийг ойлгож болох эсэх талаар, жагсаал цуглаан дээр аливаа асуудал үүсэхэд зохион байгуулагчийн хариуцлагын асуудалтай холбоотой тул хуульд тодорхой туссан байх шаардлагын талаар, жагсаал, цуглааныг албадан тараах нөхцөл тогтоогдсон бол уг жагсаал, цуглааныг тараах эрх бүхий этгээдийн талаар, мөн хуулийн төсөлд тусгагдсан аяндаа бий болсон жагсаал, цуглаан гэсэн зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийнхээ аюулгүй байдлыг хамгаалах талаар хуулийн төсөлд туссан эсэх, мөн органикаар үүссэн жагсаал, цуглааныг санаатай эсхүл төлбөртэй болон бусад нөхцөлөөр жагсаал, цуглааны үндсэн зорилгыг өөр тийш чиглүүлдэг асуудлыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр төрөөс жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл авдаг журамладаг эсэх гэхээсээ илүүтэй үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүний жам ёсны суурь эрх, эрх чөлөөг эдлүүлэх гэдэг агуулгаар боловсруулж, өргөн мэдүүлсэн Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа талаар байр сууриа илэрхийлж, зарим оронд хуульчлагдсан байдаг төлбөртэй, зохион байгуулалттай жагсаал, цуглааны талаар Хууль зүйн сайдын байр суурийн талаар асуулаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд улс төрийн эрхээ эдэлж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал, цуглаан хийх эрх чөлөө хумигдмал байх нь хүний эрхийн индекст хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа болон уг хууль хэрэгжиж эхлээд нийгэмд тодорхой хэмжээний үйлчлэл үзүүлсэн тохиолдолд тэр хүний эрхийн үнэ индекс хэрхэн өсөх талаар харьцуулсан судалгаа хийсэн эсэх, уг хуулийн төслийн талаарх иргэд олон нийтийн саналыг хэрхэн авсан, мөн хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар өнгөрсөн хугацаанд Монгол Улсад зохион байгуулагдсан жагсаал, цуглааны талаарх статистик тоо баримт, мэдээллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хууль зүйн дүгнэлтэд жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарласан талаарх зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусган байгааг анхаарах талаар дурдсантай холбогдуулан тайлбар авч, асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мэргэжлийн Байнгын хорооноос ахлах боломжоор хангаж өгөх талаар, мөн ажлын хэсэг дээр хуулийн төслийн нэр томъёог анхаарах. Тус хуулийн гол амин сүнс болох олон нийтийн аюулгүй байдлыг хангахдаа хууль сахиулах байгууллагын эрх үүргийг нарийн тодорхойлох шаардлагатай талаар, мөн Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлтийн хүрээ хязгаарын талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд хууль зүйн дүгнэлтээр хувийн өмчийн газар дээр жагсаал, цуглаан зохион байгуулах асуудал тухайн өмчлөгчийн зөвшөөрлийг авах шаардлагын талаар дурдсан нь зүйтэй талаар, жагсаал, цуглааныг сошиал орчинд сурталчилж уриалсан этгээдийн зохион байгуулагч гэж тооцох эсэх талаар, мөн 1 газар 1 зэрэг олон жагсаал цуглаан болох тохиолдлыг цаашид ажлын хэсэг анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал олон нийтийн эрх ашгийг хамгаалахаас гадна жагсагсдын эрхийг хамгаалах, жагсаал цуглаанд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах талаар хуулийн төсөл олон улсын гэрээ конвенцод нийцэж байгаа эсэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргаж буй механизмыг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн

Б.Энхбаяр улс төрийн нөлөө бүхий этгээд жагсаал цуглааныг саармагжуулах зорилгоор мэдээлэл хийсэн тохиолдолд хэрхэн анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд шинэ хууль тогтоомж батлахаас илүүтэй одоо хүчин төгөлдөр байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарах талаар, жагсаал цуглаан хийх нэрийн цаана улсынхаа хөгжлийн сайн сайхны зүйлийг харлуулдаг, хүний нэр алдар хүнд, бие махбодод халддаг зүй тогтол бий болсон байгааг анхаарах талаар, нөгөө талдаа жагсаал, цуглаан зохион байгуулах эрх чөлөөний асуудал хөндөгдөж байгаа боловч нөгөө талдаа бусдын эрхийг ноцтойгоор зөрчих асуудал байж болохгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар иргэний тайван жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөө нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон суурь эрх бөгөөд энэхүү эрхээ эдлэхдээ төрөөс зөвшөөрөл эсхүл төрийн зөвшөөрөл олгох эсэх асуудал байж болохгүй талаар, мөн хувийн өмчийн газар жагсаал, цуглаан зохион байгуулж болох талаар хуулийн төсөлд тусгагдсан байгаа нь Үндсэн хуульд заасан өмчлөх эрхтэй холбоотой зөрчил байгааг анхаарах талаар тус тус үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дүгээр хэсэгт Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасны дагуу санал хураалт явуулахад Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцсэн эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэхэд өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл Хууль зүйн, дотоод хэргийн сайд, Нэргүй Мягмар тус яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нармандахын Жамъянхүү тус яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Баатарсүрэнгийн Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Сүхээгийн Лхагвадорж Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Ажиллагааны хэлтсийн дарга, Гөлгөөгийн Гүррагчаа Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга, Намсрайн Лхагвасайхан Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал хангах албаны дарга, Олзвойн Мандах Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн шинжээч.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс

урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Бид Улсын Их Хурлаар хаврын чуулганаар жагсаал, цуглаантай холбоотой энэ асуудал, мөн хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой хуулийн зохицуулалтын асуудал, мөн бас Хүний эрхийн үндэсний 2 дугаар хөтөлбөрийн тухай ойлголт, Хүний эрхийн багц хууль, тэгээд эдгээр асуудлуудыг ярьж байгаа нь, хэлэлцэж байгаа нь бас санамсаргүй зүйл биш юм. Тодорхой хэмжээгээр олон жил хүлээгдсэн, гацсан. Бид нар томоохон төсөл хөтөлбөрүүд эдийн засгийнхаа хөшүүргийг явуулъя гэдэг ч гэсэн яг энэ хууль дээр байгаа хүний эрхтэй холбоотой, хүний эрхийг хамгаалахтай холбоотой иргэн рүүгээ чиглэсэн зүйл дээр бас нэлээн ийм өндөр анхаарал ач холбогдол өгч оруулж ирж байгаа нь их зүйтэй гэж харж байгаа. Тэр утгаараа бол мэдээж олон талын үзэл бодол байх, шүүмжлэлтэй хандлагууд байх, давуу сул талууд байх ч гэсэн Улсын Их Хурал нэгэнт ноднин жил хүн төвтэй шийдвэр гаргалт хийнэ гээд стратегиа баталчихсан учраас энэ шалгуур дээрээ маш сайн цензур тавьж үзэх ёстой. Энэ цензур бол ерөөсөө хориглох, хаах, боох гэхээсээ илүүтэйгээр хүний эрхийг хангаж байж чадаж байна уу энэ хэм хэмжээний зохицуулалт гэдэг дээрээ л бид маш тунгалаг олон талын шалгуурыг авч үзэх ёстой. Энэ утгаараа энэ жагсаал цуглаантай холбоотой асуудлыг дэмжих 2 шалтгаан байгаа.

1 дүгээрт энэ зөвшөөрөл авна гэдэг байдлаар төрийн дарамтад жагсаал нь өөрөө жагсаал биш болдог байдлыг халах зохицуулалт байна.

2 дугаарт нь мэдээж энэ субъект буюу санаачлагч, оролцогчдыг олон төлөв болгох энэ боломжийг нээж байгаа.

Эцсийн эцэст яах вэ, жагсаал цуглааны үеэр хүний ямар нэгэн байдлаар амь нас, эрүүл мэнд хохирохгүй байх, эрх ашиг нь хөндөгдөхгүй байх, улс төрийн үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө хууль шүүхийн байгууллагад хавчигддаггүй байх энэ зүйлүүдийг бид нар хэлэх ёстой. Хэдэн жилийн өмнөх жагсаал дээр тэр шөнө орой жагсаж байгаа залуучуудыг хүч хэрэглэж тараах, татаж гулдчих, тэгээд өмссөн зүүсэн хувцаснаас нь татахаар зарим биеийнх нь хэсгүүд ил гарах эд нар гээд маш олон төрлийн зүйлүүд болж байсан.

7 сарын 1-ний жагсаалттай холбоотой эмгэнэлт гашуун түүх бид нарт байсаар байгаа. Тийм учраас аль болох л энэ хүний эрх рүүгээ чиглэсэн зүйл рүү энэ хууль маань олон талын хэлэлцүүлэгтэй, олон талын мэтгэлцээний дараа сайн шийдвэрүүд ялгарч гарч гарах ёстой гэж үзэж байгаа. Яагаад гэвэл энэ бол Үндсэн хуулийн суурь зарчим учраас.

Өмнөх Байнгын хорооны хэлэлцүүлэг дээр бол сайдаас асууж байсан тэр симуляцын асуудал гэж. Одоо энэ Хэвлэлийн эрх чөлөөний хуулийн асуудал ч яригдсан ч тэр, жагсаал, цуглааны хуулийн асуудал яригдсан ч тэр, ер нь бид нар ингээд дэлхийд бодит байдлаараа муухай харагддаг, бодит байдлаараа хуулийн үйлчлэл нь хүний эрхээ хамгаалж, хангаж чадахгүй байгаа нөхцөл байдлыг яаж засварлах вэ гэдэг ойлголт байгаад байгаа юм. Тэр утгаараа энэ хууль батлагдсанаар энэ хүний эрхийн индекс ямар түвшинд өсөх юм бэ гэдэг симуляцыг хуулийн үйлчлэлийг хийгээч гэж хэлж байгаа. Энийг хийх боломжтой юу. Хуулийн хэлэлцүүлгийн шатад ямар хугацаанд энийг хийх боломжтой гэж та харж байна вэ гэдэг 1 дүгээр асуулт.

2 дугаарт. Ер нь Монгол Улсын энэ хүний эрхийн индекс 4,4 оноотой байгаа 10-аас. Тэгэхээр ер нь бараг 60, 70 хувь нь шүү. 60, 70 хувь нь яг энэ хүний улс төрийн эрхтэй холбоотой асуудал дээр бид уналтад ороод байгаа. Энэ дээр тэр хүний эрхийн форум болон НҮБ-аас өгч байгаа 170 орчим зөвлөмжүүдээс хэчнээн нь энэ жишээлбэл энд хангагдах вэ. Яг энэ хуулийн зохицуулалтаар НҮБ-ын гишүүн орнуудын Монгол Улсад зөвлөж байгаа зөвлөмжүүдээс хэд нь хамаарах вэ.

Тэгээд сүүлийнх нь 1 зүйл нь тэр Ардчилсан намын дэргэдэх Хүний эрхийн хорооны Д.Ганбаяр тэргүүтэй хүмүүс Хууль зүйн сайдад бас асуулт, асуулга тавиад, саналаа гаргаад байгаа юм билээ. Тэр дээр нь та бас хариу өгчихвөл болох уу. Энэ асуултуудыг асууя.

Д.Амарбаясгалан: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Оюунсайханы Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Хүний эрхийн асуудал дээр 60-70 хувь нь хүний улс төрийн эрхтэй холбоотой асуудал байна гэдэг бол бас үнэн байгаа юм. Тэгээд бид бол яг энэ асуудлууд дээр өнгөрсөн удаад Хүний эрхийн Үндэсний комиссын тайлан, илтгэл, олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, ямар тохиолдолд иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөө зөрчигдөж байна, нэн ялангуяа жагсаал цуглаан эрх чөлөөтэй зөрчигдөж байна гэдэг дээр өгсөн зөвлөмжүүдээс нийт бид 5 удаагийн жишээлбэл, Хүний эрхийн Үндэсний комиссын илтгэлийг л үзэхэд бид нийт 5 удаагийн илтгэлд дурдагдсан тэр 27 асуудлаарх давхардсан тоогоор 27 асуудлаарх зөвлөмжийн бид нар яг 70 хувийг оруулчхаад байгаа юм.

Тэгэхээр энэ симуляцтай холбоотой асуудал Эрдэнэболд гишүүн ярьж байгаа. Ажлын хэсэг байгуулагдаад явахад яг энэ асуудлыг судалж шийдвэрлээд, цаашаа ярилцаад явах бүрэн боломжтой гэж бид нар харж байгаа. Тэгэхээр энэ хүний эрхтэй холбоотой, нэн ялангуяа жагсаж цуглах эрхтэй холбоотой асуудал бол олон нийтийн анхаарлын төвд байдаг. Жагсаал цуглаанд оролцсон хүмүүст хэрхэн яаж хандаж байна. Эдгээр иргэдтэй холбоотой асуудал хэрхэн яаж шийдвэрлэгдэж байна. Хүний эрхийн ямар зөрчил гарч байна гэдэг нь олон нийтийн нүдэн дээр ил тод байдаг. Нэн ялангуяа гаднын эрх чөлөөний индекс болоод бусад үзүүлэлтүүдийг гаргадаг экспертүүдийн эх сурвалж болж ашиглагддаг учраас жагсаал цуглааны үеэр гарсан аливаа хүний эрхийн зөрчил гэж харагдахуйц үйл явдал бол энэ индексийг сөргөөр харагдуулахад нөлөөлдөг. Тэгэхээр хууль тогтоомжийн тодорхойгүй байгаа байдал үүнд бас нөлөөлдөг. Жишээлбэл өнөөгийн хуулиар бол энэ бүртгүүлээгүй жагсаал цуглаан бол хууль бус байгаа. Цагдаагийн байгууллага очоод шаардлага тавьдаг, бүртгүүлээгүй байдаг. Цагдаагийн байгууллага хуульд заасан үүргээ биелүүлэхийг эрмэлздэг.

Нөгөө талаас бид нар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй. Яаж байгаа юм гэдэг эсэргүүцэл гардаг. Энэ үндсэн дээр яг гадна талдаа яаж харагдаж байна вэ гэвэл үнэхээр энэ хүний тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлагдаад байна л гэж харагдаад байдаг учраас хүний улс төрийн эрхтэй холбоотой чухал асуудал гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Хүний эрхийн хороо гэж ярьж байна. Ардчилсан намд албан ёсоор хүний эрхийн хороо гэсэн бүтэц бол байдаггүй. Тэгэхдээ иргэнийхээ хувиар болон энэ

хүний эрхийг хамгаалах чиглэлээр гаргаж байгаа бүхий л төрлийн хүсэлт саналыг авч шийдвэрлэхэд бэлэн байгаа гэдгээ илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгөх үү. Болсон байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би Байнгын хороон дээр тодруулаад хариулт авч чадаагүй 2 асуултаа энд тодруулаад асуучихъя. Ялангуяа энэ хуулийн төслийн 10 дээр дараах зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хориглоно гээд Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдалд хохирол учруулж, эмх замбараагүй байдал бий болгох, үндэсний аюулгүй байдал, хуулиар хориглосноос бусад зорилгоор зохион байгуулсан гээд нийтийн ёс суртахуун, нийтийн эрүүл мэнд, хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хамгаалах зорилгод нийцсэн байх гээд өөрөөр хэлбэл нийтийн ёс суртахуун, нийтийн хэв журам гээд яг хэнийг, юуг хэлээд байгаа гэдэг нь маш тодорхойгүй. Хамгийн ийм ерөнхий байдлаар тухайн үедээ хууль батлагдлаа гэхэд субъектив байдлаар хэрэглэж болзошгүй, жагсаал цуглааныг тараахад ашиглаж болзошгүй, субъектив байдлаар ашиглаж болзошгүй, улс төрийн зорилгоор ашиглагдаж болзошгүй ийм байдлаар хууль маань өөрөө бас орж ирж байгаа. Энэ асуудал дээр та нэг тайлбар өгөөч. Хуулийн 10 болон 13 дугаар зүйл дээр.

Дагалдаж орж ирж байгаа хуулиуд дээр бас үнэхээр санаа зовоохуйц асуудлууд бас орж ирсэн. Урд нь бол Засаг даргын шийдвэрийг гээд Цагдаагийн албаны тухай хуулиар бол Засаг даргын шийдвэрээр гэж байдаг байсан бол одоо эрх бүхий этгээдийн шийдвэр гээд орж ирсэн. Дээрээс нь төрийн албан хаагчийг бид нарын жагсаал, цуглаан тараах шийдвэрийг төрийн албан хаагчийг гаргах ийм хуулийн төсөл орж ирж байна. Тэгэхээр хуучин Засаг дарга, одоогоор бол Засаг дарга гаргаж байгаа. Тэгээд яагаад Засаг дарга гаргах энэ эрх мэдлийг нь, бүрэн эрхийг нь, хариуцлагыг нь, энэ чинь бас хариуцлага яригдана шүү дээ. Үүний цаана. Тэгэхээр энийг яагаад төрийн алба руу хутгаад байгаа юм бэ. Төрийн албан хаагч энэ шийдвэрийг гаргах зайлшгүй шаардлага байгаа юм уу. Жагсаал цуглааны асуудал чинь ихэвчлэн дандаа улс төрийн агуулга, зорилготой байгаад байдаг. Тэгэхээр энэ асуудал дээр нэг тайлбар өгөөч.

Мөн нөгөө дагалдаж орж ирж байгаа Дайны байдлын тухай хуульд орж ирж байгаа өөрчлөлтөөр эрх бүхий этгээдэд мэдэгдээгүй жагсаал, цуглаан гэх мэтээр эрх бүхий этгээдэд хууль бус жагсаал цуглааныг гэж өөрчлөх гээд Дотоодын цэргийн тухай хууль дээр ийм субъектив байдлаар маш их ерөнхий байдлаар зохицуулсан зохицуулалтууд орж ирж байгаа нь өөрөө хууль батлагдсаны дараа их сөрөг үр дагавар дагуулна гэж харж байгаа. Тэгэхээр эдгээр асуудлууд дээр Хууль зүйн сайдын хувьд тайлбар өгөөч ээ гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Оюунсайханы Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Энэ жагсаал цуглааныг зохион байгуулах хориглолт хязгаарлалттай холбоотой зүйл заалтууд орсон. Энэ бол хамгийн их анхаарах ёстой, бид нарын хамгийн их судлах ёстой хэлэлцэх ёстой зүйл учраас энэ дээр нэлээн олон өргөн хэмжээний судалгаа хийж эдгээр орсон юм. Таны хэлээд байгаа нэр томьёо тодорхойлолттой холбоотой зүйлүүдийг бид нар ямар зорилгоор оруулсан бэ гэхээр олон улсын гэрээ конвенцоор тодорхой хэмжээний хязгаарлалтууд хийж болно гээд. Тодорхой хэмжээний хязгаарлалтаа жишээлбэл үндэсний аюулгүй байдалтай холбоотой зүйлүүд байгаа юм. Тодорхой хэмжээнд

хязгаарлалт хийж болно шүү гэдэг энэ олон улсын гэрээ конвенцод заасан зүйлээрээ бид нар оруулсан. Нэр томьёоны хувьд хэтэрхий өргөн ойлгогдож байгаа гэдэг юм уу ингэж ойлгогдож байгаа тал байж байсан магадгүй юм. Таны тайлбараар бол. Бид бол яг энэ өмнөх хууль дээр байсан харилцааг аль болохоор хүрээ хязгаарлалтыг нь багасгая гэж бодоод, тэнд байсан зарим нэг нэр томьёог хэвээр нь оруулаад, энэ зүйлүүдийг оруулчихсан байгаа юм. Албадан тараах шийдвэр гаргах субъект дээр нэлээн олон асуудал болсон. Ер нь бид нар мэдэж байгаа. Тухайн нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга гэдэг бол аль нэг намын төлөөлөл байдаг. Тухайлах юм бол аль нэг аймгийн дарга орон нутгийн сонгуульд ороод ялах юм бол аймгийн Засаг дарга болно. Сумын намын дарга сонгуульд ороод ялах юм бол сумын Засаг дарга болно. Яг улс төрийн субъект байдаг.

Гэтэл жагсаал цуглаан маань дандаа улс төрийн шаардлага тавьдаг, улс төрийн өнцөгтэй зүйлүүд байх нь их байдаг. Өөрөөр хэлэх юм бол улс төрийн эрхтэй холбоотой байх нь их байдаг. Тэгэхээр төрийн алба бол бид нар өнөөдөр яах вэ, янз янзын байдалтай байгаа боловч яг хууль дээр бичсэнээрээ бол төрийн албан хаагч өнөөдөр намаас биш мерит зарчмаараа Төрийн албаны тухай хуулийн дагуу шалгалтаа өгсөн, шалгуур хангасан хүн томилогдож байгаа. Тэгэхээр бид нар цэвэр намаас томилогддог, энд аль ч нам нь байж болно. Цэвэр намаас томилогддог хүн улс төрийн эрхээ эдэлж байгаа жагсаалыг тараагаад байх нь зохимжтой юу, үгүй юу гэж үзээд тухайн нутаг дэвсгэрт байгаа төрийн захиргааны хамгийн том ийм ранкийн албан хаагчийг зааж өгсөн л ийм зорилготойгоор орсон юм.

Дагах хуулиуд дээр жишээлбэл одоо энэ Дотоодын цэргийн тухай хуульд ч юм уу нэмэлт, өөрчлөлт оруулах орох шаардлага нь болохоор бид нар чинь нөгөө жагсаал, цуглаан хийх зохион байгуулахыг хориглочихсон газрууд байгаа. Жишээлбэл төрийн ордон, нутаг дэвсгэр, эмнэлгийн байгууллага, нисэх онгоцны буудал, төмөр зам, улсын онц чухал объект, түүний хамгаалалтын бүс гээд ингэхээр энд бол хамгаалалтыг нь зохион байгуулдаг нь дотоодын цэрэг байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хориглосон газарт жагсаал, цуглаан хийхэд ямар субъект оролцох вэ гэдгийг үзээд, тэр оролцож байгаа субъектүүдээ үзэхээр яг энэ дагаж байгаа хуулиудад өөрчлөлт оруулахаас өөр аргагүй болоод л энэ дагалдах хуулийн өөрчлөлтүүдийг оруулсан гэдэг тайлбараа хэлье.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Яг энэ нөгөө субъектив байдлаар тайлбарлагдаж болзошгүй гэдэг дээр үнэхээр санаа зовоод байгаагийн бас нэг шалтгаан нь энэ хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хамгаалах зорилгод жагсаал цуглаан нь өөрөө нийцсэн байх ёстой гээд. Дахиад л 1 улс төрчийн л нэр хүнд асуудал самбар дээр ингээд л нэр усыг нь бичээд ийм л жагсаан л ер нь болно шүү дээ. Тэгэхээр тэр зорилгод нийцэхгүй байна гээд тараах шийдвэрүүд гаргаад байгаа гэсэн ийм агуулгууд энэ дотор чинь бүр маш олон газар ингэж яваад байгаа учраас би танаас тодруулаад асуугаад байгаа юм.

Та сая хэллээ. Жагсаал, цуглаан зохион байгуулж болохгүй хэд хэдэн газрыг заасан гээд. Нөгөө дахиад төрийн тусгай хамгаалалтынхаа дүрэм журмыг нь үзэхээр тоолоод үзэхээр тоолоод үзэхээр бараг 80 гаруй объект дээр жагсаал, цуглаан хийх боломжгүй болж байна. Улам л жагсаал, цуглаан хийх эрхийг энэ хуулийн төсөл өөрөө хязгаарлаад байгаа юм биш үү. Энэ чинь өөрөө бид нарын Үндсэн хуулиар баталгаажсан эрх шүү дээ. Тэрнээс Үндсэн хуулиар олгосон эрх

биш байхгүй юу. Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг төр баталгаажуулах, бусад хууль тогтоомжоороо нарийвчилж баталгаажуулах.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл гишүүн нэмэлт хариулт өгье.

О.Алтангэрэл: Ерөөсөө яг энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотойгоор хориглосон газруудыг тогтоосон юм. Одоо тэр Тамгын газраас гаргасан дүгнэлт дээр өргөжүүлсэн байна гээд одоогийн байгаа хуулийн хүрээ хязгаараас бид нар ерөөсөө өргөжсөн гэж үзэхгүй байгаа. Хийсэн өөрсдийн судалгааныхаа хүрээн. Тэр саяын дурдаад байгаа үндэслэлүүд бол албадан гаргах шийдвэр гаргахдаа харгалзаж үзэх хүчин зүйлүүдэд л орж байгаа. Тэрнээс биш ерөөсөө яг 1 улс төрчийн нэрийг бариад ингээд жагсвал тараана гэсэн агуулга бол ерөөсөө тийм агуулга байхгүй байгаад байгаа.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Жагсаал, цуглаан хийх эрх бол мэдээж Монгол иргэний төрөөс олгосон эрх нь биш, төрөөс энэ бол хамгаалах ёстой эрх, баталгаажсан эрх. Тэр ч утгаараа бид бас энэ хуулийн төсөл дээр илүү төр яаж энэ эрхийг нь хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах тал дээр нэлээн анхаарсан зохицуулалтуудыг оруулж ирсэн болов уу гэж бодож байна. Яах вэ энэ дээр хуулийн төсөлтэй ерөнхий үзэл санааны хувьд боломжийн санагдаж байгаа боловч би бас ганц асуудлыг илүү тодруулж асуумаар байгаа юм. Байнгын хороо дээр энийг асуусан боловч би тодорхой хариулт ерөөсөө аваагүй. Судалсан, судлаагүй нь мэдэгдээгүй.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд бол жагсаал цуглаан, түүнийг зохион байгуулах, оролцох эрхийн баталгаа гээд эрхийн баталгааг нь уг нь энэ зүйлд багтаасан юм шиг байгаа юм. Тэгээд энд 7.8-д нь болохоор бусдыг жагсаал цуглаан зохион байгуулах, түүнд оролцуулахын тулд эд мөнгөөр татах, дарамт шахалт үзүүлэх хэлбэрээр албадахыг хориглоно гэгчихсэн. Энэ маань тэгвэл энэ хориглосон заалт маань бусад энэ жагсаал, цуглаан, түүнийг зохион байгуулах, оролцох иргэний эрхийн баталгаа энэ хууль дээр заасан баталгаатай яаж холбогдох вэ. Та бүхэн мэдээж энд эд мөнгөөр татаж, энэ жагсаал цуглаан хийхийг хориглох байгаа юм байна хуулиараа. Гэхдээ яг үнэнийг хэлэхэд нийгэмд болдог асуудал бол залуучууд үнэхээр органик, өөрийн хүсэл зоригоороо цуглаад, үзэл бодлоо илэрхийлж байтал дундаас нь ч юм уу, дараа нь ингээд хажуугаас нь баахан төлбөртэй ч юм уу, өөр санаа зорилготой хүмүүс ирээд жагсаалыг нь булаадаг. Өөр тийш нь хөтөлдөг. Өөр үзэл агуулгатай болгодог. Тэгэхээр энэ дээр бид нар яаж энийгээ үнэхээр бид нарын хамгаалах ёстой, аюулгүй байдлыг нь хангах ёстой, эрхийг нь баталгаажуулах ёстой жагсаал, цуглааны зохион байгуулах эрхийг нь баталгаажуулах вэ.

Нөгөө талаараа та бүхний энэ хууль дээрээ мэдээж хориглоод байгаа эд мөнгөөр татсан жагсаал, цуглаан хийхийг хориглож байгаа, үүнтэйгээ уялдуулсан зохицуулалт байх вэ гэдэг дээр би асуумаар байгаа юм.

Тэгээд танилцуулга, үзэл баримтлалыг уншихаар та бүхэн энэ гадаадын бусад орны жишиг гээд АНУ, Франц, Япон гэх зэрэг улсад ийм байна. Ингэх тогтолцоотой байна гээд ингэж байгаа юм. Тэгэхээр энэ улсууд чинь ер нь энийг яаж зохицуулдаг юм. Энэ төлбөртэй жагсаал өөр зорилгоор жагсаалыг өөр тийш нь хөтлөх ч гэдэг юм

уу, өөр санхүүжилттэй жагсаал чинь хууль зүйн хувьд яаж харах ёстой юм. Ёс зүйн хувьд яаж харах ёстой юм. Улс төрийн хувьд яаж харах ёстой юм гээд олон өнцөг байгаа. Энийг та бүхэн ер нь энэ жагсаал цуглааныг төлбөртэй жагсаал, цуглаан хийж байгаа хүмүүсийн эрхийг нь бид нар адилхан баталгаажуулах ёстой гэж үзэж байна уу. Яах ёстой гэж үзэж байна. Энэ дээр судалсан зүйл, бас Хүний эрхийн Комисс эд нараас энэ талаар санал авсан юм байна уу. Энэ дээр дэлгэрэнгүй, яг энэ асуултад л хариулаад өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Тийм. Яг энэ төслийн 7.8-д бусдыг жагсаал, цуглаан зохион байгуулах түүнд оролцуулахын тулд эд мөнгөөр татах, дарамт шахалт үзүүлэх хэлбэрээр албадахыг хориглоно гэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол хүн өөрийн хүсэл зоригийн үндсэн дээр жагсаал, цуглаан хийх эрхтэй болохоос биш албадлагын үндсэн дээр, тэр эд мөнгөөр юм уу дарамт сүрдүүлгийн үндсэн дээр чи энэ дээр оролцохгүй бол хохь чинь шүү гэдэг дарамт сүрдүүлгийн үндсэн дээр энэ эрх хэрэгжихгүй. Тийм учраас жагсаал, цуглаанд оролцох эрхийн баталгаанд хамаарч байгаа юм. Өөрөөр хэлбэл өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлэх хүрээнд өөрийнхөө үндсэн хуулиар олгогдсон эрх чөлөөний хүрээнд жагсахад энэ зүйл заалт хамаарч байгаа юм. Өнөөгийн хууль дээр яг хориглосон зохицуулалт байгаа. Эд мөнгөөр татахтай холбоотой хориглосон зохицуулалт байгаа юм. Тэгэхээр бид нар Хүний эрхийн Комиссоос бол яг энэ асуудал дээр бид нар нөгөө хуулийн төслөө явуулаад, яг энэ асуудал дээр тусгайлсан санал өгөөгүй. Байнгын хороо дээр хэлэлцүүлгийн үеэр өөр бусад улс оронд бүр жагсаал хийдэг компани байна. Тэгээд энэ мөнгөө төлөөд, тэгээд төлсөн мөнгөнийх нь үндсэн дээр жагсаал цуглаан хийдэг хэлбэр байна. Тэгээд энэ хэлбэрийг бол яах юм бэ. Тусгах юм уу гэдэг ч юм уу. Эсвэл жагсаал цуглаан хийгээд орлого олоод байгаа хүмүүсээс татвар хураамж авах юм уу гэдэг ч юм уу санаа санаачилгууд гарч байсан л даа. Тэгээд яах вэ, энэ судалгаатай холбоотой зүйлүүд дээр манай ажлын хэсгээс нэмээд хариулчхаарай. Бид бол яг энд байгаа тэр эд мөнгөөр татахыг хориглоно гэдэг хуучин хуульд байгаа зохицуулалтаа л авчихсан юм. Таны хэлж байгаа бол 100 хувь хүлээн зөвшөөрч байна. Ерөөсөө энэ жагсаал цуглаантай холбоотой зүйлийг харлуулах гэдэг юм уу, үндсэн зорилгоос нь төөрүүлэх холдуулах үндсэн арга болчхоод байгаа юм. Мөнгө өгсөн. Мөнгөний жагсаал болсон гэдэг. Бүр яг бодитой жишээ гэх юм бол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэлийг бас уй гашуу тохиолдчихсон, хүнд үед нь жагсаал зохион байгуулсан, эд мөнгөөр татсан гэсэн ийм мэдээлэл яваад, энэ дээр нь цагдаагийн байгууллага гомдлынх нь хүрээнд шалгалтын үйл ажиллагаа явуулсан ийм жишээ тохиолдол ч байна.

Тэгэхээр бид нар яг энэ эд мөнгөөр татах гэж энэ зүйлийгээ яг хуучин хуулийнхаа концепцыг энэ дээр хадгалаад оруулчихсан. Одоо цаашдаа харин яг тэр яригдаад байгаа хэлбэр лүү явуулах уу, үгүй юу гэдэг дээр хэрвээ өөрчлөлт хийнэ гэвэл хуулийн төслийг хэлэлцэх явцдаа манай гишүүдийн зүгээс санал гаргаад ирж болох байх.

Бид бол ямарваа нэг байдлаар хүнийг санхүүгийн байдлаар санхүүгийн, биеийн, төрөл бүрийн байдлаар дарамт үзүүлж, өөрийнхөө хүслээр жагсаал, цуглаанд оролцуулах эрхийг нь хязгаарлаж болохгүй гэдэг зорилгоор л яг энэ хуулийн зүйлийг оруулсан. Манай ажлын хэсгээс тэр судалгаатай холбоотой зүйлийг нэмээд хариулья.

Д.Амарбаясгалан: Хариулт өглөө. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн. Ажлын хэсгээс хэн нэмж хариулах юм. Ажлын хэсгийн 6 дугаар микрофон.

Н.Мягмар: Номинчимэг гишүүний асуултад тодруулж хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Энэ жагсаал, цуглааны журмын тухай хууль бол хэрэгжээд олон жил болж байгаа. Энэ хүрээндээ энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг Хууль зүй, дотоод хэргийн яам хийсэн. 2022 онд хийсэн. Энэ хүрээндээ бол энэ хэрэгжилтийг дүгнэлтээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаатай хангахад дарамт шахалт гэдэг юм уу эд мөнгөний ийм байдлаар илэрхийлдэг энэ явдлыг баталгаажуулах зохицуулалт бол хэвээр хадгалагдах ёстой гэдэг дүгнэлт дээрээ үндэслэж энэ хориглолт маань хэвээр орж ирсэн байж байгаа.

Яг таны саяын хэлж байгаагаар тодорхой юу гэдэг юм эд мөнгөөр зохион байгуулах энэ жагсаал цуглааныг байж болох уу, үгүй юу гэдэг дээр мэдээж хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн тохиолдол бол ажлын .../минут дуусаав/

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн тодруулж асууя.

О.Номинчимэг: Яах вэ, энэ та хэд нөгөө жагсаал цуглааны хуулиа яг энэ тулгамдаж байгаа асуудлаа хэр нарийн судалсан бэ л гэдгийг би уг нь ухаад асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр жишээ нь үзэл бодлоо илэрхийлэхийн тулд тэр жагсаж байгаа, 1 газар уулзаж байгаа тэр хүртэлх жишээ нь логистикоор, нөгөө транспортоор, тээврээр хангах ч байдаг юм уу, жагсахад нь хэрэглэгдэх самбар энэ тэрийн мөнгө гаргах асуудал дээр ерөөсөө энийг төлбөртэй гэж үзэхгүй. Энийг бол ямар нэг эд мөнгө, эд зүйл тараасан эд хөрөнгө мөнгөөр татах гэсэн юманд багтахгүй гэдэг юмнууд олон улсын стандарт. Улс улсаасаа хамаараад энэ дээр өөр байгаа. Ер нь бид нар мөнгөтэй юу, мөнгөгүй юу гэдгээсээ илүүтэйгээр энэ тайван жагсаал болж чадаж байна уу. Олон нийтийг илүү замбараагүй байдалд хөтлөхгүй, яг тайван үзэл бодлоо илэрхийлсэн жагсаал болж байна уу гэдэг дээр хууль өөрөө гол нь фокус болдог. Тэгэхээр нөгөө хуучин заалт маань л ийм байсан учраас ийм гэхээсээ илүү яг энэ нарийн ... /минут дуусав/

Д.Алтангэрэл: Алтангэрэл сайд. Хүний эрхийн комиссоос санал авсан юм уу. Алтангэрэл сайдад нэмэлт хариулт өгье.

О.Алтангэрэл: Бид нар хуулийн төслийнхөө хүрээнд ер нь хүний эрхтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанд оролцдог бүхий л байгууллагаас санал авсан.

Д.Амарбаясгалан: Тийм ер нь яах вэ, энэ асуудал хэлэлцэх эсэх нь дэмжигдээд явсан тохиолдолд энэ Номинчимэг гишүүний хэлээд байгаа зүйл үнэн л дээ. Хүний эрх талаасаа их олон боломжуудыг нь л нээж өгөх гээд байгаа шүү дээ. Жагсаал цуглаанаа зохион байгуулж болно. Төрөл хэлбэр нь тодорхой байна. Тайван жагсаал бол тайван жагсаал, суулт бол суулт гэх мэтээр. Гол нь тэрийг зөвшөөрөл авч хийдэг биш, тэр төрлөө өөрөө мэдэгдээд, тэр хэлбэрээрээ хийж чаддаг, хэм хэмжээгээ мэддэг, хариуцлагатай иргэн, хариуцлагатай жагсагчид. Тэгээд мэдээж аюулгүй байдлыг нь хангадаг төр байх ёстой гэсэн л ийм л үндсэн зарчим дээр энэ Жагсаал, цуглааны хуулийн төсөл бол хэлэлцэгдэж явах ёстой.

Тэгэхээр тэр байр суурь дээр Улсын Их Хурал талаас хандана. Энд бас Жудагийн Баярмаа гишүүнээр ахлуулчихсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Тэгэхээр

мэдээж хэлэлцэх эсэхтэй холбоотой асуудал шийдэгдсэний дараа энэ ажлын хэсэг олон гишүүд оролцоотойгоор энэ асуудлыг шийдээд явах боломж байгаа гэж бодож байна.

Өнөөдөр их чухал асуудал хэлэлцэж байгаа. Харамсалтай нь хэд хэдэн гишүүд нэрээ өгчхөөд танхимд алга байна. Нэрсийн жагсаалтаас хасна. Жуковын Алдаржавхлан, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвжавын Сайнзориг, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Цэндийн Сандаг-Очир, Сүхбаатарын Эрдэнэбат. Өө Эрдэнэбат гишүүн байна уучлаарай. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Батын Батбаатар гишүүн гэсэн гишүүд нэрээ өгсөн, танхимд байхгүй байгаа учраас нэрсийн жагсаалтаас хаслаа. Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төслийн талаар ярьж байна. Биеэрээ очоод жагсахаас гадна, нөгөө сэтгэлээрээ жагсдаг хүмүүс зөндөө байдаг. Гадаадад амьдарч байгаа монголчууд ялангуяа эх орныхоо талаар их сэтгэл санаа нь зовж, видеогоор өдөр шөнө цагийн зөрүү үл ялган хардаг. Энэ талтай холбоотой тэгээд хэд хэдэн асуулт байгаагаа тодруулъя. Энэ хуулийн төслийн 7.9-д жагсаал цуглаанд тавих аливаа хязгаарлалт нь хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд нийцсэн байна гэнэ. Сонсохоор их гоё уг нь сонсогдож байна. Тэгэхдээ үүнийгээ яг яаж тодорхойлж байгаа юм. Хязгаарлалтын арга хэмжээ авч байгаа эрх бүхий байгууллагууд, түүний ажилтан, хууль сахиулагч нар авч хэрэгжүүлж байгаа энэ арга хэмжээгээ олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн гэдгээ тухай бүрд нь бүрэн өөрсдөө мэдрэх боломж байх уу. Хэрэгжилт дээр нь асууж байгаа гэсэн үг.

Мөн хуулийн төслийн 8.12 нь аяндаа үүссэн жагсаал цуглаан нь зохион байгуулагчтай болсон тохиолдолд тэр даруй эрх бүрийн байгууллагад мэдэгдэнэ гэсэн зохицуулалт байгаад байгаа юм. Энэ бас хэрэгжилт дээр яг бодитойгоор хэрэгжих боломж байгаа юу. Хэрвээ энэ тухай огт мэдэгдэхгүйгээр цааш үргэлжлээд явчихвал үр дагавар нь яг юу байх вэ гэдэг асуудал надаа байна.

Түрүүн Баасанжаргал гишүүний асуулт дээр давхардаж байгаа байх. Тэгэхдээ энэ 13.5-д Засаг даргын Тамгын газрын дарга жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэр гэдэг нь энэ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжтойгоо хэр зэрэг нийцэж байгаа вэ гэдэг асуудал байна. Тухайн субъект нь ийм эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн хувьд, зарчмын хувьд ч гэсэн тохиромжтой буюу боломжтой байдаг уу.

Энэ хууль хэрэгжсэнээрээ ер нь Монгол Улс ямар түвшинд тайван замаар жагсаал хийх, цуглаан хийх эрх нь хангагдах уу. Хууль, эрх зүйн орчин түүний хэрэгжилт дээрээ сайжрах уу. Энэ түвшинд нь хэр зэрэг өөрчлөлт орно гэж дүгнэж байгаа вэ. Тэгээд мөн энэ жагсаал цуглаан хийж байхад уг нь одоо энэ чинь олон нийтэд мэдээллээр хангах ёстой гээд 11.4-д заачихсан байгаа. Хүний эрхийн хамгаалагч, хөндлөнгийн ажиглагч хяналт тавих, ажиглалтад мониторинг хийх гээд. Гэтэл энэ чинь хэвлэл мэдээллийн байгууллагуудаар шууд дамжуулалт явах гэхээр интернэтийн сүлжээг нь унтраадаг, зориудаар гацаадаг, холбогдох төрийн байгууллагуудаас сүлжээг унагаадаг гэсэн асуудал яригдаад байдаг. Энэ нь яг үнэн зөв, бодитой байдаг юм уу. Эсвэл энэ бол зүгээр л бас өөр юу байдаг юм бол. Эдгээр асуултдаа хариулт авчихъя.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Бүр яг ярианы эхнээс нь авч үзэхэд Ганмаа гишүүн ээ, бид нар бүр энэ хуулийн төслөө хийж байхдаа нөгөө биеэрээ очихоос сэтгэлээр гэдгээс онлайн жагсаал цуглааны хэлбэр гэж бид нар бүүр төсөл дээрээ оруулчихсан байсан юм. Нэлээн удаан явж байгаад хэлэлцүүлгийн шатад энийг бол заавал хуульчлаад байх шаардлагагүй юм байна гээд ажлын хэсгийнхэн маань дүгнэсэн.

Түрүүн Их Хурлын даргынхаа асуултад бас нэмж хариулахад манай ажлын хэсэгт Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Нарантуяа бас орж ажиллаж байсан гэдгийг хэлье.

Энэ аяндаа үүссэн жагсаал цуглаан зохион байгуулагчтай болсон бол гээд. Ер нь бол аяндаа үүссэн жагсаал, урьдчилж мэдэгдсэн жагсаал 2-ын гол үндсэн ялгааг бол бид нар юу гэж томъёолоод байгаа юм гэхээр аяндаа үүссэн жагсаал бол тухайн цаг үеийн ямарваа нэг үйл явдал дээр өөрсдөө цугларчих ёстой гэсэн ийм санаатай байгаа. Тэгээд аяндаа үүсээд өөрсдөө жагсаал цуглаан хийж байвал заавал зохион байгуулалтад ороод, 1 хүнтэй бол гээд албадахгүй. Гэхдээ аяндаа үүссэн жагсаал өөрөө цаашаагаа удирдаад аваад явчихдаг, тэрийг удирдагчтай, зохицуулагчтай болчих ийм тохиолдолд судалгаа гаргахаар түгээмэл байгаад байгаа юм. Аяндаа жагсаал үүслээ. Нэг удирддаг хүнтэй боллоо, тэр нь дуу хоолойгоо хүргэж байвал, тэгвэл энэ жагсаалдаа та хэд маань бүртгүүл. Одоо та хэд зохион байгуулалтын хэлбэрт орчихлоо. Магадгүй 1 нь тэнчээнээс гудас авчраад л, 1 нь тэнчээнээс бэлтгэл хийгээд л эхэлж байгаа бол та хэд нэгэнтээ бэлтгэлтэй болоод удирдан зохион байгуулах хүмүүстэй болчихсон бол зорилгоо тодорхойлоод бүртгүүлчих гэдэг ийм л тодорхойлолтыг бид нар өгүүлэх гээд байгаа юм.

Тэр албадан тараах эрх бүхий субъектийн хувьд бол Засаг даргын Тамгын газрын дарга байх бол энэ хууль зүйн хувьд бүрэн үндэслэлтэй. Өнөөдөр Засаг даргын Тамгын газрын даргад тавигдаж байгаа хуулийн шаардлагууд дотор энэ албан тараах эрх мэдлийг өгч болохгүй гэсэн хуулиар хориглосон хязгаарлалт ерөөсөө байхгүй байгаад байгаа. Энэ бол яах вэ, жишээлбэл Засаг дарга хийж байсан хүмүүсээс манай Их Хурлын гишүүд тухайлаад Засаг дарга хийж байсан хүмүүс наадах чинь бол хэрэггүй. Засаг даргад нь хэвээрээ үлдээ гэсэн санал гаргаж байна лээ. Хэлэлцүүлгийн явцад хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явбал энэ сольчиход асуудал байхгүй. Тэгэхдээ бид бол ямар санаагаар оруулж байна вэ гэхээр тэнд байгаа улс төрийн биш, яг хууль зүйн хувьд улс төрийн биш хамгийн өндөр албан тушаалтанд төрийг хариуцаж байгаа учраас энэ ямарваа нэг улс төржилтгүйгээр дундын шийдвэр гаргах болов уу гэсэн ийм үндэстэйгээр бид нар оруулсан шүү.

Төсөл батлагдсанаар бид нар бол дэвшил гарна гээд тооцож байгаа. Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын 4, 5 удаагийн илтгэлд дурдагдсан зүйлүүдийн бид нар 70 хувийг нь шийдчихэж байгаа. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл маань гаднын байгууллагууд хүний эрхийн индекс гарах, бид нар улс төрийн эрхийг тодорхойлоход нөлөөлдөг учраас энэ асуудлууд шийдвэрлэгдээд, иргэдийн маань ингээд чөлөөтэй жагсаал цуглаан хийх эрх чөлөө нь баталгаажаад ирэх юм бол яг бид нар энэ индекс ч бай, хүний эрхийн нөхцөл байдалд ч бай бид нар нэлээн ахиц гарна гэж бодож байгаа. Нэн ялангуяа сүүлийн их олон жилийн турш шүүмжлүүлж байсан энэ бүртгэл нэртэй зөвшөөрлийн тогтолцоо халагдах нь энд сайнаар нөлөөлнө гэж үзэж байгаа.

Тэр сүлжээ унагаадаг гэдэг асуудалтай холбоотой тайлбарууд нь бол ерөөсөө 1 дор гар утасны сүлжээ хэрэглэгч олон хүн цугларснаар сүлжээ унана гэдэг тайлбар тавьдаг юм байна лээ. Тэгээд яах вэ энэ тайлбар бас үндэстэй юу, үгүй юу гэдэг дээр би бас яг энэ хүний эрх чөлөөний зөвлөлд асуудал тавьж байсны хувьд эргэлзэж байсан. Гэтэл сүүлд бол тохиолдол ярихад Сүхбаатарын талбай дээр ирсэн тэр инфлүенсер залуу шууд дамжуулалт хийж байхад хүмүүсээ холдоорой сүлжээ нь уналаа гээд орилдог юм байна лээ. Тэгэхээр яалт ч үгүй олон хэрэглэгч ирэхээр манай сүлжээнээс шалтгаалаад тэр унадаг юм байна лээ шүү.

Д.Амарбаясгалан: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууя.

Х.Тэмүүжин: Өнөөдрийн чуулганаар яг нэг алдаа гэдэг юм уу, завхрал дээр суурилсан 2 хууль хэлэлцэж байгаа юм. Түрүүн Амьтны хууль хэлэлцсэн. Тэр амьтны хууль дээр ямар агуулга гарсан бэ гэхээр төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа хуулийн биелэлтийг хангуулах гэж байгаа албан тушаалтнууд хуулийн бүрэн мэдлэггүйгээсээ болдог юм уу, эсвэл байгаа хуулийг хэрэглэхгүй байх тийм хүсэл зоригосоо болдог юм уу, иргэдэд хүндрэл учруулдаг учраас арга ядаад дахиад хууль янзлах гэж оролдож байгаа байхгүй юу. Галт зэвсгийн хууль дээр өөрийнхөө эзэмшиж байгаа галт зэвсгээр амь нас, эд хөрөнгөө хамгаалахын тулд хэрэглэнэ гээд бүүр заалт байж байгаа. Хууль байж байгаа. Гэтэл энэ хуулийг хэрэглэхгүйгээр иргэдэд та бол зөвшөөрөлтэй ан амьтан агначихсан байна гээд мөнгө нэхээд, хариуцлага шаардаад эхэлж байна гэдэг бол хуулийг буруу хэрэглэж байгаа, хуулийг иргэнд ээлгүйгээр хэрэглэж байгаа хамгийн том жишээ юм.

Жагсаал цуглаантай холбоотой асуудал бас тийм. Бүртгэх гэдэг энэ хуулийн зохицуулалтыг яг даргын нүдээр, эрх мэдэлтний нүдээр иргэнийг дээрээс доош чиглэсэн үл тоосон нүдээр уншаад, тэгээд энийгээ бүр зөвшөөрөл болгоод, хүнд суртал болгоод, иргэний Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг бүр байхгүй болтол нь үгүй хийж байгаа практик бол ерөөсөө л энэ хууль уншиж байгаа нүднээс шалтгаалж байгаа юм.

Хуулийг 2 янзын нүдээр уншиж байна. Нэг нь зөвхөн эрх мэдэлтэн өөрөө өөрийгөө хамгаалах, улс төрийн тогтвортой байдлаа бэхжүүлэх, эрх мэдлээ хадгалж үлдэх зорилгоор хуулийг уншиж тайлбарлаж байна.

Жирийн иргэд тэр хуулиас өөрийнхөө эрх чөлөөг жоохон ч гэсэн өлгөж аваад хэрэгжүүлчих юм сан гэсэн горьдсон нүдээр олж уншиж байгаа юм. Хуулийг. Тэгээд эрх мэдэлтний нүд хэт субъектив байна. Хуулийг уншихдаа хамгийн түрүүнд л ерөөсөө л хорьж хаах, айлган сүрдүүлэх, мэдэн будилах, үл хэрэгсэх, бүр сүүлдээ хуулийг хувийн бодлоороо орлуулах хэмжээнд уншиж хэрэглэж байгаа юм. Тэрнээс болоод энэ жагсаал, цуглаантай холбоотой зохицуулалт эцсийн дүндээ юу болоод хувирч байна гэхээр яаж Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөний энэ хэсгийг төрийн дур зоргоос хамгаалах вэ гэдэг том асуултад хариу өгөх хэмжээнд ирж байгаа юм.

Энэ хуулийн концепцыг ч гэсэн бид нар дахиад нягтлах ёстой болж байгаа юм. Жагсаал, цуглаан зохион байгуулах эрх чөлөөтэй холбоотой энэ хууль тогтоомж гэж гарчгаа нэрлэж байгаа бол энэ хуулийн үндсэн концепц төр юу хийж болохгүй вэ гэдэг рүү бас чиглэх ёстой. Саяхан ойрынх нь түүх Засгийн газрыг огцруулах, хариуцлага тооцохтой холбоотой залуучууд жагсаал хийсэн чинь тэр жагсаалынх нь дундуур зохион байгуулалттайгаар хэсэг бүлэг итгээд Украйны далбааг гаргаж ирж зураг аваад, буцаагаад Украйныхаа далбааг хумьж аваад, тэр зургаа

сошиалаар сэвээд, дайныг Украйны талд явдаг хүмүүс Монгол Улсын Засгийн газрыг эсэргүүцэж байна гээд бүр сэвээд эхэлж байгаа байхгүй юу. Энийг жирийн иргэд зохион байгуулахгүй. Энийг бүр тусгай албадын түвшинд зохион байгуулж байгаа юм шиг маш нарийн хийж байгаа. Бүр технологитой. Яг гүйцэтгэх ажил хийж байгаа юм шигээр хэн далбааг нь барьж гарч ирэх вэ, хэн зургийг нь авах вэ, хэн зохион байгуулж сэвэх вэ, текст нь хаанаас бичигдэх вэ гэх мэтчилэн. Ийм зүйлүүдийг таслан зогсоож чадах Монголын төрд байна уу. Иргэнийхээ Үндсэн хуульд заасан үзэл бодлоо илэрхийлэх, энэ үзэл бодлоо жагсаал, цуглааны хэлбэрээр олон нийтийн газар олуулаа нийлж илэрхийлэх тэр эрх чөлөөг нь Засгийн газар, төрийн байгууллага тусгай албад орж ирээд саармагжуулдаг, өөрчилдөг ийм үйлдлийг таслан зохих боломжийг энэ хууль бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайд хариулт өгье.

О.Алтангэрэл: Ер нь бол ямар тохиолдолд ямар газруудад хориглох вэ, ямар тохиолдолд хязгаарлалт байх вэ гэдэг энэ хуульд зааснаас бусдаар ямар нэгэн хязгаарлалт огт байх ёсгүй. Тэмүүжин гишүүний хэлж байгаа үгийг бүрэн дэмжиж байна. Ер нь энэ жагсаал, цуглааныг эсрэг жагсаал хийхийг хориглоно гэдэг, олуулаа жагсаж, цуглаж болохгүй гэдэг янз янзын үйл бодолтой байж болохгүй гэдэг энэ олон хориглолт, хязгаарлалтууд өнөөгийн хууль дээр байгаа хориглолт, хязгаарлалтууд сүүлдээ юу болж хувирсан бэ гэхээр яаж явагдаж байгаа тэр жагсаал цуглааныг тараах вэ, яаж тэр зорилгоос нь хэрвээ үнэхээр тэр жагсаал цуглааныг таалагдахгүй байгаа эрх барьж байгаа субъектэд таалагдахгүй бол яаж өөрөөр харуулах вэ гэдэгт их олон ашиглагдсан. Бид нар энэ хуулийн төслийг бичихдээ ингэж ашиглах цоорхой завсар аль болох бага байлгахыг бид нар хичээсэн. Саяын асуудлыг бүрэн шийдвэрлэхийн тулд дагалдаад бас бид нар бусад хуулиудад ч гэсэн нэмэлт, өөрчлөлт бас оруулах ёстой болно. Саяын асуудлыг бүрэн шийдвэрлэнэ гэвэл. Ерөөсөө жагсаал, цуглаан хийж үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэдэг бол иргэдэд байдаг юм байна. Жагсаал, цуглаан хийж үзэл бодлоо илэрхийлж байгаа мэт хэлбэрийг ямарваа нэг байдлаар эрх мэдлийг хадгалах болон эрх мэдэл рүү нь чиглэж байгаа тэр аюулыг холдуулах хэрэгсэл болгож ашиглаж болохгүй гэдэг энэ зарчмыг бол бүрэн дүүрэн дэмжиж байна.

Д.Амарбаясгалан: Тэмүүжин гишүүн тодруулж асууя.

Х.Тэмүүжин: Тэгээд саяын агуулга дотор үнэхээр бид нар хуулийн концептууд дээрээ зарим талаараа иргэний үндсэн эрхийг хангахад чиглэж байгаа, тэгээд энэ эрхийн төлөө гэж хуулиа гарчиглаж байгаа хуулиуд дотор концепцын хувьд энэ эрхийн эсрэг төр юу хийж болохгүй тухай бас тодорхой зохицуулалтуудыг хийхээс өөр аргагүй юм байна лээ. Төр хийсэн бол үүнийхээ төлөө хариуцлага хүлээдэг хариуцлагын механизмуудыг бас бий болгож авахгүй бол болохгүй юм байна лээ. Тэр дундаа энэ яг Үндсэн хуульд байгаа энэ эрх, эрх чөлөөтэй холбоотой асуудлууд дээр төр засгийн зүгээс хязгаарлалтууд хууль бусаар хийж оролцож байгаа бол түүнийг нь парламент дээр бас хянаж шалгаж, парламентын хяналтын туслалцаатайгаар иргэний Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг парламент бас хамгаалдаг шүү гэдэг тогтолцоог бүрдүүлж авахгүй бол бас бидэнд сул парламентын засаглал бүхий энэ улсын хувьд бол сул байгаа юм байна лээ.

Дээр нь парламентын засаглалтай холбоотой дахиад нэг юм ярихад .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Хуулийг дэвшилтэт талууд байгаа гэж харж байгаа боловч хэтэрхий их олон хориглосон заалтууд байгаа юм шиг санагдаж байна. Сүүлийн үед үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө хумигдлаа. Хэвлэл мэдээллийн индексээрээ бид нар ухарлаа. Тэр нь тодорхой болсон. Одоо Жагсаал, цуглаан хийх хуулиар оролдож эхэллээ. Хууль бус жагсаал цуглаан гэж юуг нь хэлээд, хууль ёсны жагсаал цуглаан гэдэг нь юуг нь хэлэх юм бэ. Хуулийн төсөлд жишээ нь шөнийн цагаар жагсаал хийхийг хориглосон байна. 22 цагаас хойшоо. Аяндаа үүссэн жагсаал, аяндаа үүсээгүй жагсаал гэдгийг яаж тайлбарлах юм бэ. Энэ нь бүрхэг байна. Шөнө жагсаал яагаад хийж болдоггүй юм. Жагсагчдыг хамгаалахгүй гэнэ ээ. 2024 оны 12 сарын 4-нд Солонгос Улсын Ерөнхийлөгч онц байдал зарласан. Тэр шөнө Солонгост юу болсныг та бүхэн дэлхий нийтээрээ хараад, Солонгост жинхэнэ ардчилал байгаа юм байна гэж бүгдээрээ шагшсан. Тэгвэл яагаад Монгол хүн шөнө жагсах эрхгүй байдаг юм. Шөнө ямар нэгэн юм болбол юу болох вэ. Алийг нь төлбөртэй жагсаал, алийг нь төлбөргүй жагсаал, алийг нь хууль ёсны, алийг нь хууль бус гэх юм гэдэг чинь иргэд өөрсдөө үзэл бодлоо илэрхийлснийг яаж ч мушгин гуйвуулж, яаж ч эрүүгийн хэрэг үүсгэж болохоор байна шүү дээ. Тэгээд энэ хариуцлага тооцно гэсэн заалт байх юм.

Жагсаал, цуглааны тухай хуулийг зөрчсөн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна шүү дээ. Жагсаал, цуглааны хуулийг зөрчсөн гэж үзэж болох нь нээлттэй байна. Тэгэхээр би бол энэ хуулийг бол үнэхээр хүний эрхийг бол зөрчиж байгаа хууль байна гэж үзэж байна. Бид нар яагаад өнөөдөр ардчилсан Монгол Улс байж үг хэлээ хэлсэн болгоныг тэнэг мангар, үг хэл, үзэл бодлоо илэрхийлсэн хүнийг хэн нэгний мөнгөөр жагсаж байгаа, энэ хууль ёсны жагсаал, энэ хууль бус жагсаал, 22 цаг боллоо та нар тар, та нар зөвшөөрөлгүй, удирдагч гараад ирэх юм бол бүртгээд авна ч гэх шиг ийм сонин сонин юм хэлэлцээд сууж байгаа юм. Би бол ингэж болохгүй гэж бодож байна.

Тэгэхээр энэ хуулийн төслийг дэмжихгүй байна. Бүхэлд нь. Монгол Улс үг хэлэх, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, жагсаж, цуглах эрхтэй баймаар байна. Энийг нь бид нар ангилаад байх хэрэггүй гэж бодож байна шүү дээ. Хууль ёсны жагсаал, хууль бус жагсаал тэгмээргүй байна. Тийм учраас хуулийн төслийг бүхэлд нь дэмжмээргүй байна. Үг хэллээ.

Д.Амарбаясгалан: Мөнхбаясгалан гишүүн үг хэллээ. Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Жагсаал цуглаан хийх эрх бол Үндсэн хуулиар баталгаажсан, Монголын бас ардчиллын гол эрхүүдийн нэг. Тэгээд өнгөрсөн хугацаанд бол жагсаал, цуглаан хийх эрхэд бол удаа дараалан халдсан үйл явдлууд ч бас нэлээн гарсан. Тэгээд сая жишээлэх юм бол энэ хуулийн төсөл яригдаад эхлэнгүүт л бас Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нэг нөхөр ийм ярилцлага өгчихсөн байгаад байгаа юм.

Төв талбайд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн үед жагсаал цуглаан хийх хүсэлт ирэхэд хойшлуулдаг гээд. Зүгээр захиргааны албан хаагчийн ийм яриа өгөөд сууж байна л даа. Тэгээд төв талбай гэдэг бол Улаанбаатар хотын бас цохилох зүрх, яг нийгмийн амьдрал бүхэлдээ, хотын

амьдрал бүхэлдээ энэ төв талбай дээр буцалж байдаг. Гэтэл сүүлийн жилүүдэд ямар практик газар авсан бэ гэхээр ерөөсөө л энэ улс төрийн өндөр идэвхжилттэй цаг үеүдэд болохоор төв талбай дээр янз бүрийн арга хэмжээ төлөвлөдөг, завгүй байлгадаг энэ маягаар бүр хуулиас гадуур маркаар жагсаал цуглааныг бүртгэхгүй байдаг ийм нөхцөл байдлыг бий болгож байгаа. Одоо ч төв талбай дээр нэг талд нь гуанз ажиллаж байх шиг байна. Нөгөө талд нь бас ийм үүргийн худалдаа явж байх шиг байна гэх мэтчилэн ийм хязгаарлалтууд бол байсаар ирсэн. Гэх мэтчилэн ийм захиргааны шинж чанартай хязгаарлалтуудыг бол энэ хуулийн төслийн хүрээнд авч үзсэн үү гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт нь бол ер нь энэ жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль гэж урьд нь байсан. Тэр хуулийг бол бид дандаа л тэгж шүүмжилдэг байсан. Яахаараа жагсаал цуглаан хийх эрхийг журамладаг юм бэ. Элдэв янзын хязгаарлалт нэмэгдэх тусмаа илүү хүний эрхийг хязгаарласан, хориглосон, тэгээд дээрээс нь юу гэдэг юм захиргааны байгууллага, цагдаагийн байгууллагуудын эрх, үүргийг нэмэгдүүлсэн ийм зүйл рүү аваачдаг. Тийм учраас энэ журмын тухай хууль гэж байж болохгүй гэж бас шүүмжилдэг байсан.

Тэгээд энэ Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль гэсэн нэртэй болсноороо бас их айхтар бас ахиц дэвшилтэй зүйл бол харагдахгүй байна. Засаг даргад бүртгүүлдэг тэр арга хэлбэрийг цагдаад хүсэлт илгээдэг хэлбэрээр өөрчилж байгаа юм байна. Энэ бол бараг л дордсон зохицуулалт болов уу гэж харж байгаа. Ер нь манай цагдаагийн байгууллага ч гэсэндээ аливаа зүйлд ямагт тэр хориглох хязгаарлах талаас нь ханддаг. Тэгээд энэ жагсаал цуглаантай холбоотой асуудал дээр ч гэсэндээ цагдаагийн байгууллагын зүгээс энэ хүний эрхийн мэдрэмжийг дээшлүүлэх чиглэлээр ямаршуу арга хэмжээнүүд авч байна вэ гэдэг дээр бас санаа зовниж байна. Тэгэхээр энэ утгаараа бол бид энэ хуулийг бас л их л нухацтай авч үзэхгүй бол эргээд энэ хүний эрх, эрх чөлөөг боомилсон тал руугаа явчих вий гэсэн маш тийм том болгоомжлол байна. Тухайлах юм бол 2008 оны 7 дугаар сарын 1-ний тэр эмгэнэлт үйл явдлууд бол бас Монголын нийгэмд маш том хар толбо үлдээсэн шүү дээ. Тэгээд л бараг бүтэн хэдэн үе залуусыг ийм айдаст автуулсан. Тэгээд сая сүүлийн жилүүдэд гарсан жагсаал, цуглаан дээр болохоор булаадаг л гэнэ. Эсвэл янз бүрээр хорьж цагдах зүйлүүд ч гэсэндээ маш ихээр гарсан. Тэр болгон дээр бид нар ерөөсөө дүгнэлт хийгээгүй. Тэгээд ерөөсөө дүгнэлт хийхгүй явсаар тэгсэн хэр нь хууль тогтоомжийг нь бол өөрчилье гээд ингээд оруулаад ирж байгаа юм. Тэгэхээр өмнөх тэр зүйлүүд дээр бас ямар тухайлсан дүгнэлтүүд хийсэн юм. Ер нь ямар ямар алдаа мадаг гарсан юм. Хэчнээн хүний эрх, эрх чөлөөнд халдсан юм гэх мэтчилэн зүйлүүд дээрээ бас нэг хариулт авмаар байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энэ удаа бас Алтангэрэл сайд Засгийн газраас энэ Жагсаал, цуглааны хуулийн шинэчилсэн найруулгыг оруулж ирж байгаа юм. Энэ бол бас нэлээдгүй хугацааны дараа, удаа дараа яригдаад хийгдэж чаддаггүй байсан ажлыг амжуулж байна гэж харж байгаа. Тэгэхээр Улсын Их Хурал энэ дээр ажил хэрэгчээр хандаа, иргэдийн эрхийг хангах, хамгаалах чиглэл дээр бас дэмжиж ажиллах нь зөв байх гэж бас бодож байгаа. Тэгээд Алтангэрэл сайд асуултад хариулъя.

О.Алтангэрэл: Ер нь одоо байгаа хууль нь ямар байна гээд нэг харчих ёстой юм шиг байгаа юм. Тэгээд дээрээс нь энэ хуулийн төсөлтэйгөө холбогдуулаад бид нар нэг судалгаа бас эмхэтгээд ингээд өгч байгаа. Тэр дээр энэ хэрэгжилтийн үнэлгээнд нь хийсэн тайлан, бусад газраас өгсөн саналууд байгаа. Тэгэх юм бол

аль хэсгээрээ яаж сайжирсан нь харагдана. Жишээлэх юм бол ямарваа нэг улс төрийн албан тушаалтан биш Засаг даргад өгдөг биш тэгээд тэрнийхээ хариу нь бүртгэхгүй бол бүртгэхгүй гэлээ гэдэг биш зүгээр л цагдаа руу мэдэгдэл өгнө гэж байгаа шүү дээ. Энэ яахаараа дордсон гэж үзэж байгааг би жишээлбэл Жаргалан гишүүний асуултыг ойлгохгүй байна. Урьд нь зөвшөөрөл хүлээдэг байсан бол зүгээр бичиг аваачаад өгчих, 48 цагийн өмнө. Тэгээд энэ чинь өөрөө цагдаагийн байгууллага олон улсын жишгээрээ бид нар их олон улсын жишиг дээрээс энийг харсан юм. Цагдаагийн байгууллага тухайн жагсаал цуглаантай холбоотой зүйлүүдийг энд жагсаал, цуглааныг зохион байгуулж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээгээ л авна. Зөвшөөрөх, зөвшөөрөхгүй ямар ч ойлголт байхгүй. Аяндаа үүссэн жагсаал дээр бол тухайн цаг үед нь нөхцөлтэйгөөр энэ зөвшөөрөлгүй шууд ирээд л цугларчих гэж байгаа юм. Тэгэхээр энэ бол бид нар бол хамгийн дэвшилттэй, хамгийн сайжирсан зохицуулалт гэж үзээд байгаа юм.

Тэгээд бид нар дүгнэлт хийхгүй биш, харин дүгнэлт хийгээд энэ удаагийн хуулийн төсөл боловсруулагдаж байгаа. Таны саяын тэр дурдаж байгаа 7 сарын 1-ний асуудал, өнгөрсөн жилүүд болсон жагсаалын асуудал. Тэгээд энэ асуудлууд зохицуулалтгүй байх тусам заримдаа хүний эрхийг хязгаарлах хүчин зүйл болоод байгаа юм. Цагдаагийн байгууллага тэнд очоод хуулиараа үүрэгтэй бүртгэлгүй бол тараа гэдэг үүрэгтэй. Жагсаал цуглааныг мөнгөөр татсан бол зөрчлүүд гарсан бол арга хэмжээ ав гээд цагдаагийн байгууллагад үүрэг хүлээлгэчихдэг. Цагдаагийн байгууллага хуулиа мөрдөх үүрэгтэй. Цагдаагийн байгууллага тэнд оролцогч зохион байгуулагчдын бүгдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Ингээд одоогийн байгаа хуулийн дагуу болчихоор хэт ерөнхий харилцаан дээр цагдаагийн байгууллага үүргээ гүйцэтгэх гэхээр өнгөрсөн жилүүдэд гарч байгаа тэр олон хүний эрхийн зөрчлүүд гэдэг чинь гарч ирээд, цагдаа бид нар хуулиа бүрдүүлнэ гэдэг, иргэд бид нар эрх, эрх чөлөөтэй гэдэг. Аль болохоор энэ харилцааг бид нар нарийн журамлаад өгвөл болно гэдэг энэ асуудал бол шийдвэрлэгдэнэ гэдэг энэ утгаар л бид нар хандаж байгаа юм. Ер нь энэ харилцаа детальчилж сайн заагдах тусмаа, нэн ялангуяа хууль сахиулагч, цагдаагийн байгууллагын гүйцэтгэж байгаа үүрэг нь тодорхой болох тусмаа иргэд цагдаа нарын хооронд харилцан үл ойлголцол үүсэх нь багасна. Иргэдийн эрх, эрх чөлөөнд учрах энэ аюул багасна гэдэг үндсэн дээр бид нар хийсэн юм. Тэгээд энэ жагсаал цуглааныг байршилтай холбоотой зүйлүүдийг ярьж байгаа юм. Энэ байршилтай холбоотой чинь Сүхбаатарын талбай дээр бол Сүхбаатар дүүргийн энэ асуудлыг л харж байгаа байхгүй юу. Тэгээд Нийслэлийн Засаг даргыг харж байгаа. Тэгээд энд ёстой тэр нэг хоолоо ажиллуулна уу, юугаа ажиллуулна, яасан бол өгөхгүй гээд шалтаг нь тэр ажил болж байгаа юм. Энэ асуудал цагдаагийн байгууллагад очих юм бол тэр талбай дээр нь хоол зарж байна уу, ном зарж байна уу цагдаагийн байгууллагад хамаагүй шүү дээ. Өөрөөр хэлэх юм бол зөвшөөрдөг субъект биш учраас энэ дунд хүмүүс жагсах юм байна гээд л цагдаагийн байгууллага бэлтгэлээ хийгээд эхэлнэ. Энэ майхнуудын хажууд жагсах юм байна. Төчнөөн хүн жагсах юм байна. Аюулгүй байдлыг нь ингэж хангах юм байна гээд л ажиллагаа хийгдэг. Ингээд энийг бол бид дэвшил л гэж үзэж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Жаргалан гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалан: Наад дээр чинь бас яг эсрэг аргумент хэлж болж л байна л даа. Яагаад вэ гэхээр Засаг засаг даргад хүсэлт өгнө гэдэг нь бол өөрийнхөө сонгосон тэр улс төрийн албан тушаалтанд хүсэлт өгнө гэдэг нь бол яг ийм иргэний журмаар явж байгаа харилцаа. Тэгэхээр би өөрийнхөө сонгосон, өөрийнхөө нутаг дэвсгэр

дээр тэр дүүрэг дээрээ байгаа, амьдарч байгаа хүний хувьд тэнд явуулах гэж байгаа үйл ажиллагаа дээр иргэний журмаар тэр албан тушаалтанд хандаж болж байна. Цагдаад хүсэлт өгнө гэдэг чинь бол цаанаасаа л бүр ийм жоохон дарамттай тийм харилцаа болоод эхэлнэ шүү дээ. Мэдэгдэл. Харин тийм. Тэгэхээр яах вэ, Цагдаагийн байгууллагатай харилцах нэг асуудал. Манай цагдаагийн байгууллагын тэр хүний эрхийн мэдрэмж ямар байгаа билээ. Цагдаагийн байгууллагатай харилцана гэдэг нэг асуудал. Тэр өөрийнхөө сонгосон албан тушаалтай харилцана гэдэг чинь бас шал өөр харилцаа байхгүй юу. Тэгэхээр тэн дээр энэ цагдаагийн байгууллагад чинь санаа зовоод байна шүү дээ. Яг хэр зэрэг хүний эрхийн мэдрэмжтэй асуудалд хандаж байна. Ер нь тэр бусад харилцаанууд нь ямар байна гэдэг дээр.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Н.Лхагвасайхан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам болон олон нийтийн аюулгүй байдлын албаны дарга, хурандаа Лхагвасайхан илтгэж байна. Ер нь Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд бол 1200 орчим жагсаал цуглаан болсон ийм дүн мэдээ байдаг. Энд 16 орчим мянган хүн оролцсон. Ер нь энийг яг дотор нь ангилаад үзэх юм бол жагсаал нь бол 188, цуглаан нь 1012 гээд тоо гардаг. Ер нь цагдаагийн байгууллагын зүгээс ер нь цаашдаа энэ систем динамикийн аргачлалаар тооцоод үзэхээр 2025 онд 250 орчим жагсаал цуглаан болно. 2026 онд 264, 2028 онд 293 гээд ер нь улам л энэ жагсаал цуглааны нөхцөл байдал хүндрэх, жил ирэх тутам олон болох ийм юмнууд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Н.Лхагвасайхан: Тэгэхээр энэ хуулийн гарч байгаа гол зохицуулалт хийж байгаа санаанууд маань түрүүн сайд хэллээ. Үндсэндээ энэ Засаг даргаас Засаг даргад бүртгүүлээд жагсаал, цуглаан хийдэг байсныг болиулж байгаа нь ер нь ард иргэд цагдаагийн байгууллагын хоорондын энэ зөрчилдөөн чинь ихэнх нь эндээс гарч байгаа юм. Өнгөрсөн хугацаанд болсон жагсаал цуглааны 86,7 хувь нь ерөөсөө бүртгэлгүйгээр шууд жагсаал цуглаан хийчихсэн. 10 гаруй хувь нь л бүртгэлтэй гэдэг байдлаар гарсан байгаа. Тэгээд энэ дээр гол нь цагдаа очоод, бүртгэлгүй байна. Тэрийгээ тар гэдэг. Тэгээд шаардлага, мэдэгдэл өгдөг. Үүнээс үүдээд цагдаа, иргэд 2-ын дунд тодорхой хэмжээний зөрчилдөөн үүсдэг. Энийг бас хамгийн наад зах нь зохицуулчих хууль тогтоомж бас санаачлагдаад явж байгаа гэдгийг танд хэлье.

Хүний эрхийн чиглэлээр бол цагдаагийн байгууллагаас Хүний эрхийн Үндэсний Комисс, мөн энэ ОУБ-тай хамтраад бол хүний эрхийг дээдлэх чиглэлээр сургалт зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг бол авч байгаа. Ер нь бол цагдаагийн байгууллагаас бас тодорхой хэмжээний хүний эрхийн мэдрэмжтэй ажиллаж байгаа. Сүүлийн жилүүдэд гарсан жагсаал, цуглааныг бол албадан тараасан ийм тохиолдол байхгүй. Аль болохоор нөхцөл байдлыг хүндрүүлэхгүй, хүний эрх, эрх чөлөөг хангах, тайван арга замаар жагсаалыг зохицуулалт тараах ийм л ийм зохион байгуулалтын арга хэмжээ авч байгаа. Дууслаа.

Д.Амарбаясгалан: Жаргалан гишүүн дахин тодруулж асууя.

Б.Жаргалан: Сая цагдаагийн байгууллагын төлөөллийн хэлсэн үгэн дээр нэг зүйл гарч байна л даа. Ирэх жилүүдэд бол энэ жагсаал цуглаан олширно. Нөхцөл

байдал хүндрэх хандлагатай байна гэсэн зүйл хэллээ. Тэгэхээр харин яг ийм хандлага байгаад байдаг учраас бас санаа зовниод л байгаа юм. Яагаад вэ гэхээр жагсаал, цуглаан гэдэг чинь ардчилсан нийгэмд эрүүл зүйл шүү дээ. Олширлоо гээд нэг их аймар нийгмийн хэв журам алдагдаад, асуудал хүндрээд байх зүйл ерөөсөө биш. Ардчилал ийм нээлттэй, ил тод, энд хүмүүс дураараа жагсаад, үзэл бодлоо илэрхийлээд явж байна гэдэг бол байх ёстой асуудал байхгүй юу. Гэтэл нөгөө олшрох гээд байна энэ чинь хүндрэх гээд байна гэдэг хандлагаар манай цагдаагийн байгууллага бас хандаж байгаа нь өөрөө асуудал байна л гэж хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр цаашид бид нар энэ хандлагаа улам засмаар байгаа байхгүй юу.

Тэгэхээр чинь яг энэ хандлагаас болоод цагдаагийн байгууллагад хүсэлт өгөхөөсөө, мэдэгдэл өгөхөөсөө айж бол болзошгүй нь байна шүү дээ. Цагдаагийн байгууллагад би мэдэгдэл өгч байна гээд. Тэгэхээр ийм айдсыг бид нар бий болгож ../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лхагвасайхан дарга сая үгэндээ цагдаагийн байгууллага тодорхой хэмжээний хүний эрхийн мэдрэмжтэй ажиллаж байгаа гэж хариулж байна. Тодорхой хэмжээний биш, ер нь өндөр хэмжээний хүний эрхийн мэдрэмжтэй ажиллана гэдэг энэ ойлголт байх ёстой. Тийм ээ. 21 дүгээр зуунд энэ Улсын Их Хурлын зүгээс хүний эрхийг дээдэлсэн хууль, эрх зүйн орчныг бодитой бий болгоё. Хүн төвтэй хуультай болъё. Хүний эрхийг хангах, хамгаалах асуудал эн тэргүүний асуудал байя гэдэг ийм том зорилго тавьж ажиллаж байгаа. Тэгэхээр хууль сахиулах байгууллага ч гэсэн бас энэ дээр илүү анхаарал хандуулж ажиллаж байх хэрэгтэй.

Манай цагдаагийн байгууллагын хувьд ч гэсэн цагдаагийн тангаргаас өгсүүлээд олон зүйл дээр философийн хувьд жоохон өөрчлөлт хийх шаардлагатай гэж бас боддог юм. Мэдээж тангараг өргөсөн хууль сахиулагч хүн аюулгүй байдлыг хангахын төлөө, аюулгүй байдлыг сахиулахын төлөө ажилладаг. Тэгээд эн тэргүүнд бол хүний эрхийг хангахын төлөө гэдэг энэ ойлголт, үзэл санааг бас цагдаагийн тангараг, баримталж ажиллах зарчим гээд олон зүйл дээр оруулж ирэх нь аяндаа энэ өөрчлөгдөж, шинэчлэгдэж байгаа нийгэмд хөл нийлж алхах тэр боломжийг бий болгоно гэдэг талаасаа харж, та бүхэн маань бас шинэчлэлийн үзэл санааг хэрэгжүүлээрэй гэж ингэж хүсэж байгаа юм.

Ер нь жагсаал, цуглаан зохион байгуулах хэрэгцээ шаардлага гэдэг бол ардчилсан нийгэмд иргэн бүрд л байх боломжтой зүйл. Нээлттэй байх боломжтой зүйл. Тийм ээ. Харин тэр жагсаал цуглааныг улс төрийн өнцгөөс өрөөсгөл хэлбэрээр дүгнэдэг байдлыг бас бид өөрсдөөсөө эхлүүлж, засаж залруулах ёстой юм байгаа юм.

Ялангуяа жагсаал, цуглаан аяндаа үүссэн тохиолдолд ямар учир шалтгаан нөхцөл байдлаас болж ард иргэд жагсаж цуглаж өөрсдийнхөө үзэл бодлыг илэрхийлж байна вэ гэдэг дээр нарийвчилсан социологийн судалгааг энэ дотор бас хийж, тэр жагсаал цуглаанаас үүдсэн, жагсаал цуглааныг бий болгож байгаа нөхцөл байдлыг засаж залруулж арилгахын төлөө төр ажилладаг байх тийм зарчим руу шилжих нь өөрөө бас хүний эрхийг дээдлэх, хангах чиглэл дээр бол онцгой үүрэгтэй шүү.

Тэгэхээр энэ төслийг бас хэлэлцүүлгийн шатад энэ зүйл дээр анхаарч ажиллаарай гэдгийг бас та бүхэнд хэлье.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу үг хэлэхээр байгаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлье. 1 дүгээр индэрт урьж байна.

С.Эрдэнэболд: Яах вэ, ер нь бид нар ингээд асуудал бэрхшээлтэй ажиллах шаардлагатай байгаа нь үнэн. Гэхдээ хэцүү гээд асуудлыг шийдэхгүй байх шиг амархан зүйл байхгүй. Яагаад гэхээр энэ хуулийн үйлчлэл, орон зай, хэм хэмжээг нарийсгах, хүний эрхийг хангах шаардлага байна уу гэвэл байгаа. Тэгэхээр яах вэ, мэдээж олон талаас мэтгэлцээн өрнүүлээд, шүүмжлэлтэй хандаж байгаа ч гэсэн үүний үндсэн дээр ингээд больё гээд больчихдог бол бас хэцүү. Энэ хэвлэл мэдээллийн хууль ч тэр, энэ жагсаал цуглааны хууль ч тэр. Цаанаа хүний эрхийг хангах асар том хөшүүргийн тухай бид нар ярьж байгаа.

Тэгэхээр би 2 төрлийн зүйл хэлнэ. 1 дүгээрт нь болохлоор энэ Сүхбаатарын талбай ч юм уу, ер нь томоохон талбай, эрх чөлөөний талбай гээд эдгээр талбай бол тухайн үндэстний ардчилал эрх чөлөөний бэлгэ тэмдэг байдаг. Гэтэл сүүлийн жилүүдэд яг улс төрийн идэвхжилтэй сар улирлуудад энэ талбайг дүүргээд баахан худалдааны лангуу ажиллуулдаг. Энэ нь хүмүүст харахад их гоё юм шиг боловч цаагуураа бас яг энэ улс төрийн хүсэл зоригийг илэрхийлэх, улс төрийн эрхээ эдлэхэд нь тодорхой хэмжээний ийм хаалт болдог гэсэн зүй тогтол ажиглагдаж байгаа. Энийг бас бид нар тооцож үзэх ёстой. Жагсаал, цуглааны хувьд бас нэлээн харлаа. Харьцангуй Азийн орнуудын хувьд илүү их зохион байгуулалттай, эмх цэгцтэй болсон. Энэ нь яагаад вэ гэхээр энэ Солонгос ч гэдэг юм уу, Хонг конг ч гэдэг юм уу энэ улс орнуудад энэ жагсаал цуглааны тухай хуулиуд бол нарийвчилсан, хариуцлага хүлээх эздийг нь тодорхой болгосон, эрх, үүргийн хэм хэмжээг нь маш нарийн зохицуулсантай холбоотой. Сүүлийн жилүүдэд бидний үлгэрлэн ярьдаг барууны орнуудад бол жагсаал, цуглааны асуудал маш хүнд төлөвтэй болсон. Жишээлбэл Европын орнуудад жагсаал болонгуут л тэр даруйдаа эмх замбараагүй байдал болж, машин тэрэг шатаадаг, галдан шатаадаг, тийм турхирдаг ийм зүйлүүд болсон. Ялангуяа энэ цагаачлалын асуудлаас хойш энэ бол 2021 он гэхэд Трампыг эхний бүрэн эрхээс буусны дараагаар ч гэсэн төрийн ордон руугаа дайрсан ч гэдэг юм уу ийм зүйлүүд болсон. Мэдээж энэ чинь нөгөө нээлттэй нийгэм, чөлөөт медиа, хэвлэл мэдээллээр улс орон дэлхий дахинд юу болж байгааг иргэд, олон нийт, залуучууд харж байгаа учраас ер нь энийгээ дагаад энэ зүй тогтлоо дагаад бид нар талбай дээр махан биеэр физикли жагсана гэхээсээ гадна бас энэ чөлөөт нийгмийн үзэл санаа болсон янз бүрийн энэ сошиал медиагаар хүмүүс мэдээлэл аваад, талбай дээр цуглардаг энэ үзэгдэл.

Сүүлийн жилүүдэд дунджаар жилд 250 орчим жагсаал цуглаан болж байгаагийн ихэнх нь улс төртэй холбоотой болж байгаа. Тэгэхээр энэ жагсаал цуглааныг хувь улс төрч гэдэг юм уу, төрийн өндөр албан тушаал хашиж байгаа тэр тусмаа эрх барьж байгаа хүмүүс өөрсдийн нүдээр шүүмжилдэг иргэдийг айдаст оруулдаг байж болохгүй. Энэ жагсаалыг тийм хүн санхүүжүүлж байгаа. Тийм тийм газрууд ингэж байгаа, энэ үндэсний аюулгүй байдалд заналхийлж байгаа гэх мэтээр иргэдийн улс төрийн эрхээ эдлэх эрх чөлөөнд нь халдаж болохгүй. Энийг бас оруулмаар байгаа юм.

Дараагийн нэг зүйл нь болохоороо Засаг дарга гэдэг өөрөө нөгөө улс төрийн албан тушаалтан учраас энэ бол бас их ээдрээтэй. Тэр утгаараа зүгээр хүсэлт биш, цагдаад мэдэгдэх гэдэг аюулгүй байдлыг хангах талаасаа бол зохицуулалтыг бол

зөв гэж харж байгаа. Сая бас Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан Удирдах ажилтны зөвлөгөөн дээр бас хүний эрхийн даргын хувьд очиж орсон. Тэгэхэд манай цагдаагийн байгууллага аль болох хүний эрхийг бүхий л үйл ажиллагаандаа ингээд хангана гэсэн ийм жилийн уриа эд нар гаргаад явж байгаа. Гэхдээ юм л бол нохойд барьдаг мод гэдэг шиг цагдаагаа бид нар шүүмжлээд байж болохгүй. Асуудалд саруул ухаанаар, мэргэн ухаанаар хандах ёстой. Аль аль талуудынх нь байр суурь, нөхцөл байдал, эрсдэлийг тооцож үзэж байгаад энэ хуулийг үзэл санааны хувьд дэмжиж цааш нь явуулах ёстой гэсэн байр суурьтай байна.

Тийм учраас хэлэлцүүлгийн явцад бол олон талын олон ургалч үзлийг шигтгэж, хамгийн зөв хүний эрх хангасан хуулийг батлах ёстой гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлье. 1 дүгээр индэрт урьж байна.

С.Эрдэнэбат: Жагсаал, цуглааны тухай хуультай холбоотойгоор хэдэн саналуудыг бас хэлье.

1 дүгээрт бол одоогийн хуульд бол жагсаал, цуглааны зарим зүйл заалтууд бол тодорхойгүй байдгаас болж, иргэд болон жагсагч нар хууль хүчний байгууллагууд, мөн хууль хяналтын байгууллагын дунд үл ойлголцох байдал үүсдэг. Тийм учраас бол тэр тодорхойгүй заалтуудыг бол тодорхой болгох ёстой. Тухайлбал бүртгүүлнэ гэдэг нэрийдлийн доор 3 хоногийн дотор бол хариу өгөх ёстой. 3 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд жагсаал эхэлсэн тохиолдолд бол үүнийг бол бүртгэлгүй жагсаал буюу шууд торгуулийн арга хэмжээ рүү орж байсан. Миний хувьд ч гэсэн яг ийм байдалтай үүсээд, тодорхой хэмжээгээр би хувь хүний хувьд болон байгууллагын хувьд бол торгуулж байсан. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэхүү хууль нь өөрөө бүртгэнэ гэдэг нь өөрөө бүртгэх тэр процессоо хийгээгүй мөртөө бусдыг хууль зөрчсөн мэтээр бүртгэлгүй жагсаал хийсэн гэдэг нь шууд түлхдэг нэг ийм хуулийн цоорхой байгаад байгаа юм. Тийм учраас энийг бол тодорхой болгож байгаа нь бол зөв.

Харин нөгөө талаар бүртгэл гэдэг дотор техник хэрэгслийг оруулахгүй байх, тэгээд тайз, тог өгөхгүй байх гэдэг юм уу иймэрхүү аж ахуйн гэдэг юм уу тийм байдлаар бол хязгаарлах арга хэлбэрүүд бол байгаад байгаа юм. Тийм учраас энэ тал дээр нь энэ хууль дээр бол бас тодорхой тусгах зүйл байна. Өөрөөр хэлбэл ийм байдлаар бол жагсаал, цуглааныг хязгаарлах ийм зүйлийг бол захиргааны аргаар болон хясан боогдуулах замаар бол хаах гэдгийг хуульд тодорхой тавихгүй бол энэ хамгийн их төвөгтэй байдал руу аваачдаг. Энэ бол эргээд төр засаг энэ жагсаал цуглааныг хийхийг эсрэг байгаад байгаа нь хүчээр ингээд боломж олгохгүй байна гэдэг ийм буруу мессеж ирдэг учраас энийг бол тодорхой болгох ёстой.

Мөн хууль дээр бас нэг зүйл байна. Засаж өгсөн. Энэ дээр бол Байнгын хороо дээр зарим гишүүд тэр хувийн өмчийн газар жагсаал цуглаан хийхийг хориглоно гэдэг байдлаар гэдэг байдлаар оруулах шаардлагатай гэдэг санал өгсөн байна лээ. Хувийн өмч гэдэг дотор тухайн хувийн өмчийн компани, аж ахуйн нэгж, байгууллага эдгээр зүйл дээр ажилчид ажиллаж байдаг. Тухайлбал тухайн байгууллагын ажилчид тодорхой асуудлаар маргаан гараад жагсаал цуглаан байгууллага дээрээ хийж болно. Гэтэл хувийн өмчийн газар хийж болохгүй гэдэг байдлаар шууд хуулиар хориглох юм бол энэ жагсаал, цуглаан хийх эрхийг үндсэндээ хааж байгаа. Тэгэхээр

энэ байдал бол зөвхөн Сүхбаатарын талбай дээр жагсаал хийдэг юм биш. Маш олон газруудад хийдэг. Дээрээс нь төмөр зам, эмнэлэг, нисэх, тэгээд төрийн тусгай хамгаалалттай газар, хилийн боомт эд нар гээд оруулаад тавьчихсан байж байгаа. Энэ тухайн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах байдлаар жагсаал хийхийг хориглоно гэдэг байдлаар байхаас биш, тэнд хийж болохгүй гэдэг байдлаар хуульд оруулаад ирчихсэн. Тэнд бас ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс тухайлбал, төмөр замчид, эрүүл мэндийн ажилчид, нисэхийн ажилчид, хилийн боомт дээр ажиллаж байгаа жолооч, тээвэрчид, мөн бусад энэ улсын онц юутай гэдэг хүмүүс Өмнөговьд байж байгаа. тодорхой тээвэр хийж байгаа хүмүүс тэгвэл Сүхбаатарын талбай дээр ирж жагсаал хийх юм уу. Өөрийнхөө ажлын байран дээр ажил олгогч нартайгаа хандаж жагсаал цуглаан хийдэг үе тохиолдлууд зөндөө байдаг. Тэгэнгүүт энийг нь нийтлэг утгаар нь аваачаад хааж байгаа нь бол бас буруу байна гэдгийг бол хэлье. Үүнд бас анхаараач ээ. Энэ бол олон улсад иргэний нисэхийн газар хийж л байдаг, төмөр зам дээр хийж л байдаг, авто тээврийн газрууд дээр хийж байдаг, хилийн боомт хавьд бол хийж л байдаг. Харин тэгэхдээ хэвийн үйл ажиллагааг нь хаах гэдгийг нь бол тодорхой хэмжээгээр хязгаарласан ийм зохицуулалтыг хийдэг юм.

Мөн дээрээс нь хүний эрх, эрх чөлөөг хаах зорилгоор төрийн тусгай хамгаалалт гэдэг байдлаар энэ хориглосон газруудыг өргөжүүлэхгүй байх гэдгийг олон улсын хүний эрхийн факторын ерөнхий зөвлөмж дээр бол тусгасан байдаг. Эдгээр газруудыг өргөжүүлэхгүй байгаа. Одоогоор бол манай улсад бол 33 газар байгаа юм байна. Цаашдаа ингээд Засгийн газар ч гэдэг юм уу ингээд хориглоод байх юм бол энэ бол илүү хямгадах газар луу орох нь. Энийг бол хуульд зохицуулж өгөх шаардлагатай гэж хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа. Улаанбаатар хотод 18 цаг 04 минут болж байгаа тул өнөөдрийн нэгдсэн хуралдаан хаасныг мэдэгдье. Дараагийн чуулганаар санал хураалт болон бусад асуудлыг хэлэлцэнэ.

18.04 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ